

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛААС “ЭРҮҮДЭН ШҮҮЛТ ТУЛГАХ, ХҮНЛЭГ БУС,
ХЭРЦГИЙ ХАНДАХААС АНГИД БАЙХ ХҮНИЙ ЭРХИЙН ХЭРЭГЖИЛТ” ХҮНИЙ
ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨГ ХАНГАХТАЙ ХОЛБООТОЙ ХЯНАЛТЫН СОНСГОЛЫН
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

2024.11.20

“Их-Эзэн Чингис хаан” танхимд

Сонсгол даргалагч П.Сайнзориг - Сайн байцгаана уу? Та бүхэнд энэ өглөөний мэндийг дэвшүүлье. Сонсгол тун удахгүй эхэлнэ. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-д заасны дагуу Байнгын хороо, дэд хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирснээр хяналтын сонсголыг хүчинтэйд тооцох болсон тул гишүүдийг танхимдаа орж ирэхийг хүсье. Одоогийн байдлаар Хууль зүйн байнгын хорооны дарга, Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар ирсэн байна. Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал, Х.Тэмүүжин гишүүн, Г.Уянгахишиг ирсэн, Ц.Сандаг-Очир нар ирсэн байна. Гишүүдийг танхимд орж ирэхийг хүсье.

Хууль зүйн байнгын хорооны гишүүд сонсголын ирцдээ орохыг хүсье. Иргэд цагтаа цуглаад байна. Оролцогч байгууллагууд бас цагтаа цуглаад байна. Би одоо ирцийг дахин нэг танилцуулья. Өнөөдрийн Эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахаас ангид байх хүний эрхийн хэрэгжилтийн сонсголд Улсын Их Хурлын гишүүн Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар ирсэн байна. Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал ирсэн, Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг ирсэн, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир ирсэн, Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин ирсэн, Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг ирсэн байна, чөлөөтэй байгаа Н.Алтанхуяг гишүүн байна.

Гадаад томилолттой Б.Заяабал гишүүн, С.Одонтуяа гишүүн байна. Өвчтэй У.Отгонбаяр гишүүн, Дав.Цогтбаатар гишүүн өвчтэй гэсэн байна бусад гишүүд яаралтай бас сонсгол хийх танхимд орж ирэхийг дахин хүсье. Ж.Алдаржавхлан гишүүн, Б.Бат-Амгалан гишүүн, Х.Баттулга гишүүн, Б.Бат-Эрдэнэ гишүүн, Д.Ганбат гишүүн, Л.Мөнхбаатар гишүүн, М.Нарантуяа-Нара гишүүн, О.Номинчимэг гишүүн, Б.Пүрэвдорж гишүүн, Б.Энхбаяр гишүүн, С.Эрдэнэболд гишүүн гэсэн эдгээр хүмүүсийг яаралтай сонсгол хийх танхимд орж ирж, ирцэд орохыг хүсье.

Манай оролцогчид тайван байж байгаарай оролцогч та бас бусдыгаа хүндэтгэх хэрэгтэй байна Шинэбаяр гуайд дэг сануулж байна. Та бас бусдыгаа хүндэтгээд түр хүлээцтэй жоохон байж байгаарай. Улсын Их Хурлын гишүүд маань бас өнөөдрийн энэ сонсголд бас хариуцлагатай хандья. Санаачлагч гишүүдээсээ эхлээд Хууль зүйн байнгын хорооны гишүүд бүгд хоцорч байна.

Оролцогчид бүгд хүлээгээд ирчихсэн байж байна. Түрүүчээсээ бухимдаад байна гишүүд хариуцлагатай бай битгий биеэ өмөөрөөд бай Ж.Баярмаа гишүүн Та орж ирэх бололцоотой байгаа. Хууль зүйн байнгын хорооны ирцийг би дахин танилцуулья. Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-д зааснаар байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирснээр хяналтын сонсголыг хүчинтэйд тооцно гэж заасан учраас өнөөдрийн сонсголд Хууль зүйн байнгын хорооны 22 гишүүнээс дор хаяж одоо 12 нь ирж байж бас энэ сонсголыг эхлүүлэх бололцоо бүрдэх юм. Хууль зүйн байнгын хорооны гишүүдээс ирсэн гишүүдийг би дахин нэг танилцуулья.

Бусад гишүүдийг яаралтай танхимдаа орж ирэхийг хүсэж байна. Хууль зүйн байнгын хорооны дарга, Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар ирсэн, Улсын Их

Хурлын гишүүн Баасанжаргал ирсэн, Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг ирсэн, Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг ирсэн, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир гишүүн ирсэн, Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин гишүүн ирсэн байна, Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг гишүүн ирсэн.

Одоогийн байдлаар эдгээр 7 гишүүн ирсэн байгаа. Санаачлагч гишүүдээс түрүүн Ө.Шижир гишүүн ирсэн, Ж.Баярмаа гишүүн ирсэн байна. Ардчилсан намын бүлгийн гишүүдийг төлөөлж Д.Батбаяр гишүүн бас ирсэн байна. С.Эрдэнэболд дарга ирсэн, М.Нарантуяа-Нара гишүүн ирсэн байна. Ирцдээ орохыг хүсье яаралтай ирцийн мэдээг дахиад өгөөдөх, ирээгүй гишүүдийн нэрийг дахиж хэлнэ сонсголд ирсэн төрийн байгууллага болон оролцож байгаа иргэдийг Улсын Их Хурлын гишүүд хүндэтгэхийг бас би хүсэж байна.

Цаг бол цаг байгаа өчигдөр болон бусад бүх байдлаар энэ зар мэдээллийг хүргэсэн өнөөдөр давхцаж байгаа байнгын хороо бол байхгүй байгаа. Тийм учраас би бас энэ нийтийн сонсгол явж байгаа. Ж.Алдаржавхлан гишүүн танхимдаа орж ирэхийг хүсье, Б.Бат-Амгалан гишүүн танхимдаа орж ирэхийг хүсье, Х.Баттулга гишүүн танхимдаа орж ирэхийг хүсье, Д.Ганбат гишүүн танхимдаа орж ирэхийг хүсье, Л.Мөнхбаатар гишүүн танхимдаа орж ирэхийг хүсье, Б.Пүрэвдорж гишүүн танхимдаа орж ирэхийг хүсье, Б.Энхбаяр гишүүн танхимдаа орж ирэхийг хүсье, Дав.Цогтбаатар өвчтэй, У.Отгонбаяр гишүүн өвчтэй байгаа юм байна.

Б.Заяабал гишүүн гадаад томилолттой, С.Одонтуяа гишүүн гадаад томилолттой, чөлөөтэй Н.Алтанхуяг гэсэн ийм гишүүд өнөөдрийн байдлаар өөрөөр хэлэх юм бол өвчтэй, чөлөөтэй, гадаад томилолттой 5 гишүүн бусад гишүүд ямар нэгэн байдлаар Улсын Их Хурлын Тамгын газарт өвчтэй чөлөөтэй гадаад томилолттой гэдгээ хэлээгүй тул бас яаралтай танхимдаа орж ирэхийг хүсье. Ер нь бол гишүүд маань бас энэ сонсгол дээр бас яг цагтаа цуглах ёстой.

Сонсгол бол цагаараа эхлэх ёстой ийм хуультай байгаа боловч хүчин төгөлдөр ирцтэйгээр энэ сонсгол эхлэх ёстой гэдэг бас хуулийн заалт байгаа учраас бас та бүгдийгээ миний бие буюу сонсгол даргалагч хүлээлгээд байгааг бас хэлье.

Тэгээд бүх Хууль зүйн байнгын хорооны гишүүдийн өмнөөс бас та бүгдээсээ хүлцэл өчье. Одоо тун удахгүй 3 гишүүн ороод ирвэл сонсгол маань эхлэнэ. Хоцорсон гишүүдийнхээ өмнөөс хүлцэл өчье. Янз бүрийн байдлаар би шалтаг сонсохгүй цаг бол цаг байгаа. Сонсголыг бас санаачилсан гишүүдээс болон бусад Улсын Их Хурлын гишүүд ирсэн байгааг би бас танилцуулж байя гэж бодож байна. Ж.Баярмаа гишүүн, мөн Д.Батбаяр гишүүн ирсэн, Ө.Шижир гишүүн ирсэн, Д.Энхтүвшин гишүүн ирсэн байгааг бас илтгэе.

Эдгээр гишүүд маань Хууль зүйн байнгын хороонд одоо харьяалагддаггүй боловч зарим гишүүд маань бас сонсголыг санаачлагч болон одоо бусад байдлаар оролцохоор ирсэн гишүүд байгаа гэдэг зүйлийг бас хэлэх нь зүйтэй байх яаралтай гишүүд маань орж ирье. Одоо 3 гишүүн ороод ирвэл бас ирц бүрдэж сонсголын ажиллагаа эхлэхэд бэлэн болоод байна. Хууль зүйн байнгын хороонд харьяалагддаг боловч ирээгүй гишүүдийг дахин хэлье. Одоо би орж гишүүдийг орж ирж ирц бүрдэх хүртэл бүх нэрээр нь хэлнэ. Хан-Уул дүүргээс сонгогдсон Ж.Алдаржавхлан гишүүн ирцдээ орж ирье. Баянзүрх дүүргээс сонгогдсон Э.Бат-Амгалан гишүүн ирцдээ орж ирье. Баянхонгор аймгийн болон төвийн бүсээс сонгогдсон Д.Ганбат гишүүн, Л.Мөнхбаатар дарга дотоод томилолттой байгаа юм байна хөдөө орон нутгаас ирж байгаа гэдэг мэдээлэл байна. Би бас энэ ирцэд хэлье Д.Ганбат гишүүн ирж байна гэнэ.

Б.Пүрэвдорж гишүүн ирцдээ орж ирье, Дав.Цогтбаатар гишүүн бас ирцдээ орж ирье, Б.Энхбаяр гишүүн ирцдээ орж ирье эдгээр гишүүдээс орж ирээд бас сонсгол одоо хүчин төгөлдөр ирцтэй тооцож эхлэх гээд байна. Иргэд болон төрийн байгууллагууд бол цагтаа суудлаа эзэлсэн байгаа гэдгийг би бас энэ хариуцлагатайгаар энэ индэр дээрээс хэлэх нь зөв байх. Гишүүд харин цагтаа орж ирэхийг хүсье. Одоо нэгэнт цаг бараг 26 минут хүлээчихсэн байна шүү яаралтай орж ирэхийг хүсье.

Одоогийн байдлаар ирцийг дахин нэг танилцуулья Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар ирсэн байна, Улсын Их Хурлын гишүүн Х.Баттулга ирсэн, Х.Баасанжаргал гишүүн ирсэн, М.Нарантуяа-Нараа гишүүн ирсэн, О.Номинчимэг гишүүн ирсэн, П.Сайнзориг гишүүн ирсэн, Ц.Сандаг-Очир гишүүн ирсэн, Х.Тэмүүжин гишүүн ирсэн, Г.Уянгахишиг гишүүн ирсэн, С.Эрдэнэболд гишүүн ирсэн байна. Одоо сонсголыг санаачлагч гишүүдээс болон бусад Улсын Их Хурлын гишүүд бас ирсэн байгаа. Одоо яаралтай ирцдээ орохыг Ж.Алдаржавхлан гишүүнээс Э.Бат-Амгалан, Б.Бат-Эрдэнэ гишүүн, Б.Пүрэвдорж гишүүн, Дав.Цогтбаатар гишүүн, Б.Энхбаяр гишүүдээс одоо яаралтай залгаж ирцдээ орохыг хэлээрэй.

Н.Алтанхуяг гишүүн чөлөөтэй байна, Б.Заяабал гишүүн гадаад томилолттой, Л.Мөнхбаатар гишүүн дотоод томилолттой, С.Одонтуяа гишүүн гадаад томилолттой өвчтэй У.Отгонбаяр гишүүн, Дав.Цогтбаатар гишүүн байгаа юм байна, одоо 2 гишүүн ороод ирвэл эхлэх ёстой. Улаанбаатарт 10 цаг 39 минут хурал сонсгол эхлэх цагаасаа 39 минут хоцорч байгааг бас нийт оролцож байгаа төрийн байгууллага болон иргэдээсээ бас хүлцэл өчиж байна. Ингээд одоо Хууль зүйн байнгын хорооны ирцийг дахин танилцуулья.

Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар ирсэн байна, Улсын Их Хурлын гишүүн Х.Баттулга ирсэн байна, Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал ирсэн, Улсын Их Хурлын гишүүн М.Нарантуяа-Нараа ирсэн, Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг ирсэн, Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг ирсэн, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир ирсэн байна, Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин ирсэн байна, Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг ирсэн байна, Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд ирсэн байна.

Одоогийн байдлаар 10 гишүүн байна. Чөлөөтэй байгаа гишүүдийг дахин бас танилцуулья. Н.Алтанхуяг гишүүн чөлөөтэй, гадаад томилолттой 2 гишүүн өвчтэй байгаа 2 гишүүн байна хуралдаа оролцох боломжтой одоо яаралтай орж ирэхийг хүсэж байна. Дараах гишүүдийн нэрийг хэлье. Ж.Алдаржавхлан Б.Бат-Эрдэнэ Д.Ганбат, Б.Пүрэвдорж, Б.Энхбаяр гишүүдийг яаралтай ирцдээ орж ирэхийг бусдыгаа хүндэтгэе тэгэх үү? Ж.Алдаржавхлан гишүүн орж ирлээ. Ж.Алдаржавхлан гишүүн яаралтай ирцдээ орчих.

Шинэбаяр гуай би танд сүүлийн удаа бас нэг анхааруулж хэлье. Та түр тэвчээртэй хүлээж байна уу? Ямар ч байсан эхлээд Хууль зүйн байнгын хорооны ирц бүрдээдэхье. Тэр хойноос хэлсэн хүний саналыг бүрэн дэмжиж байна. Яг цагаараа цагийг сунгаж хэлнэ. Сонсгол эхлэх гэж байна Э.Бат-Амгалан гишүүн ороод ирлээ. Би ирцийг танилцуулья. Э.Бат-Амгалан гишүүн яаралтай ирцдээ ороод суучихна уу? манайхан дуугаа намсгаж байгаарай хэдүүлээ сонсголоо эхэлье ирц бүрдчихлээ Э.Бат-Амгалан гишүүн суучих Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.3-т заасны дагуу Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооноос зохион байгуулж байгаа хүний эрх, эрх чөлөөг хамгаалахтай холбоотой хяналтын сонсголд оролцогч Та бүгдийнхээ энэ өдрийн амгаланг эрье.

Ингээд өнөөдөр бас ирц бүрдэх энэ асуудлаас шалтгаалаад хурал бас 48 минут бас хоцорсонд юун түрүүнд бас сонсгол даргалагч болон Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны гишүүдийн нэрийн өмнөөс миний бие та бүгдээсээ хүлцэл одоо өчиж байна. Ингээд хэдүүлээ бас энэ алдсан цагаа хойшоо тавиад ерөнхийдөө 17:10-д энэ сонсгол дуусна гэсэн хуваарьтай байсан бол энийг одоо хойшоо 50 минутаар сунгаад 18:00 цаг хүртэл энэ арга хэмжээг яг энэ хөтөлбөрийн дагуу явуулна гэдэг зүйлийг би юун түрүүнд бас цохон тэмдэглэж хэлье.

Сонсголд оролцогч байнгын хорооны гишүүдийн ирцийг дахин нэг албажуулж бас хэлэх нь зүйтэй өнөөдрийн Улсын Их Хурлын, Хууль зүйн байнгын хорооноос зохион байгуулж байгаа сонсголд Хууль зүйн байнгын хорооны дарга, Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлан, Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалан, Улсын Их Хурлын гишүүн Х.Баттулга, Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал, Улсын Их Хурлын гишүүн М.Нарантуяа-Нара, Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг, Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин, Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг, Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд гэсэн гишүүд ирснээр ирц бүрдэж өнөөдрийн сонсголын үйл ажиллагаа эхлэхэд бэлэн.

Өнөөдрийн сонсголыг зохион байгуулалт хүсэлт гаргасан гишүүдийн 22 гишүүний төлөөлөл болж Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа гишүүн маань ирсэн байна. Улсын Их Хурлын сонсголыг одоо бас оролцож, бас үзэл бодол, байр сууриа хэлэхээр Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаяр гишүүн Улсын Их Хурлын гишүүн Ө.Шижир Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин гишүүн ирсэн, Улсын Их Хурлын гишүүн Ч.Лодойсамбуу нарын гишүүд ирсэн байгааг хэлэх нь зүйтэй байх. Өнөөдрийн сонсголд ингээд ирц бүрдсэн учраас сонсголыг эхэлье.

Сонсголыг иргэд, олон нийтдээ нээлттэй байлгах үүднээс 15-ны өдрийг хүртэл тодорхой хэмжээнд бүртгэлийн үйл ажиллагааг хийсэн. Өнөөдөр ажиглагчаар оролцохоор 2 хүн хүсэлт өгснөөс хоёулаа ирсэн байна. Төрийн байгууллагыг төлөөлөөд 45 хүнээс 37 нь ирсэн байна. Төрийн бус байгууллага болон иргэдийн төлөөлөл нийт одоо 75 хүн бүртгүүлснээс одоогийн байдлаар 46 хүн нь бүртгүүлсэн, нийт 122 хүн одоо иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын төлөөлөл оролцохоос нийт 85 хүн ирсэн байгаа гэдгийг би хэлэх нь зүйтэй байх. Мөн цахимаар 2 хүн оролцох хүсэлт тавьсан, цахимаар холболт хийгдсэн байгааг хэлье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 126 дугаар зүйлийн 126.4-т заасны дагуу Монгол Улсын Их Хурлын хяналтын сонсгол нээлттэй хаалттай хэлбэрээр зохион байгуулж болох бөгөөд хувь хүн, хуулийн этгээд, төрийн нууцад хамаарах болон үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбоотойгоос бусад асуудлаар сонсголыг хаалттай явуулахыг хориглоно гэж заасны дагуу өнөөдрийн сонсгол нээлттэй явуулж байгаа бөгөөд хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөл оролцох эрхтэй байгааг мөн цохон дурдаж байна.

Монголын Үндэсний олон нийтийн радио, телевиз болон парламентын шууд дамжуулах сувгаар дээрх сонсголыг олон нийтэд хүргэж байгаа гэдгийг хэлэх нь зүйтэй. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 124.4, 124.5-д заасны дагуу хэл яриа сонсголын бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй байлгах, тэдний сонсголд оролцох, ажиглах боломжийг хангах зорилгоор өнөөдрийн сонсголыг Үндэсний олон нийтийн радио, телевизээр дохионы хэлмэрчтэй явуулж байгааг энэ дашрамд хэлье.

Та бүхэнд өнөөдрийн сонсголын зорилго дэс дараалалыг танилцуулья. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.3-т заасны дагуу иргэн хууль, ёсны, ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа иргэн хуулийн этгээдийн гаргасан хүсэлтийг тухайн асуудал эрхэлсэн Байнгын хороо, дэд хороо хэлэлцэн хүлээн авсан, Улсын Их Хурал дахь цөөнхийн бүлэг хүсэлт гаргасан, Улсын Их Хурлын 15-аас доошгүй гишүүн хүсэлт гаргасан бол хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой хяналтын сонсголыг Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасны дагуу зохион байгуулна гэж заасны дагуу нэр бүхий 22 гишүүн одоо хүсэлт гаргасны дагуу өнөөдрийн сонсголыг хийж байгаа гэдэг зүйлийг хэлье.

Дээрх гишүүдэд Монгол Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа тэргүүтэй одоо 22 гишүүн хүсэлт гаргасан гэдгийг би энэ дашрамд хэлэх нь зүйтэй байх. Дээрх хүсэлтийг Улсын Их Хурлын даргад гаргасны дагуу хүсэлтийг Хууль зүйн байнгын хорооны 2024 оны 8 дугаар сарын 15-ны өдрийн хуралдаанаар хэлэлцээд Хяналтын сонсголын товыг тогтоох сонсгол даргалагчийг сонгох тухай 02 дугаар тогтоолыг баталж, хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой эрүүдэн шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандлагаас амьд байх хүний эрх, эрхийн хэрэгжилтийн хяналтын сонсголыг зохион байгуулахаар шийдүүлж даргалагчаар Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг намайг сонгосон байгаа.

Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 27.1-д заасны дагуу хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах, үр дүнг сайжруулах, хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалах чиг үүрэг бүхий төрийн байгууллага албан тушаалтны үйл ажиллагаанд илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, мэдээлэл авах, үнэлэх зорилгоор дээрх сонсголыг явуулна гэж заасны дагуу өнөөдрийн сонсголын зорилго чиглэж байгаа гэдэг зүйлийг хэлье. Улсын их хурлаас зохион байгуулж байгаа хяналтын сонсгол нь олон нийтийн оролцоотой явагддаг хэлэлцүүлэгтэй адилгүй бөгөөд зөвхөн Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасан журмаар, дэгээр явагддаг болохыг би онцлон тэмдэглэж, дэгээ барихыг, журмаа барихыг бас нийт оролцогчдоосоо бас хүсэж байна.

Өнөөдрийн сонсголд оролцож байгаа Та бүхэн дэгтэйгээ танилцаж тодорхой мэдээллүүдийг авсан байх гэж би найдаж байна. Эрх, үүргийг дахин Та бүгдэдээ танилцуулна. Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 126.3-д хуульд өөрөө заагаагүй бол оролцогч сонсголын үеэр сонсгол даргалагч, гишүүн бусад оролцогчоос асуулт асуухгүй гэж заасан бөгөөд мөн зүйлийн 124 дүгээр зүйлд заасан сонсголд оролцогчийн эрх үүргийг Та бүгдэдээ уншиж сонсгоё. 124.1-д сонсголд оролцогч дараах эрхийг эдэлнэ.

Энэ хуульд заасан үндэслэл журмын дагуу асуултад хариулах тайлбар санал хэлэх эрхтэй, сонсголын тэмдэглэл гарсан шийдвэртэй танилцах өөрийн хэлсэн санал тайлбарыг хянах эрхтэй байна. Мөн сонсгол зохион байгуулагч болон даргалагчаас тэнцвэртэй, хүндэтгэлтэй хандахыг шаардах эрхтэй байна.

Мөн хуулийн 124.2-д заасны дагуу сонсголд оролцогч дараах үүргийг хүлээж байгаа 124.2.1-д Сонсгол зохион байгуулагчийн дуудсанаар сонсголд хүрэлцэн ирэх сонсголыг дэг сахих, сонсгол зохион байгуулагч болон сонсгол даргалагчийн хууль, ёсны шаардлагыг биелүүлэх, сонсголд үнэн зөв мэдүүлэг мэдүүлэх, бодитой дүгнэлт өгөх, ингээд холбогдох бусад хууль тогтоомжид заасан үүрэг хүлээх гэж тус тус заасан байгааг та бүгдэд уншиж сонсголоо.

Тус хуулийн 125.2.8-д заасны дагуу сонсгол даргалагчийн сонсголын асуулт, хариулт, тайлбар, санал мэдээлэл болон сонсголын сэдэвтэй хамааралгүй, сонсголын хүрээ хязгаарыг сонсгол явуулах энэ сэдвийн хүрээнд явах ёстой гэдэг зүйлийг анхаарах, ялгаварлан гадуурхсан, бусдыг доромжилсон үг хэллэг хэрэглэсэн бол таслан зогсоох, сонсголын дэг зөрчсөн, сонсгол даргалагчийн зөвшөөрөлгүйгээр үг хэлэх, хүч хэрэглэх зэрэг зохисгүй үйлдэл гаргасан оролцогчид сануулах зайлшгүй шаардах ёстой үг хэлэх эрхийг нь хасах сонсголын тогтсон сэдвээс өөр сэдвийг хөндсөн тохиолдолд сануулга өгөх буюу сонсголын үйл ажиллагаанаас саад учруулсан этгээдийг танхимаас гарах хүртэл арга хэмжээ авах эрхтэй болохыг би энд сануулан хэлье.

Монгол Улсын Их Хурлаас зохион байгуулж байгаа өнөөдрийн сонсголын гол ач холбогдол бол мэдээллийг сонсох, цуглуулах, төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн мэдэх эрхийг хангах, саналыг сонсож шийдвэр гаргах түвшиндээ нэгдсэн нэг ойлголттой болох төрийн байгууллага албан тушаалтны үйл ажиллагаанд илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах асуудлаар Засгийн газар болон холбогдох бусад байгууллагад чиглэл зөвлөмж өгнө. Та бүхэндээ сонсголын хөтөлбөр, дэс дараалалыг танилцуулья.

Нэгдүгээрт эрүүдэн шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахаас ангид байх хүний эрхийг хангах холбоотой байгууллагын дүгнэлтийг хуульд заасны дагуу сонсох болно. Өөрөөр хэлбэл эрүүдэн шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахаас ангид байх эрхтэй холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилт төрийн байгууллага албан тушаалтны үйл ажиллагаанд хийсэн Хүний эрхийн Үндэсний комиссын дарга Д.Сүнжид танилцуулна. Түүний дараагаар эрүүдэн шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандалтаас ангид байх хүний эрхийн хэрэгжилтийн талаарх Засгийн газрын мэдээллийг Хууль зүй, дотоод хэргийн яамны төлөөлөл хийнэ. Эрүү шүүлт тулгах гэмт хэргийн талаарх мэдээллийн талаарх Улсын ерөнхий прокурорын газрын мэдээллийг мөн сонсоно.

Эрүү шүүлт, эрүүдэн шүүх гэмт хэргийн шүүхийн шийдвэрлэлт ба гэмт хэргийн улмаас хохирч учирсан сэтгэцэд учирч байгаа хор уршгийн зэрэглэл тогтоох, нөхөн төлүүлэх асуудлаар Хууль тогтоомжийн хэрэглээ шүүхийн практикийн талаар Улсын дээд шүүхийн мэдээллийг сонсоно.

Эрүүдэн шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахаас ангид байх хүний эрхийг хангахтай холбоотой асуудлаар бусад байгууллагуудын мэдээллийг сонсоод Зэвсэгт хүчний нэгтгэл анги, байгууллагуудын хүний эрх, эрх чөлөөг зөрчих дүрмийн бус харилцааны талаар гаргасан гомдол мэдээллийн шийдвэрлэлт болон авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар Зэвсэгт хүчний жанжин штабын мэдээллийг сонсоно.

Төрөлжсөн асрамжийн газарт амьдарч байгаа ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдийн эрхийн хэрэгжилтийн талаарх Гэр бүл, хөдөлмөр, нийгэм хамгааллын яамны мэдээллийг сонсоно. Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн хэвтэн эмчлүүлэх болон байнгын асруулагчийн эрхийн хэрэгжилтийн талаарх мэдээллийг Эрүүл мэндийн яамны мэдээллийг сонсоно. Эдгээр байгууллагуудын мэдээллийг 5-аас 15 минутад сонсоод хөтөлбөрийн 3 дугаар хэсэг рүү орж байгаа. Мөн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 126.1.4-т заасны дагуу сонсголд оролцогч санал мэдээллээ 3 минутад хэлж оролцоно. Одоогийн байдлаар энэ сонсголд ирсэн 45 хүнээс бид нар байр суурь, үзэл бодлоо илэрхийлэх хүмүүсийг урьдчилан бичгээр зөвшөөрөл хүсэлтүүдийг нь авч байгаа гэдэг зүйлийг хэлье. Оролцогчид маань 3 минутад байр сууриа хэлнэ.

Тодруулах шаардлагатай асуудал дээр 1-ээс 2 минутыг сонсгол даргалагчаас өгөх болно гэдгийг хэлье. Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 126.1.7-д заасны дагуу сонсголд оролцогчоор бичгээр ирүүлсэн мэдээллээс дурдагдаагүй үлдсэн мэдээллүүд буюу биечлэн ирж мэдээллээ өгч чадаагүй бичгээр хүсэлт өгсөн иргэдийн мэдээллийг миний бие сонсох болно. Улсын Их Хурлын гишүүдээс сонсголд оролцож байгаа төрийн байгууллагын мэдээлэл болон нийт оролцож байр сууриа хэлсэн иргэдээс 10 хүртэл минутад асуулт, асууж хариулт авна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 126 дугаар зүйлийн 126.1.6-д Улсын Их Хурлын гишүүд 5 минутад багтааж үг хэлж болно. Дэг дарааллын дагуу, хөтөлбөрийн дагуу явна гэдэг зүйлийг та бүгдэд уншиж сонсгоё. Хяналтын сонсголын дэг болон дараалалыг танилцуулж дууслаа. Сонсголын үйл ажиллагаанд орцгооё.

Индэрт Хүний эрхийн Үндэсний комиссын дарга Д.Сүнжидийг урьж байна. Эрүүдэн шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандалтаас ангид байх эрхтэй холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилт, төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд хийсэн Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын дүгнэлтийг бид хуульд заасны дагуу сонсголын үеэр хамгийн түрүүнд сонсох ёстой. Д.Сүнжид даргыг дүгнэлтээ танилцуулахыг индэрт урьж байна.

Хүний эрхийн Үндэсний комиссын дарга Д.Сүнжид- Улсын Их Хурлын эрхэм гишүүд, энэхүү сонсголд оролцож байгаа нийт оролцогч та бүхэндээ энэ өглөөний мэндийг хүргэе. Хүний эрхийн Үндэсний комиссын Эрүү шүүлт, хүнлэг бус, хэрцгий, нэр төрийг гутаан доромжилж харьцахаас ангид байх эрхийн хэрэгжилтийн талаар дүгнэлтийг 2024 оны 10 сарын 03-нд Хууль зүйн байнгын хороо, Хүний эрхийн дэд хороонд хүргүүлсэн. Энэхүү дүгнэлтийг хийхдээ юун түрүүн эрүүдэн шүүхийн эсрэг Монгол Улсын нэгдэн орсон конвенцын 2 заалтыг дурдах ёстой.

Эхний заалт нь эрүүдэн шүүх гэж нэг хүн эсвэл 3 дахь этгээдээс мэдүүлэг авах, тухайн хүн буюу 3 дахь этгээдийн үйлдсэн буюу сэргээгдсэн хэрэгт шийтгэх, айлган сүрдүүлэх, шахалт үзүүлэх, аливаа байдлаар алагчлах зорилгоор төрийн албан тушаалтан, албан үүрэг гүйцэтгэж буй бусад хүний өдөөн хатгалт, ил, далд зөвшөөрлөөр тухайн хүн буюу 3 дахь этгээдийн бие махбод сэтгэл санаа хүчтэй шаналган зовоох аливаа санаатай үйлдлийг хэлнэ гэдэг 16.1 дэх зүйлд нь саяын 1 дүгээр зүйлд хэлсэн эрүү шүүлтэд тооцогдохгүй бусад үйлдлийг төрийн албан тушаалтнаас тэдгээрийн өдөөн хатгалт, ил далд зөвшөөрлөөр үйлдэгдэх, хэрцгий, хүнлэг бус, хүний нэр төрийг доромжлон харьцах шийтгэх бусад үйлдлээс сэргийлэх үүргийг төр хүлээдэг юм гэдгийг онцолж хэлдэг.

Бид энэ хүрээндээ бид нар өнөөдрийн Хууль зүйн байнгын хороонд хүргүүлсэн нээлттэй сонсголд хүргүүлсэн дүгнэлттэй холбоотой 4 агуулгын хүрээнд багцлая нийт 27 хуудас хүргүүлсэн байгаа. Ерөнхий мэдээллийг өгье энэ дээр Хүний эрхийн Үндэсний комисс бол 2001 онд байгуулагдсан. Ингээд 23 удаа Улсын Их Хуралд хүний эрх чөлөөний төлөв байдлын талаарх илтгэлийг жил болгон хүргүүлж байсан.

Үүнээс 9 удаа нь буюу хамгийн олон удаа иргэний болон улс төрийн эрхийн чиглэлээр эрүү шүүлт тулгахаас ангид байх, халдашгүй чөлөөтэй байх, шударгаар шүүлгэх эрхийн талаар илтгэлдээ тусгасан байдаг. Хамгийн сүүлд энэ 2022, 2023 буюу одоо энэ оны 2024 оны үүний өмнөх оны 2023 оны илтгэл мөн энэ асуудлыг тулгаж тодорхой санал зөвлөмжийг өгсөн. Улсын Их Хурлын өмнө бол 2021 оноос өмнө бол Хууль зүйн байнгын хороо 2021 оноос хойш бол Улсын Их Хурлын тогтоолоор энэтэй холбоотой зөвлөмжүүдийг Засгийн газарт үүрэг болгон өгсөн

байгаа. Эрүү шүүлт тулгах гэмт хэргийн нөгөө эрүү шүүлт тулгах гэмт хэрэг хүнлэг бус, хэрцгий харьцах, нэр төрийг гутаан доромжлох энэ байдал ямар байна вэ гэдгийг юуны хувьд бусад оролцогч талууд буюу мөрдөн шалгах ажиллагаа явуулдаг байгууллагууд өөрсдөө Улсын ерөнхий прокуророос, Хууль зүй, дотоод хэргийн яамнаас, Зэвсэгт хүчний жанжин штабаас шүүхээс мэдээлэл хийх учир илүү Комиссын хийсэн үйл ажиллагаан дээр төвлөрч танилцуулья.

Энд бид эрүү шүүлтэд саяын хэлсэнчлэн төрийн тодорхой институт байгуулах дээр эрүү шүүлт, тулгах гэмт хэрэг гарах эрсдэл байдаг нөхцөл үүсдэг. Тийм учраас тодорхой институтийг бид нар байнгын энд хүний эрхийн зөрчил байна уу? үгүй юү гарсан бол түүнийг нь таслан зогсоох, тодорхой этгээдэд хариуцлага хүлээх буруутай этгээдэд хариуцлага хүлээх тухай асуудлыг бид нар ярьдаг.

Комисст ирсэн гомдол мэдээллийг аваад үзэх юм бол 2020 оноос хойш нийтдээ сүүлийн 2 жил бол 108, одоо 2020 онд 47, 2021 онд 27, 2022 онд 15, 2023 онд 60, 2024 онд 48 ирсэн. Эндээс холбогдох байгууллагуудыг нь ялгаад үзэх юм бол цагдаагийн байгууллагын алба хаагчтай холбоотой 55 хамгийн олон холбогдсон, эрүү шүүлт тулгасан, хянадаг бус хэрцгий харьцсан гэж байгаа. Энэ зөрчил гэмт хэргийн мэдээлэл ирдэг прокурортой холбоотой 4, Авлигатай тэмцэх газрын мөрдөгчтэй холбоотой 3, шүүгчтэй холбоотой 1, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын алба хаагчтай холбоотой 45 ирсэн байна. Сүүлийн зөвхөн 2023 оны бүтэн жилийн байдлаар, 2024 оны 10 сарыг хүртэлх байдлаар ирсэн энэ 108 гомдол мэдээллийн шийдвэрлэлтээс 34-ийг энэ бол гэмт хэрэг бөгөөд зөрчлийн шинжтэй байж болзошгүй байна гэж үзэж Авлигатай тэмцэх газарт шилжүүлсэн.

Гурвыг нь Цагдаагийн ерөнхий газарт шилжүүлсэн. Эндээс цаашаа ажиллагаа явагдсан байна вэ гэдгийг харахаар хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс 17-г нь татгалзсан, нээсэн 2, цагдаагийн байгууллага болон прокурорт шилжүүлсэн, шийдвэрлэгдсэн 11 байна, эрүү шүүлт тулгах гэмт хэргийн бид нар одоо яаж энийг шалгах ажиллагааг явуулж байгаа вэ гэхээр энэ дээр журмын дагуу өмнө нь бол нөгөө прокурорын мөрдөн шалгах ажиллагаа явуулдаг алба байсан.Түүний дараагаар бол Улсын ерөнхий прокурор, Цагдаагийн ерөнхий газар, Авлигатай тэмцэх газар, Тагнуулын ерөнхий газар энэ хэрэгтэй холбоотой гомдлуудыг сөөлжлөх байдлаар хүлээн авч, мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаа. Нийтдээ шийдвэрлэгдсэн гэмт хэргийг аваад үзэхээр 2016-аас 2023 онд 14 гэмт хэрэг шүүхээр яг эцэслэн шийдвэрлэгдсэн юм билээ 30 хүнд холбогдож байгаа 14 хэрэг шийдвэрлэгдсэн. Тэгээд нийт ирсэн гомдолтой харьцуулах юм болбол 500 орчим гомдол жилдээ бүх байгууллагуудад Хүний эрхийн Үндэсний Комисс төдийгүй Цагдаагийн байгууллага, Авлигатай тэмцэх газар, Улсын ерөнхий прокурор гээд энэ байгууллагууд ирж байгаа.

Энэ гомдлын шийдвэрлэсэн байдлыг нь харьцуулах юм бол ихэнх нь буюу 300 орчим нь хэрэгсэхгүй болдог юм байна. Тэгээд үүнээс цаашаа үргэлж л шалгаж явж байгаад шүүхээр шийдвэрлэгдсэн гэдэг тоог харахаар бид нар жилдээ 1-ээс 2 л хэргийг дунджаар шийдвэрлэж байгаа гэдэг ийм үзүүлэлттэй байна. Ингээд харахаар бид нар бол эрүү шүүлт тулгасан гэж хүлээж авч байгаа гомдол, мэдээлэл хүлээж авсан гомдлын тоо шийдвэрлэж байгаа байдлыг харахаар энэ тоо бол харьцангуй, энэ шийдвэрлэлт нь бол энэ шүүхээр бага шийдэгддэг юм байна гэдэг дүгнэлтийг бид нар хийж болно. Энэ 14 хэргийн 30 хүнд холбогдох хянан шийдвэрлэсэн байдал нь цагдаагийн албан хаагчид холбогдох нь 21, тагнуулынх 5, авлигатай тэмцэх газрынх 2, Прокурор 1, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын 1 албан хаагч байгаа юм.

Эрүү шүүлтийн хэлбэр ашигласан бэ гэдэг дээр хүнд, хүндэвтэр, хөнгөн

гэмтэл учруулсан, гэмтэл учруулаагүй гэж байгаа. Гэхдээ энэ бусдын бие махбодыг шаналган зовоосноос гадна сэтгэл санааг шаналган зовоох гэдэг энэ манай Монгол Улсын эрүүгийн хуульд ч бий, олон улсын гэрээ конвенцод нь ч гэсэн заасан байдаг ойлголтоо энэ сэтгэл санаа шаналган зовоох, хэлбэр дээр дарамтлах, өөр зовууртай байдал үүсгэх зохисгүй үг хэллэг хэрэглэх, санал тавих, болзол тавих, өмгөөлөгчтэй уулзуулахгүй байх, тэгээд дуу авиа гаргах гэх мэтээр энэ нөхцөл байдлуудыг хэлсэн байна.

Энэ ирсэн гомдлын агуулга ямар хэлбэрээр, ямар аргаар хэрхэн яаж хийсэн юм бэ гэдэг дээр зодно, цохино, эрх чөлөөг хасна, мессеж илгээх гэдэг юм уу одоо тэр дарамтлах үйлдэл сүрдүүлэх үйлдлээ олон янз байдлаар ашигладаг, элдэв зэвсэг хэрэгсэл бас ашигласан гэдгээ ингэж хэлж байна. Хүнлэг бус хэрцгий, хүний нэр төрийг доромжлон харьцаж шийдэхийн эсрэг энэ асуудал дээр ямар байна вэ гээд тэгэхээр эд нар нэг хэдэн 4 онцолж ярих ёстой байгаа юм. Хорих ангийг бид нар ярих ёстой хорих байрыг ярих ёстой, хорих анги дээр нийтэд нь дүр зургийг харах юм бол бид нар ялын бодлого буюу 2017 онд Эрүүгийн хууль баталсны дараагаар хорих ангид хоригдож байсан хоригдлын тоо эрс буурсан. Хорих анги дээр нийтэд нь бүр өсөн нэмэгдэж байгаа. Одоо энэ жилийн байдлаар гэхэд 4526 болсон.

Энэ нь өмнөх жилээс даруй 200- 300-гаар, жил бүр, ер нь бол 200-аас 300-гаар хоригдлын тоо өсөж байна. 1200 хоригдлуудын дунд судалгааг явуулсан. Энэ сүүлийн 3 жил байнга л судалгаа явуулж байгаа 1 дүгээрт хяналт шалгалтыг Хүний эрхийн Үндэсний Комисс тодорхой хорих анги, цагдан хорих байр, баривчлах байр дээр хийдэг. Түүнээс гадна хорих ангиудад очиж хийдэг эндээс ингээд үзэхээр нийт оролцсон хоригдлуудын халдашгүй эрхэд хандаж байна гэж үзэж байгаа нь 22,8 байгаад байдаг Хүний эрхийн Үндэсний комисст жилд дунджаар 1100 орчим гомдол ирдэг. Үүний 20- 30% нь бол халдашгүй байх эрхэд халдлаа буюу шударгаар шүүх хэрэгт халдлаа, хууль зүйн туслалцаа авах эрхийг маань хангахгүй байна.

Түүнчлэн эрүү шүүлтээс ангид байх хүнлэг бус нэр эрхэд халдах, нэр төрийг гутаан доромжлуулж, хандахаас ангид байх эрхийг маань хангасангүй ээ гэдэг байх утга агуулгатай гомдол ирдэг. Энэ нь бол буурахгүй байгаа. Оролцогчдын хувьд ч гэсэн зөвхөн гомдлын хувьд авч үзэхэд энэнээс 2020-оос 30% байдаг. Түүнээс гадна хоригдлуудын дунд явуулсан судалгаагаар ер нь бол хүнлэг бус хэрцгий харьцаа байна. Эсвэл хамт хоригдож байгаа хүнд ийм үйлдэл илэрсэн гэж хэлж байгаа 22 байгаа болохыг энэ судалгаанаас харж болно. Хоригдлуудын тоо ихэссэнтэй холбоотой бас яагаад энийг ярьж байгаа вэ гэхээр нөхцөл байдлын асуудлыг бол бид нар байнга хөндөх ёстой байдаг.

Энэ дээр 12 анги цэвэрлэх байгууламжид холбогдоогүй, гадна бие засах орчинтой байгаа хэвээрээ байгаа. Хүүхдийн сургалт хүмүүжлийн төв гээд байна. 405 гээд байна, Эмэгтэйчүүдийн хорих анги гээд байна эд нар бүгдээрээ стандартын шаардлага хангахгүй байна гэдгийг нь мэргэжлийн байгууллагаас тогтоочихсон байранд үйл ажиллагаа явуулсан хэвээрээ байгаа. Тэгэхээр энэ дээр бид нар нөхцөл байдлын тухай асуудлыг ярих ёстой тэгээд хоригдлын тоотой холбоотой бас хүний нөөцийн асуудал хүрэлцээний тухай асуудлыг байнга ярих хэрэгцээ гардаг. Тэгэхээр энэ одоогийн байдлаар бол 2-оос 48%-аар хоригдлын тоо зай талбайн стандарт гэж бий Нэгдсэн Үндэсний Байгууллагын хоригдолтой харьцах наад захын жишиг дүрэм байна.

Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн сайдын баталсан стандартууд байна. Энэхүү стандартын дагуу үзэхээр 2-оос 48-аар хэтэрчихсэн, дагаж гардаг асуудал юу вэ гэхээр эм, эмнэлгийн тусламж үйлчилгээ авах эрх гэдэг энэ асуудал бол байнга хөндөгддөг 1 дүгээрт эмчийн хүрэлцээ бол хангалтгүй байна. Орон тоо

байгаа гэсэн авч 1 дүгээрт орон тоог нэмэгдүүлэх бол зайлшгүй шаардлагатай одоо байгаа орон тоон дээрээ ажиллаж байгаа эм эмнэлгийн хэрэгсэл, эмчийн хүртээмж энд зохион байгуулалт, тоног төхөөрөмж бол хангалтгүй хэвээрээ байгаад байна.

Энэний улмаас бас хүний эрхэд шууд хөндөгдөнө, зөрчигдөнө, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авч чадахгүй болно. Ийм асуудал бол үүсэж байна. Хорих анги, цагдан хорих байр дээр орчин нөхцөл, энэ дэд бүтэц, багтаамжийн асуудлыг авч үзэх ёстой хоолны хүртээмжийн асуудал илчлэг гэдгийг ярих ёстой. Өмнө нь бол 2020 онд Хүний эрхийн Үндэсний комиссоос явуулсан зөвлөмж Сангийн сайдад зөвхөн энэ илчлэг бүхий хоолыг нөхөхийн тулд нэг жилд 9,5 тэрбум төгрөг энэ төсөвт нь тусах ёстой байна гэдэг тооцуулсан.

Нийгмийн ажил сэтгэл зүйн үйлчилгээ бас хангалттай биш байна гэдгийг хэлж байгаа. Ирж байгаа хүмүүс сэтгэл зүйн оношилгоо хийхээр тэрний 2 хүн тутмын нэг нь сэтгэл зүйн үйлчилгээ авах шаардлагатай гэдгээ илэрхийлдэг. Эсвэл сэтгэл зүйч нь энэ дээр бас үйлчилгээ үзүүлэх ёстой байна гэдгийг хэлдэг эргэлт, уулзалт авах өргөдөл, гомдол гаргах эрх хэрэгжиж байгаа боловч зарим стандартыг хангах тухай асуудал бас яригддаг. Нөгөө талаар эмэгтэйчүүдийн хорих анги, хүүхдийн сургалт хүмүүжлийн анги, 110 дугаар сургууль Улаанбаатар хотод ганцхан байршилтай учраас тэнд эргэлт, уулзалтын асуудал хязгаарлагдах, ирэх, очих гэдэг энэ асуудал бас яригддаг.

Хоригдлын хөдөлмөр эрхлэлтийн хувьд гомдол, зөрчил бол илрээгүй 2022 онд нэгдсэн байдлаар судалгаа хийж үзсэн. Гэхдээ тэнд тавьдаг асуудал хаалттай. Хорих ангид хоригдлуудыг хөдөлмөр эрхлүүлэх боломж хомс байдаг. Тийм учраас тодорхой арга хэмжээ авах шаардлагатай гэдэг. Мөн хоригдлын хөдөлмөрийн хөлсөө зөв зохих ёсоор тооцож авч байгаа эсэх дээр нь бол байнга хяналт шалгалт тавьж байх ёстой. Түүнчлэн энэ орон тоо бол байнга дутуу явж байгаа. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага энэнтэй холбоотойгоор албан хаагчид үүсэх ачаалал ихэсдэг. Тэгээд энэ дээр албан хаагчид хариуцлага ногдуулж байгаа байдал бол жилдээ 200 орчим байдаг юм байна лээ.

Энэ нь хоригдолтой хүнлэг бус харьцлаа бие махбодод нь халдлаа, сахилгын болон ёс зүйн зөрчил гаргалаа гэдэг үндэслэлээр үүнээс болоод бас албан хаагчид энэ шилжилт хөдөлгөөн их байдаг дутуу орон тоо нөхөгддөггүй дутуу орон тоо нөхдөггүйн улмаас 2-оос 4 ээлж ажиллах ёстой газар ажиллаж чадахгүй тэр хэрээрээ бас энэ ачаалал үүсдэг. Ийм асуудал байна. 2-т нь баривчлах байрны орчин нөхцөл дээр 2017 онд шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг дагаад энэ дээр хуульд заасны дагуу цагдаагийн байгууллага руу шилжүүлэх ёстой. Энэ ажлыг 2025 оны нэг сар хүртэл үе шаттайгаар шилжүүлнэ гэдэг журам гарсан гэхдээ одоогийн байдлаар энийг шилжүүлэхийн тулд 14 байр хэрэгтэй. Шинээр хийгдэх ийм тооцоо байгаа бөгөөд 5 аймаг л шилжүүлсэн бусад нь шилжүүлээгүй хэвээр байгаа гэдэг ийм мэдээлэл байгаа юм. Тэгээд энэний цаад учир шалтгаан нь ахиад нөгөө хүний эрх зөрчигдөхөд хүрнэ, стандартын асуудал яригдана.

Цагдаагийн байгууллагын хүний нөөцийн хүртээмжийн асуудал яригдана. Энэ бүх асуудлууд хөндөгдөнө тийм учраас энийг тэр шийдвэрлэх хууль нь гарсан журам нь гарсан тэгээд төсөв хүний нөөц шилжүүлэх асуудлыг нь шийдвэрлэж байж бид нар баривчлах байран дахь хүний эрхийг зөрчлийг багасгах тэр стандартыг хангах тухай асуудлыг бас ярих нэг үндэслэл болж байгаа юм. Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн нөхцөл байдал энэ дээр бид нар 4 удаа Хүний эрхийн Үндэсний комиссоос хяналт шалгалт хийж байсан юм байна хамгийн сүүлд 2021 онд хийсэн. Энд байгаа асуудал юу вэ гэхээр 2023 оны байдлаар 39 хүн, 2024 оны байдлаар 39 хүн яг энэ албадан эмчлүүлж байгаа. Тэгээд эндээс 13 нь болбол засрал сайжрал

болоогүй учраас цаашаа 5-аас 20 жилийн үргэлжлүүлж эмчилнэ гэж байгаа. Гэхдээ энд байгаа асуудал юу вэ гэхээр 2021 онд очиж хяналт шалгалт хийсэн тэнд шаардлага өгсөн. Гэсэн хэдий ч гэсэн түүн дээр дахин холбогдох үүрэг хүлээгчдээс анхаарах ёстой асуудал байсаар байгаа асуудал нь байрны хүртээмжийн асуудал байгаа юм.

Түүн дээр ерөөсөө тэр стандартыг нь бол хангаж чадахгүй. Тэгээд эмнэлгийн үйлчилгээ гэдэг асуудал ярьж байгаа юм. Энэ хугацааны асуудал тэгээд энэ бол ерөөсөө тодорхой нөхцөлийг нь хангаж өгөөгүй цагт бол шийдэгдэхгүй, асуудлууд үргэлжилсээр байна цэргийн анги байгуулагдах дүрмийн бус харьцаа энэ 6 удаагийн уучлаарай. 5 удаагийн Хүний эрхийн Үндэсний комиссын илтгэлд цэргийн дүрмийн бус харьцааны асуудлыг авч үзсэн.

Хамгийн сүүлд 21 дэх илтгэлд авч үзэхээр тухайн үед цэргийн хугацаат цэргийн алба хааж байгаа алба хаагчид болон өмнөх жил хугацаат цэргийн алба хаагаад дууссан. Энэ хүмүүсээс авсан зүгээр одоо асуудал нь бол 5 цэргийн албан хаагчийн тутмын нэг нь ямар нэг байдлаар дүрмийн бус харьцаанд өртсөн гэж өөрийгөө 2021 онд хэлээд байгаа юм. Тийм учраас энэ дээр тоо харах юм бол бас ялгаагүй.

Энд цэргийн албан хаагчийн амь нас хохирсон эрүүл мэнд хохирсон одоо байдал буурахгүй байгаа юм. 2021-2024 онд гэхэд Зэвсэгт хүчний жанжин штаб дээр бол 5 хугацаат цэргийн албан хаагч амь нас үрэгдсэн нийлээд 19 офицер болон хугацаат цэргийн албан хаагч эрүүл мэндээр хохирсон үзүүлэлт гарсан зөрчил гарсан. Хил хамгаалах байгууллага дээр энэ хугацаанд 14 цэрэг эрүүл мэндээрээ хохирсон.

Одоо энэ цэргийн дүрмийн бус харьцаан дээр Хүний эрхийн Үндэсний Комиссоос гаргасан тогтоол дээр 3 заалтыг оруулсан. Энэ тогтоолын нэг дэх заалт нь цэргийн байгууллагууд дотоод хяналт шалгалтыг эрчимжүүлэх дотоод судалгаагаа хийгээд түүний хариу арга хэмжээг авах, урьдчилан сэргийлэх, дасан зохицох идэвхтэй арга хэмжээ аваач гэдэг ийм зөвлөмжийг өгсөн. Энэний хэрэгжилтийг 2024 оны 3 сард бид хэлэлцэж байгаад 30%-тай байна хангалтгүй байна гэдэг ийм дүгнэлт гарч байгаа. Цэргийн дүрмийн бус харьцааны эрх зүйн байдлыг сайжруулаач гэсэн. Тэрийг бол цэргийн дүрэмдээ тусгасан байна 100% хэрэгжсэн гэж хэлж байгаа урьдчилан сэргийлэх чиглэл дээр үе шаттай арга хэмжээ байнга тогтмол зохион байгуулаач гэдэг.

Энэ 3 дахь заалтын хувьд бол 70%-тай буюу төлөвлөгөө гаргаад үргэлжлүүлээд явж байна гэдэг дүгнэлтийг хийжээ. Дараагийн нэг онцлох ёстой энэ эрүү шүүлт, хүнлэг бус харьцаа дээр гардаг асуудал бол уулзалт энэ мэдүүлэг авах өрөө байна прокурорын байгууллагын журам хэрэгжиж байна. Одоо мэдүүлэг авах өрөө камертай байна, хяналт тавих боломжтой байна гээд тэгээд эндээс нийтдээ 565 улсын хэмжээний мэдүүлэг авах өрөө байна. Одоогийн байдлаар авсан мэдээллээр 482 нь яг зохих стандартын дагуу камертай тоноглогдсон байна гэж гарч ирж байгаа.

Энэ дээр мэдүүлэг авах өрөөг яагаад онцлоод байгаа вэ гэхээр Хүний эрхийн Үндэсний Комисст сүүлийн 2 жилийн хугацаанд нэг жил хагасын хугацаанд ирсэн тэр 108 гомдол дунд хамгийн их дурдагддаг. Хаана энэ зөрчил гарав гэхээр энийг хэлдэг. Хаана тэднийг нь нотлох зорилгоор камерын бичлэг үзэх хамт байлцсан гэрчтэй буюу албан хаагчдыг лавлахаар камер байхгүй камер нь ажиллагаагүй байсан зарим тохиолдолд тог тасарсан бичлэг хадгалдаггүй гэх мэт шалтгааныг хэлж байсан тохиолдол түгээмэл. Ийм учраас энэ камержуулалтыг прокурорын

байгууллагын дээр гаргасан стандартын дагуу мэдүүлэг авах өрөөг тохижуулах ажил бол үнэхээр чухал байна.

Энэ 2024 онд Хүний эрхийн Үндэсний Комиссоос бүх хийж байгаа хяналт шалгалт цагдаагийн байгууллагад мөрдөх байгууллагын энэ стандартыг үзэж байгаа. Сүүлийн 5 аймагт Хүний эрхийн Үндэсний Комисс ажиллаж байгаа. Ийм бүсчилсэн байдлаар явж байхад аймгуудад орон нутгийн зарим нь бол төсвийн дэмжлэгтэйгээр энэ стандартын дагуу камержуулах ажлыг ихэнх нь хийж байна. Булган аймгийн хувьд бол нэг цагдаагийн байгууллагын байр нь өөрөө хүрэлцээгүйн улмаас мөрдөгчийн өрөөнд зарим тохиолдолд бас авах боломжтой одоохондоо болбол цөөхөн гэмт хэрэг нь үедээ бол тэрийг энэ уулзалт мэдүүлэг авах өрөөгөө ашигладаг гэдгийг хэлж байгаа.

Тэгэхээр бид нар цааш цаашдаа тэр орон байрны хүрэлцээг хангах, ажлын байран дээрээ биш тусдаа мэдүүлэг авах өрөөг үнэхээр прокурорын байгууллагын тавьсан стандартын дагуу байлгах камерын бичлэгийг нь хадгалах, хянах боломжтой байх, камерын бичлэгийн гадуур хийхгүй байх уулзах, мэдүүлэг тайлбар авахгүй байх энэ ажиллагаа явуулахгүй байх энэ бол үнэхээр чухал байна. Энэ эрүү шүүлтээс ангид байх, мөрдөн шалгах, хэрцгий, хүнлэг бус харьцаанаас ангид байх, энэ зөрчлийг багасгах, гэмт хэргийг багасгах, энийг арилгахад бол үнэхээр чухал байна гэж үзэж байгаа гүйцэтгэх ажил нууц мөрдөн шалгах ажиллагаатай холбоотой асуудлууд байна. Манай Хүний эрхийн Үндэсний Комисст ирсэн гомдлууд байна.

147 гишүүнтэй хэлмэгдэгчдийн холбоо нийтэд үйлчилдэг Төрийн бус байгууллага гээд нэрлэсэн гишүүд ирж байгаа. Ингээд иргэдээс ирсэн гомдол дунд нэг ийм асуудлууд явдаг нууц учраас өөрөө танилцаагүй. Тийм болохоор давж заалдах гомдол гаргах буюу өөрийгөө цагаатгах эсвэл гэм буруугийн нэхэмжлэл гаргах ийм эрх үүсэхгүй байна гэдэг энэ асуудлыг тавьдаг. Тийм болохоор төрийн болон албаны нууц мэдээ дагуулсан гэсэн шалтгаанаар ер нь энэ нэг эрх зүйн хувьд нь илүү тодорхой болгоод хэсэгчлэн зарим тохиолдолд хэрвээ нууцад хамаарахаас бусдыг нь нууц болон нууц биш нь хэрэг нь ингээд хамт явж байвал нууц бишэд хамаарахыг нь хэсэгчлэн нээлттэй хийх зохион байгуулах тэр боломжийг тавих эсвэл нийтэд нь шүүхийн шатанд ирэхэд бүх нотлох баримт эсвэл нээлттэй байх ёстой юу? Ямар ч байсан энэ нэг нөхцөл байдлыг мөрдөн шалгах ажиллагаа хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шийдвэрлэж энд хүний эрхийн зөрчил гарахгүй байх энэ нөхцлийг бүрдүүлэх ёстой байна гэж үзэж байгаа.

Сонсгол даргалагч П.Сайнзориг-Нөхөн төлбөрийн асуудал дээр хохирогч бол хэрвээ хохирсон бол олон улсын гэрээ конвенцод ч хэлнэ. Сүнжид дарга дүгнэлтээ хэлэх 2 минут тавиад өгөх нэгмөсөн. Яг хамгийн гол тодорхой дүгнэлт.

Хүний эрхийн Үндэсний комиссын дарга Д.Сүнжид-Ингээд тодорхой 11 саналыг өгсөн юм. Юун түрүүн 1 дүгээр багц дүгнэлт нь бол хууль тогтоомжийг сайжруулах хэрэгтэй байна олон улсын эрүүдэн шүүхийн эсрэг конвенц түүний эсрэг нэмэлт протоколд нийцүүлэх. Яагаад гэвэл манай Эрүүгийн хуульд заачихсан энэ ойлголт нь өөрөө сая түрүүн хэлсэн 2 хамгийн анх эхлэхдээ дурдсан 2 заалтыг нэг заалтад оруулаад томьёолчихсон байдаг. Тэгэхээр энэ нь хэрэглэхэд хүндрэлтэй болдог зөрчлийг ялгахад хүндрэлтэй болдог тийм болохоор энэ нөгөө хууль тогтоомжийг нийтдээ 10 орчим хууль тогтоомжийн тухай ярьж байгаа эрх зүйн орчныг нь боловсронгуй болгох гэдэг 1 дүгээр санал, дүгнэлтийг хэлж байгаа юм.

2 дугаарт эрүү шүүлт тулах гэмт хэрэг энэ зөрчлийн шалтгааныг мөрдөн байцаах мөрдөн шалгах ажиллагааны явуулж байгаа байгууллагуудын чадавхтай холбоно. Энэ дээр бол энэ хүн байгууллагуудын үйл ажиллагаа явуулах чадвар

төрийн албан хаагчийн мэдлэг ойлголт, хандлага, зөрчлөөс ангид байх дадал хэрвээ зөрчил гаргах юм болбол түүнийг нь хариуцлага тооцдог энэ механизм хэрэгтэй байна. Тиймээс энэ дээр арга хэмжээ авах ёстой гэдгийг нь хэлж байгаа. Дараа нь хорих ангиудын нөхцөл байдал сая дурдсан сэтгэцийн эрүүл мэнд, хорих анги, цагдан хорих байр, баривчлах байр гээд энд холбоотойгоор нөхцөл байдлыг нь сайжруулах хэрэгтэй байна.

Бид нар нөхцөл байдал дэд бүтэц орчныг сайжруулалгүйгээр хангамж төсвийг сайжруулахгүйгээр тэр хүмүүст бас эрүү шүүлтийг тулгахгүй байх хүнлэг бус харьцахгүй байх тэр нөхцөлийг бүрдүүлэх боломж үнэндээ байхгүй байна. Стандартыг түрүүн та бүхэн харсан. Одоо байгаа стандарт нь аль хэдийн 2-оос 8 дахин их хэвээрээ байгаа. Энийг юу гэдэг юм тухайн байгууллага өөрөө юм уу албан хаагч шийдэх боломжгүй ийм асуудал байдаг. Тэгэхээр институт бүтцийн хувьд энийг нь шийдэх ёстой асуудлууд байна гэдгийг хэлж байна. Хамгийн сүүлд нь эрүү шүүлтийн хохирогчдыг үр нөлөөтэй хамгаалах хэрэгтэй байна.

Монгол Улс Үндсэн хуульд заасны дагуу хохирогчийг хамгаалах ёстой тэгээд хохирогч нь хэрвээ хохирсон гэдэг нь тогтоогдсон юм бол хэрэг нь цагаадсан юм бол түүн дээр хохирлыг нь нөхөн төлүүлэх эрхийг нь сэргээн эдлүүлэх механизм үйлчилж байх ёстой энэ бол Монгол Улсад хангалтгүй байна гэж 1 дүгээрт хууль тогтоомжид ажлын хэсэг байгуулах одоо энэ сүүлийн 10 жил ярьж байгаа хүмүүс байна.

Би эрүү шүүлтэд өртөөд хохирчихлоо гээд тэгээд энэ хэрэгсэхгүй болчихсон тогтоолтой, шүүхийн шүүхээр гарчихсан, шийдвэртэй тогтоолтой тэгвэл энэ хүмүүсийн тэр эрх нь үнэхээр зөрчигдсөн юм болбол тэрийг нь шүүх өөрөө тогтоочихсон юм бол тэр чинь хууль хяналтын байгууллага тогтоочихсон юм бол энэ хүмүүсийн эрхийг сэргээх ажлын хэсэг байгуулдаг юм уу эсвэл хууль тогтоомжид нь өөрчилж болдог юм уу хэрвээ бүр болохгүй бол нэг удаагийн шинжтэй ч гэсэн хохирлыг нөхөн төлөх хууль гарах гаргалгаа байх уу гэдэг ийм саналыг оруулж байгаа, цэргийн албан хаагчдын дунд дүрмийн бус харьцаанаас үүдэлтэй гэмт хэрэг, зөрчлийг, хариуцлагын тогтолцоог нь цэргийн байгууллагуудын дотоод хяналтын үйл ажиллагаа урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа, таслан зохих үйл ажиллагаа, хариуцлага тооцох механизмыг цаашид сайжруулах ёстой. Нэн тэргүүн дотоод хяналт нь сайн ажиллах ёстой гэдэг дүгнэлтийг хэлж байна.

Ийм дүгнэлтүүдийг хийе ингээд тодорхой асуултууд байгаа байх оролцогчид болон Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүд, гомдол хянан шалгалтын хэлтсийн даргын зүгээс тодорхой асуултуудад хэлэлцүүлгийн цаг санал асуулгын цагаар асуултад хариулахад бэлэн. Анхаарал тавьсанд баярлалаа.

Сонсгол даргалагч П.Сайнзориг - Баярлалаа. Дараагийн илтгэл, мэдээллийг Эрүү шүүлт болгох, хүнлэг бус, хэрцгий хандахаас ангид байх хүний эрхийн хэрэгжилтийн талаарх Засгийн газрын байр суурь шүү. Тийм учраас уг нь Алтангэрэл сайдыг Засгийн газрын хуралдааныхаа асуудлыг зохицуулаад орж ир гэсэн. Мэдээллийг ямар ч байсан Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар өгч байя. Өөрөө ямар ч байсан энэ хуралдаанд орж ирэх ёстой. Өөрөөр хэлэх юм бол ийм оролцогч орноо гэдгээ байгууллагуудад бичгээр өгч байгаа Засгийн газар болон Хууль зүй, дотоод хэргийн яамнаас би оролцож чадахгүй гэдэг байдлаар янз бүрийн байдлаар байр суурь бичгээ өгөөгүй байгаа шүү гэдэг зүйлийг би энэ хуралдааны явцад цохон тэмдэглэе.

Тэгээд Хууль зүй, дотоод хэргийн сайд бас энэ сонсголд орж ирэхийг хүсэж байна. Дэгийн тухай холбогдох хуулийн дагуу заавал орж ирж энэ мэдээлэл болон гишүүдийн асуултад хариулж мэдээллээ бас өгөх ёстой байгаа юм. Ингээд Н.Мягмар

дарга яг цагаа бариад 10 минутаар танилцуулья

Хууль зүй, Дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар-Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе! Хууль зүй, дотоод хэргийн сайд Засгийн газрын өнөөдөр хуралдаанд бас хэд хэдэн асуудал хэлэлцүүлж байгаа учраас хуралдаанаар хэлэлцүүлж асуудлаа дууссаны дараа орж ирнэ гэдэг зүйлийг хэлсэн болохыг энэ дашрамд уламжилж хэлье. Өнөөдрийн эрүү шүүлтээс болон ялгаварлан гадуурхалтаар ангид байх хүний эрхийн хэрэгжилтийн талаар болон одоо гэмт хэргийн улмаас нөхөн олговор олгох сантай холбоотой асуудлаар бэлтгэсэн мэдээллийг та бүхэнд танилцуулья.

Миний бэлтгэл илтгэл, мэдээллийн маань үндсэн агуулга Монгол Улс олон улсын хүний эрхийн тогтолцооны өмнө хүлээсэн үүрэг ямар юм бэ? Одоо энэ хүрээндээ хууль тогтоомжийн шинэтгэлийг ямар байдлаар өнөөдрийн түвшинд хийгээд байна вэ? Дараагийн дугаарт нь эрүү шүүлт тулгах болон хүнлэг бус хэрцгий байх хүний эрхийг хэрэгжилтийг хангах хүрээнд бас Хууль зүй, дотоод хэргийн салбарт ямар арга хэмжээ авсан эцэст нь одоо гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр болох сангийн талаар мэдээллийг танилцуулах юм.

Олон улсын өмнө Монгол Улсын хүлээсэн үүрэг бол 1 дүгээрт хүний эрхийн түгээмэл тунхаглал иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын факт Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц, Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль, Эрүүгийн хууль, Эрүүгийн хянан шийдвэрлэх тухай хуулиуд бол үндсэндээ эрүүдэн шүүхийн эсрэг хүний эрхийг олон улсын болон бус дотоодын хууль тогтоомжийн үндсэн одоо эх сурвалжид нь эдгээрийг дурдаж болох юм.

Хүний эрхийн болон иргэний болон улс төрийн эрхийн фактуудад дурдагдсан ийм эрүүдэн шүүхээс ангид байх талаарх хүний эрхийн тунхаглалуудын заалтууд энд харагдаж байна. Та бүхэнд би уншиж танилцуулахаас илүү энийг бол бараг Монгол Улсын иргэд маань бол мэдэж байгаа учраас энэ хэсгийг бас цагаа товчлоод үлдээе. Ялангуяа Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын хүрээнд гишүүн улс орнууд бол 4 жилийн хугацаанд конвенцын хэрэгжилтийн талаар илтгэлээ хүргүүлдэг.

Энэ үүргийнхээ дагуу Монгол Улс 2020 онд Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын Монгол Улсын хэрэгжилтийн тайлан 3 дахь тайланг хүргүүлсэн. Энэхүү 3 дахь тайлангийн хамгаалалтыг сая энэ оны 11 сарын 12-ноос 13-ны өдрүүдэд Нэгдсэн Үндэсний Байгууллагын Женевт хамгаалсан. 2-т нь энэ Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын нэмэлт протоколд Монгол Улс нэгдэн орсон энэ хүрээндээ Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулж эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний механизмыг бий болгосон.

Өнөөдөр Хүний эрхийн Үндэсний комисст эрүү шүүлтийн асуудал хариуцсан тусгай гишүүнтэй болсон. Энэ гишүүн маань эрүү шүүлтийн эсрэг болон өөрийн эрхээр гарч болох боломжгүй бүхий л газарт хүний эрхийн зөрчлийг ялангуяа эрүүдэн шүүхийн эсрэг арга хэмжээг урьдчилан сэргийлэх зорилгоор хянан шалгаж, гомдол мэдээллийг хүлээн авах. Дээрээс нь бүрэн эрхийг хэрэгжүүлэх үндэсний ийм тогтолцоо бүрдэж, Монгол Улсад хэрэгжээд 2 дахь жилдээ явж байна.

Хүний эрхийн Үндэсний Комиссын хуульд орсон гол зүйлүүд энэ олон улсын гэрээ конвенцоор хүлээсэн үүргийн хүрээнд Монгол Улсын эрүүдэн шүүх буюу дур зоргоор саатуулахтай холбоотой энэ ажиллагааг үндэсний хууль тогтоомжоороо илүү боловсронгуй болгох хүрээндээ сэжигтэн болон сэжигтнийг хойшлуулшгүйгээр

баривчлах хууль зүйн зохицуулалтуудын Монгол Улсын Их Хуралаас 2024 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд орсон өөрчлөлтүүдийг та бүхэн энд харж байна. Ялангуяа хойшлуулшгүйгээр явагдсан одоо баривчлах ажиллагаанд шүүхийн хяналтыг сайжруулах зорилгоор шүүх хойшлуулшгүйгээр баривчлагдсан яллагдагчид таслан сэргийлэх арга хэмжээ авах тухай прокурорын саналыг хүлээн авснаас хойш даруй эс үгүй бол 24 цагийн дотор шүүхийн хэлэлцүүлгийг товлон явуулж хойшлуулшгүй явагдсан баривчлах ажиллагааг хүчинтэйд тооцох.

Цаашид Прокурорын саналын дагуу яллагдагчид таслан сэргийлэх арга хэмжээ авах эсэхийг хянан шийдвэрлэх ийм эрх зүйн орчинтой болсон. Мөн энэ хүрээнд бас сэжигтнийг хойшлуулшгүйгээр баривчлах болон хязгаарлалт тогтоох, цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээ авах эсэх асуудлыг шийдвэрлэх. Шүүхийн хяналтыг ажлын цагаар хязгаарлахгүйгээр хуанлийн өдөр бүр шөнийн цагаас бусад цагт тасралтгүй хэрэгжүүлэх жижүүрийн шүүхтэй болох энэ зохицуулалтыг бий болгосон.

Мөн 2024 оны 6 дугаар сарын 5-ны өдөр батлагдсан Шүүх байгуулах тухай хуулиар баривчлах ажиллагаа цагдан хорих болон бусад төрлийн таслан сэргийлэх арга хэмжээнд зөвшөөрөл олгох хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх шүүхийг тусад нь байгуулж ингэхдээ одоо нийслэлд, дүүргийн эрүү иргэний хэргийн хялбар ажиллагааны анхан шатны тойргийн нэг шүүх байгуулахаар хуульчилсан.

Хойшлуулшгүйгээр баривчлах ажиллагааны талаар суллагдсан хүн шүүхэд гомдол гаргах эрхийг нээж, сэжигтнийг баривчлах хугацаа 48 цагаас хэтэрч болохгүй гэдэг. Энэ зохицуулалтыг нь хуульчилж дээрээс нь энэ эрх, үүргийг нь тайлбарлаж байх зохицуулалтуудыг бол улам сайжруулж өгсөн. Монгол Улсын Их Хуралаас 2015 онд шинэчлэн баталсан Эрүүгийн хуульд эрүү шүүлт тулгах үйлдлийг гэмт хэрэгт тооцохоор хуульчлан хэрэгжүүлж байгаа. Цаашид энэ эрүү шүүлт тулгах гэмт хэргийн шинжийг илүү тодорхой болгож Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцод нийцүүлэх зорилгоор Эрүүгийн хуульд бол нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр Хууль зүй, дотоод хэргийн яам бэлтгэж байгаа түүнчлэн хорихоос өөр төрлийн ял шийтгүүлж болох гэмт хэрэг үйлдсэн хүнд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг хэрэглэхийг хязгаарлах зорилгоор 2024 оны 1 дүгээр сарын 17-ны өдөр баталсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулиар Эрүүгийн хуулийн тусгай ангид хорих ял оногдуулахаар заасан.

Гэмт хэргийн яллагдагчид өөр төрлийн таслан сэргийлэх арга хэмжээ авах боломжгүй гэж үзвэл цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авахаар тусгаад түүний үндэслэлийг нь нарийвчилж өгсөн. Та бүхэн харж байна. Хорих ялын дээд хэмжээ 5 жил хүртэл байх юм бол 6 сар хорих ялын дээд хэмжээ, 5 жилээс дээш байх юм бол 12 сар хорих ялын дээд хэмжээ, 8 жил түүнээс дээш байх юм 18 сар одоо хүртэл цагдан хорих хугацаа зааж өгсөн.

Үндсэн хугацааг нь нэг сар хүртэл байна гэдэг ийм зохицуулалтыг хийж өгсөн. Хорихоос өөр төрлийн ялын төрлийг нэмэгдүүлэх зорилгоор Эрүүгийн хуульд зорчих эрхийг хязгаарлах ялын төрлийг хуульчилж өгсөн. 2021 оноос хэрэгжүүлж эхэлсэн хууль хэрэгжиж эхэлснээс хойш өнөөдрийг хүртэл 6443 ялтанд энэ төрлийн ялыг оногдуулан хяналт тавьж ингэж ажиллаж байна ингээд хууль тогтоомжийн хүрээнд олон улсын гэрээ конвенцоор хүлээсэн үүргээ дотоодын хууль тогтоомждоо илүү сайжруулах зорилгоор авч хэрэгжүүлсэн Засгийн газрын боловсруулж Улсын Их Хуралаар батлуулсан хууль тогтоомжийн талаарх мэдээллийг танилцууллаа.

Одоо харин энэ эрүү шүүлтээс ангид байх чиглэлээр Хууль зүй, дотоод

хэргийн салбарт авч хэрэгжүүлж байгаа зарим арга хэмжээний талаар явья. Сая Хүний эрхийн Үндэсний Комиссын илтгэлд дурдагдсан. Ялангуяа энэ мэдүүлэг авах өрөөний нөхцөл байдлыг сайжруулах ёстой. Тэгэхгүй бол энэ эрүү шүүлт буюу хүнлэг бус харьцаа, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг гомдол мэдээлэл тасрахгүй байна гэдэг агуулгын хүрээнд Хүний эрхийн Үндэсний Комиссоос өгсөн зөвлөмжийг бас хэрэгжүүлэх хүрээндээ манай цагдаагийн байгууллагын мэдүүлэг авах өрөөг 2024 оны Цагдаагийн ерөнхий газрын даргын 367 дугаар тушаалаар уулзалт мэдүүлгийн хэсгийн үйл ажиллагаа код 324 гэдэг ийм журмыг шинэчлэн баталсан.

Мэдүүлэг авах өрөөний талбай, агааржуулалт, гэрэлтүүлэг, хана, тааз, өрөөнд тавигдах эд зүйл, техник хэрэгсэл, хяналтын камерын тоо хэмжээ, хүчин чадал, бичлэг, хадгалах хугацаа зэрэг 22 заалт бүхий ийм журмыг бол шинэчилж, баталж хэрэгжүүлж эхэлж байна. 2024 онд жишээ нь нийслэл, дүүргүүдийн хэмжээнд албан өрөөндөө мэдүүлэг авдаг байсан явдлыг зогсоогоод 122 мөрдөгчийн энэ заалны системээр нь суулгаад дээрх суларсан өрөөнүүдэд нь мэдүүлэг авах зориулалтаар ингэж ашиглаж байна.

Ялангуяа мэдүүлэг авах өрөөнд бол 2-оос 3 ширхэг хяналтын камер байршуулах бичлэг хадгалах хугацааг 6 сараас нэг жилийн хугацаатай байлгах тал дээр анхаарч тоног төхөөрөмжүүдийн хүчин чадлыг үе шаттай нэмэгдүүлж байна ер нь эндээс ялангуяа камерын хяналтын энэ тоног төхөөрөмжийг шинэчлэх мэдүүлэг авах өрөө болон хорих анги байгууллагууд энэ тоног төхөөрөмжийг шинэчлэх талаар авсан арга хэмжээнүүдээ талаар энэ дээр гарч байна. Тэгээд цаг хугацаа бага юм байгаа учраас дараагийнхаа хэсэг рүү орё.

Энэ сургалт хүний эрхийн мэдрэмжтэй хандлага, харилцаа болон эрүүдэн шүүхийн эсрэг арга ажиллагаанд хууль сахиулах байгууллагуудын албан хаагчдыг Хүний эрхийн Үндэсний комисс болон бусад байгууллагуудтайгаа энэ сургалтыг зохион байгуулж тогтмол хийгдэж байна. Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангийн тухайд энэ 2012 оноос ингэж олгож эхэлсэн. 2020 оны Засгийн газрын тусгай сангийн хуульд өөрчлөлт орсноор гэмт хэргийн хохирогчид олгох гэмт хэргийн тоог нэмэгдүүлж гэмт хэрэг ямар гэмт хэргүүдэд олгохоор заасан байгааг харж байна. Та бүхэн энэний 11 дээр бол эрүү шүүлт тулгах гэмт хэргийн улмаас учирсан хохирогчид энэ сангаас бол олгох бололцоотой.

2010 он 2012 оноос хойш бол нийт энэ санд 31,4 тэрбум төгрөг төвлөрсөн энэ сангаас нийтдээ 516 хохирогчид 3,2 тэрбум төгрөгийг олгоод байна. Санд буцаан төлүүлэх арга хэмжээний хүрээнд 1,2 тэрбум төгрөгийг энэ санд буцаан төвлөрүүлээд байна. Энэ сангаас дийлэнхдээ Эрүүгийн хуулийн 10.1-д заасан хүн алах гэмт хэргийн хохирогчийн нийтдээ энэ сангаас олгосон мөнгөний 88% нь олгогдож байна харин эрүү шүүлт тулгах энэ зүйл ангиар шүүхээр шийдвэрлэгдсэн.

Сонсгол даргалагч П.Сайнзориг- Уг нь бол хөтөлбөрийн дагуу өгчихсөн юм. Товч тодорхой энэ 10 минутдаа мессежүүдээ өгмөөр байх юм дахин нэг минут тэгээд дараагийн сонголт бол байхгүй яг хүмүүс сонсох ёстой хамгийн сүүлийн гол пойнт нь энэ эрүү шүүлт тулгах гэмт хэргээс болбол хохирогчид олгох нөхөн төлбөр энэ сангаас олгогдоогүй байж байгаа энэ сангийн хуулиараа одоо шүүхийн шийдвэрт заасан тохиолдолд олгох ёстой.

Хууль зүй, дотоод хэргийн яамны төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар-Тийм учраас энэ шүүхийн шийдвэр яг энэ сангаас олгохтой холбоотой шүүхийн шийдвэрт тусгайлан заасан хохирлын хэмжээ байгаагүй учраас олгогдоогүй байж байгаа эрх зүйн хувьд болоод тогтолцооныхоо хувьд энэ сан бол

олгох бүрэн боломжтой. Монгол Улсын эрх зүйн тогтолцоо бол үйлчилж байна. Анхаарал тавьсанд баярлалаа.

Сонсгол даргалагч П.Сайнзориг-Хууль зүй, дотоод хэргийн яамны, Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмарт баярлалаа. Дараагийн мэдээлэл байгаа энэ мэдээллийг Улсын ерөнхий прокурорын газрын орлогч прокурор М.Чинбат танилцуулна. Эрүү шүүлт болох гэмт хэргийн одоо шийдвэрлэлттэй холбоотой мэдээллийг өгнө. Манай хүмүүс яг цагаа барихыг хүсэж байна. Бас оролцогчид маань байр суурь одоо хэлнэ. Хэрэг гарсан тохиолдолд ямар арга хэмжээ авч урьдчилан сэргийлж байгаа, энэ гарсан хүмүүсүүдийг хэрхэн яаж хохирлыг нь барагдуулж байгаа зөрчигдсөн эрхийг нь нөхөн сэргээж байгаа бэ гэдэг асуудлыг одоо мэдээллийг сонсож байгаа. Тэгэхээр бэлэн болсон бол цагийг өгье. Тэгээд яг цагаа барихыг хүсэж байна. Оролцогчид нэлээн олон байгаа учир цагийн дагуу аль болохоор шахаад явья гэж бодож байна.

Улсын ерөнхий прокурорын орлогч прокурор М.Чинбат -Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе! Эрүү шүүлт тулгах, гэмт хэргийн шийдвэрлэлт, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил хүний эрх хангах чиглэлээр хийсэн ажлын талаарх мэдээллийг танилцуулъя. Прокурорын байгууллага 2019 онд эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх асуудалд онцгой анхаарал хандуулж Улсын ерөнхий прокурорын 2019 оны 42 дугаар тушаалаар Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх зөвлөлийг Улсын ерөнхий прокурорын газрын бүтцэд анхлан шинээр байгуулж өнөөг хүртэл ажиллуулаад байна.

Энэхүү зөвлөл нь зөрчил шалган шийдвэрлэх, эрүүгийн хэрэг бүртгэх, мөрдөн байцаах болон ял эдлүүлэх ажиллагааны явцад хууль дээдлэх, хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээх, эрүү шүүлт тулгах, гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгах эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх ажлыг Прокурорын байгууллагын хэмжээнд нэгтгэн зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлж ирсэн.

Аймаг, нийслэл, тээвэр, дүүргийн Прокурорын газрын ерөнхий прокурор нь эрүүгийн эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх ажлыг биечлэн хариуцаж иргэд төрийн болон Төрийн бус байгууллага энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хүний эрхийг хамгаалах байгууллагуудтай хамтран ажиллаж байна. Хүний эрхийг хангах эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх хүрээнд дараах ажил арга хэмжээг авч хэрэгжүүлсэн болно. Улсын ерөнхий прокурорын газрын 2019 оны 6 дугаар сард мөрдөн шалгах ял эдлүүлэх ажиллагааны явцад хүний эрхийг зөрчих, хүнлэг бус, хэрцгий хандах, нэр төрийг доромжлох, аливаа үйлдлийг гаргахгүй байх дээд шатын прокурорын хяналтыг сайжруулах зорилгоор эрүү шүүлт тулгахаас урьдчилан сэргийлэх тухай зургаа дугаартай албан даалгавар гаргаж биелэлтийг нь жил бүр тооцож ажилласан.

Энэ хүрээнд прокурорын газрууд дангаараа болон хүний эрхийг хамгаалах, мөрдөх эрх бүхий мөрдөх байгууллагуудтай хамтран эрүүдэн шүүхийн эсрэг гэрээ конвенц, хууль тогтоомжуудаар сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулах гарын авлага, зөвлөмж, зурагт хуудас гаргаж тараах, видео, контент бэлтгэн олон нийтийн сүлжээгээр түгээх, эрүү шүүлт тулгах, гэмт хэргийн гарал шийдвэрлэлтийн байдал шалтгаан нөхцөлийг нь судалж дүгнэх хууль тогтоомжийн хэрэгжилтийг судлан шалгах ажлуудыг тогтмол хийж ирсэн болно.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэг мөр хэрэгжүүлэх хүрээнд 2020 онд хүнийг гэмт хэрэгт сэжиглэх үндэслэл илэрсэн тохиолдолд гэрчийн мэдүүлэг авахгүй байх гэрчийн мэдүүлэг авсан бол яллах ажиллагаанд мэдүүлгийг

нотлох баримтаар үнэлэхгүй байх зөвлөмжийг гаргаж хэрэгжилтийг нь хангуулан ажиллалаа. Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх зөвлөлөөс 2023 онд эрүү шүүлт тулгах гэмт хэргийн гаралт, шийдвэрлэлтийн байдал, шалтгаан нөхцөлийн талаар хавсарга судалгааг хийсэн. Энэхүү судалгаанд 2020-оос 2022 онд улсын хэмжээнд үйлдэгдсэн гэмт хэргийн нөхцөл байдлыг нь судалж хүний эрхийн зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох, эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх ажил арга хэмжээний талаар зөвлөмж гаргаж харьяа нэгж прокурорын газрууд үйл ажиллагаандаа ашиглаж байна.

2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу эрүү шүүлтээс ангид байх сэдэвт урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээг энэ оны 10-аас 11 дүгээр саруудад улс орон даяар зохион явуулж байна. Энэ арга хэмжээний хүрээнд нэгж прокурорын газрууд Хүний эрхийн Үндэсний комисстой хамтран хяналтын харьяа байгууллагуудад эрүү шүүлтээс ангид байх эрхийн талаар сургалт явуулах, эрүү шүүлт, тулах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нээлттэй өдөрлөгийг иргэд олон нийтийн олон нийт хэвлэл мэдээллийн байгууллагуудыг одоо хамруулан зохион байгуулах, иргэдэд хууль, эрх зүйн мэдээлэл өгөх, видео контент, нэвтрүүлэг бэлтгэн түгээх ажлуудыг зохион явуулж байна.

2020-2022 онд Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхим, Хүний эрхийн Үндэсний Комисстой хамтран Эрүү шүүлт тулгах гэмт хэрэг сэдэвт 4 удаагийн цогц сургалтыг прокуроруудад зохион байгуулсан. 2023 онд Хүний эрхийн Үндэсний Комисстой хамтран цагдаагийн байгууллагын мөрдөгч нарт эрүү шүүлт тулгах гэмт хэрэг сэдэвт 3 удаагийн сургалтыг танхим болон цахим хэлбэрээр эрүү шүүлт тулгах, хүнлэг бус харьцаа, ялгаварлан гадуурхахаас ангид байх сэдвийн хүрээнд хүний эрхийн сургагч багш бэлтгэх сургалтыг тус тус зохион явуулсан байна.

Түүнчлэн 2024 онд Хүний эрхийн Үндэсний Комисстой хамтран Нэгдсэн үндэсний байгууллага хүний эрхийн хороодын ерөнхий тайлбар сэдэвт сургалтыг зохион байгуулж үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө хувийн халдашгүй чөлөөтэй байх эрх сэдвээр мэдээлэл хүргэсэн байна. Прокурорын байгууллагын сургалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу эрүү шүүлт тулгах, хүнлэг бус харьцах, доромжлон харьцаж шийтгэх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх хүний эрхийг хангах нь сэдэвт сургалтыг танхим болон цахим хэлбэрээр зохион явуулсан. Аймаг, нийслэл, тээвэр, дүүрэг, сум дундын прокурорын газрууд Улсын ерөнхий прокурорын 6 дугаартай албан даалгавар болон Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх зөвлөлөөс өгсөн зөвлөмж мэдээллийн дагуу цөөнгүй ажил арга хэмжээг хэрэгжүүлж ажиллалаа.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд 25 дугаар зүйлийн 25.1 дүгээр зүйлийн 17 дахь хэсэгт заасны дагуу Улсын ерөнхий прокурорын 2017 оны тушаалаар мэдүүлэг авах хариунд тавигдах шаардлагыг батлан эрх бүхий байгууллагууд хэрэгжүүлж прокурорт хяналт тавин ажиллаж байна. Мэдүүлэг авах хариунд тавигдах шаардлага нь гэрч, хохирогч, шинжээч, сэжигтэн, яллагдагчаас мэдүүлэг авах, нүүрэлдүүлж мэдүүлэг авах, таньж олуулах зэрэг мөрдөн шалгах ажиллагаа хэвийн явагдах, нөхцөлийг нь бүрдүүлэх, эрүү шүүлт, хүнлэг бус харьцаанаас ангид байх, хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, аюулгүй байдлыг хангах зорилготой байна.

Прокурорын байгууллагаас мэдүүлэг авах өрөөний шаардлагын хэрэгжилтийг сүүлийн 5 жилд 154 удаа шалгасан шалгалтын мөрөөр прокурорын 12 шаардлага 95 албан бичгийг холбогдох эрх бүхий байгууллагуудад хүргүүлж биелэлтийг нь тооцож ажилласан болно Прокурорын хяналт шалгалтын үр дүнг үндэслэн мөрдөн шалгах ажиллагаанд хүний эрх, эрх чөлөөг хангах зорилгоор мэдүүлэг авах өрөөнд

тавигдах шаардлагыг шинэчлэн боловсруулах ажлын хэсгийг байгуулж ажиллаж байна.

Энэхүү ажлын хэсэг маань нэгд ажлын хэсэг маань Нэгдсэн Үндэсний Байгууллагын Эрүүдэн шүүхийн эсрэг дэд хорооноос 2017 онд Монгол Улсад өгсөн зөвлөмж Хүний эрхийн Үндэсний комисс болон мөрдөн шалгах байгууллагуудаас ирүүлсэн саналуудыг тусгаж мэдүүлэг авах өрөөнд тавигдах шаардлагыг шинэчлэн боловсруулаад байна. Мөрдөн шалгах ажиллагааны явцад хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэг мөр хангуулах зорилгоор яллагдагч цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг хуульд заасан үндсэн үндэслэл журмын дагуу авч байгаа эсэхэд прокурор хяналт тавин ажилладаг улсын хэмжээнд 1009 хэрэг 2022-оос 2024 оны 3 дугаар улирлын байдлаар шалгаж судалсан байгаа.

2020 онд таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан 18 яллагдагчийн 9,9 хувьд нь 2021 онд 8 хувьд нь 2022 онд 8,4 хувьд нь 2023 онд яллагдагчийн нийт яллагдагчийн 7,6 хувьд нь 2024 оны 3 дугаар улирлын байдлаар нийт яллагдагчийн 7,1 хувьд нь таслан сэргийлэх цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг хэрэглэсэн байгаа.

Ер нь бол жилд дунджаар 17-гоос 18 мянган яллагдагчийг бид таслан сэргийлэх арга хэмжээ авагддаг. Энэнээс ойролцоогоор 1800-аас анх 2020 онд бол 1800 орчим хүнд таслан сэргийлэх арга хэмжээ авч байсан. 2024 оны 3 дугаар улирлын байдлаар 1100 орчим яллагдагчид хуульд заасан үндэслэл журмын дагуу цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг хэрэглэсэн байна. Энэ шалгалтынхаа дүнд үндэслэж зөвлөмж боловсруулан хуулийг нийгэм хэрэгжүүлэх талаар прокурор, мөрдөгч нарт сургалт зохион байгуулахаар ажиллаж байна. Улсын ерөнхий прокурорын 2023 оны 1 дүгээр улиралд гэмт хэрэгт холбогдсон хүнийг эрүүгийн хэрэг үүсгэж яллагчаар татахын өмнө гэрчээр мэдүүлэг авсан тохиолдлыг судалж үзсэн.

Энэ судалгааны дүнгээ үндэслэн хуулийг нэг мөр хэрэгжүүлж ажиллах талаар Цагдаагийн ерөнхий газрын даргад албан бичиг хүргүүлж харьяа нэгж прокурорын газрууддаа чиглэл хүргүүлж биелэлтийг нь хангуулж ажиллалаа. Судалгааны дүн, илэрсэн зөрчил, анхаарах асуудлын талаар нийт прокуроруудад сургалт зохион байгуулж Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд Улсын дээд шүүхийн тайлбарыг зөв ойлгож хэрэглэх талаар хэлэлцүүлэг зохион явуулсан. Прокурорын байгууллага 2022 онд ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих ажлынхаа хүрээнд цагдан хорих байр хорих ангиудыг техникийн хяналт хамгаалалтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулсан эсэхийг улсын хэмжээнд шалгасан шалгалтаар хорих анги цагдан хорих байранд ашиглагдаж байгаа теле камер бичлэгийн төхөөрөмжийн ашиглалтын хугацаа дууссан өнгө дүрсний шаардлага хангахгүй болсон.

Зарим өрөө, тасалгаа, зорчих бүсийг камерын хяналтад бүрэн хамруулаагүй цөөнгүй зөрчлүүдийг илрүүлсэн дээрх зөрчлүүдийг арилгуулахаар бичсэн прокурорын шаардлагын мөрөөр шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь хорих анги цагдан хорих төв байруудад 10 ширхэг хөдөлгөөн мэдрэгч төхөөрөмж, 353 ширхэг теле камер дагалдах хэрэгслийг шинээр суурилуулж, хоригдол, хоригдогч нарын өрөө, зорчих хэсгийг теле камерын бүрэн хяналтад оруулж хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангасан байна.

Прокурорын байгууллага 2021 онд баривчлах байрны ахуйн нөхцөл хууль тогтоомжийн шаардлагад нийцэж байгаа эсэхийг бас шалгасан шалгалтаар зарим

баривчлах байр нь эрэгтэй, эмэгтэй бол мөн прокурорын байгууллага 2021 онд хорих анги, цагдан хорих, баривчлах байранд хоригдогчийг эрүүдэн шүүх бусад хэлбэрээр хүнлэг бус харьцсан эсэхийг шалгасан. Мөн шалгалтын мөрөөр илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах талаар холбогдох байгууллагуудад нь болон прокуроруудад анхаарах асуудлыг албан бичиг, зөвлөмж, даалгавраар хүргүүлж ажиллалаа.

2022 онд хорих байгууллагын бүтэц төрөлд байхгүй хуяглан хүргэлт нэгжийг байгуулж шүүхийн шийдвэрээр хоригдсон хүмүүсийг хорьж байсан. Энэ зөрчлийг таслан зогсоож ажилласан байна саатуулах байрны ахуйн нөхцөл, саатуулагдсан этгээдийн эрх, үүрэгтэй холбоотой хууль тогтоомжийн хэрэгт л хэрэгжилтийг 2023 онд судалсан.

Цагдаагийн зарим байгууллагын хэмжээнд түр саатуулах байр байхгүй зөрчил үйлдсэн хүний зориулалтын бус байр өрөө тасалгаанд саатуулсан зэргээр хүний эрх хууль тогтоомжийн заалтыг хангаагүй цөөнгүй зөрчил илрүүлж зөрчлийг арилгуулахаар Цагдаагийн ерөнхий газарт албан бичиг хүргүүлж хэрэгжилтийг нь хангуулж ажиллалаа. Швейцарын Холбооны Улсын Женев хотноо 2024 оны 11 дүгээр сарын 12-ноос 14-ний өдрүүдэд зохион байгуулагдсан Нэгдсэн Үндэсний Байгууллагын Эрүүдэн шүүхийн эсрэг хорооны 81 дүгээр чуулганы нээлттэй хуралдаанд Улсын ерөнхий прокурорын төлөөлөл Монгол Улсын Засгийн газрын төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд орж ажилласан. Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын ээлжит 3 дахь илтгэлийг 2020 онд хүргүүлснээс хойш хууль эрх зүйн орчинд хийсэн шинэчлэл, бодлого үйл ажиллагааныхаа талаар чуулганы хуралдаанд танилцуулж хорооны гишүүдийн асуултад хариулан ээлжит илтгэлээ амжилттай хэлэлцүүлсэн болно.

Нэгдсэн Үндэсний Байгууллагын Эрүүдэн шүүхийн эсрэг хороо манай улсын дүгнэлт зөвлөмжийг энэ он энэ сардаа багтаан танилцуулахаар болсон байна. Эрүү шүүлт тулгах гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл, хэргийн шийдвэрлэлтийн талаар ярья. Улсын хэмжээнд 2017 оны сүүлийн хагасаас 2024 оны эхний 9 сарын байдлаар нийт 603 мянган гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл хүлээн авч шалгасан.

Эрүү шүүлт тулгах гэмт хэргийн талаарх 478 гомдол, мэдээлэл шалгагдсан нь нийт гомдол мэдээллийн 0,08%-ийг эзэлж байна. Эдгээр 478 гомдол мэдээллийн 323 буюу 67%-ийг нь прокурор мөрдөгчийн саналыг үндэслэл үзэж хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж шийдвэрлэсэн 150 буюу 31,4 хувьд нь хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн нээсэн байна. 2017 оны 7 дугаар сарын 01-нээс 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийг хүртэлх хугацаанд энэ төрлийн гэмт хэрэг, хэрэг бүртгэлтийн шатанд 196 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулснаас 163 буюу 83,2%-ийг нь хааж 5 буюу 2% 10-ны 5%-ийг нь нэгтгэж, 18 хэрэг буюу 9,2 хувьд нь эрүүгийн хэрэг үүсгэж яллагчаар татаж шийдвэрлэсэн.

Одоо 10 хэрэг хэрэг бүртгэлтийн шатанд шалгагдаж байна. Хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан үндэслэлийг нь аваад үзэх юм болбол 160 гэмт хэргийн шинжгүй үндэслэлээр 3 хэргийг хөөн хэлэлцэх хугацаа дууссан үндэслэлээр хааж шийдвэрлэсэн. Дээрх хугацаанд нийтдээ 22 хэрэгт мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан 2 хэргийг нь хэрэгсэхгүй болгосон 36 хүнд холбогдох 18 хэргийг шүүхэд шилжүүлсэн. Одоо 2 хэрэгт мөрдөн байцаалтын ажиллагаа явагдаж байна. Шүүхэд шилжүүлсэн 38 хүнд холбогдох шүүхэд шилжүүлсэн 18 хэргээс 30 хүнд холбогдох 14 хэргийг эцэслэн шийдвэрлэгдсэн энэ 14 хэргийн 28 хүнийг нь гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож 2 хүнд холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож цагаатгаж шийдвэрлэсэн.

Одоо шүүхийн шатанд 6 хүнд холбогдох 4 хэрэг хянан хэлэлцэгдээгүй эрүү шүүлт тулгах гэмт хэргийг үйлдэх явцдаа хүний эрх, хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулсан 2, хүндэвтэр гэмтэл учруулсан 1, хүнд гэмтэл учруулсан 2, нийт 5 хэрэгт 5 хүнийг давхар зүйлчлэн яллах дүгнэлт үйлдэж хэргийг нь шүүхэд шилжүүлсэн. Шүүхээр шийдвэрлэгдсэн 14 хэргийн шалтгаан нөхцөлийг одоо бид судалж үзсэн.

Энэ гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцогдож эрүүгийн хариуцлага хүлээсэн 28 шүүгдэгчийг авч үзэхэд цагдаагийн байгууллагын 21 албан хаагч тагнуулын 4 шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2 прокурорын нэг албан хаагч байна. Эдгээр 14 хохирогчоор тогтоогдсон 17 иргэний 15 нь эрүүгийн хэрэгт холбогдон сэжиглэдэн 2 нь бол зөрчлийн хэргийн холбогдогч байна. Шүүгдэгч нь хохирогчоор тогтоогдсон хүнийг хэрэг зөрчил хүлээлгэх энэ талаар мэдүүлэг авах тухайн үйлдэлд нь шийтгэх ялгаварлах зорилгоор ёс бус үгээр доромжлох, гэрэлтүүлэггүй өрөөнд хонуулах, нэг бүрийн тусгай хэрэгсэл ашиглаж бие махбодод нь халдах зэргээр эрүү шүүлт тулгасан.

Эдгээр 14 хэргийн 12 нь ажлын байранд, 2 нь бусад газарт үйлдэгдсэн бол 5 хэрэг шөнийн цагаар үйлдэгджээ. Шүүхээр шийдвэрлэгдсэн 14 хэргийн 17 хохирогчийн биед нь халдаж зодсон. Үүнээс 5 хэрэг дээр нь бол одоо энэ бороохой, цахилгаан гүйдлээр цохиж ашигласан үйлдлийн улмаас хохирогчийн эрүүл мэндэд хохирол учирсан, хүндэвтэр, хөнгөн, хүнд хохирол учирсан тохиолдлыг та бүхэнд хэллээ.

Гадаад улсуудын эрх зүйн зохицуулалт яг энэ төрлийн гэмт хэргийг яаж зохицуулсныг ямархуу байдлаар зохицуулсныг бид бол судалж үзсэн. Монгол Улсын Эрүүгийн хуульд эрүү шүүлт тулгах гэмт хэргийг Эрүүгийн хуулийн 21 дүгээр бүлэг буюу Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэгт тооцсон Франц Улсад бол энэ гэмт хэргийг бол хүний бие махбодын болон сэтгэл зүйн эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэгт, Канад Улс болбол хүний эрх, нэр төрийн эсрэг гэмт хэрэгт, Герман Улсын албан тушаалын гэмт хэрэгт, Австрали Улс бол энэ Эрүүгийн хуульдаа тусдаа бие даасан хэсэг болгон ингэж хуульчилсан байдаг юм байна.

2015 оны Эрүүгийн хуульд эрүү шүүлт тулгах гэмт хэргийн субьектийг нь өргөжүүлж төрийн албан хаагч гэж тодорхойлсон боловч Эрүүгийн хуулийн 21 дүгээр бүлэг буюу хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэгт тооцож хуульчилсан нь Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын агуулгатай бол нийцэхгүй байна. Энэ гэмт хэргийн субьект зөвхөн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн албан хаагч хохирогчийн хувьд гэмт хэрэг, зөрчилд холбогдсон, сэргэдэгдсэн этгээд байх энэ ойлголт бий болж гэмт хэргийн субьект болох хохирогчийг явцуу хүрээнд хүрээнд тодорхойлох энэ нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Конвенцын 1 дүгээр зүйлд заасан бие махбод эс үгүй бол сэтгэл санаанд хүчтэй өвдөлт шаналал зовлонг учруулсан гэсэн энэ шинжийг эрүүгийн хуульд тусгахдаа бусдын бие махбод сэтгэл санааг шаналган зовоосон гэж хуульчилснаар хохирогчийн бие махбодод хүчирхийлэл үйлдсэн шаналан зовоосон идэвхтэй үйлдлийг эрүү шүүлт тулгах гэмт хэрэгт тооцох ойлголтыг бүрдүүлсэн бол энэ шүүхэд шилжүүлсэн болон шүүхээр эцэслэн шийдвэрлэсэн хэргийн хэрэглээ практикаас тодорхой харагдаж байна.

Цаашдаа Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын орчуулгыг

агуулгын хувьд нь дахин авч нягталж үзэх Эрүүгийн хуульд заасан эрүү шүүлт тулах гэмт хэргийн шинжийг конвенцын тодорхойлолтод бүрэн нийцүүлэх тусгай ангийн зохих бүлэгт нь оруулж хуульчлах. Түүнчлэн мөрдөн шалгах эрх бүхий байгууллага Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын мэдүүлэг авах өрөөний хүртээмжийг нэмэгдүүлэх мэдүүлэг авах өрөөнд тавигдах шаардлага болох одоо техник тоног төхөөрөмжийн хяналтын бичлэг, өрөө, байрны хүрэлцээг бүрэн хангуулахад чиглэсэн зорилтот арга хэмжээг авах шаардлагатай байна гэж үзэж байна. Анхаарал тавьсан та бүхэнд баярлалаа.

Сонсгол даргалагч П.Сайнзориг-Баярлалаа би бас оролцогчдоосоо бас нэг зүйлийг хүсье цаг жоохон хоцорч эхэлсэн. Уг нь бол өдийд бол цайны завсарлага уг нь явах ёстой байсан. Ямар ч байсан Монгол Улсын дээд шүүхийн мэдээллийг сонсоод бусад бас эрүү шүүлт явагдаж болзошгүй нөхцөл байдал гарч болзошгүй зарим байгууллагууд байдаг. Эдгээрийг эрхлэх асуудлын хүрээнд хамаатуулдаг яамдуудын мэдээллийг сонсоод цайны завсарлагыг явуулчихаад орж ирээд 2 байгууллагын мэдээлэл сонсоод оролцогчдынхоо байр суурийг сонсоод явья гэсэн дэгийн дэс дарааллаар явья гэж бодож байна.

Бас өглөөнөөс хойш бүгд танхимд одоо суучихсан учраас бас ингээд нэлээн чилээрхэж байгаа байх. Ямар ч байсан 2 байгууллагын мэдээллийг сонсоод цайны завсарлагыг өгье гэж бодож байгаа шүү. Ингээд эрүү шүүлт, эрүүдэн шүүх гэмт хэргийн шүүхийн шийдвэрлэлт ба гэмт хэргийн улмаас хохирогчид учирсан сэтгэцийн хор уршгийн зэрэглэл тогтоох, нөхөн төлүүлэх, одоо талаарх хууль тогтоомжийн хэрэглээ шүүхийн практик энэ талаарх мэдээллийг Улсын дээд шүүхийг төлөөлөн ахлах референт, доктор М.Хатанзориг танилцуулна. М.Хатанзориг бас цагаа барихыг хүсэж байна.

Улсын Дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхим хариуцсан ахлах референт М. Хатанзориг-Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе! Цагаа бариад аль болох товчхон мэдээлэл хүргээд явья гэж бодож байна. Энэ гэмт хэргийн шүүхэд шийдвэрлэгдсэн байдал сэтгэгцэд учирсан хор уршгийг арилгах талаарх мэдээллийг хүргэх гэж байна. Үндсэндээ бол сая бас дурдагдаж байна. Одоо Шүүхийн шийдвэрийн нэгдсэн санд мөн бүртгэлтэй байгаа. Анхан шатын шүүхийн 14 шийдвэр, давж заалдах шатын шүүхийн 14 шийдвэр хяналтын шатын шүүхийн 4 шийдвэр тус тус одоо сүүлийн 5 жилд бол гарч, байршсан байгаа.

Энэ дээр бас одоо тухайн гэмт хэрэгт ял шийтгүүлсэн этгээдийн ажил байдлыг мөн шүүхийн харьяалалыг бид нар эндээс харж болж байна 14 иргэн 7 нь нийслэл хотод, 7 нь бол орон нутагт үйлдэгдсэн байна тэгэхээр шүүхийн практикаас бид нар тухайн шүүхийн шийдвэрлэж байгаа хянан шийдвэрлэж байгаа ажиллагаанд нутаг дэвсгэрийн байдал бусад хүчин зүйл хэрхэн яаж нөлөөлж байна вэ гэдэг дээр дүн шинжилгээ хийх боломжтой байдаг.

Тэгэхээр гэмт хэргийн нэг онцлог нь зөвхөн тухайн Эрүүгийн хуульд заасан 12 дугаар зүйлийн зүйлчлэлээс гадна давхар зүйлчлэлтэй явах тохиолдлууд бол бас цөөнгүй байдаг. Энэ нь эрүүдэн шүүх буюу эрүү шүүлт тулгах гэмт хэргийн улмаас бусдын эрүүл мэндэд болон амь насанд хохирол учруулах тохиолдлууд бүртгэгддэг шүүхийн практикаас харагдаж байна.

Давж заалдах шатын шүүхээс шийтгэх тогтоолыг хүчингүй болгосон нэг, хяналтын шүүхээс магадлал шийтгэх тогтоолыг хэвээр үлдээсэн нэг мэтчилэн энэ мэдээллүүдийг бол та бүхэн эндээс бас харж болохоор байна. Гэмт хэрэгт холбогдсон этгээдүүдэд оногдуулсан ял шийтгэлийн талаар аваад үзвэл одоо Эрүүгийн хууль дээр хуульчилсан байгаа торгох ял оногдуулсан байдал бол 8 за

хорих ялыг зорчих эрх хязгаарлах ялаар сольсон нь бол нэг эрх хасах нэмэлт ял оногдуулсан 2 тохиолдол бол тус тус бүртгэгдсэн байна.

Тэгэхээр энэ гэмт хэргийн нэг онцлог нь бол зөвхөн тухайн Эрүүгийн хуульд заасан 12 дугаар зүйлийн зүйлчлэлээс гадна давхар зүйлчлэлтэй явах тохиолдлууд бол бас цөөнгүй байдаг. Энэ нь бол эрүүдэн шүүх буюу эрүү шүүлт тулгах гэмт хэргийн улмаас бусдын эрүүл мэндэд болон амь насанд хохирол учруулах тохиолдлууд бүртгэгддэг шүүхийн практикаас харагдаж байна.

Тухайлбал, дан зүйлчлэлтэй буюу одоо зөвхөн эрүү шүүлт тулгах гэмт хэргийн талаарх 9 шүүхийн шийдвэрийг бид нар харах боломжтой байгаа бол давхар хүнийг алах хүний эрүүл мэндэд хүнд, хөнгөн, хүндэвтэр хохирол санаатайгаар учруулах гэмт хэргүүд бас давхар энэ дээр зүйлчлэгдэж орж ирж байгааг харах боломжтой байгаа юм. Хяналтын шатын шүүх буюу Улсын дээд шүүх дээр шийдвэрлэгдсэн 4 тогтоол бий. Энэ 4 тогтоолоос харвал магадлалыг хэвээр үлдээсэн магадлалыг хүчингүй болгож тогтоолыг хэвээр үлдээсэн тогтоол, магадлалыг хүчингүй болгож, хэргийг прокурорт буцаасан тогтоол магадлалыг хэвээр үлдээсэн.

Ийм 4 төрлийн шийдвэр бол гарсан байгаа, энэ дээрээс хүснэгтээс одоо та бүхэн бас дэлгэрэнгүй мэдээллийг харж болж байна. Нэг бүрчлэн уншихгүйгээр цаг хэмнэх үүднээс харуулаад явчихъя энэ гэмт хэргийн шийдвэрлэсэн байдал дээр Эрүүгийн хуульд бол өөрчлөлт ороод гэмт хэргийн субьектийг харьцангуй өргөн хүрээнд Эрүүдэн шүүлтийн эсрэг конвенцод нийцүүлсэн байдлаар хуульчлаад явсан байгаа.

Ийнхүү яг хуульчлахаас өмнөх тохиолдолд бас Улсын дээд шүүхээс албан ёсны хуулийн тайлбараас гадна тогтоолоороо хуулийн хэрэглээний нэгдмэл байдлыг тогтоох үүднээс шүүхийн тодорхой жишгийг тогтоож, зөвхөн хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчаас гадна бүр мөрдөн байцаалтын ажиллагаанд оролцох боломжтой бусад субьектийг энэ гэмт хэргийн субьектэд тооцсон байдлаар бас жишиг тогтоогоод явж байсан байгаа.

2 дугаар агуулгын хүрээнд гэмт хэргийн улмаас хохирогчид учирсан сэтгэцийн хор уршгийн зэрэглэл тогтоох нөхөн төлүүлэх талаар хууль тогтоомжийн хэрэглээний хувьд энэ дээр 2024 оны эхний хагас дээр хяналтын шатны шүүх дээр бол бид нар судалгаа хийж бэлдсэн байсан. Нийтдээ бол одоо 30 гомдол ирсэн байгаа. Хяналтын шатны шүүхэд үүнээс 17-г нь бид нар хуульд заасан үндэслэл бүхий байна гэж хүлээн авч шийдвэрлэсэн. Энэ шийдвэрээс ямар ямар хэргүүд хяналтын шатны шүүхээр орж ирсэн бэ гэдэг дээр одоо дүн шинжилгээ хийгээд үзэхээр үүнээс бол 11 нь хуулийг буцаан хэрэглэхтэй холбоотой асуудал байсан.

Өөрөөр хэлбэл, өнгөрсөн 2023 оны 7 дугаар сарын өмнө үйлдэгдсэн гэмт хэргүүд дээр сэтгэцийн хор уршгийг тооцсон ийм шүүхийн практикуудыг бол буцаагаад хяналтын шинэ шүүх дээр хуульд нийцүүлж явуулсан байгаа дээрээс бол цөөхөн тохиолдолд энэ 4 тохиолдолд тухайлбал Улсын дээд шүүхээс баталсан журмын дагуух зохицуулалтад нийцүүлээгүй гэж ойлгож болох нь байна. Хүнийг санаатай алах гэмт хэрэг дээр заавал Шүүх шинжилгээний хүрээлэнгээс шинжээч томилуулах ёстой байтал хүснэгтээр шууд хохирлыг гаргуулсан энэ тэр тохиолдлууд бол байсан. Тэгэхээр энэ болгоныг хяналтын шатын шүүхээс хуулийн хэрэглээнд нийцүүлж холбогдох шийдвэрүүдийг гаргаад явуулсан байна.

Улсын дээд шүүхээс Шүүхийн тухай хуулийн дагуу хууль санаачлагчид бас энэ сэтгэцэд учирсан хор уршгийг арилгах журамтай холбоотойгоор Шүүх шинжилгээний тухай хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн саналыг албан ёсоор

хүргүүлсэн байгаа тухайн саналыг энд мэдээлэл өгөх үүднээс товчхон дурдвал олон улсад болон онолын хувьд үндсэндээ хүний эрүүл мэнд бие махбодод учирсан хохирлоос шалтгаалан сэтгэл зүйд учирсан хохирол нэг тусдаа гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хор уршиг буюу сэтгэцийн өөрчлөлтөд орсон байдал бол ингээд 2 тусдаа байдаг.

Тэгэхээр 1 нь бол эхнийх нь одоо тэр хохирлыг барагдуулах нь олон улсын зарим жишгээс туршлагад харьцуулаад үзэхээр нөхөн төлбөрийг шууд хүснэгтээр гаргуулаад өгчхөж бол болдог хүн гэмт хэргийн улмаас тодорхой эд эрхтнээ алдсан ч юм уу энэ тохиолдолд ийм байдлаар нөхөн төлбөр олгоно. Харин сэтгэцэд учирсан хор уршиг буюу сэтгэцэд нь өөрчлөлт орсон сэтгэл зүйн эмнэл зүйтэй холбоотой асуудал үүссэн тохиолдолд түүн дээр зайлшгүй шинжээч томилуулж энэ хүнд ямар сэтгэл зүйн хор уршиг учирсан юм бэ гэдгийг бас авч үздэг. Ийм сайн туршлага жишиг бол байдаг. Тэгэхээр энэ талаарх саналаа хууль санаачлагчид хууль тогтоосон журмын дагуу бас албан ёсоор хүргүүлсэн байгаа ингээд анхаарал хандуулсан та бүхэнд баярлалаа.

Сонсгол даргалагч П.Сайнзориг - Дараагийн мэдээлэл хөтөлбөрийн дагуу бол Зэвсэгт хүчний жанжин штабын дарга С.Ганбямба дарга Зэвсэгт хүчний нэгтгэл, анги байгууллагад хүний эрх, эрх чөлөөг зөрчих дүрмийн бус харилцааны талаарх гаргасан гомдол мэдээллийн шийдвэрт болон авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх мэдээллийг өгнө.

Зэвсэгт хүчний жанжин штабын дарга С.Ганбямба- Сонсгол даргалагч болон та бүхний энэ өдрийн амрыг эрье. Сонсгол даргалагчийн зүгээс өгсөн чиглэлийн дагуу Зэвсэгт хүчний нэгтгэл анги, байгууллагуудад хүний эрх, эрх чөлөөг зөрчих дүрмийн бус харилцааны талаар гаргасан гомдол мэдээллийн шийдвэрлэлт болон авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар та бүхэнд илтгэе.

Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний жанжин штаб цэргийн алба хаагчид болон иргэдээс ирүүлсэн гомдол, өргөдөл, гомдлыг шийдвэрлэхдээ Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2022 оны 180 дугаар зарлигаар батлагдсан Цэргийн нийтлэг дүрмүүд болон Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 67 дугаар тогтоол Батлан хамгаалахын сайдын 2017 оны 90 дүгээр тушаалаар батлагдсан Батлан хамгаалах яам цэргийн албан хаагч бэлтгэл болон чөлөөнд гарсан офицер, ахлагч, ажилтан, албан хаагчид, иргэдээс хандаж гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай журам, Зэвсэгт хүчний жанжин штабын даргын тушаалаар батлагдсан Зэвсэгт хүчний жанжин штабын хөдөлмөрийн дотоод журам болон бусад хууль тогтоомж эрх зүйн актуудыг мөрдлөг болгон хуулийн хугацаанд шийдвэрлэн ажиллаж байна.

Цэргийн алба хаагч болон иргэдээс сүүлийн 5 жилийн байдлаар Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний жанжин штаб, цэргийн командлал, Барилга инженерийн цэргийн удирдах газар, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбар, байгууллагад нийтдээ 49250 өргөдөл гомдлыг хүлээж авсан байна. Нийт ирүүлсэн өргөдөл гомдлоос 48544 өргөдлийг шийдвэрлэн өргөдөл гомдол гаргагчид хуулийн хугацаанд нь хариуг хүргүүлж 690 өргөдлийг хариу мэдээллийн дагуу бусад байгууллагад шилжүүлж, 16 өргөдлийг хуулийн хугацаанд шийдвэрлэхээр ажиллаж байна. Өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авсан хэлбэрээр нь та бүхэнд энэ слайд дээр харуулж байна.

Өргөдөл, гомдлыг биечлэн иргэнээс одоо хүлээж авсан тоо 3305, Засгийн газрын Иргэд олон нийттэй харилцах 1111 төвөөр дамжуулан хүлээн авсан 431,

Батлах хамгаалах яам болон Зэвсэгт хүчний жанжин штаб дээр өргөдөл гомдол хүлээж авдаг тусгай дугаар байдаг Батлан хамгаалах яаман дээр 811, Зэвсэгт хүчний жанжин штаб дээр 5040, энэ тусгай дугаараар 672 өргөдөл гомдол мөн 2020 оноос эхлэн одоо цахим шуудангаар бид өргөдөл гомдлыг хүлээж авч байгаа 811 өргөдөл гомдлыг хүлээж авсан байна олон нийтийн сүлжээгээр бусад байгууллагаас харьяаллын дагуу манай 44028 өргөдөл шилжиж ирсэн байна эдгээр нийт 49250 Өргөдөл, гомдлоос хүний эрх, эрх чөлөө, дүрмийн бус харилцааны талаар 25 өргөдөл сүүлийн 5 жилд ирсэн байна.

Үүний 19 өргөдлийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэн 3 өргөдлийг бусад байгууллагад шилжүүлсэн 3 өргөдөл өнөөдөр хуулийн хугацаанд хянагдаж байна. Иргэдээс хүний эрх, эрх чөлөө, дүрмийн бус харилцааны талаар гаргасан өргөдөл, гомдол, мэдээлэл нь нийт өргөдөл, гомдол, мэдээллийн 05%-ийг одоо эзэлж байна зэвсэгт хүчний нэгтгэл анги байгууллагуудад хүний эрх, эрх чөлөөг зөрчих дүрмийн бус харилцааг бууруулах талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар та бүхэнд танилцуулъя.

Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний жанжин штаб нь гэмт хэрэг, осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гарсан зөрчлийн шалтгаан нөхцөлийг тодорхойлон цаашид гаргахгүй байх бүх төрлийн арга хэмжээг хэрэгжүүлж зэвсэгт хүчинд ёс зүйтэй, сахилга баттай, шинэлэг, сэтгэлгээ, зөв хандлагатай, чадварлаг офицер, ахлагч, ажилтан алба хаагчдыг бүрдүүлэн хуулиа дээдэлдэг, иргэндээ үйлчилдэг, цэргийн алба хаагчийн эрхийг дээдэлдэг алба болгон төлөвшүүлэх зорилгоор олон арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

1 дүгээрт нь цэргийн алба хаагчийн эрхийг хамгаалах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох хүрээнд Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд бид нэмэлт, өөрчлөлт орууллаа, цэргийн алба хаагч нь өөрөө хуулиар давуу эрх эдэлдэг мөн түүнчлэн эрхийн хязгаарлалттай ийм субъект байдаг. Энэ хуулиар 2024 онд орсон хуулийн өөрчлөлтөөр бид цэргийн албан хаагчийн эрх зүйн баталгааг дээшлүүлсэн мөн түүнчлэн Хүний эрхийн Үндэсний Комиссын 21 дүгээр илтгэл дээр заагдсан зөвлөмжийг хэрэгжүүлж хууль тогтоомжид цэргийн албан хаагчийн эрхийн хязгаарлалт хууль тогтоомжид заасан ажил эрхлэлт хөдөлмөрийн харилцаанд аливаа дарамт шахалт үзүүлэх ялгаварлан гадуурхах нь хязгаарлана.

Цэргийн албан хаагч гэдэг энэ зохицуулалтыг хуульчлан баталгаажуулж өгсөн байгаа, түүнчлэн Цэргийн алба хаагчийн тэтгэвэр тэтгэмжийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт орууллаа. Цэргийн алба хаасны тэтгэвэр хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр тэжээгдсэн алдсаны тэтгэвэр нэг удаагийн тэтгэмжийг тогтоох олгох эрх зүйн нөхцөлийг сайжруулсан.

Цэргийн алба хаагч эмэгтэй нь жирэмсний болон амаржсаны хүүхэд асрах чөлөөтэй байсан хугацааг цэргийн алба хаасан хугацаанд оруулан тооцох эрх зүйн зохицуулалтыг энэ хуульд тусгаж өгсөн байна. Монгол Улсын Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчаар цэргийн нийтлэг дүрмүүдийг Зэвсэгт хүчний жанжин штабын даргын тушаалаар цэргийн албыг зохион байгуулах зааврыг шинэчлэн баталгаажууллаа. Цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль хуулийн 2,3 дээр цэргийн албан хаагчийн цэргийн албаны үүрэг гүйцэтгэхтэй холбогдсон энэ хуулиар зохицуулаагүй бусад харилцааг Монгол Улсын Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн баталсан Цэргийн нийтлэг дүрмээр зохицуулахаар заасан байдаг.

Энэ зохицуулалтын хүрээнд дүрэм зааврыг боловсруулан баталгаажууллаа түүнчлэн Батлан хамгаалахын сайдын тушаалаар цэргийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг баталгаажуулж 2024 оны 5 сараас эхлэн хэрэгжүүлж байна Зэвсэгт хүчний

нийт бие бүрэлдэхүүн дүрэмд заасны дагуу ёс зүйн андгай өргөх энэ арга хэмжээг бид хэрэгжүүллээ, хүний эрх, эрх чөлөөг зөрчих дүрмийн бус харилцааг бууруулах талаар төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах чиглэлээр дараах ажил арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүллээ.

Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн зүгээс 2023 оныг Залуу офицеруудын жил, 2024 оныг Ахлагчийн жил болгон зарлаж төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын дунд Соёл урлаг спорт мэргэжлийн олон талт цогц арга хэмжээг зохион байгуулж хэрэгжүүллээ. Энэ хүрээндээ 2023 онд тэргүүний залуу офицеруудын чуулга уулзалт 2024 онд тэргүүний ахлагч нарын чуулга уулзалтыг тус тус зохион байгуулсан нь офицер ахлагч нар албандаа итгэлтэй байх ёс зүйн манлайлалтай байх албаны хандлагыг дээшлүүлэхэд чиглэсэн ийм арга хэмжээ болсон.

Хүний эрхийн Үндэсний Комиссын 21 дүгээр илтгэлтэй холбогдуулж бид Батлан хамгаалах яам, Хүний эрхийн Үндэсний Комисс хамтран ажиллах санамж бичгийг байгуулан ажилласан энэ хүрээнд хэрэгжүүлсэн нэгэн томоохон ажил бол Хүний эрхийн Үндэсний Комиссын зүгээс бид сургалт авч 67 цэргийн алба хаагчийг хүний эрхийн сурагч багшаар бэлтгэж, нэгтгэл, ангиудад ажиллуулж байна бид цэргийн алба хаагчдын сэтгэл зүйн тогтвортой байдлыг хангах үүднээс төрийн болон төрийн бус байгууллагуудтай нягт хамтарч ажиллаж байгаа.

Хүний эрхийн Үндэсний комиссын одоо 21 дүгээр зөвлөмж дээр цэргийн алба хаагчдад сэтгэл зүйн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зөвлөмжийг бид нарт өгсөн. Үүнтэй уялдуулаад Батлан хамгаалахын сайдын шийдвэрээр 2022 оноос Үндэсний батлан хамгаалах их сургууль цэргийн сэтгэл зүй соёл хүмүүжлийн ажилтныг дахин бэлтгэж эхэлсэн. Өнөөдрийн байдлаар 55 сонсогч үндсэн бакалаврын сургалтад хамрагдаж байна түүнчлэн бид тусгай хөтөлбөрөөр богино хугацааны сургалтаар 66 цэргийн сэтгэл зүйч, соёл хүмүүжлийн ажилтныг сургаж зэвсэгт хүчний нэгтгэл ангиудад томилуулан ажиллуулж байна. Зэвсэгт хүчний жанжин штаб нь сэтгэл зүйн хөдөлгөөнт бүлгийг Зэвсэгт хүчний нэгтгэл анги салбаруудад ажиллууллаа. 2 жилийн хугацаанд нийтдээ 41 анги, 11 тусгай салбарын 5200 гаруй цэргийн албан хаагч үүн дотроо 3500 гаруй хугацаат цэргийн албан хаагчдад 4 төрлийн сэтгэл зүйн судалгаа явуулан оношилж бүлгийн болон ганцаарчилсан хэлбэрээр сэтгэл зүйн зөвлөгөө өгч бие бүрэлдэхүүнд сэтгэл зүйн сургалт зохион байгуулж тэдний сэтгэл зүйн тогтвортой байдлыг ханган ажилласан байна.

Цэргийн албан хаагчийн нийгмийн хамгаалал, хангалт үйлчилгээ, алба байх орчин нөхцөлийг сайжруулах чиглэлээр зэвсэгт хүчний офицер ахлагч нарын цалин нэмэгдэл бусад төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудтай адил түвшинд хүрсэн тодорхой үе шаттайгаар нэмэгдүүлсэн байгаа.

2022 оноос 2024 онд хугацаат цэргийн алба хаагчдын албаа ая тухтай хаах орчин нөхцөлийг сайжруулах арга хэмжээг бид авч хэрэгжүүлсэн. Нийтдээ бол 16 нэгтгэл ангийн 29 цэргийн байрны гадна дотно фасадын асуудал, дээврийн засварын асуудал мөн алба хаагчдын хувийн эд хэрэглээний шинэчлэлийн асуудлыг авч хэрэгжүүллээ цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 5.1.3-д цэргийн алба хаагч албаны үүргээ гүйцэтгэх үедээ цэргийн дүрэмд тус техник материал хэрэгсэл ажиллах нөхцөл бололцоогоор хангагдах эрхтэй төсөв хөрөнгийн хүрэлцээгүй байдлаас шалтгаалаад энэ эрх зөрчигдөж ирсэн гэхдээ 2024 онд төсөв нэмэгдсэнтэй холбогдуулаад бид эхний ээлжид офицер ахлагч нарын хээрийн хувцасны хангалтыг 100% шийдсэн байгаа.

2025 онд цаашдаа үе шаттайгаар бусад хувцас хэрэглэлийн хангалтыг одоо шийдвэрлэхээр ажиллаж байна. Хяналт шалгалт хүний эрхийн зөрчлийг бууруулах чиглэлээр хийсэн зохион байгуулалтын арга хэмжээний хувьд батлан хамгаалахын хяналт шалгалтын нэгдсэн тогтолцоог бүрдүүлсэн Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний жанжин штаб хяналт шалгалтын нэгжийн үйл ажиллагааны уялдаа холбоог хангасан давхардал хийдлийг арилгасан одоо нэгдсэн төлөвлөлтөд оруулсан байна.

Цэргийн хүрээ хотхонуудад цэргийн, цагдаагийн нэгжийг байгуулан ажиллаж байна хүний эрхийн комиссын зүгээс зөвлөмжийн дагуу Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллагад камерын хяналтын нэгдсэн системийг үүсгэж тэгээд иргэдээс авах тусгай дугаарыг ажиллуулан гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил арга хэмжээг хэрэгжүүлж байна.

Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний дараах саналуудыг илтгэж байна. Цэргийн насны залуучуудын эрүүл мэндийн байдал төрөөс бодлогоор анхаарахгүй бол болохгүй болсон байна. Цэрэг татлагаар ирж байгаа залуучуудын 30% нь ч эрүүл мэндээр тэнцэхгүй байна сая 2 дугаар ээлжээр цэрэгт татагдсан алба хаагчдыг Батлан хамгаалахын сайдын шийдвэрээр давтан эрүүл мэндийн үзлэгт хамрагдахад өнөөдрийн байдлаар 100 гаруй залуу залуучууд одоо эрүүл мэндээр дахин тэнцэхгүй ийм нөхцөл байдал үүссэн байна.

Сонсгол даргалагч П.Сайнзориг- Цагаа барья. Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллагуудад хүний эрх, эрх чөлөөг хангах нөхцөлийг бүрдүүлэх цэргийн алба хаагчийн хуулиар олгогдсон давуу эрх хэмжээ буюу дүгнэлтээ танилцуулах 2 минут өгье.

Зэвсэгт хүчний жанжин штабын дарга С.Ганбямба- Ойлголоо, зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллагад хүний эрх, эрх чөлөөг хангах нөхцөлийг бүрдүүлэх цэргийн албан хаагчийн хуулиар олгогдсон эрх давуу эрхийг бүрэн баталгаажуулахын тулд Зэвсэгт хүчний төсвийг нэмэгдүүлэх, тогтвортой байдлыг хангах, цэргийн албан хаагч түүний гэр бүлийн нийгмийн хамгаалал, баталгааг дээшлүүлэх, цэргийн албан хаагчдын ажил ажиллаж амьдрах орчин нөхцөлийг сайжруулах хэрэгцээ шаардлага байгаа.

Ингэснээрээ Зэвсэгт хүчний нэгтгэл анги салбаруудад гарах, хүний эрх, эрх чөлөөг зөрчих дүрмийн бус харилцаа тодорхой хувиар буурна гэж үзэж байна. Та бүхэнд баярлалаа.

Сонсгол даргалагч П.Сайнзориг - За баярлалаа хэдүүлээ яах вэ? Хөтөлбөрийн дагуу дахиад 2 төрийн байгууллагын мэдээлэл байгаа. Өглөө бас сонсгол хоцорч эхэллээ оролцогчид маань бас жоохон чилээрхэж байж магадгүй цайны завсарлага 20 минут аваад, 2 байгууллагын мэдээлэл болон энд ирүүлсэн байр сууриа илэрхийлнэ гэсэн 40 хүн байна ямар ч байсан 2 байгууллагын мэдээллийн дараа Бат-Ялалт байгаа юу? хүндэтгэн үзэх шалтгаан байгаа учраас Бат-Ялалтаар эхлүүлэе. Тийм учраас яг цайны цагийн дараа 2 байгууллагын мэдээлэл сонсоод, дэс дарааллаар оролцогчид маань мэдээллээ өгнө. 12:40-д бүгдээрээ яг танхимдаа буцаад орж ирье.

Сонсгол даргалагч П.Сайнзориг - Сонсголын зохион байгуулалтыг хариуцаж байгаа Улсын Их Хурлын Тамгын газрын ажилчид гадаа байгаа хүмүүсээ оруулаарай.

Улсын Их Хурлын гишүүдэд сонсгол үргэлжлэн явагдах гэж байгаа талаар мэдээллийг яаралтай өгье. 2 минутын дараа эхэлье.

Цаг хоцорч явж байгаа учраас сонсголдоо буцаж орьё. Төрийн байгууллагын хоёр мэдээлэл байгаа. Энэ хоёр мэдээллийн дараа өөрийн байр сууриа, дуу хоолойгоо хүргэхээр ирсэн хүмүүсийн төлөөллөөс сонсоод явна.

Ингээд Гэр бүл, Хөдөлмөр, Нийгэм хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул даргыг урьж байна. Төрөлжсөн асрамжийн газарт амьдарч буй ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдийн эрхийн хэрэгжилт, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар ерөнхий сэдэв тавьчихсан байна шүү Мөнхзул дарга энийгээ зөвхөн эрүү шүүлт, хүнтэй хүнлэг бус, хэрцгий хандах эрхийн хэрэгжилттэй холбогдуулж мэдээллээ өгөөрэй. Сэдэвтэй хамаагүй юм яривал би таны мэдээллийг таслах болно гэдгийг хэлье. Сэдвийн хүрээндээ мэдээллээ өгөхийг хүсэж байна. Мөн цагаа барихыг хүсэж байна.

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул - Баярлалаа. Өнөөдрийн сонсголыг удирдан зохион байгуулж байгаа Сонсгол даргалагч, Улсын Их Хурлын байнгын хорооны дарга, эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Оролцогчдодоо мөн энэ өдрийн мэндийг хүргэе.

Манай гол илтгэл, мэдээлэл, асуудал асрамжийн газарт амьдарч байгаа ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдийн эрх хамгааллын хэрэгжилтийн асуудал дээр мэдээлэл бэлтгэсэн.

Сонсгол даргалагч П.Сайнзориг - Манайхан дуугаа жоохон багасгаад өгөхийг хүсье. Бие биедээ хүндэтгэлтэй хандаад, санал солилцох юмнуудаа гарч байгаад ярихыг хүсэж байна. Энд хүн мэдээлэл өгч байгаа учраас бие биедээ жоохон хүндэтгэлтэй хандъя. За баярлалаа үргэлжлүүлье.

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул - Улсын хэмжээнд нийтдээ ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэний 12 асрамжийн газар байдаг. Эндээс хөгжлийн бэрхшээлтэй иргэний төрөлжсөн асрамжийн үйлчилгээ үзүүлж байгаа зөвхөн хоёрхон асрамж байгаа. Нийтдээ улсын төсвөөс 9.5 тэрбум төгрөгийн төсөв олгоод явдаг.

Улсын хэмжээнд 507 ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд асрамжийн байгууллагаас үйлчилгээ авч үйлчлүүлж байна. 241 хүн эдгээр асрамжийн газруудад ажиллаж байна. Хүний эрхийн үндэсний комиссоос 2022 он, ер нь жил болгон ахмад настны асрамжийн газруудад үзлэг шалгалт хийж, зөвлөмж өгдөг.

2023 онд өгсөн зөвлөмжийн хүрээнд Батсүмбэр дэх үндэсний асрамжийн төвд сэтгэцийн эмчийг ажиллуулах, уламжлалт анагаах ухааны эмчийг ажиллуулах, асруулагчаас гарсан эрх зүйн зөрчлийн тухай гомдол мэдээллийг бүртгэдэг болох хэрэгтэй байна.

Мөн түүнчлэн сургалт зохион байгуулах, төрөлжсөн асрамжийн үйлчилгээтэй холбоотой захиргааны хэм хэмжээний журмуудыг батлуулж, улсын хэмжээний нэгдсэн бүртгэлд хамруулах шаардлагатай, хараат бусаар тогтмол хяналт шалгалт хийх шаардлагатай байна гэсэн ийм зөвлөмжүүдийг өгсөн. Зөвлөмжийн хэрэгжилтийн хүрээнд 2023 оноос эхлээд ерөнхийдөө хүний нөөцийн асуудлуудыг тодорхой хэмжээнд шийдэж, эмч болон хүний их эмчийг ажиллуулж байгаа. Орон тооны тогтвор суурьшилтын хувьд асуудалтай байдаг. Ямар ч байсан өргөдөл гомдлын дэвтрийг тогтмол ажиллуулж хэвшсэн, хөндлөнгийн хараат бус сэтгэл ханамжийн үнэлгээ байнга авдаг болсон.

Дараагийн ээлжид бид нарын хийх гэж байгаа зүйл гэвэл, хөндлөнгийн санаандгүй байдлаар хараат бус хяналт хийх олон улсын жишигт нийцсэн аргачлалыг мөрдүүлэхээр ажиллаж байна. 2018 оноос хойш Улаан загалмайн нийгэмлэгтэй хамтарч тэнд ажиллаж байгаа албан тушаалтан, албан хаагчдыг хүнлэг бус болон бусад харилцаанаас сэргийлэх ангид байх чадавх бэхжүүлэх сургалтуудыг хийж ирсэн.

Хүүхдийн асрамжийн төвүүд, цаашдаа ахмад настны асрамжийн тулгамдаж байгаа асуудлуудыг эрх зүйн хүрээнд 2024 онд Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэсэн. Цаашдаа олон ахмад настныг нэг дор төвлөрүүлэх гэхээс илүүтэй олон улсын байгууллагуудаас болон Хүний эрхийн үндэсний комиссоос өгч байгаа зөвлөмжийн дагуу аль болохоор цөөн ахмад настныг төрөлжсөн байдлаар байлгуулах, асаргааны хувилбар үйлчилгээг нэвтрүүлэх боломжийг хууль дээр тусгасан 2025 оноос холбогдох төсөв нь суугаад, анх удаа хэрэгжиж эхлэхээр төсөвлөгдсөн байна.

Мөн шинээр асрамжийн үйлчилгээ үзүүлэх, барилга байгууламж барих, хувийн хэвшлийн байгууллагууд төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх дээр асуудал хууль эрх зүйн орчинд бүрдсэн. Байнгын асаргаа шаардлагатай үйлчлүүлэгчид ноогдох нормативд зардлын хэмжээ Хүний эрхийн үндэсний комиссын шалгалт, дүгнэлт, зөвлөмжийн дагуу нэмэгдүүлэх шаардлагатай. Инфляц үнийн өсөлтийг хангаагүй байна гэж дүгнэсэн. Энэ хүрээнд 2023 онд шинэчлэгдэж, 2024 оны 1 дүгээр сарын 1-нээс нэмэгдсэн. Ингээд 2025 оноос хүнд хэвтрийн дэглэмд амьдардаг үйлчлүүлэгч нарын норматив зардлыг 3 дахин нэмэгдүүлэхээр эрх зүйн орчин бүрдэж, холбогдох төсөв нь 2025 онд суугдсан байгаа.

Төрөлжсөн асрамжийн газарт хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр ажилтнуудын ур чадварыг сайжруулах, ёс зүйн дүрмүүдийг мөрдүүлэхээр ажиллаж байна. Хараат бус хяналт шалгалтыг тогтмолжуулна. Үйлчлүүлэгчдийн санал, гомдол, хүсэлтийг илэрхийлэх боломжийг бүрдүүлж байгаа. Зөрчлийг илрүүлэх эрсдэлийг бууруулах тогтолцоог бүрдүүлэх дүрэм, журам гаргаж ажиллаж байгаа.

Эрүүл мэндийн яамны харьяанд сэтгэцийн өвчтэй хүний асрамжийн газрыг зайлшгүй шинээр байгуулах шаардлага байгаа. Албан тушаалтан гэхээсээ илүү сэтгэцийн хүнд хэлбэрийн өвчтэй ахмад настан ирсэн тохиолдолд нөгөө бусад асаргаа, үйлчилгээ авч байгаа хүмүүсийн аюулгүй байдал, тав тухтай байдал, эрхийн асуудалд зөрчил үүсдэг. Тэгэхээр энэ асуудал дээр бид нар холбогдох яамтай хамтарч ажиллаж байгаа.

Хүүхдийн асрамж, халамжийн төвийн мэдээллийг товчхон өгье. Цаг бага байгаа учраас би ерөнхийдөө товчилъё. Хүүхдийн асрамж, халамжийн төвийн үйл ажиллагаа 3 хууль, эрх зүйн хүрээнд одоо мөрдөгдөн үйл ажиллагаа нь явагдаж байгаа. Хүүхдийн асрах үйлчилгээнд тавигдаж байгаа дүрэм, журам, стандартыг дурдах юм бол хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд тавигдах нийтлэг стандарт мөрдөгдөж байгаа 2017 онд батлагдсан. Мөн хүүхэд асрах хувилбарт үйлчилгээ үзүүлэх шинэ журмыг 2024 онд баталсан. Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулга 2024 оны 1 дүгээр сарын 11-нд Улсын Их Хурлаар батлагдаж хүүхэд хамгааллын асуудал дээр эрх зүйн хувьд нэлээд дэвшилтэт зүйл гарсан байгаа. 2022 оноос эхлээд хувийн хүүхдийн асрамжуудад улсын төсвөөс тодорхой хэмжээнд хоолны хувьсах зардлын санхүүжилтийг олгож ирсэн.

Цаашдаа бие даан амьдрах чиглэлээр асрамжийн газруудад амьдарч байгаа хүүхдийн эрх ашгийг хамгаалах, илүү гэр бүлд байгаа мэт орчин бүрдүүлэх

асуудлаар бие даан амьдрах хөтөлбөрийг 2021 оноос хэрэгжүүлж эхэлсэн. Улсын хэмжээнд нийтдээ 29 хүүхдийн асрамжийн төв ажиллаж, үйл ажиллагаагаа явуулж байна. Ихэнх нь Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байна. Нийтдээ хүүхдийн асрамжийн байгууллагуудад 500 орчим хүн ажиллаж байна. Улсын төсвөөс тодорхой хэмжээний санхүүжилт олгогдоод явж байгаа.

Өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн байдал 1992-2014 оны хугацаа болон түүнээс хойших хугацаанд хүүхдийн асрамж халамжийн төвийн үйл ажиллагаа хүрээгүй хүүхдийг хэрцгийгээр хүнлэг бусаар эрүүдэн шүүхтэй холбоотой өргөдөл гомдлын бүртгэл байхгүй байна. 2014-2024 оны 9 сарын байдлаар хүүхдийн тусламжийн утас 108 тусгай дугаарт эрүүдэн шүүсэн талаарх гомдол мэдээлэл ирээгүй. Гэхдээ асрамжийн газарт байгаа хүүхдүүдтэй холбоотойгоор болон асрамжийн газарт ажиллаж байгаа хүмүүсээс нийтдээ 46 мэдээлэл ирсэн байна. Эдгээрийг ангилж үзэх юм бол өргөдөл гомдол аймагт 6, нийслэлд 40 ирсэн. Одоогийн байдлаар эдгээр өргөдөл гомдлыг шийдвэрлэсэн 33, шалгагдаж байгаа нь 13 байна. Мэдээллийн байдлаар нь ангилж үзэхэд хамгийн их гомдлыг бэлгийн болон бие махбодын хүчирхийлэлд өртсөн байж болзошгүй гэсэн дуудлага эзэлсэн байна. Дуудлага ирмэгц бид холбогдох арга хэмжээг авч батлагдсан дүрэм журмын хүрээнд баг гаргаж шалгалт хийж, тогтоох ажлуудыг хийдэг.

Хүүхдийн асрамж халамжийн төвд илэрсэн хүүхдийн эсрэг гэмт хэргийн мэдээлэл 2018 онд Нийслэлийн Засаг даргын дэргэдэх Хүүхэд залуучуудын сургалт хүмүүжлийн тусгай цогцолборт үйлчилгээ авч байсан хүүхэд бэлгийн хүчирхийлэлд өртсөн гэмт хэрэг гарсан. Энэ гэмт хэрэгт холбогдсон 17 настай хүүхэдэд шүүхээс 12 жилийн хорих ял ноогдуулсан.

2020 онд мөн тус асрамжийн газар 5 хүүхэд, бага насны 5 хүүхдэд хүчирхийлэл, бэлгийн хүчирхийлэл үзүүлсэн гэмт хэрэг гарсан. Ингээд 4 хүүхэд шүүхээс ял авч хоригдож байна. Эдгээр гэмт хэргийн хохирогч болсон хүүхдүүдийг Хүүхэд хамгааллын тухай хуулийн дагуу нөхөн сэргээх үйлчилгээнд хамруулсан. Мөн тодорхой тооны хүүхдүүдийг гэр бүлд нь эргэн нэгтгэсэн. Гэмт хэрэг гарсан энэ байгууллагын удирдах албан тушаалтнуудад хариуцлага тооцох арга хэмжээнүүд авагдсан тохиолдлууд байгаа.

2024 оны байдлаар 2 жил тутамд энэ стандартын дагуу үйлчилгээ үзүүлж байна уу? гэдгийг Хүүхэд гэр бүл хөгжлийн ерөнхий газраас шалгаж байгаа. 2024 оны байдлаар ...

Сонсгол даргалагч П.Сайнзориг - Дэг барья. Оролцогч дэгээ барья. Улсын Их Хурлын гишүүд түрүүчээсээ орж ирээд сууж байна, дэлгэцээр явж байгаа. Дэгээ бариарай, танд би санууллаа. Тамгын газрынхан гишүүдэд хэлээрэй, оролцогч нар гишүүдийг бүгд орж ирж суухыг шаардаж байгаа юм байна. Тэгэхдээ энэ мэдээлэл Олон нийтийн үндэсний телевиз болон нилээд олон суваг, телевизээр явж байгаа. Парламент телевиз буюу гишүүд өөрсдөө энэ мэдээллүүдийг дэлгэцээр ч гэсэн авах бололцоотой байгаа. Тэгэхдээ орж ирээд суух нь зөв байх. Би хэлүүлье.

Та бүхэн шууд битгий ингэж хандаарай, дэгээ барья. Мэдээллүүд тасрах тусам л сонсгол эмх замбараагүй болох байх. Хажидмаа танд би санууллаа.

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул - Оролцогчдоо би мэдээллээ үргэлжлүүлээд явъя.

Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд тавих нийтлэг стандарт гэж байгаа. Энэ стандартыг бид мөрдөж ажиллаж байгаа. Стандартын хэрэгжилт дээр манай

агентлаг, Хүүхэд гэр бүлийн асуудал хариуцсан хөгжлийн ерөнхий газар хяналт шалгалтууд хийдэг. Ковидын үед онлайн хяналт шалгалтууд хийсэн, түүнээс хойш асрамжийн газруудад баг томилогдон ажиллаж хяналт шалгалт хийдэг.

Ерөнхийдөө 2022 онд 31 асрамжийн байгууллагад хяналт шалгалт хийгдсэн. Хяналт шалгалтын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээг холбогдох байгууллагуудад зөвлөмж л өгөөд байж байгаа.

Сонсгол даргалагч П.Сайнзориг - Мөнхзул даргын мэдээллийг дуусгах цагийг нь өгчих.

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул - Цаашид хүүхдийг асрамжийн газар байлгах гэдэг үзэл конвенц Хүүхдийн эрхийн Конвенцын тусгалд хамрагдахгүй байгаа. Өнөөдөр дэлхийн 195 орон нэгдсэн Хүүхдийн Эрхийн Конвенцын өдөр. Тэгэхээр Монгол Улс 1990 онд нэгдсэн.

Цаашдаа хүүхдийг аль болох эхний ээлжид төрөл садны болон гэр бүлд нь асруулах. Хэрэв төрөл садан, гэр бүл байхгүй хүүхдийг асралт гэр бүлд асруулах, бүр боломжгүй буюу төр зайлшгүй хамгаалалт авах шаардлагатай хүүхдүүдээ хамгаалж, үйлчилгээгээ үзүүлнэ. Асрамжийн байгууллага үйлчилгээнд хамруулах гэсэн ийм 3 шатлал байхаар Хүүхэд хамгааллын тухай хуульд энэ онд маш сайн дэлгэрэнгүй туссан, энэ чиглэлээр үйл ажиллагаанууд явж байгаа.

Бид хүүхдийн эрхийн зөрчил, хүүхэдтэй хүнлэг бус харьцах асуудлаас хамгийн гол чухал зүйл бол соён гэгээрүүлэх асуудалд ажилтан, албан хаагчдыг хамруулах нь зүйтэй. Мөн цалин мөнгө, хөлсний асуудал, хяналт шалгалтын асуудал энэ бүгдэд өндөр ач холбогдол өгч ажиллаж байгаа.

Тэгээд 1 дүгээр сарын 01-нээс эхлээд асралт гэр бүлийг бэлтгэж, шүүх үйлчилгээний шинэ хувилбарыг анх удаа нэвтрүүлж байгаа учраас манай яам болон холбогдох агентлагтай хамтран ажиллаж, анхаарал хандуулж ажиллаж байгаа. Анхаарал хандуулсан та бүхэнд баярлалаа.

Сонсгол даргалагч П.Сайнзориг - За баярлалаа. Дараагийн мэдээллийг Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд хэвтэн эмчлүүлэгчдэд болон байнгын асруулагчийн эрхийн хэрэгжилтийн талаарх Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Очирбат мэдээллийг өгнө. Таныг индэрт урьж байна.

Цаг барихыг хүсэж байна. Мэдээллийг агуулгын хүрээнд болон сэдвийн хүрээнд өгөхөд анхаарна уу. Цагийг нь тавиад өгөөрэй.

Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Очирбат - Эрхэм хүндэт Улсын Их Хурлын гишүүд ээ, сонсголд оролцож байгаа оролцогчидоо та бүхэндээ энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж үйлчилгээг авах эрхтэй гэж заасан байдаг. Энэхүү эрхийг хангах хүрээнд сэтгэцийн эмгэгтэй иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээг Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуулийн гол суурь болгон зохицуулж байна. Тус хууль нь хүн амын сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, дэмжих, сэтгэцийн эмгэгийн урьдчилан сэргийлэх талаар төрөөс баримтлах бодлого, зарчмыг тодорхойлж, сэтгэцийн эмгэгтэй хүний эрхийг хамгаалах, нийгэм, эдийн засгийн харилцаанд оролцох бие даасан байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх

сэтгэл зүйн тусламж авах нөхцөлийг хангахад иргэн, хуулийн этгээдийн хүлээх үүрэг, сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлдэг байгууллага, эмнэлгийн мэргэжилтний үйл ажиллагааны эрх зүйн үндсэн үндсийг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулж байдаг юм.

Хуулийн хэрэгжилтийн хүрээнд Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв нь өнөөгийн байдлаар 487 ажилтантай, 570 хэвтүүлэх, эмчлэх ортой, 18 амбулаторийн кабинеттай тусламж үйлчилгээ үзүүлж, жилд дунджаар 80 мянга гаруй сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүргэж байна.

Энэхүү сонсголд Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд урт хугацаанд хэвтэн эмчлүүлж тусламж үйлчилгээ авч байгаа сэтгэцийн архаг өвчтэй, байнгын асруулагчид болон шүүхийн шийдвэрээр эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээтэй өвчтөний эрх, эрхийн хэрэгжилт, тулгамдаж байгаа 2 асуудлаар голчлон танилцуулга хийе.

Эхний асуудал урт хугацааны тусламж үйлчилгээ шаардлагатай сэтгэцийн архаг өвчтэй байнгын асруулагчид үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тус төвд сэтгэцийн архаг өвчний улмаас удаан хугацаагаар байнга байрлан асрамжийн болон хэвтүүлэн эмчлэх үйлчилгээг нийтдээ 1-36 жил таслалгүй авч байгаа 244 өвчтөн байна. Хүйсийн хувьд 49,5 нь эмэгтэй байна. Насны хувьд 0-8 насны хүүхэд 0,8%, 18 насны хүүхэд 89,3%, 18-60 насны өвчтөн үлдсэн 9,8%-ийг, 60-аас дээш насны өвчтөн хамрагдаж байна. Сэтгэцийн эмэгтэй урт хугацааны тусламж үйлчилгээ үзүүлж байгаа тасгийн ор нь тус эмнэлгийн нийт орны 42,8%-ийг, эмнэлгийн нийт төсвийн 24%-ийг эзэлж байгаа. Тус эмнэлэгт хэвтэн эмчлүүлж байгаа эдгээр өвчтөний эм, эмчилгээний зардлыг 2021 онд нэг үйлчлүүлэгчид ноогдох зардлыг 17,5 сая төгрөгөөр, 2022-2023 онд 18,2 сая төгрөгөөр, 2024 оны 1 дүгээр сараас 22 сая төгрөгөөр тооцож зөвхөн энэ эф 99 оноштой буюу 244 хүндээ 5,2 тэрбум төгрөгийг улсын төсвөөс эмнэлэгтээ шууд олгож байна.

Сэтгэцийн эмэгтэй урт хугацааны тусламж үйлчилгээ шаардлагатай өвчтөнд үзүүлэх нийгмийн халамж үйлчилгээг Нийгмийн халамжийн тухай хуулиар зохицуулж байдаг. Тус хуулиар хөгжлийн бэрхшээлтэй иргэн байнгын асаргаа шаардлагатай иргэнд үзүүлэх нийгмийн халамжийг тусгайлсан үйлчилгээ хэмээн заасан байдаг.

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв нь удаан хугацаагаар байршиж байгаа сэтгэцийн архаг өвчтэй хүмүүст төрөлжсөн асрамжийн үйлчилгээг дан ганц эрүүл мэндийн тусламж үйлчилгээ хэлбэрээр үзүүлсээр өнөөдрийг хүрсэн. Энэ нь тус хуульд заасан хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлэх хувцас, соёл, ахуй, сэтгэл зүй, боловсролын үйлчилгээ нь эмнэлэгт хэвтүүлснээрээ орхигдож байгааг хэлмээр байна.

Цаашид урт хугацааны тусламж үйлчилгээ шаардлагатай сэтгэцийн архаг өвчтэй иргэдэд эрүүл мэндийн, нийгмийн халамжийн тусгайлсан үйлчилгээг Дэлхийн Эрүүл мэндийн байгууллагаас улс орнуудад зөвлөж байгаа. Нийгэм хамт олонд нь тулгуурласан сэтгэц, нийгмийн сэргээн засах тусламж үйлчилгээ хэлбэрээр зохион байгуулж салбар хоорондын хамтын ажиллагааны хүрээнд шийдвэрлэх шаардлага байна гэдгийг хэлмээр байна. Мөн эдгээр үйлчлүүлэгч, нийгмийн байнгын асруулагчид Нийгмийн халамжийн тухай хуульд заасан байнгын асаргаа шаардлагатай иргэний нийгмийн халамжийн тэтгэмж, нийгмийн халамж, тэтгэврийг авах боломжийг бүрдүүлж өгөх хэрэгтэй байна.

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд 2024 оны эхний 10 сарын байдлаар хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаагаа тогтоолгон тус эмнэлэгт хэвтэн

эмчлүүлж байгаа архаг явцтай сэтгэцийн эмгэгтэй өвчтөнүүдийн 8,1 хувь нь энэхүү тэтгэмжээ өөрөө захиран зарцуулдаг, 41,3% нь тухайн өвчтөний ар гэр захиран зарцуулдаг, 26,2% нь тус эмнэлгийн нийгмийн ажилтнаар дамжуулан өвчтөн өөрөө зарцуулдаг ийм судалгаа байгаа юм. Гэсэн хэдий ч 6 үйлчлүүлэгч ямар нэгэн бичиг баримтгүй регистрийн дугаар олгогдоогүй зэрэг шалтгаанаар тэтгэмжээ авах боломжгүй байдалд хүрээд байгаа юм. Энэ талаар Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн шүүхэд удаа дараа хандаж нас хүйсийг тодорхойлуулан Улсын бүртгэлийн ерөнхий газарт хандан регистрийн дугаар авч бүртгэлжүүлэх ажлыг зохион байгуулсан боловч асран хамгаалагч нь байгууллага бус иргэн байх ёстой гэдэг шалтгаанаар энэ тайлбарт нэлээн хэдэн удаа татгалзсан байдаг.

Иймд өнөөгийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль эрх зүйн орчин улам боловсронгуй болгох, эдгээр иргэдийн бүртгэлжүүлэх асуудлын талаар даруй шийдвэрлэх шаардлагатай байгаа юм.

2 дахь асуудлын хүрээнд шүүхийн шийдвэрээр эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээтэй өвчтөнд үзүүлэх нийгмийн тусламжийн талаар Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв шүүх сэтгэцийн эмгэг судлалын клиник ажиллаж байгаа бөгөөд нийтдээ 37 ортойгоор үйл ажиллагаагаа явуулдаг. Өнөөгийн байдлаар тус тасагт 33 өвчтөн эмчлэгдэж байгаагийн 7 өвчтөн тус төвд 10-22 жилийн турш байсан байна. Өнөөгийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Эрүүгийн хуулийн 7 дугаар зүйлийн 7.4.1 дэх хэсгээр зохицуулсан гэмт хэрэг үйлдэх үедээ хэрэг хариуцах чадваргүй байсан, гэмт хэрэг үйлдсэний дараа хэрэг хариуцах чадваргүй болсон нөхцөлд шүүхээс эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг авч хэрэгжүүлнэ гэж заасан байдаг.

Тус хуулиар гэмт хэрэгт үйлдсэн этгээдэд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авах, албадан эмчилгээ хийх, шүүхийн шийдвэрт эмчилгээний дэглэм хугацааг тогтоосон нь шүүхийн тогтоол гаргаж байгаа нь эмчийн эмчлэх оношлох эрхтэй зөрчилдөж байгаагийн зэрэгцээ тогтоолдоо эрүүл мэндийн байгууллагын нэр, тухайн байгууллагын тасаг, эмчилгээний хугацааг зааж ирүүлж байгаа нь сэтгэцийн эмэгтэй буюу оюуны хомсдолтой эмчлүүлэгч үйлчлүүлэгч эрх зүйн чадамжгүй иргэдийн талаарх олон улсын гэрээ Үндсэн хуулиар олгогдсон бусад хууль эрх ашигийг зөрчигдөж, хөндөгдөж байна.

Анагаах ухааны практикт эмч өвчтөнөө оношлох эмчлэх хугацааг тухайн өвчтөний өвчний явц, тавилан, эмчилгээний тактик, үр дүн зэргээс хамаарч тухайн үед нь шийдвэрлэдэг учир тогтоолд тухайн асуудлыг тусгаж байгаа тул асуудлыг эргэж харах шаардлагатай байна. Мөн Эрүүгийн хуулийн 7 дугаар зүйлийн 7.4.8 дахь хэсэгт заасан эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг сунгах, өөрчлөх, зогсоох эсэхийг шинжээчийн дүгнэлтийг үндэслэн шүүх шийдвэрлэж өгдөг. Тус тасагт нийт 9 өвчтөн эмчлэгдэн өвчтөний сэтгэцийн байдал тогтворжиж байгаа, засагдаж сайжралын байдалд орсон. Цаашид уг албадлагын арга хэмжээг хэрэглэх шаардлагагүй гэсэн прокурорын дүгнэлтийг гарсан байдаг. Гэвч асран хамгаалагч харгалзан дэмжих хүнгүй, эсвэл ар гэрээс нь авахаас татгалзсаны улмаас шүүх шийдвэрлэх боломжгүй нөхцөл байдал тус эмнэлэгт байсаар байна. Өөрөөр хэлбэл, эдгээр хүмүүсийг цаашид хэний харьяалалд авах вэ гэдэг асуудал тодорхойгүй хэвээр байна.

Эрхэм хүндэт Улсын Их Хурлын гишүүд ээ! Сонсгол даргалагч, сонсголд оролцогчидоо Монгол Улсад хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой сэтгэцийн эмгэгтэй өвчтөнүүдийн тусламж үйлчилгээнд тулгамдаж байгаа асуудлын талаар товч танилцууллаа. Эдгээр иргэд Үндсэн хуулиар олгогдсон эрүүл, аюулгүй орчинд амьдрах, эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж, үйлчилгээ авах эрхийг

хангахад өнөөдрийн сонсголын ач холбогдол очно гэдэгт итгэлтэй байна. Илтгэл танилцуулгыг хийж дууслаа. Баярлалаа та бүхэнд.

Сонсгол даргалагч П.Сайнзориг - За баярлалаа. Төрийн байгууллагуудын зүгээс өгөх дүгнэлт, мэдээлэл үүгээр өндөрлөж байгаа. Одоогийн байдлаар 40 хүн, сонсголд оролцогчдоос үг хэлж, өөрийн дуу хоолойг хүргэхээр нэр ирсэн байна. Хөтөлбөрт заасны дагуу үндсэн арга хэмжээ рүүгээ оръё.

Та бүгдэд дэгийг дахин сануулж мэдээлэл өгөх нь зүйтэй байх гэж бодож байна. Монгол Улсын Их Хурлын дэгийн тухай хуульд заасны дагуу та бүгд бусдыг ямар нэгэн байдлаар доромжлох, ялгаварлан гадуурхалт гаргах үг хэлэхгүй байхыг сануулж байна.

2 дугаарт сэдвийн хүрээнд ярья. Өнөөдөр эрүү шүүлт тулгах болон хүнтэй хүмүүнлэг бус харьцах эрхийн хэрэгжилтийн асуудлаар ярьж байгаа гэдэг зүйлийг сонсголд оролцогч хүмүүс, иргэд анхаараасай гэж хүсэж байна. Сэдвийн хүрээнээс хальсан асуудал байвал микрофоныг хаах болно гэдэг зүйлийг урьдчилаад хэлэх нь зүйтэй байх.

Үдээс өмнөх хуралдааны үед Бат-Ялалтаар эхэлчихье гээд хэлсэн байгаа. Иргэн Бат-Ялалтад хүндэтгэн үзэх шалтгаан, үдээс хойш ажилтай юм байна. Энийг нь хэдүүлээ ойлгоод ингээд явчихъя.

Ирсэн нэрсийн дарааллаар үг хэлүүлээд явъя. Дараагийн хүн Мөнхбаярын Хувцагаан гээд, өмгөөлөгч Хувцагаан гуай байх шиг байна. Манайхан нэг микрофоныг султгаад байгаа юу? Дараагийн хүн бэлдэж байгаарай. Цаг явж эхэлье. 3 минутаар мэдээллээ багтаан танилцуулаарай. Шаардлагатай бол би 1-2 минутыг сунгаж өгнө. Бат-Ялалт танд микрофоныг нээж өгье.

Иргэн Бат-Ялалт - 3 минутад үг хэлэх боломж олгосон та бүхэнд баярлалаа. Өнөөдрийн энэ арга хэмжээг зохион байгуулж байгаа, нээлттэй сонсгол зохион байгуулж байгаа та бүхэнд баярлалаа. Өнөөдөр 2 төрлийн хурал болоод байна уу гэж ажиглагдаж байна.

1 дүгээрт нь Хууль зүйн байнгын хорооны өргөтгөсөн хурал юм шиг байна, ирц тоолоод байна. Нийтийн сонсголын тухай хуульд энэ тухай байхгүй байгаад байгаа байхгүй юу. Тэгэхлээр энэ нийтийн сонсгол зохион байгуулаад байгаа юм уу? Хууль зүйн байнгын хорооны хуралдаанд байгаа юм болов уу гээд гайхаад сууж байна. 1 дүгээр асуудал.

2 дугаарт нь эрүүдэн шүүлт тулгах гэдэг зүйлийг яриад байх юм. Эрүүгийн хуульд эрүү шүүлт тулгах гэмт хэрэг байгаа юм. Тэгэхлээр эрүүдэн шүүх, эрүү шүүлт тулгах гэдэг 2 чинь нэг зүйлийн тухай яриад байна уу? 2 зүйлийн тухай яриад байна уу гэдгийг эрүү шүүлтээ бид нар ойлгомоор байна. Эрүү шүүлт гэдэг хүний эрх, эрх чөлөөг хууль бусаар булааж авах хүчирхийллийг л хэлээд байгаа шүү дээ. Тэгээд энд өнөөдөр цэргийн тухай тэр сэтгэцийн өвчтэй хүний тухай ярих нь бол илүү энэ эрүү шүүлтийн тухай ойлгож шийдэл гарц шийдэл олоход нэлээн төөрөгдөл үүсгэхээр ийм сонсгол болж байна гэж би ойлгож байна. Эрүү шүүлттэйгээ тойроод яримаар эрүү шүүлт гэдэг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг зөрчсөн төрийн тусгай субъектүүдийн тухай асуудал байгаа байхгүй юу.

Тэгэхлээр энэ дээр би 4 бодитой санал тавьж байгаа юм Улсын Их Хурлын гишүүд оролцож байгаад би их баяртай байна. Эрүү шүүлтийг таслан зогсоох маш

амархан. Хүсэх юм бол маш амархан байхгүй юу. Төрийн албан хаагчид өөрсдөө хуулиа ягштал мөрдөөд явчихдаг бол энэ ерөөсөө эрүү шүүлтийн тухай бид нар ингэж цаг зав зарцуулах ямар ч шаардлагагүй.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль дээр энэ хуулийг хэрэг үйлдсэн мөрдөн байцаагч, прокурор, шүүх чанд сахина гэсэн заалт байгаа шүү дээ. Гэтэл өнөөдөр хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч чанд сахидаггүй хүний асуудал, хувь заяагаар бизнес хийдэг энэ асуудал нь хэрээс хэтэрсэн учраас энд олон хүмүүс гомдол гаргаад ирж байна. Эрүү шүүлт юунаас эхэлдэг юм гэхлээр жижигхэн юмнаас эхэлнэ.

Зарлан дуудах хуудас өгөхөөс, 5 дахь өдөр хүнийг цагдан хорихоос, гомдол гаргах эрхийг нь хязгаарлахаас эхэлж байгаа. Жишээлбэл, над дээр нэг жижигхэн хөнгөн гэмтэлтэй хэрэг дээр ингэж байгаа юм. Өнөөдөр сонсголд оролцоно гэнгүүт л шүүх хурал зарлаад зарлан дуудах хуудас өгч байгаа юм. Прокурорын байгууллагад гомдол гаргаж байгаа юм. Гомдол гаргахлаар би 5 удаа гомдол гаргасан байгаа байхгүй юу. Гэтэл 1 ч хариу өгөхгүй байж байснаа нэг дугтуйнд 5 хүн хариу ирж байгаа юм. Энэ юуг доромжлоод байгаа юм. Тэгээд энэ чинь өөрөө манай прокурорууд, шүүгч нар хуулиа зөрчих замаар үйлддэг гэмт хэрэг учраас энэ гэмт хэргийн эргэн тойрон...

Сонсгол даргалагч П.Сайнзориг - нэг минут нэмээд өгчихье.

Иргэн Бат-Ялалт – Би 4 саналтай ирсэн юм.

1 дүгээрт нь эрүү шүүлт гэдэг эрүүгийн байцаан шийтгэх, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой зөрчсөн үйлдэлтэй холбоотой учраас хүн өөрийнхөө эрүү шүүлтэд өртсөн тухайгаа гомдол гаргах эрхийг нээж өгөөч. Хүний эрхийн Үндэсний комиссын тухай хуулийн 22 дугаар зүйлийг Улсын Их Хурлын гишүүдээ өөрчилж өгөөч. Эрүү шүүлттэй тэмцэнэ гэдэг чинь эрүүдэн шүүгээд байгаа хүмүүсийн тухай гомдлыг л хүлээж авах тухай асуудал. Гэтэл эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой гомдлыг Хүний эрхийн Үндэсний комисс хүлээж авахгүй гээд заачихсан байгаа байхгүй юу. Тэгсэн мөртлөө 2 бүлэг эрүү шүүлтээс урьдчилан сэргийлнэ гээд заачихсан. Тэгэхлээр Хүний эрхийн үндэсний комисс бусад байгууллагуудад хүний эрх зөрчсөн, байцаан шийтгэх ажиллагаа зөрчсөн гомдлыг хүлээж авах боломжийг хуульчилж өгөөч гэж нэг санал байгаа юм.

2 дугаар санал нь хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулдаг байгууллагууд, Цагдаагийн байгууллагыг бие дааж шийдвэр гаргадаг болгоод, прокурорын байгууллага зөвхөн хяналт тавимаар байна. Өнөөдөр прокурорын байгууллага хяналт тавих биш шийдвэр гаргагч болчихсон нь Үндсэн хуулийн зөрчил шүү. Үндсэн хуулийн 56 дугаар зүйл дээр прокурорын байгууллага ...

Сонсгол даргалагч П.Сайнзориг - Шинэбаяр оролцогчид би дахин санууллаа. Та дахиж энэ чанга дуугаар хурлыг үймүүлэх юм бол дараагийн удаа би танхимаас гаргана. Танд сануулга өглөө. Та бусад хүмүүст хүндэтгэлтэй хандаад би энэ хурлаа удирдаад явуулчихъя. Би танд санууллаа манай бусад оролцогчид бие биедээ хүндэтгэлтэй хандъя. Бат-Ялалт аа өөрөө нэг минут гэхээр нэг минутаар тавьсан, нэг минут өгчихье эндээ дуусгаад юмаа хэлээдэх үү?

Иргэн Бат-Ялалт - За баярлалаа. Уучлаарай. 2 дахь санал бол хэрэг бүртгэх байгууллага, мөрдөн байцаах байгууллага, прокурорын хяналт 2-ыг хуульд нийцүүлж өөрчлөхгүй бол болохгүй байна.

3 дугаарт нь өмгөөлөх эрхийг чөлөөлмөөр байна. Хүн хүссэн хүнээрээ өмгөөллийн хууль зүйн туслалцаа авмаар байна шүү дээ. Зөвхөн хууль зүйн туслалцаа гэхгүй тусгай мэргэжлийн эмч хүнээс, эдийн засагч хүнээс туслалцаа авдаг боломжийг хуульчилж өгөх. Хуучин хуульд байсан тэр сайн зүйлүүдийг сэргээх шаардлагатай байна.

4 дүгээрт нь шүүх бүрэлдэхүүнд ард түмний төлөөллийг оролцуулдаг болох гэсэн ийм үндсэн 4 санал байгаа юм. Тэгээд энэ саналаа бичгээр хэвлээд, аваад ирсэн учраас Та бүхэнд тараагаад өгчихье. За баярлалаа.

Сонсгол даргалагч П.Сайнзориг - Ямар ч байсан дараагийн хүн микрофон дээр сууж байя. Хувцагаан өмгөөлөгч.

Бат-Ялалтын үгэн дээр нэг зүйл байна. Эрүүдэн шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандах асуудлыг зөвхөн хууль сахиулах байгууллагын хүрээнд авч үзээд байгаа юм. Бид нэгдэн орсон конвенцын агуулгын хүрээнд хүнтэй хүнлэг бус эрүү шүүлт тулгах нөхцөл байдал бүрдэж болох тэр байгууллагууддаа авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээг бүрэн сонсох ёстой юм. Бүрэн мэдээлэлтэй байж хэдүүлээ бүрэн шийдэл ярина. Түүнээс биш тал мэдээлэлтэй байж энэ асуудалд өнгөц хандах болчихоод байгаа юм.

2 дугаарт энэ сонсголын хүрээ хязгаар буюу сэдвийг санаачлагчид гишүүд гаргадаг гэдгийг би энэ дээр тайлбар хүргэе. Санаачлагч гишүүдээс гаргасан эрүүдэн шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий, хандахаас ангид байх эрхийн асуудлын хүрээнд өнөөдөр явж байгаа. Тийм ч учраас Батлан хамгалах яам, Гэр бүл, нийгэм хамгаалал, хөдөлмөрийн яам болон шаардлагатай бусад институцийн мэдээллийг сонсож байгаа гэдэг зүйлийг би тодотгон хэлье.

За микрофон танд нээлттэй байна. Та сууж байгаад ярьж болно. 2 дугаар микрофон, 2 номерын микрофоныг цаг хэмнэх үүднээс султгачихья. Микрофоноо асаагаарай.

Иргэн Хувьцагаан - Би өмгөөлөгчөөр 45 жил, улсад нийтдээ 58 жил хөдөлмөрлөсөн. Өнөөдрийн энэ сонсголд оролцож байгаа та бүхэнд бүгдэд нь энэ сайхан өдрийн мэндийг хүргэе. Хэлэлцэж байгаа асуудлын хувьд дүгнэлт хэлэхэд бол цаг үеэ олсон амин чухал Хүний эрх эрх чөлөөний тухай асуудлыг хөндөж ярьж байгаад өмгөөлөгч хүнийхээ хувьд талархалтай байна.

Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын конвенц зэрэг эрх зүйн актуудаар хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулах талаар багагүй ажлыг хийсэн гэж би төр засгийн бодлогыг дэмжиж явдаг хүний хувьд бодож байна. Өнөөдрийн сэдэв бол товчхондоо мэдээлэл, сонсгол, дүгнэлтүүд дээр онолын үүднээс нэлээн шинжлэх ухааны үүднээс үндэстэй тайлбарлаад ярьчихлаа. Зарим хүмүүс энийг ойлгохгүй байж болзошгүй. Би хэнд ч ойлгомжтой энгийнээр тайлбарлая гэж бодож байна.

Хамгийн энгийн ойлголтоор хэн нэгэн хүнд хэрэг хүлээлгэх нотлох баримтыг өөрөөр нь гаргуулан авах, гэм буруутай гэдгийг нь хүлээн зөвшөөрүүлэх, түүнийг нь өөрийнх нь эсрэг ашиглах, ял хариуцлага хүлээлгэх гэсэн агуулгыг илэрхийлдэг. Энэ агуулгыг илэрхийлэхдээ янз бүрийн арга хэрэгсэл хэрэглэдэг.

Би 45 жил өмгөөлөгчөөр ажиллахдаа миний ажилласан 45 жилийн 3/1 болох 15 жилийн хугацаанд би нэг хүний хэргийг өмгөөлсөн. 15 жилийн турш миний үйлчлүүлэгчийг сэтгэл санаа, эдийн засаг, эрүүл мэнд, ар гэрийн ахуй амьдрал, биеийн хүчний хувьд дарамталж хилсээр хэрэг хүлээлгэж тэрний үндсэн дээрээс

үйлчлүүлэгч хилс хэргийг хүлээж мэдүүлэг өгснөөрөө 25 жилийн цаазын ял сонссон. 25 жилийн ял авч улмаар уйгагүй хөөцөлдөж явсны үр дүнд хүн цагаадсан ч гэсэн би өмгөөлөгчийнхөө хувьд үйлчлүүлэгчээ их зовсон, шаналсныг хүртэл миний сэтгэлээс гардаггүй, байнгын унах гунигтай, сэтгэлийн дарамттай явдаг.

Ингээд энэ дээр юу анхаарах ёстой юм бэ гэхээр, би хэдхэн зүйлийг энэ халуун тогоонд чанагдаж байгаагийнхаа хувьд, өмгөөлөгч хүн гэдэг Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар Эрүүгийн байцаан шийтгэх хууль болон бусад хуулиудад зааснаар эрх зөрчигдсөн, эрхийн зөрчилтэй иргэн хүнд эрх зүйн туслалцаа үзүүлэх үүрэгтэй, эрхтэй, үүрэгтэй. Энэ үүргээ биелүүлэх явцад эрүүдэн шүүлт тулгах гэдэг тодорхой субъектүүдийн дунд болж байгаа шүү дээ.

Ерөөсөө мөрдөгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх ийм хүмүүсүүдийн дунд...

Сонсгол даргалагч П.Сайнзориг - Таны цаг дуусчихаад байдаг хэлэх зүйл дүгнэж хэлж чадаагүй байх шиг байна. Надад 2 минутын боломж байгаа, 2 минутад багтаагаад та хэлэх гэсэн санаа, дэвшүүлж байгаа асуудлаа хэлэхийг хүсье. За 2 минут нэмж өгье.

Иргэн Хувьцагаан - Тэгэхээр 1 дүгээрт хүнийг хилсээр шийтгэсний үр дагавар нь юу гардаг юм бэ гэхтэйгээ зэрэг тэр хүний болоод тэр хүний гэр бүлд хэзээ ч, юугаар ч нөхөшгүй улс төрөөс ямар нөхөн олговор олгоод ч засахгүй ийм нийгмийн хор уршиг учирдаг юм.

2 дугаарт. Энэ цаг хугацаа бага байгаа учраас. Хүн нэг талаас байгалийн амьтан нөгөө талаасаа нийгмийн амьтан. Хүнийг байгалийн амьтнаас нийгмийн амьтан болгон хөгжүүлэх явцад ёс суртахууны боловсрол гэдэг юм чухал байдаг юм байна. Тэгэхээр энэ боловсролыг хүүхэд эхийн хэвлийд байхаас эхлүүлээд төрсөн цаг мөчөөс насанд нь тохирсон боловсролыг олгох, ингэсний үндсэн дээрээс хүн, хүн шиг хүн болж тэр хүн үнэтэй цэнтэй хүн болж улс орон, нийгэмдээ их зүйлийг хийж чаддаг юм байна гэдгийг би цөөн үгээр хэлэх байна. Тэгээд хамгийн гол нь сая манай Бат-Ялалт өмгөөлөгч хэлсэн.

Манай Бат-Ялалт чинь олон төрлийн ажил хийсэн л дээ. Хамгийн гол нь энэ ажлыг чинь хүн л хүнийгээ хэлмэгдүүлж болохоос биш, ямар амьтан ирээд хүнийг хэлмэгдүүлээгүй шүү дээ. Тийм учраас л хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх энэ субъектүүд өөрсдөө хүн шиг хүн чанар гаргаж, ёс суртахуунтай, хүнийг энэрдэг, хайрладаг, ичдэг, зовдог, үйл ажиллагаандаа нягт нямбай ханддаг, гаргасан үйл ажиллагааны үр дүн нь нийгэмд ашигтай тустай ийм үйл ажиллагаа хийх ёстой гэж боддог.

Ил тод байдал дээр би ганцхан л зүйл хэлж байна. Ил тод байдал бол байх ёстой. Гэхдээ ил тод байдал гэдэг бол хоёрдмол утгатай.

1 дүгээрт байгаа юмыг ил тод болгож байна гэж зарлаж байгаа боловч нөгөө талаараа ил тод байдлыг буруугаар ашиглаж байна.

Сонсгол даргалагч П.Сайнзориг - За баярлалаа. Ингээд таныг саналаа хэлсэнд баярлалаа. Чухал асуудлуудыг хөндөж байна. Эрүүдэн шүүх, хүнтэй хүнлэг бус харьцах харьцаанаас үүсэж байгаа нийгмийн хор уршиг эргээд хэзээ ч нөхөж баршгүй маш олон хохирол, хор уршгууд учирч байгаа гэдэг зүйл байна. Хүнтэйгээ ажиллах ёстой. Хүнээ соён гэгээрүүлж хандлагаа өөрчлөх ёстой гэдэг зүйлээс эхлээд чухал санаанууд дэвшүүлж байна.

Дараагийн хүн Лхамсүрэнгийн Нямзундуй гэдэг хүн байна. Та микрофон дээр

сууж байна уу? 2 номерын микрофон дээр очиж суугаад байр сууриа хэлье. Дараагийн хүн Оюундэлгэр гэж хүн мөн үү? зөв байна. 2 номер болон 7 номерын микрофоныг хэдүүлээ султгачихъя.

Нямзундуй гуай үг хэлж байхад дараагийн хүн Оюундэлгэр гуай ирээд суудалдаа суучихсан байя. Ийм зохион байгуулалтаар явчихъя. Ингээд Нямзундуй Та байр сууриа хэлнэ үү?

Иргэн Л.Нямзундуй - Өмгөөлөгч асан, Хууль зүйн ухааны магистр Нямзундуй та бүхэнтэй мэндчилж байна. Тэгэхлээр агуу бүхэн энгийнээс эхэлдэг болохоор эрүүдэн шүүлтээс ангид байх, хүний эрхийг хэрэгжүүлэхэд юуны өмнө төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг нь хуулийн дагуу шийдэх асуудалд онцгой анхаарах ёстой, эндээс л бүх юм эхлэх ёстой. Хэрвээ ингэж чадах юм бол эрүүдэн шүүлт чинь шат шатдаа дор дороо таслан зогсоогдох боломжтой юм. Тэгээд ч энэ Улсын Их Хурлын тухай хуульд Улсын Их Хурлын үндсэн зорилт ард түмний засаглах эрхийг хангахад оршино гээд заачихсан байгаа. Миний ойлгож байгаагаар ард түмэн засаглах эрхээ хэрэгжүүлж байгаагийн нэг тод илэрхийлэл нь өргөдөл гомдлоо хуулийн дагуу шийдүүлж чаддаг байх явдал юм. Ингэж чадвал засаглах эрхээ эдэлж байна гэж ингэж ойлгох ёстой гэж би үзэж байгаа юм. Өнөөдөр харамсалтай нь иргэд өргөдөл, гомдлоо хуулийн дагуу шийдүүлж, дийлэнх нь хуулийн дагуу шийдүүлж чадахгүй хад мөргөөд гацаж байгаа.

Тэгэхлээр илт хууль бусаар шийтгэл оногдуулах, хөндөгдсөн эрхийг нь хуулийн дагуу сэргээн эдлүүлэхгүй байх нь эрүүдэн шүүхээс ялгаа байхгүй. Тэгэхлээр хууль тогтоомжийн биелэлтийг шалгах үндсэн чиг үүрэгтэй нь холбогдуулаад би өөртөө тохиолдсон жишээнд үндэслэж Захиргааны хэргийн шүүх, Хууль зүй, дотоод хэргийн үе үеийн сайд нар Үндсэн хууль, Захиргааны ерөнхий хуулийн холбогдох заалтуудыг огт хэрэглэхгүй буюу мушгин гуйвуулж тайлбарлаж байгаад Улсын Их Хурлын анхаарлыг хандуулахыг хүсэж байна. Би өмгөөлөгч байсан. Хуулиар хүлээсэн үүргээ шударгаар биелүүлж, үйлчлүүлэгчийнхээ эрх, хууль, ёсны ашиг сонирхлыг хуульд үл харшлах бүхий л арга хэрэгслээр бүрэн тууштай хамгаалсныхаа төлөө товчхондоо эрүүдэн шүүлттэй тэмцсэнийхээ төлөө, шударга бусын хонгилоор орж хууль зүй, тухайн үеийн Дээд шүүхийн, Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн шүүгчийн захиалгаар илт хууль бусаар өмгөөллийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлөө хүчингүй болгуулсан.

Илт хууль бус гэдгийн учир нь юу байна гэхлээр,

1 дүгээрт хөөн хэлэлцэх хугацаа дуусчихсан байсан. 30 хоногийн дотор асуудал шийдэх ёстой байтал 68 хоногийн дараа шийдсэн.

2 дугаарт сахилгын шийтгэлийг давхардуулан оногдуулсан ийм үндэс байхгүй. Яагаад давхардуулсан бэ гэхээр тухайн тэр фактаар 7 хоног баривчлагдах шийтгэл хүлээгээд биеэр эдэлчихсэн байсан. Энэ 7 хоног баривчлагдах шийтгэл гэдэг хууль бус, өмгөөлөгчид хамаарахгүй заалтаар өмгөөлөгчийг ингэж шийтгэсэн. Яагаад гэвэл хамаарах заалт нь ердөө л 25 мянган төгрөгөөр торгох санкцтай байсан учраас. Заавал хууль бусаар өөр зүйлээр 7 хоног баривчлах шийтгэл надад оногдуулсан. Тэгэхлээр энэ бол хууль бус учраас Өмгөөлөгчдийн холбооны саналыг хүчингүй болгооч гэдэг асуудлыг Одбаяр сайдад тавьсан.

Сонсгол даргалагч П.Сайнзориг - За Танд нэг минут өгье.

Иргэн Л.Нямзундуй - Түүнээс хойш сайд солигдох болгонд л асуудал тавьдаг, ерөөсөө хүлээж авдаггүй, хуулийн дагуу шийддэггүй гэсэн үг. Тэгэхдээ жижүүрийн хариу өгдөг таны асуудлыг шүүх шийдчихсэн байна л гэдэг. Эсвэл та урьд нь энэ асуудлаар хандсан учраас дахиж хариу өгөх боломжгүй гэдэг ийм жижүүрийн хариу

өгдөг. Би өргөдөлдөө маш тодорхой бичдэг шүүхийн тушаал, шийдвэр хуульд нийцсэн эсэхийг хянаагүй. Зөвхөн хөөн хэлэлцэх хугацаа хэтэрсэн гээд буцаах үндэслэл тогтоогдож байхад хэрэгсэхгүй болгосон.

2 дугаарт төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан гомдол, мэдээллийг дахин хянах үндэслэлгүй, хянахгүй гэж байгаа. Тэгвэл Захиргааны ерөнхий хууль батлагдсан явдал, өргөдөл гомдлыг хуулийн дагуу шийдээгүй явдал дахин хянах үндэслэл мөн. Ингээд хянаач, тэгтэл Захиргааны ерөнхий хууль батлагдсанаар маш тодорхой заалт орсон.

Сонсгол даргалагч П.Сайнзориг – Баярлалаа. Хэдүүлээ олон оролцогч байгаа, бүгдийг нь оролцуулах үүднээс бие биедээ хүндэтгэлтэй хандъя. Аль болохоор сэдвийн хүрээнд ярья. Таны хэлж байгаа санааг ойлголоо. Хууль зүй, дотоод хэргийн сайд энэ удаагийн сонсгол дээр оролцож байна. Хууль зүй, дотоод хэргийн яам энэ чиг үүрэг мэдээж Хуульчдын холбоо, Өмгөөлөгчдийн холбоо руу шилжсэн байгаа учраас асуудлуудыг хуулийн байгууллага холбогдох байгууллагууддаа хандах нь зүйтэй байх гэж бодож байна. Дараагийн хүн Оюундэлгэр байна. Таны микрофоныг нээхэд бэлэн болсон байна нээж өгнө үү?

Иргэн Б.Оюундэлгэр - За сайн байна уу? Намайг Батмөнхийн Оюундэлгэр гэдэг. Өнөөдөр Монгол Уэрүү шүүлт гэж байна уу? Хонгил гэж байна уу? энийг бүр ард түмэн, хууль тогтоогч нарын хэмжээнд ийм зүйл байгаад байна. Газар аваад байна гээд бүр өнөөдөр ийм хэмжээнд хүрээд Улсын Их Хурлаас, Хууль зүйн байнгын хорооноос энэ сонсголыг ард түмнээ сонсохоор энд дуудаж авчирсанд маш их талархаж байна.

Миний бие нь Батмөнхийн Оюундэлгэр гэдэг, би 1999 оноос Гаалийн байгууллагад шалгагч, гаалийн улсын байцаагч, ахлах байцаагч, хэрэг бүртгэгч, хүний нөөцийн дарга, сургалтын төвийн даргаар ажиллаж байгаад 2015 онд Төрийн захиргаа, хамтын ажиллагааны газрын даргаар томилогдсон юм.

Тангарагтаа үнэнч ямар ч хууль бус үйлдэл, эс үйлдэхүй огт хийгээгүй байж байтал намайг гаалийн улсын 2 байцаагчийг шилжин ажилласан асуудалд 1 сая 500 мянган төгрөг авсан гэж яллахын тулд эрүүдэн шүүж 8 жил ажлаас минь түдгэлзүүлж, 8 жил хилийн хориг тавьж, тэр 8 жил хонгилд намайг түгжсэн гэж боддог.

Бүр 8 жил ингэж байлгаж байгаад торгуулийн ял оногдуулсан. Тэгээд энэ дээр би өнөөдөр эрүү шүүлт гэдэг юмыг нөгөө кэйсээр нь шууд ингээд яаж хүнийг эрүүдэн шүүдэг юм гээд намайг, надад 2015 оны 7 сард худал мэдээлэл Авлигатай тэмцэх газарт өгөгдөж ажиллагаа хийгдсэн юм байна лээ. Тэгээд энэ нь тогтоогдоогүй учраас хаагдчихсан. Тэгээд байж байтал 2015 оны 11 сарын 24-нд ээлжийн амралттай гэртээ байж байхад 2 хүн орж ирж ирээд Танаас тодруулах зүйл байна гэж авч очсон. Энэ очсон үеэс эхлээд би нөгөө эрүү шүүлтэд өртсөн.

Яагаад гэвэл эхлээд мэдүүлгээ би өгсөн. Ямар ч хууль бус үйлдэл хийгээгүй хэнээс ч авилга аваагүй гээд. Хүний эрхийн үндэсний комисс шүүхийн бүх дүгнэлтүүд нь байгаа учраас товчхон ярьчихъя. Тэгж байхад явуулахгүй серверийн өрөөнд хорьж байгаад 10 цаг хүртэл тэнд сэжигтнээр мэдүүлэг авчхаад явуулахгүй байсан. Үндсэн хуульд заагдчихсан баталгаатай эдлэх эрх хаана эдлэгдэх юм? Бид нарыг эрүүдэн шүүж байна, эрхийг минь хориглож байна, өмгөөлүүлэх эрхийг минь хангахгүй байна.

Тэгэнгүүтээ тэр хооронд тэр 2 комиссар надад хэрэг үүсгэсэн. Комиссарууд

надаас мэдүүлэг авах эрх нь байдаг юм уу? би хууль тогтоогч нар дунд сууж байгаа учраас энийг хэлээд явчихъя. Тэгээд бүр нөгөө хүмүүс чинь бичлэг хийж байна. Өөрсдөө дундуур нь бүтэн бичлэг нь байвал маш сайн. Гэтэл хэдэн үг хэлүүлж авчхаад тэр нь миний тэр бичлэгээр нь үгүйсгэгдэнэ. Тэгэнгүүт тэрүүгээр өнөөдөр хүнийг эрүүдэн шүүгээгүй гээд яллаад, энэ бичлэг чинь намайг эрүүдэн шүүсэн гээд бүр тогтоочоод байна шүү дээ. Миний нөгөө өмгөөлүүлэх эрхийг минь танилцуулж байгаа хууль ...

Сонсгол даргалагч П.Сайнзориг – Цаг нэмээд өгчихье. арай дуусаагүй байх шиг байна 2 минут нэмээд өгчхөөрэй.

Иргэн Б.Оюундэлгэр - Би нөгөө бодит жишээг нь хэлчихье. Энэний түрүүнд нөгөө 2019 оны 6 сард, 9 сард хэлэлцүүлэгт орж байсан юм. Прокурор Чинбат гуай энд байсан юм. Тэгэхлээр хүмүүсийг нөгөө эрүүдэн шүүчихээд яаж худлаа хариу хэлдэг юм. Би ерөөсөө энийг л хэлээд өгчихье. Энд нөгөө 2 удаа хэрэг бүртгэлтийн хэргийг хаах тухай гээд бүр энийг ингээд хүмүүсийг эрүүдэн шүүгээд шүүгээгүй гэж тогтоодог байхгүй юу. Хууль тогтоогч нараа ард түмэн энийг бид нар ингээд би бүр энэ жишээн дээр нь хэлээд өгчихье.

Энд ингээд намайг хар хэрэг бүртгэх хаасан гээд Чинбат прокуророо таныг ч хуурчхаж байгаа байх. Энэ хүмүүс чинь намайг хуурч байна таныг хуураад байна, худлаа юм өгөөд манай ажлын 2 хүнийг ингээд нэр нь байгаа намайг эрүүдэн шүүгээгүй гэдгийг бид нар бие биеийгээ тэнд байгааг мэдэхгүй шүү дээ. Нотолсон гэрч болгож оруулж ирээд байх шиг байгаа юм. Нөгөө мөрдөгч нь тэнд байсан комиссар энэ 2-ын мэдүүлэг, тэгэнгүүт дундуур нь тэр комиссеруудын хийсэн бичлэг. Тэр бичлэг дээр ерөөсөө намайг эрүүдэн шүүгдээгүй гээд тогтоочих байтал тэр бичлэгийг оруулж ирснээ, энэ нь ерөөсөө эвлүүлэгдээгүй байна ч гэнэ үү. Ингээд л болоо. Шалгасан баримт нь энэ.

Прокуророо таныг хуурчхаад байна шүү дээ. Намайг хуурсан шиг ерөөсөө ингээд л ийм сонин юмнуудаар бичээд өгчихдөг бүр хэрэг нь нотлогдохгүй хууль дээр бичсэн зүйл ангийг ингээд биччихдэг юм байна лээ. Өнөөдөр эрүүдэн шүүсэн бүх баримт нь хавтаст хэрэгтэй танилцахад байгаа. Энийг шүүх рүү явуулаач гэхлээр явуулж өгөхгүй, ерөөсөө л бүх газраа ингээд хуураад байгаа байхгүй юу. Энэ хууль журам гэдэг чинь юу юм бэ? Хүн хэрэгжүүлнэ шүү дээ. Бид нар хэрэгжүүлнэ. Тэнд байгаа хүмүүс чинь өнөөдөр сая ингээд 2019 оноос сайн эрчимжүүлээд бид нар ингээд эрүү шүүлтийг шалгасан гэж байна. Үгүй ээ тэгээд хувь хүн ингээд л яваад байна шүү дээ. Би 2019 онд хэлэлцүүлэгт орж байсан. Тэгэхэд өнөөдөр ингээд л би энийгээ тэр хэргийг нь ч гэсэн товчхон ярьчихъя. Ингээд л Дээд шүүх дээр хүртэл би очсон хүний эрхийг ерөөсөө зөрчиж болохгүй гээд буцаагаад явуулчихсан. Шүүх намайг эхлээд нөгөө гэмт хэрэг хийгээгүй, энэ хараа 4 удаа ...

Сонсгол даргалагч П.Сайнзориг - Цаг болсон байна. Байр сууриа хэлсэн танд баярлалаа. Ойлголоо дараагийн хүн Бадамзул гээд хүн байна. Та ойрхон микрофон дээр суугаарай. 2 дээр суучихсан юм байна. Бадамзулын дараа Даваасүрэн гэж хүн байгаа юм байна.

Иргэн Бадамзул - Өдрийн мэнд энэ боломжийг олгосон бүх гишүүддээ талархаж байна. Үнэхээр эрүүдэн шүүлт тулгаж хүнийг ингэж өгсөн өргөдөл, гомдол дээр нь бүр ингэж эргүүлж өөрийг нь юугаар холбогдогчоор торгож шийтгэдэг, хууль мэдэхгүй араас нь явах хүнгүй гэснийг нь ингэж хүлээж аваачаад л ингээд судлаад байж байдаг. Тэгээд араас нь явах хүнгүй, энэний араас хэн нь явах нь гээд л хүлээгээд байж байдаг. Тэгээд хууль мэддэг, хууль хэрэгжүүлдэг, хууль судалдаг хүмүүс хэргийг яллаад, наймаалцаад байж байдаг. Би 284 өргөдөл, гомдол өгсөн

байдаг. Тэрний хариу нь цагдаа нар агуулга нь өөрчлөөд, би хохирчихсон хохирогч хүн байгаа. Агуулгыг нь өөрчлөөд л прокурор луу явуулчихдаг, прокурортойгоо хуйвалдаад хэргийн араас хэн ирэх нь вэ гээд өвөрлөөд, түрийлээд л байж байдаг. Хоорондоо наймаалцаад. Тэгээд би энэ хэргийнхээ араас явахдаа цагдаа нарт зодуулж, тамлуулж, гэр оронд, үүдэнд ирж машинтай дагаж ирж араас мөргөдөг, хөөдөг, энэ цагдаа нар бүлэглээд бөөнөөрөө ингээд байж байдаг.

Тэгээд миний эрүүл амьд явах эрхэд хүртэл халдаад намайг цохиж зодоод янз бүрийн хэрэг төвөг хүлээлгэх гэж элдэв бусын юм асууж, тагнаж чагнаж, насанд хүрээгүй хүүхдүүдээс хүртэл мэдүүлэг авч, сургууль дээр нь хүртэл очиж нүцгэлж, сургууль цэцэрлэгийн орчинд нь хүртэл тэр хүүхдүүд дотор ичээж зовоож илт сургууль асран хамгаалагчгүй, хууль ёсны төлөөлөгчөөс нь зөвшөөрөл авахгүйгээр хүүхдүүдийг ингэж байцааж шалгаж янз бүрийн байдлаар манай гэр бүлд бүр санаатайгаар халдаж байгаа.

Гэрт орж ирээд бүтэн жилээр ус хаачихсан, тэгээд тэр асуудлаа явахаар барьж аваад зодоод, эс үгүй бол бүр өдөржин харанхуй өрөөнд оруулаад тамлаад, зодоод, зовоогоод тарчлаагаад байж байдаг.

Эрүүл мэндээрээ хохирчхоод эмнэлгээр явсан эрүүл мэндийн карт, эмчийн бичгүүд байж байна. Ингээд хохирчхоод байгаа юм.

Хүний эрхийн Үндэсний комисст хандахаар цагдаагийн асуудалд оролцохгүй гээд Ууганбаатар урдаас шууд няцаачихдаг. Олон улсын хүний эрхийн конвенцод уламжилж өгөөч? Би ингээд бүхэл бүтэн амьдралаараа, үр хүүхдээрээ хохирчхоод явж байгаа ээж хүн байгаа. Иргэн хүн байна. Иргэн хүн гээд гомдол гаргаад 284 гомдлыг шууд ураад хаячихдаг, миний нүдэн дээр ураад таслаад ...

Сонсгол даргалагч П.Сайнзориг - Байж байгаарай. 2 минут нэмээд өгчихье.

Иргэн Бадамзул - ахиад олон хүний гарын үсэгтэй бич, юу ч чиний өмнөөс бид нар ингэж гаргаж чадна шүү, бүх хүмүүсийг цуглуулж байгаад чиний эсрэг явуулж чадна шүү гээд дарамтлаад, сүрдүүлээд хэрэг хаачихдаг. Урдаас ураад хаячихдаг. Би бүхэл бүтэн 2010 оноос хойш тамлуулаад, тарчлаагаад намайг. Би бизнес хийдэг байсан хүн. Бизнесийг бүр хаачихсан, энэ дээр байгаа ингээд хандаж байна. Би өргөдлөөрөө энэ хүн нь 18 лангуу эзэмшдэг нь үнэн гэсэн бичиг байж байгаа. Лангуу савыг минь хураах, ажлыг минь хийлгэхгүй байх, бизнесийг минь хийлгэхгүй байх, хэн нэгнээр сайт, телевизээр гүтгүүлэх, доромжлуулах, санаатайгаар худал мэдээлэл олон нийтэд тараах юм байж байгаа?

Би 2018 онд олон улсын үзэсгэлэнд оролцоод явсан. Тэгээд энэ хятад хүнтэй суусан, хятад хүнтэй юу яасан гэж? Ингэж худал мэдээлэл тарааж, худал гүтгэлэг, доромжлол зовлонгоо даахгүй ингээд яая гээд явж байхад, өмнөөс өргөдөл, гомдлыг ураад тастаад хаячихдаг. Цагдаа нар барьж аваад нийлээд зоддог, чи дийлэхгүй чадахгүй гээд хүүхдийг аваад явчихсан. 6 сар би хүүхэдтэйгээ уулзаж чадахгүй байгаа.

Хаана байгаа нь мэдэгдэхгүй, хүүхэд минь амьд үгүйг ч мэдэхгүй. Ингээд хүний эрхийн байгууллага Ууганбаярт өргөдөл, гомдлоо гаргахаар цагдаагийн асуудалд оролцохгүй гээд тэр авч явсан цагдаа нь 42 дугаар хорооны байцаагч, манай оршин сууж байгаа хорооны байцаагч байгаа. Тэр хүн машинаараа ирээд сургуулийн орчинд ирээд намайг дагадаг, араас хөөдөг, эс үгүй бол байрны үүдэн дээр отоод цагдаа нар зогсоож байдаг. Тэгээд би бүр дарамтад ороод шахалт дарамт, эрүү шүүлтэд ороод аргаа бараад явж байгаа зовлонгоо даахгүй явж байгаа

хүн байна. Хүүхэд болохоор хохирчихсон.

Сонсгол даргалагч П.Сайнзориг - За ойлголоо, дэгээ барья. Дэгийн дагуу би танд 5 минут өгсөн байгаа. Та хэдийг сонсчихоод Улсын Их Хурлын гишүүдээс төрийн байгууллага болон оролцогчдоос лавлаж асуух боломжтой байж байгаа учраас өнөөдрийн сонсгол дээр үгээ хэлчихсэн юм чинь битгий гарч яваасай боломжтой бол танхимдаа сууж байгаарай. Тэгээд гишүүдээс лавлаж тодруулах байдлаар таныг нэмэлт мэдээлэл өгөх бололцоо байж болох юм гэдэг зүйлийг би энэ ташрамд хэлмээр байна.

Дараагийн хүн Даваасүрэн гуай. Даваасүрэн гуай шиг микрофоны ард байж байвал битгий босоорой манайхан цаг хэмнээд микрофонухоо ардаас ярьчих. 7 номерын микрофон дээр ирээд суугаарай гэж хэлмээр байна. Даваасүрэн Та саналаа хэлээрэй.

Иргэн Даваасүрэн - Бидний хэдэн улс саналаа нэгтгээд хэдэн залуучууд дээр дараах санал шаардлагыг тавьж байна. Энэ хүний эрхийн байгууллагыг Үндсэн хуулийн байгууллага болгоё. Ингэж байж л хүний эрх хангагдана. Энэ шүдгүй арслантай байгаад ерөөсөө нэмэр алга.

2 дугаарт нь Улсын Их Хурлын 318 хуулийн 800 гаран хүний эрхийн зөрчилтэй хууль баталж ингэж иргэдийн эрхээ зөрчсөн байна. Энэ хуулиа ирэх 12 сарын 10-наас өмнө хүчингүй болгож өгөө, энүүнд хариулт өгөөрэй. Энийгээ хүчингүй болгож бүгдийг нь нэг бүрчлэн хүчингүй болгож өгөөрэй.

Дараагийн зүйл нь Засгийн газар хүний эрх, авлигал, авлигачдын хөрөнгийг хууль бус хөрөнгийг хураана гээд үгүй. Тэр цацрагийн цөмийн энергийн хуулийг яаралтай хэлэлцэж байхаар энийг яаралтай хэлэлцэж өгөөч гэж ингэж хэлэх байна.

Дараад нь хаалтын гэрээний асуудал. Засгийн газар нь юм уу? хаанахын хаалтын гэрээ хийгээд ерөөсөө иргэний мэдэх эрх байхгүй. Нөгөө хэвлэлийн эрх чөлөө байхгүй. Энийг бүгдийг нь ил тод болгоод тэр хариуцдаг улсуудад нь хариуцлага тооцоод энийг хориглож өгөөч. Энэ чинь Америкийн Нэгдсэн Улс энэ Дээд шүүх болон олон улсад хориглочихсон байна лээ шүү дээ. Манайх яагаад ингэж яваад байна. Нөгөө талаар Цэц гэж нэг байгууллага байна. Ерөөсөө хүний эрхийн талаар өргөдөл өгөөд ерөөсөө шийддэггүй. Тэгээд маш их ёс суртахуун, ноцтой алдаа дутагдал, хариуцлага алддаг. Тэр Баясгалан, Одбаярыг огцруул шууд огцруул ийм шаардлага тавьж байна. Тэгээд нөгөө Эрүүгийн хууль гэж ингэж нэрлээд байгаа энэ давхаргын хуулийг Сайнзориг гишүүн, Тэмүүжин гишүүн та нар хүчингүй болгосон уу? Үгүй ээ, давхаргын хуульгүй, гэрч, хохирогчийг хамгаалах хуульгүй, өнөөдөр хүнийг эрүүдэнэ гээд яриад байгаа юм. Энийг хэзээ батлах вэ? энийгээ хэлж өг. Ийм шаардлага тавьж байна.

Нөгөө талаар Зоригийн хэрэг гээд л баахан ярьдаг энийг олон улсаар мөрдөн байцаалт олон улс руу шалгуулах биш бүр олон улсын хэд хэдэн багаар мөрдөн байцаалт энэ юуг нь шалгуулах. Тэгэхгүй бол энэ ерөөсөө бүх хүн шатандаа үүрлэчихсэн хуулийн мафид орчихсон ерөөсөө ингээд хэцүүхэн юм байна гэж ингэж үзэж байгаа юм. Нөгөө талаар энэ 2022 оноос авхуулаад ингээд хэлмэгдсэн өчнөөн улсуудад ганц сая төгрөг өгсөн. Энийг тэрбум төгрөг болго, тэр сая төгрөгийг нь хасаад эргүүлж өгөө. Жишээлбэл, 20, 30 ачтай хүнд ганц сая төгрөг л өгсөн шүү дээ.

Тэрийг тэрбум болго. Олон улсын жишгээр энэ чинь бараг 3 тэрбумаас доошгүй байдаг юм байна лээ шүү. Энэ нөхөн төлбөр өгөө гэдгийг ингэж хэлэх байна. Нөгөө талаар хамгийн их хууль зөрчдөг, хамгийн их эрүүддэг газар чинь 2022

оноос хойш Данзан бид нар өвөг дээдэс авхуулаад л ингээд хядаж ирсэн. Хууль зүй, дотоод хэргийн яам, Мөрдөн байцаах алба шорон шүү дээ. Энэ дээд зэргээр эрүүдэгч ийм байгууллагууд. Энэ байгууллагад бараг олон улсын шүүхэд шилжүүлж байж л тэр эрүүгийн шүүхэд шилжүүлж байж энийгээ шинэчлэх хэрэгтэй. Тэгэхгүй бол ерөөсөө шинэчлэгдэхгүй юм байна.

Сонсгол даргалагч П.Сайнзориг - За баярлалаа. Дараагийн хүн байж байгаарай. Шинэбаяр гуай та дэг барина шүү. Би дараагийн хүн гэж хэлээгүй байна. Манай энэ хурал зохион байгуулах залуучуудад миний даралт ихсээд байна гэсэн юм байна. Тэгээд та хэдийгээ ойлгоосой гэж хүсээд Шинэбаяр гээд хүнийг түрүүлээд хэлүүлчихье. Тэгээд үүний дараагаар Баярмаа та микрофоноо бэлдэж байгаарай гэж хүсэж байна. За ингээд 2 номерын микрофон.

Иргэн Шинэбаяр - Би анх 2020 оны 6 сард Хүний эрхийн комисст хандсан байдаг юм. Хүүхдийн байгууллага хүүхдийн эсрэг аймаар асар их хүчирхийлэл үйлдэж байна. 108-д хүүхдийг тамласан гээд ингээд хүний эрхийн комисс 2 жилийн дараа надад энэ Нэгдсэн Үндэсний Байгууллага нэгдэн орсон хүүхдийн эрхийн гэрээ конвенц контрактыг биелүүлээгүй хүлээсэн үүргээ биелүүлээгүй. Таны хүүхэд дээр хүний эрхийн зөрчил үүсгэсэн бичиг гаргаад өнөөдрийг болтол хүүхдийн байгууллага 2 жил миний ач хүү дээр ямар ч ажиллагаа хийгээгүй. Хүний эрхийн Үндэсний комиссыг үнэтэй байлгамаар байна. Хүний эрхийн зөрчлийн бичгийг хууль ёсны бичиг болгож харагдуулмаар байна. За энийг ингээд хардаггүй.

Энэнээс хойш намайг прокурорууд Шар хадны больницод хэвтүүлэх гэж үзсэн. Шар хадны больницод хэвтээгүй гээд пактын үүрэг даалгавар биелүүлээгүй гээд зөрчлийн хэрэг нээсэн, дараад нь намайг прокурорууд 3 удаа шүүхээр оруулж яллуулсан. Энэ гэмт хэрэгтнүүдийг илрүүлж хүүхдийн байгууллагынхан дээр арга хэмжээ ав гэснийхээ төлөө 3 удаа шүүхээр оруулж яллуулаад 2-ыг нь Монгол Улсын шүүх цайруулсан. Нэгэн дээр нь би 100 мянгын торгуультай гарсан. Би 650000-ын тэтгэвэр авдаг хүн би 100 мянгаа өгмөөргүй байна гээд Дээд шүүхэд нь гомдол гаргасан хэргээ цайруулъя би гэмт хэрэгтнүүдийг л илрүүлсэн гээд Цэлмэг гишүүнд удаа дараа хэргээ цайруулъя гэж өргөдөл өгсөн чинь Цэлмэг гишүүн хууль байхгүй гэсэн.

Миний өмнө ярьж байгаа Бат-Ялалт үнэн хэлсэн. Та нар хуулиа батал за юу? Би энэ прокуроруудад бүр үнэхээрийн гомдож байгаа. Төлөөлж ирсэн Чинбатад нь хэлье. Улсын Их Хурлын гишүүн Дэлгэрсайхан байж байж шүүхээр авч орох ёстой байдаг юм уу далд хүн төрийн бусын Ууганбаяр намайг 2 өрөө байр авсан мөнгө төгрөг хүүхдийн байгууллагаас авдаг, шантаажилдаг таны хэргийг шалгаж байгаа гээд ордны баруун талд яриад өнөөдөр тэр хүний хэрэг нь хөөн хэлэлцэх хугацаагаар дуусаж байна. Прокурорууд та нар хөөн хэлэлцэх хугацааг нь тооцож байх ёстой байхгүй юу Чинбат аа. Хөөн хэлэлцэх хугацаанд заавал Улсын Их Хурлын гишүүн байж байж энэ Ууганбаяртай шүүхээр ордог юм уу? Шударга хууль хаана ч алга. Би өөрөө бага боловсролтой хүн. Би 4 жилийн өмнө юу ч мэдэхгүй байсан. Иргэн Шинээ гээд 32 мянган дагагчтай пэйж хуудас ажиллуултлаа би энэ хүний эрхийн төлөө тэмцэж чадаж байгаа байхгүй юу.

Намайг ийм болтлоо хуультай нийгэмд, төр улстай тусгаар тогтносон улсад ийм болгож чадаж байна. Би энэ прокурор, төрийн байгууллагуудад маш их гомдож байгаа намайг нууцаар тагнаад цаана чинь байна нотлох баримтыг бүрдүүлж болохгүй ээ гээд Тагнуулын ерөнхий газар гомдол гаргахад Тагнуулын ерөнхий газраас надад хэлсэн. Шинэбаяр гуай энэ хэрэг, эрүүгийн хэрэг гээд тэр хэргийг хаасан. Шинэбаяр гуай та танилгүй мөнгөгүй юм чинь танигдах хүүхдийн байгууллага тагнаж чагнаж болно гээд 2021 онд хаасан. Харин Чинбат надад 2023

онд нотлох баримтыг хүүхдийн байгууллагын эргүү тэнэгүүд өөрсдөө гаргаж өгсөн учраас Чинбат хэргийг нээж өгөөд, нээгээд шалгасан ямар ч асуудал байхгүй хаагдсан. Би яахаараа нууцын зэрэглэлтэй юмаа хүүхдийн байгууллагад тагнуулж, чагнуулж өчнөөн олон хүн олшруулаад ямар кино тарааж байгаа юм уу? намайг өчнөөн байгууллагууд ...

Сонсгол даргалагч П.Сайнзориг - Шинэбаяр гуай микрофонд хэлж болно. Би танд хамгийн түрүүнд боломж олгосон. Тайван сууж байгаад үгээ дуусгачих байлаа. Таны минут дууссан. Дараагийн хүн Баярмаа. Дэг барья, Иргэн Шинэбаяр гуай Та дэгээ барина уу? Би танд өмнө нь нэг сануулсан байгаа. Дараагийн оролцогч Баярмаа, 18 номерын микрофоныг өгье.

Иргэн Баярмаа - Монгол Улсын иргэн 54 настай, Баярмаа би анх 1991-1994 онд төрийн прокурорын нэгж байгууллагад ажиллаж байхдаа захиргааны хэлмэгдэл буюу цаг үеийн хэлмэгдэлд хохирсныгоо 2023 онд “Шүүр” ажиллагаагаар мэдсэн байдаг юм. Би 30 жил Монгол Улсаас нэг ч гарч үзээгүй. Хэлмэгдлийнхээ тэр үр дагавраар би ингээд бүх насаараа эрүүдэн шүүлгээд шүүхгүйгээр яллуулаад явж байгаа. За ингээд энэ асуудлаа прокурор дээр тавихаар зэрэг янз бүрийн шалтаг шалтгаан хэлдэг. Би тэр “Шүүр” ажиллагаа дээр төв талбай дээр тэр төрийн өндөр албан тушаалтан нь авлига авсан хэрэг дээр Та нөгөө нэг талбай дээр би хоногоор 54 настай хүн суулт хийлгээд, суулт хийгээд нийгмийн гамшгийг нуруун дээрээ үүрээд, ингээд өтгөн шингэнээ гаргахад хүртэл би хүндрэлтэй байна. Би эрүүдэн шүүлгэсэн гэж өөрийгөө үзэж байгаа.

Яагаад гэвэл миний энэ бүх хэрэг Захиргааны шүүх дээр хандахаар энэ санкц миний 15 сарын турш өгөөгүй 500 мянган төгрөгийн юу? Төрийн прокурорын газарт би 3 сая 500 мянган төгрөгийн цалинг тийм албан хаагч хүнтэй өөрийнхөө эрх хэмжээг хэтрүүлж, ингэж миний нөгөө нэг захиргааны хэлмэгдлийг шүүхгүйгээр яллаж хийсэн. Ийм юм чинь дандаа эрүүгийн заалттай юм байна. Тэгээд би ингээд хууль зөрчсөн ажиллагааны тухай лавлагааг ерөөсөө надад өгөхгүй инээж, надаар ингээд тохуурхаж миний 30 жил Монгол Улсад тийм хүн байхгүй. 20 дугаар 100-нд би юу хүсэж байна гэвэл би нэр төрөө сэргээлгэмээр байна. Улсад би нарийн бичгийн даргынхаа ажлыг хийж чадаагүй. Эзэмшсэн мэргэжлээрээ би цорын ганц би 30 жилийн турш бүх юм нээгдчихсэн хүмүүс зах зээл гээд л бүх юм явж байхад би өөрийнхөө төрсөн эгч дүү 2-т 30 жил Монгол Улсаас гараад явсан энэ хүнд амьдралаас зугтаагаад явсан эгч, дүү 2 дээрээ очих эрх байдаггүй. Надад хэзээ ч тийм виз дарагддаггүй. Шалтгаан нь гэвэл би 30 сая төгрөгийн ийм хууль бус үйл ажиллагаанд хамтран оролцогчоор байгаа учраас, нотлох баримт нь байгаа учраас надад хэзээ ч ил гаргаж өгөхгүй байсан шүү.

Би тэр талбай дээр хэвтэж байж. Би энэ “Шүүр” ажиллагаанд өөрөө санаачилсан иргэдийн нэг шүү, нөгөө нэг шүгэл үлээгч иргэдийн хувьд цагдаагийн байгууллагаас гаргасан энэ шүгэл үлээгчийн энүүгээр өөрийгөө хамгаалуулаарай гээд тэр Ууганбаатар хэзээ ч миний юуг юу яадаггүй, манай ажиллагаа биш манайх биш гээд байдаг байхгүй юу. Тэгээд би энэ асуудлаараа би энэ манай прокурорын энэ тайлагна прокурорын үйл ажиллагааг тайлагнадаг газар чинь Улсын Их Хурлын юм байна шүү дээ. Тэгээд би энэ хүний эрхийн нөгөө Хууль зүйн байнгын хороо гээд байгаа энэ хорооны чинь хүний эрхийн сонсголд ингээд оролцож байна.

Сонсгол даргалагч П.Сайнзориг - Сэдвийн хүрээнд яриарай. Та болж өгвөл тодорхой ярихгүй бол гишүүд болон бусад хүмүүст жоохон ойлгомжгүй л байгаад байна. Ямар хэрэгт ороод яагаад тийм байдалтай байгаа. 2 минут нэмээд өгчихье.

Иргэн Баярмаа – Би бичгээс бичгийн хооронд яваад байна. Ингээд 2024 оны

11 сарын 11-нд хамгийн сүүлд өгсөн бичгүүд нь энэ бүх бичгүүдээ ингээд надад өгсөн бичгүүдээ тайлагнаад байгаа байхгүй юу. Жинхэнэ захиргааны хэлмэгдэл, би зүгээр төрийн байгууллагад ажлаас хоцорсоныхоо төлөө байгууллагын захиргааны арга хэмжээ авагдаж байсан. Тийм хүнийг төрийн байгууллагад захиргааны нарийн бичгийн даргаар ажилд аваагүй. Миний бүх нотлох баримт тэр нарийн бичгийн даргын хариуцлагатай нарийн бичгийн даргийн бүртгэлээс бүгдээс нь хасаад намайг ул мөргүй болгож Монгол Улсад тухайн үед би юу хийж байсан нь мэдэгдэхгүй болгож намайг ул мөргүй болгож эрүүдэн шүүсэн.

Би энэ дээрээ үнэн шударгаар миний ар өврөөр асуудлыг хэлэлцэх биш, надад үнэнийг тэр лавлагаа мэдээллээ өгөх ёстой гээд Засгийн газрын Хяналт хэрэгжилтэд танайхаар, энэ шүүр ажиллагаагаар би энэ нотлох баримтаа олж авсан юм гээд хандахаар зэрэг надад тэгж зөвлөгөө өгөөд байгаа. Энэ прокурорын газрын дээд байгууллага чинь Засгийн газрын хяналт хэрэгжилт ерөөсөө биш Улсын Их Хурлын юм байна. Тэгэхээр би хандах газраа зөв хандаад энд явж байгаа тэгээд та бүхэн ойлгохгүй зүйл байвал асуугаарай хангалттай хариулъя. Баярлалаа.

Сонсгол даргалагч П.Сайнзориг - За дараагийн хүн Бямбасүрэн гээд хүн байна. Батмөнхийн Бямбасүрэн байна. 19 номерын микрофоныг нээж өгнө үү?

Иргэн Б.Бямбасүрэн - Би Өвөрхангай аймгийн Арвайхээр сумаас ирсэн Батмөнхийн Бямбасүрэн гэж хүн байна. Тэгээд энэхүү сонсголыг зохион байгуулж санаачилсан Баярмаа гишүүн, түүний баг хамт олон, Бат-Амгалан гишүүн, Шижир гишүүн, Энхтүвшин гишүүн нартаа маш их баярлалаа. Тэгээд би энд яах гэж ирсэн бэ гэхлээр би хүүгийнхээ хэлмэгдээд нэг хэрэгт холбогдоод үүнээсээ болж хэлмэгдэж байгаа талаар.

Би энийг удаа дараа прокурорын байгууллага болон Дээд шүүхэд хандсан боловч намайг хэргийн оролцогч биш ээ гэдэг үндэслэлээр миний хүсэлт өргөдлийг хүлээж авдаггүй. Тэгээд энэ яасан бэ гэхээр 2018 онд Өвөрхангай аймгийн Бүрд сумын нутагт шүлхий өвчний постод гарч байсан 6 хүний нэг нь нас барж 4 гэрчтэй нэг хүний ийм хэрэг 6 хүний их хэрэг 4 жил гаран шийдэгдэхгүй дээд шатны шүүхээсээ 18 удаа эргэж буцаж, 18 удаагийн шүүх хурал болоод ингээд 2022 оны 9 сарын 28-ны өдөр Монгол улсын дээд шүүхийн хяналтын шатны эрүүгийн шүүх хуралдааны 130 дугаар тогтоолоор шийдэгдсэн.

Шийдэгдэхдээ миний хүү Цэрэнпил, Төмөрчөдөрийн Цэрэнпилийн Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд заагдсан халдашгүй баталгаатай эдлэх эрх, эрх чөлөөг ноцтой зөрчсөн гэж үзэж энэ талаар би шинээр илэрсэн хэрэг буюу гэж би прокурорт хэдэн удаа хандсан боловч Прокурорын дээд Ерөнхий прокуророос буцаагдаад анхан тэр Батсүх прокурор дээр очдог. Батсүх прокуророос Дэнсмаа прокурор луу явсан. Өвөрхангай аймгийн Ерөнхий прокурор луу тэгэхэд энэ Таны оролцох хэрэг биш энэ шинээр илэрсэн хэрэг байхгүй байна гээд ингээд буцаадаг. За энэ нь яаж байгаа юм бэ гэхтэй зэрэг тухайн хэрэг дээр 2 хүн оролцож энэ чинь бүлэг хэрэг болсон байна гээд Өвөрхангай аймгийн сум дундын анхан шатны шүүхийн хэргийг хянан хэлэлцээд 2022 оны 3 сарын 24-ний 39 дүгээр тогтоолоор хэргийг шүүгдэгч Төмөрчөдөрийн Цэрэнпилийг онц харгис хэрцгийгээр биеэ хамгаалж чадахгүй байдлыг мэдсээр байж хүнийг алсан бүлэглэж бие махбодод нь хүнд гэмтэл учруулсан тул шүүгдэгч Цэрэнпилийг Эрүүгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1.2, 2 дугаар зүйлийн 2.1, 2.7-д зааснаар 12 жилийн хорих ялаар, мөн Эрүүгийн тухай хуулийн хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.3-д зааснаар 5 жилийн хугацаагаар хорих ял нийлээд 15 жилийн хорих ял өгсөн.

Нөгөө хамтарч байгаа тэр шүүгдэгч Базар овогтой Гунгаадорж, Дондовын

Мөнх-Эрдэнийг бүлэглэж бие махбодын сэтгэл санааны шаналал зовуурь үүсгэж хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулсан үйл хэрэгт тус тус буруутгаж Мөнх-Эрдэнийг мөн 5 жилийн хорих ялаар шийтгээд ...

Сонсгол даргалагч П.Сайнзориг - 2 минут нэмж өгье.

Иргэн Б.Бямбасүрэн - эндээс юу харагдаж байгаа юм бэ гэхээр зэрэг хяналтын шатны шүүх болохоор анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож бүлэг хэрэг биш байна энэ дангаараа байна гээд бүлэг хэргийг нь хасаад. Манай хүүхэд дээр болох лээр зэрэг нэмж 3 жилийн ял, 2 зүйл ангиар зүйлчилж хэрэг шийдсэн байдаг юм. Гэтэл энд яагаад тэгвэл бүлэг гэдэг чинь 2 ба түүнээс дээш хүн байх ёстой. Гэтэл нэг хүнийг нь энэ бүлэг хэрэг биш байна гээд энэ хүний хэргийг хэрэгсэхгүй болгосон мөртөө, манай хүүхэд дээр 2 зүйл анги нэгтгэн зүйлчилж 15 жилийн хорих ял өгсөн. Ингээд 3 жилийн хорих ялыг бол хилс гэдэг юм уу юу гэдэг юм үндэслэлгүйгээр Үндсэн хууль бусад хуульд нийцэхгүй хууль журмаар шийдвэрлэж, шүүх эрх зүйн байдлыг нь ингээд дордуулсан байгаа. Тэгээд энэ дээр би хүүхдийнхээ төлөө энэ сонсголд тайлбарыг ингэж гаргаж байгаа нь энэ. Улсын дээд шүүх нь Үндсэн хуульд нийцээгүй, албан ёсоор нийтлээгүй, хуулийг хэрэглэхгүй, хэрэглэх эрхгүй гэсэн энэ заалтаа зөрчиж өөрийн гаргасан үндэслэл бүхий хуулийнхаа зүйл заалтын дагуу энэ хуулийг шийдвэрлэхдээ хуулийн 40.1 дэх заалтын 1.4-д хэргийн зүйлчлэлд ялыг хүндрүүлэхгүйгээр анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулна гээд өөрөө удирдлага болгосон мөртөө энийгээ зөрчөөд, өнөөдөр энэ хүүхдэд 15 жилийн хорих ял өгч байгаа. Яагаад энэ 3 жилийн хорих ялыг ингээд нэмээд өгчхөв өө гэдгийг би энэ сонсголынхоо хүсэлтдээ Баярмаа гишүүнд өгөхдөө эндээ би тодорхой бичсэн байгаа. Энэ хүүхэд өөрөө энэ талаар бичиж өгсөн манай хүүхэд өнөөдөр хоригдоод 420 ...

Сонсгол даргалагч П.Сайнзориг - Мэдээллийн чанартай нэг зүйл өгье. Бид нэг танхимд өглөөнөөс эхлэн сууж байгаа. Агаар сэлгэлт бол явж байгаа боловч магадгүй даралт ихсэж байгаа, эсвэл янз бүрийн байдлаар эмчийн тусламж үйлчилгээ авах шаардлагатай бол та бүгд манай Тамгын газрын ажилчдад хэлээрэй. Энд эмч байгаа гэдгээ хэлье. Тэгээд бид нар эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэх боломжтой байгаа шүү гэдгийг би нийт оролцогчид хандаж хэлье.

Дараагийн хүн Рэнцэнханд байна. Бямбаагийн Рэнцэнханд, 20 дугаар микрофон байна. 20 дугаар микрофоныг нээж өгье. Үүний дараа Зана гээд хүн байна. За 21 микрофон байх шиг байна дэс дарааллаар нээгээд явчихаарай.

Иргэн Б.Рэнцэнханд - Ковид 19 вакцинаас хохирогчид болон эсэргүүцэгчдийн хөдөлгөөнийг төлөөлөөд хуульч Рэнцэнханд гэж хүн байна. Сэлэнгэ аймгийн Түшиг сумаас ирсэн Дархлаажуулалтын тухай хуулийг хүчингүй болгох асуудлыг 2021 оны 5 дугаар сараас хойш тавьж явж байгаа. Хууль тогтоогч нарт...

Сонсгол даргалагч П.Сайнзориг - Та сэдвийн хүрээнд ярья. Энд дархлаажуулалтын тухай хууль гэдэг юм уу та бүгдийн ярьж байгаа юмыг түрүүнээс харсан. Энэ нийтийн сонсгол гэдэг олон нийтийн цаг, энэ олон нийтийн цаг дээр сэдэв тодорхой ярих асуудал маш ойлгомжтой.

Би дэг танилцуулсан дэгийг ингэж зөрчиж байгаа таны микрофоныг хаахаас өөр аргагүй байна гэдэг зүйлийг хэлье.

Дархлаажуулалтын хуулийн асуудал ярих гэж байгаа бол Хүний эрхийн

үндэсний комисс болоод Эрүүл мэндийн яам, Засгийн газарт хандаж болно. Ингээд микрофоныг хаагаад дараагийн хүн.

Бид сэдэв дэгээ барих ёстой, иргэд ойлгоорой гэж хүсэж байна. Энд өнөөдөр тодорхой сэдвийн хүрээнд маш олон иргэд өөрийнхөө зөрчигдсөн эрх болон бусад асуудлаар саналаа дэвшүүлэх гэж ирсэн. Танд дэг санууллаа. Дэг сануулаад боломжгүй бол би дараагийн арга хэмжээг авна гэдгээ хэлье. За ингээд Занаа гуай танд микрофоныг өгье.

Иргэн Занаа - За баярлалаа. Өнөөдөр би энд сонгож байгуулсан төртэйгөө Үндсэн хууль гэдгээ иргэний гэрээнийхээ нэг талынхаа хүнийхээ хувьд иргэнийхээ хувьд энэ хуралд ирээд сууж байна. Энэ сонсголд тэгэхээр хүний эрх бол түгээмэл салгаж болохгүй, хоорондоо нягт уялдаатай аль нэг эрхийг нь дээр, аль нэг эрхийг нь доор гэж үзэж болдоггүй ийм түгээмэл шинж чанартай хууль. Энийг хүний эрхийн түгээмэл тунхаглал болон Үндсэн хуулиар баталгаажуулж өгсөн байгаа. За тэгээд энд ямар учраас сая манай хүнийг яриулсангүй энэ эрх л ярих гэж байсан тэрнээс биш ямар нэгэн мод ярих гэж ирээгүй. Тэгэхээр та нар яаж хандах ёстой вэ гэвэл үнэхээр хууль тогтоогчид мөн юм үнэхээр эрх зүйчид мөн юм бол энд ярьж байгаа хүмүүсийн яриаг бүхэлд нь үнэлж дүгнээд тэгээд хүний эрхийнхээ зүгээс байнгын хороо нь мөн юм бол хүний эрхийнхээ зүгээс үнэлэлт дүгнэлт өгөөд тэгээд шинжилгээ судалгаагаа хийгээд Улсын Их Хурлын гишүүнийхээ хувьд, миний төлөөлөгчийнхөө хувьд, миний сонгосон төр, миний сонгож байгуулсан засгийнхаа хувьд энэ асуудалд хандах ёстой Сайнзоригоо. Түүнээс биш чи буруу ярилаа, энэ буруу яриа, чи сэдэв, энэ сэдэв тийм байж болохгүй шүү.

Сонсгол даргалагч П.Сайнзориг - би дахиад хэлье. Сэдэвтэй холбоотой зүйл ярина. Занаа гуай.

Иргэн Занаа - Би хүний эрхийн ажлыг 30 жил хийж байгаа учраас сэдэвтэйгээ ярина, ойлгосон уу? Философи нь энэ байна. Дархлаажуулалтын хуулийг ярих гээд сая чадуулчихлаа би ярина. Дархлаажуулалтын хуулийн асуудлыг тусдаа нийтийн сонсгол хийж болно.

Сонсгол даргалагч П.Сайнзориг - Таны наад сэдвүүдээр хэдүүлээ дараа нь тусад нь ярьж болно. Бие биеэ хүндэтгэе. Энд өнөөдөр нийтийн сонсгол хийх гэж байгаа хүмүүс сэдвээ гаргаад эрүүдэн шүүх, эрүү шүүлт тулгах, хүнтэй хүнлэг бус харьцах энэ асуудал байгаа.

Дараагийн хүнийг микрофонд урья. За санууллаа Занаа гуай, дараагийн хүн Шаарийбуу гуай. Эсвэл сануулаад та энэ дэгийг сахиж сэдвийн хүрээнд асуудлаа ярихгүй гэвэл бид хуультай улсад амьдарч байна. Хууль, дүрмийнх нь дагуу сонсголыг зохион байгуулж байгаа. Хэрэв та дархлаажуулалтын асуудлыг хөндөж хүний эрхийн зөрчил байна гэж байгаа бол бидэнд хүсэлтээ өгчих. Бид энүүгээрээ сонсгол зохион байгуулах ч болно. Олон хүмүүс саналаа хэлэх гэж байна. Занаа гуайд би санууллаа, сануулаад та дэгийг баримталж энэ танхимд сууж чадахгүй бол танхимыг орхин гарахыг би танаас хүсэж байна. Дараагийн үг хэлэх гэж байна. Та бусдыг хүндэтгээрэй. Манайхан Занаа гуайд хуулийг нь тайлбарлаад танхимаас гаргахыг хүсэж байна.

Дараагийн хүний микрофон. Шаарийбуу гуай хаана байна, гараа өргөнө үү? 22 дугаар микрофоныг нээе.

Та бусад хүний боломжийг хомсдуулаад байна. Зарим хүмүүс чинь үгээ хэлэх гээд байна. Энэ тусдаа сэдэвтэй учраас сэдвийн хүрээнд гэдгийг би хэлсэн байгаа.

Занаа гуай та учир мэдэх хүн. Занаа гуайг гаргая манайхан. Манайхан бие биеэ хүндэтгэе. Та бусдыг хүндэтгэ таны эрх бусдын эрхээр хязгаарлагдаж байгаа. Өнөөдөр хүний эрхийн талаарх сэдэв нь эрүүдэн шүүлт, эрүү шүүлт болон хүнтэй хүнлэг бус харьцах.

22 дугаар микрофоныг нээж өгье. Цагийг эхнээс нь тавьж өгье. 22 дугаар микрофон бэлэн болсон уу? За баярлалаа.

2 дугаар микрофон дээр суучихсан байгаа хүн та бусдыг хүндэтгээд ярих боломжийг олгоно уу? би танд санууллаа таны нэрийг мэдэхгүй байгаа учраас нэрээр чинь хэлж чадахгүй байна. Таныг танхимыг орхихыг хүсье. Манайхан дэг сахиулъя, 2 дугаар микрофон дээр байгаа хүн гараад лайваа хийхийг хүсэж байна.

Иргэн Шаарийбуугийн микрофоныг эхнээс нь нээж өгье, 22 дугаар микрофоныг нээе, техникийнхэн. Микрофоноо нээтэл Та чимээгүй хүлээж байгаарай. За Шаарийбуу гуай, Таны ээлж танд боломж олгочихсон байна. Юуны өмнө дэгтэй тул эхнээс нь цагийг нь өгөөрэй.

Иргэн Шаарийбуу - Өдгөөгөөс 19 жилийн өмнө Малайзын төр миний охиныг хороосон. Ийм учраас би охиныхоо гэгээн дурсгалд зориулж хэдхэн секунд хүндэтгэл үзүүлье.

Сайн байна уу? Та бүхэнд талархлаа. Би арай жаахан өргөн хүрээтэй 2 гуравхан асуулт тавина. Бид өнөөдөр Монголд эрүүдэн шүүх үйл ажиллагаа түүнээс гарах арга замын тухай ярилцаж байна. Энүүнд гадаадад амьдарч байгаа хүмүүсийн тухай асуудал бас яригдах ёстой юм. Гэхдээ бид юуг орхисон бэ гэхээр гараад явсан улсуудаа үнэндээ бол мартчихсан. Тэд нар бол өөрийнхөө эр зоригоор өөрсдийнхөө тэр улсын хуулиар эрх мэдэл нь хохирч явдаг. Тэгэхээр гадаадад болсон асуудлын тухайд төр хохирогч бас нэхэмжлэгч байх ёстой Би энэний төлөө 19 жил явлаа. Надад тусалцаа байдаггүй.

Би хуулийн бүх байгууллагад хэдэнтээ өргөдөл өгсөн. Надад ганцхан л хариу ирдэг юм. Тэр нь боломжгүй гэдэг хариу нь юу вэ гэхээр эрх зүйн гэрээгүй гэдэг юм. Тэгээд эрх зүйн гэрээгээ байгуулаач гэхээр Австралитай байгуулдаггүй, Малайзтай байгуулдаггүй, Францтай байгуулдаггүй, бусад оронтой байгуулдаггүй юм. Тэгэхээр эрх зүйн гэрээгүй юм бол одоо энэ ертөнцөд амьдрах хэрэг байна уу гэж би асууж байгаа юм. Дараа нь дахиад би Ерөнхий сайдад энэ асуудлаа тавьсан. Саяхан Хууль зүйн яаманд дахиад өгсөн. Бодвол надтай уулзаад боломжгүй гэдэг үгээ хэлэх болов уу гэж би горьдож байгаа манай хуулийн байгууллагууд яадаг вэ гэхээр хүний өргөдөл өгдөг, өөртэй нь уулздаггүй, нэг сар хүлээлгэдэг, хуулийн хугацаатай, ямар зорилгоор, ямар ч асуудалгүйгээр боломжгүй ээ гэсэн нэг л хариу өгдөг. Би хүн хүнтэйгээ харьцдаг гэж ойлгодог гэтэл хүн цаастай харьцдаг болоод удаж байна аа тэр нь жаахан харамсалтай байдаг шүү. Хүн эрүүдэн шүүх гэдэг ажиллагааг ярьж байгаа бол тодорхой бодитой юмны тухай ярь.

Сонсгол даргалагч П.Сайнзориг - За 2 минут нэмээд өгчихье. Та энэ 2 минутад багтаагаад өөрийн байр сууриа тодорхой хэлээрэй.

Иргэн Шаарийбуу - Үнэнийг хэлье, үнэнийг хэлж байгаа хүний эрхийг хамгаалах хууль байхгүй, манайд байхгүй тул айгаад байдаг. Тийм учраас энэ шүгэл үлээгчийн хууль гэдгээ, эрхийг хамгаалах хууль гэдгээ оруулаад хэлэлцээд өгөөч Их Хурлын гишүүд ээ! ард түмнээсээ юуг нь тусгах юм ямархуу байдалтай байх юм гэдгийг асуугаач, түрүүний Их Хурлын үед 2 удаа оруулах гээд чадаагүй оруулаагүй одоо юунаас нь айгаад байдаг юм гэхээр бидний хэн нэгэн хүний эрхэд нөлөөлсөн

тэгээд шударга үнэнийг үлээх гээд байна гэж айгаад байдаг бол харамсалтай юм болж байгаа шүү. Би одоо хоёрхон асуудал хэлье. Боломжгүй юм гэж байхгүй тэр болдоггүй гэдэг үгийг одоо би чадахгүй гэсэн үгтэй зүйрлэдэг. Тэгэхээр би Малайзын хуульд нөлөөлсөн хуульд цаазад, хуульд цаазын ялын хэд хэдэн заалтуудыг өнгөрсөн 2023 онд өөрчлүүлсэн хэрэг үйлдэгсдийн ялыг 10 сарын 10-нд би өөрчлүүлж чадсан.

Миний өмгөөлөгч үргэлж Монголоос энд ажилладаг Будрагчаагийн Баяр гэдэг хүн байдаг. Тэнд ганц энэтхэг эмэгтэй бид гурвуулаа болж байна уу гэвэл болж байна. Хил даваад хэдэн улсын цаана асуудлыг шийдэж болж байхад би эндээс дандаа болохгүй гэдэг ганцхан үгийг сонсоод сууж байх нь надад харамсалтай санагддаг гэж хэлье. Эцэст нь хэлэхэд энэ хугацаанд намайг манай Монголын төрийн өндөр албан тушаалтнууд энэ хэрэгт орооцолдсон, орсон, тэндээс очиж мөнгө авсан тэнд очиж нөлөөлсөн. Би энэ тухай саяын Хууль зүйн яаманд ерөнхий..

Сонсгол даргалагч П.Сайнзориг - За таны цаг дуусчихлаа. Уг нь 2 минут танд өгсөн надад байгаа боломж дэгээрээ ийм байдаг. Дараагийн хүнийг урья Шарийбуу гуай нэлээн ноцтой ч юм бас хэлж байна. Бид хэд цаашдаа Монгол улсаас гадаад улсад байгаа иргэдийнхээ эрх ашгийг олон талаар хамгаалах асуудал яригдаж байна. Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын хуулийг ярьж байна. Өнгөрсөн хугацаанд Улсын Их Хуралд өргөн барьсан. Шинэ Улсын Их Хурлын бүрдсэнтэй холбоотой Дэгийн хуулиар Загийн газарт буцсан байгаа ийм мэдээллийг өгье.

Дараагийн хүн Сарантуяа гэж хүн байна. Шарийбуу гуай одоо асуудлууд байвал хоёулаа дараа нь уулзаад гишүүдээс асуулт, хариулт явбал дэгийн дагуу танд боломж олгоё гэж бодож байна. Сарантуяа таныг микрофонд урья. 23 дугаар микрофоныг нээж өгье.

Иргэн Сарантуяа - Өнөөдөр эрүүдэн шүүлтийн сонсголд анх удаа оролцож байна их хэцүү асуулт байдаг юм байна. Хүнийг ер нь эрүүдэн шүүнэ гэдэг бол төрийн албан хаагчдын эс үйлдэл ажлаа хийж чадахгүй өс хонзонгоор л хүнийг эрүүдэн шүүдэг юм байна гэсэн дүгнэлтэд хүрлээ. Гадаа гудамжинд иргэдийн эрх ашгийг зөрчсөн хүний эрх ашгийг зөрчсөн эдийн засаг болон хүний эрх ашиг авлигал ашиг сонирхлыг өдөөсөн ийм заалтуудыг оруулдаг. Тэр талаар бид нар ээжүүд тэмцдэг юм.

Хавар Үндэсний баялгийн сангийн хуульд бид нар 1072 хувьцааг иргэн бүрд үнэ төлбөргүй олгохыг хориглоно гэж . Одоо үнэ төлбөртэй л олгох юм байна л даа. Тэгээд бид нар яахаараа баялагтаа эзэн больё гэж байгаа орны хүмүүс бид нар хувьцаагаа мөнгөөр авах ёстой юм бэ гээд жагсаж байсан чинь Нямбаатар өөрийнхөө туслахтай ирж байгаа бололтой. Манай ээжүүд урдаас нь Туул гол дээр 14 сая, тэрбумын гэнэ үү бургас юу хийх вэ гээд зогсоогоод асууж байсан чинь нэг бичлэг хийж байсан эмэгтэгийн утсыг хага шидээд намайг дайраад унагаасан. Бид нар Хүний эрхийн комисст хандсан. Хүний эрхийн комиссынхоо энэ ажиллагааг хүний эрхийн дэд хорооны дарга Дондов учир дутагдалтай хийсэн. Энэ дээр бид нар ээжүүд их гомдолтой байгаа. Яагаад гэвэл бид нарын нэр хүндэд халдаж байгаа байхгүй юу. Нямбаатар та нар хэнээс мөнгө авсан жагсагчид вэ? гээд Нямбаатар өөрөө бид нарын утсыг авч шидэж байгаа шүү дээ. Ийм байж болдог юм уу? Өөрөө төрийн эрх барих Хууль зүйн сайд гэж байсан хүн чинь ийм ёс зүйгүй авир гаргаж байхад чинь бид нар зүгээр гудамжинд л эрүү шүүлтэд ороод байгаа шүү дээ. Эрдэнэс тавантолгой компани дээр би асуудлуудыг нь хөндөж тавилаа. Тэгэхэд байна шүү дээ тэр БЭТ гэж байсан тэр Ж.Ганбат бол ингэж байгаа Цэгмэд, Сарантуяа гээд бид нарын нэрийг мэддэг юм байна лээ.

Уулзъя гээд уулздаггүй хүн чинь та 2-ыг хууль хяналтын байгууллагад өгч шалгуулна гэж байгаа. Бид нар мэдэх эрхийнхээ хүрээнд л 3 асуудал тавьсаны төлөө өширхөж хонзогнодог юм байна лээ. Өнөөдөр бид нарт Авлигатай тэмцэх газар 16 зүйлийн асуудлыг өгчхөөд байж байгаа. Тэгэхэд бичиг хэрэгт аваагүй таны юм бол албан ёсоор албажаагүй гээд. Бид нар мэдэх эрхийнхээ хүрээнд, Нямбаатар, Оюун-Эрдэнэ 2 харилцан хамааралтай гээд байх юм. Энийг тогтоож өгөөч гээд гомдол гаргасан чинь ёстой тогтоогдохгүй байна гээд байна. Манай Монгол улсын архив шиг сайн архив байдаггүй гэсэн шүү дээ тэгээд энийг тогтоож чадахгүй байгаа чинь өөрөө асуудал биз дээ эрх баригч нар ийм харилцан хамааралтай хүмүүс байгаад байхад Монгол улсад авлигал, ашиг сонирхол, хүний эрхийн тухай, эрүүдэн шүүлтийн тухай ярих чинь өрөөсгөл юм биш үү л гэдгийг би энд хэлэх гээд байгаа юм. Авлигатай тэмцэх газрын Гэрэлмаа гэдэг хүүхэн намайг шүгэл үлээснийх нь төлөө олон нийтийн дарга Ганбатад миний нэрийг хэлсэн биз.

Сонсгол даргалагч П.Сайнзориг - За баярлалаа. Дараагийн хүн Ганболд гэж хүн байна. 24 дүгээр микрофон байна.

Иргэн Ганболд - Шууд 2 минутаа авчихъя би хэргийн талаар бол ярихгүй. Хүний эрхийн үндэсний комиссын 2016 он, 2023 оны эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх тухай илтгэлд миний хэрэг орсон байгаа. Энийг бол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо хүний эрхийн дэд хороо, Хууль зүй, дотоод хэргийн яам, Хүний эрхийн үндэсний комисс энэ асуудлыг мэдэж байгаа. Прокурорын байгууллага 15 жил явуулж байгаа. Эрүү шүүлтээ зогсоо гэж хэлэх байна. Үндсэн хууль, Монгол Улсад нэгдэн орсон олон улсын гэрээ конвенцын зүйл заалтыг биелүүл гэж шаардах байна. Монгол Улсад ер нь хууль дүрэм нь байгаад байдаг ганцхан хувь одоо ажил хариуцаж байгаа улсууд ажлаа хийж чадахгүйгээс болоод хүн 15 жил явчихдаг. Тийм болохоор одоо ер нь бол хүний эрхийг хамгаалах талаар Монгол Улсын төр ямар хууль тогтоомжийн хүрээнд ажиллаж байна гэдэг нь тодорхой байна л даа. Хууль нь байгаад байдаг тэгээд тэр хуулиа хэрэгжүүлэхгүй ажил хариуцсан улсууд нь ажлаа хийхгүй байна. Энд одоо цаг бага юм чинь олон юм яриад яах вэ.

Улсын Их Хурлын 2024 оны 5 сарын 2-ны өдрийн 37 дугаар тогтоол гэж батлагдсан байна. Энэ тогтоолыг хэрэгжүүлэх талаар Улсын Их Хурлын онцгой анхаарч өгөөч гэсэн хүсэлтэй байна. Өөр хэлэх юм байхгүй.

Сонсгол даргалагч П.Сайнзориг - За баярлалаа. Дараагийн хүн Ганболдын Баяртогтох гэж байна. 25 дугаар микрофоныг нээж өгье.

Иргэн Г.Баяртогтох - Монгол Улсын олон улсын гэрээг би одоо ямар ч байсан эхлээд хэлье. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжилж хариуцаж шийтгэхийн эсрэг конвенцод манайх 1984 оны 12 сарын 10-нд элсэж байсан юм байна. Тийм учраас сүлдэндээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Миний бие одоо өвлөгдөх хайрхан буюу өвөг дээдсээсээ өвлөгдөж ирсэн энэ хайрхнаа үр хойчдоо өвлөгдөж үлдээх юм сан гэж бодож явдаг юм. Аргалант уул буюу аргалийн утаандаа ариусаж ирсэн Монголын ард иргэд өнөөдөр махныхаа хорыг хүртэл гаргаад иддэг байсан бид хорт хавдрын өлгий удам болжээ. Тийм учраас одоо нутагтай хүн өнөөдөр баян байдаг. Тэгээд Өвлөгдөх хайрхан Аргалант уул нутаг нийгэмд үйлчлэх Төрийн бус байгууллагын тэргүүн Ганболдын Баяртогтох хүн та бүгдийнхээ амрыг эрж байна.

Өнөөдрийн гол асуудал юу юм гэхээр нийгэмд үйлчлэх Төрийн бус

байгууллага нийгмийнхээ нийт ард иргэддээ хандаж өнөөдрийн сонсгол нь бид хэдэд үг үзэл бодлоо хэлэх зөрчигдөж байгаа хэн нэгний эрхийг хамгаалах ийм чухал сонсгол болж байна гэж харж байгаа юм. Тийм учраас одоо яг миний дурдах гэж байгаа энэ асуудлууд бол 4 асуудал биччихээд байна. Гадаад улсад байгаа Монгол хүн ажил хийж гадаад иргэний эрх чөлөөнд нь халдуулсныхаа төлөө гадаадын шүүхээр явж байна. Энэ асуудал 1-д.

2-т бол дотоодод байгаа асуудлууд шоронжуулна л гээд байдаг арга зам авч байгаа юм байна уу? урьдчилан сэргийлж байгаа зүйл байна уу? Эрүүдэн шүүхийг урдаа гаргаж тавиад байдаг олон улсынхаа жишгийг хараач. Энийг харах цаг болсон гэдгийг хэлэх гэж ирсэн.

3 дахь асуудал бол нэр хүнд өвөг дээдсээсээ өвлөгдөж ирсэн шиг аав ээжээсээ өвлөж ирсэн нэр хүнд минь буцаад үр хүүхдэд минь өвлөгдөж үлдэх ёстой. Нэр хүндээ өнөөдөр бохирдуулчихаад үр хүүхдэдээ юу гэж хэлэх юм бэ? Нэр хүндээ хамгаалж чаддаг эрх зүйтэй улсын иргэн баймаар байна гэдэг асуудлыг ярих гэж байгаа. Тийм учраас одоо энэ асуудал дээр би кэйс авч ярина. Тэгээд минут маань хүрэхгүй бол 2 минут сунгаж өгөхийг ямар ч байсан сонсгол даргалагчаасаа гуйж байна. Гадаад улсад байгаа асуудал гэж юу юм бэ гэхээр одоо гадаад улсад нэгэн Монгол иргэн өнөөдөр нэг хүн тэр Монгол иргэний эрхэнд халдсанаас болж шүүгдэж эхэлжээ. Шүүхдэж эхэлсэн иргэн маань Монголынхоо мэдээж хэрэг консул дээр очно. Монголын консул нь өнөөдөр Цахим хөгжил харилцааны яам хүртэл зарлаад Учрал сайдын хийгээд байсан ажил.

Өнөөдөр бүх зүйл цахим болчихсон гээд байсан ажил өнөөдөр цахим болоогүй байна. Тэнд хүнээс бичгээр мэдүүлгийг нь аваад өөрийнх нь өгсөн өргөдлийг гараар нь аваад орчуулах ч чадваргүй хүмүүс сууж байна. Өнөөдөр хүн Монголынхоо Үндсэн хуульдаа захирагдаж амьд явах эрхээ хамгаалуулахын тулд Монголынхоо хүний эрхийг өнөөдөр гадаадын улсад хайж Монгол Улсын иргэн болж төрсөндөө гутаж амьдарч байна. Тэгэхээр энэ хүний хэргийг нэн яаралтай шийдэж өгөөч. Нэн яаралтай хуулийн туслалцааг хүний эрхийн байгууллага нь хандаж авч өгөөч гэдэг энэ асуудлыг нэгд ярих гэж байна.

2 дахь асуудал бол мэдээжийн хэрэг дотоодод байгаа асуудал гэсэн. За энэ дээр маш олон кейс байдаг маш олон эрүүдэн шүүх

Сонсгол даргалагч П.Сайнзориг - 2 минут нэмье. Та нэг тодорхой юм яриарай. Тэр хүн маань гадаад улсад гэмт хэрэг хийчихээд байна уу, үгүй юу тэрийгээ тодорхой ярихгүй бол ойлгомжгүй тэнд юунд орооцолдчихоод байгаа иргэн дээр туслалцаа үзүүлээд байгаа юм бэ гэдэг нь хүмүүст ойлгомгүй бас тэмдэглэж авах хэрэгтэй байх. Танд 2 минут нэмээд өгье.

Иргэн Г.Баяртогтох - Тийм байна тодорхой гэсэн болохоор одоо Монгол Улсын иргэнд гадаадын иргэн халдсан байна. Гадаадын иргэнийг 2 жил өнөөдөр шоронд хорих эрх зүйн үүрэгтэй гадаадын шүүх нь ажиллаж байна. Гэтэл Монгол талын хүн эд хөрөнгө, баялаг, эрүүл мэндээрээ хохирчихсон байгаа учраас Монгол хүнээ хамгаалж өгөөч гэж байгаа юм. Энд монгол хүн хохирогч шүү.

2 дахь асуудал дотоодын маш олон асуудал байгаа маш олон шоронжиж байгаа асуудал байгаа. Энэ асуудлууд дээр би нэг асуудал ярих гэсэн юм аа. Архинаас хүн гарч болдогтой адилхан хар тамхинаас ч гэсэн залуучууд маань гарч болно. Татгалзаж болно. Энэ бол сэтгэл зүйн байдал юм. Тийм учраас хар тамхи хэрэглэсэн хүнийг аваачаад шууд эрүүдэн шүүгээд чи ялтан гэж үзээд өнөөдөр шоронд хийх нь зөв гарц гаргалгаа юм уу. Энэ хүнийг өнөөдөр нийгэмшүүлэх нь зөв

гарц гаргалгаа юм уу. Энэ дээр хүний эрхийн байгууллагатай хамтарч ажилламаар байна. Дээрээс нь яг энд хууль батлах гэж байгаа, хуулийг батлах гээд энд урдаас хараад сууж байгаа Улсын Их Хурлын гишүүд ээ! Та хэд ард иргэдийнхээ хаан биш ээ. Та хэд ард иргэдийнхээ элч төлөөлөгч учраас өнөөдөр дуудуулан дуудуулан байж ард иргэд чинь өнөөдөр 30 минутын өмнө ирээд суудлаа эзэлчихсэн байхад та хэд 40 минутын ард, араас нь орж ирж байгаа нь өнөөдөр байж болох ёстой тогтолцоо мөн юм уу?

3 дахь асуудал бол хүний нэр хүнд дээр хэвлэн нийтлэх эрх чөлөө гэж яригддаг 4 дүгээр засаглал чинь өнөөдөр харлуулах юм хийж болдог юм уу? Хэн нэгний нэр хүнд рүү халдахдаа хэн нэгэн ялтны бичлэгтэй тэр хүний бичлэгийг тасдаж аваад хэвлэн нийтэлж олон нийтийн сүлжээнд тарааж байгаа нь өнөөдөр энэ хүнийг ялтан гэж үзэж байна. Цагдаагийн байгууллага гэж байгаа юм уу, прокурор гэж байгаа юм уу, шүүх гэж байгаа юм уу энэ болгон чинь өнөөдөр тэр хүнийг ялтан гэж тогтоогоогүй байхад хэвлэл чинь өнөөдөр ялтан гээд тогтоочоод байгаа юм бол энэ байгууллагууддаа татан буулгаач ээ хэвлэлтэйгээ л ганцхан харьцаач ээ гэдгийг энд хатуу сануулж хэлье. Энд Хууль зүйн яамны сайд Алтангэрэл гэдэг хүн сууж байсан. Танд Ганболд Баяртогтох гэсэн шаардлага утас очсон байх та өнөөдрийг хүртэл хариу өгөөгүй байна. Хүний эрхийн дарга Ууганбаяр гэдэг хүний эрхийн ямар ч байсан нэг хэлтсийн дарга нь Ууганбаяр гэдэг хүн сууж байна. Танд 11 сарын 8-нд өгсөн хүн заналхийлээд байна амь нас минь хохирох гээд байна, хүнийг үхсэнийх нь дараа хүн рүүгээ харах юм уу гэсэн шаардлага өгсөн. Утсанд ганц ч удаа танайх над руу яриагүй байна ажлаа хийж байна гэж хэлдэг.

Сонсгол даргалагч П.Сайнзориг - За ойлголоо дараагийн хүн Хүрэлбат, Төмөрхүрдийн Хүрэлбат байна. 1 дүгээр микрофоныг нээж өгье.

Иргэн Т.Хүрэлбат - Сайн байна уу? Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Намайг Төмөрбүрдийн Хүрэлбат гэдэг миний дүү Төмөрбүрдийн Чимгээ гэдэг хүн Зоригийн гэх хэрэгт холбогдоод 5 жил 9 сарын ял эдэлсэн. Би дүүгийнхээ өмнөөс ярьж байгаа. Яагаад гэвэл энэ хүн одоо энд сууж байгаа. Өөрөө ярьж хэлэх гэж байгаа юмаа мартдаг будилдаг, жоохон яаруулбал сандардаг, унадаг, татдаг учраас би өмнөөс нь төрсөн ах нь ярьж байгаа, манай өмгөөлөгч хажууд сууж байна. Хууль эрх зүйн талаас нь өмгөөлөгч ярих байх. Энэ сонсгол бол Улсын Их Хурлын гишүүдэд хүргэх гэж байгаа сонсгол учраас би Чимгээ, Содномдаржаа гэдэг 2 хүн 6 жил Зоригийн хэрэг гэдэг юманд яллуулалд тухайн үеийн 2015 оны тагнуул, прокурорын тагнуулын байгууллагын зохион байгуулалтаар, прокурорын зөвшөөрлөөр, шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажилтнуудын оролцоотойгоор яргалалт тамлалт дундуур яваад 4, 5 жил 9 сар яваад гарсан.

Одоо энэ нөгөө яргалал уу? Эрүүдэн шүүлт нь үү? үргэлжилж байгаа Улсын Их Хурлын гишүүнээр түүчээлж байна. Сая 10 сарын 2-нд Зориг агсны хөшөөн дээр очоод энэ шинээр сонгогдсон Лодойсамбуу гээд гишүүн сая энд сууж байсан алга болчихлоо. Энэ хүн энэ хэрэг илэрсэн шүү дээ гээд. Монгол Улсын дээд шүүх, Монгол Улсын прокуророос энэ хэрэг хэрэгсэхгүй болоод нотлох баримтгүй юм байна гээд хэрэгсэхгүй болоод тогтоол шийдвэрүүд нь гарчихсан байж байхад Улсын Их Хурлын гишүүн нь өнөөдөр ард түмэнд ийм мэдээлэл өгөөд байж байгаа. Тэгэхээр Улсын Их Хурлын гишүүд та Улсын Их Хурлын гишүүн болонгуутаа л дураараа хэн нэгний эрхэнд халдаад хэн нэгний нэр төрийг гутаагаад байж болдог юм уу, үгүй юм уу. Энэ сахилгын хороо нь энэ Лодойсамбуу гишүүндээ арга хэмжээ авч өгөөч гэж 1 дүгээрт хүсмээр байна.

2 дугаарт энэ эрүүдэн шүүлт Монгол Улсын шүүхээр үргэлжилж байгаа. Бид нар энэ нөхөн төлбөрийн асуудлыг өнөөдөр БЗД-ийн иргэний хэргийн анхан шатны

шүүхэд хандаад 9 удаа буцаачхаад байж байна. Ганцхан Ундраа гэдэг шүүгч дээр очоод буцдаг эндээс яаж буцдаг вэ гэхээр үндэслэл нь Чимгээ, Бямбасүрэн гэдэг 2 хүн чинь Улаанбаатар хотод өглөө 9 цагт байхгүй бол чамайг шоронд хийнэ гэдэг. Ийм дарамтад энэ улсууд чинь гэр орноо тэр чигт нь хашаа байшингаа орхиод 90 настай хөгшнөө 3 хүүхдээ аваад хотод ирсэн. Энэ хойгуур 5 жил Чимгээ зөвхөн амьд байх уу, үгүй юу гэдэг асуудал дээр бид нар тэмцэл хийгээд явж байсан. Гэтэл тэнд чинь тэр хойгуур энэ 5 жилийн дараа байшин бол тэнэмэл хүмүүс, золбин нохойны үүр болоод нурах нь нурчихсан байсан. Энийгээ нэхэхээр энэ чинь ойлгомжгүй. Яагаад энийг харилцан нэхэж байгаа юм. Нэг бол нөгөө тэмдэгтийн хураамж төлөөгүй байна гээд энэ нь болохоор бас л хуулиар хэрэг бүртгэх ч юм уу, мөрдөн байцаагч, шүүх, прокурорын буруутай.

Нөхөн төлбөрийг тэмдэгтийн хураамж төлөхгүй гээд цагаан дээр хараар биччихсэн тэмдэгтийн хураамж хууль байж байхад нөгөө Ундраа гишүүн энэ дээр тэмдэгтийн хураамж төлөөгүй байна. Энэ чинь өөрөө эрүүдэн шүүлт шүүх нь өөрөө ийм хуультай юмыг өнөөдөр хуульгүй гээд өөрийнхөө дотоод итгэл үнэмшлээр асуудалд хандаж байна гээд. Ийм байхад бид нар одоо жишээлэх юм бол ямар нэг Түр хороо байгуулаад Улсын Их Хурлын гишүүдээ ямар нэг сонсгол хийгээд шүүхэд ямар ч нөлөө байхгүй байхад бид нар эндээс...

Сонсгол даргалагч П.Сайнзориг - 2 минут нэмээд өгчихье. Арай дуусаагүй байна.

Иргэн Т.Хүрэлбат - Баярлалаа. Тэгэхээр надад бол дахиад Улсын Их Хурлын гишүүдээс мэдээж энд дандаа хэлмэгдсэн улсууд байж байгаа энэ хэлмэгдсэн улсуудынхаа кейсийг нь багцалдаг юм уу нэг ойролцоо болгоод тус тусад нь хороо байгуулж байгаад эхний ээлжид энэ хэлмэгдсэн улсуудынхаа хохирлыг барагдуулчихаад дараа нь энэ эрүүдэн шүүхээс ангид байх асуудлаа яриад явахгүй бол зүгээр. Ингээд дотор нь холилдсон тэгээд дээрээс нь шүүх бид нар ямар ч сайхан хэлэлцүүлэг явуулаад ямар ч түр хороо байгаад шүүх дээр очоод л дахиад л бараг л энэ зураас чинь жоохон далий байна аа гэдэг л ийм хариу өгөх юм бол нөгөө хулгана рольхон дотор гүйж байдагтай л бид нар адилхан ийм байдалтай байгаа учраас өнөөдөр Монгол Улсын шүүхэд бид нар ерөөсөө итгэхгүй байна. Ийм учраас Их Хурлын эрхэм гишүүдээс хүсэж байгаа юм. Энд тусад нь хэлмэгдсэн улсуудын тодорхой кэйс шүү дээ энэ хэлмэгдсэн улсууд нь тусад нь хууль гаргаж өгөөч л гэж хүсмээр байна.

Сонсгол даргалагч П.Сайнзориг - Баярлалаа. Дараагийн хүн Сүхээгийн Оюунцэцэг гэдэг хүн байна. Микрофон яг дэс дарааллын дагуу байна уу? 1 дүгээр микрофон дээр л хамт байгаа юм байна, 1 дүгээр микрофоныг нээж өгье.

Иргэн С.Оюунцэцэг - Энэ өдрийн амар амгаланг айлтгая. Би Монголын Өмгөөлөгчдийн Холбооны гишүүн Сүхээгийн Оюунцэцэг гэдэг өмгөөлөгч энэ эрүүдэн шүүхийн эсрэг энэ үйл ажиллагааг хэлэлцэж байгаа нь тодорхой үр дүнтэй ажил болно гэж итгэж байна. Хүний эрх, эрх чөлөө энэ эрүүдэн шүүгдсэний улмаас яаж хүнд байдалд ордог гэдгийг та бүхэн сая энэ яриад байгаа хэлэлцүүлгүүдээс хүмүүсийн яриад байгаа байдлуудаас ойлгож мэдэж байгаа байх. Миний хувьд бол Чимгээгийн хэрэг дээр 11 дэх жилдээ явж байгаа. Тэгэхээр энэ эрүүдэн шүүх шүүлт явсан гол ажиллагаа нь бол Тагнуулын ерөнхий газрын мөрдөгч нар тухайн үед хяналт тавьж байсан прокурор нарын мөн Шүүхийн шийдвэр биелүүлэх газрын ажилтнуудын эрүүдэн шүүсэн хэрэг хүлээлгэсэн, тулган шаардсан, айлган сүрдүүлсэн, сэтгэл зүйн дарамт үзүүлсэн ийм үйл ажиллагаанаас болж хохирсон юм гэдгийг би тодорхой ярьсан энэ талаар яриад яах вэ.

Тэгэхдээ Монгол Улс Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцод 2000 онд элссэн. Энэ конвенц энэ 1984 онд батлагдаад 1987 оноос эхэлж энд нэгдэн орсон улсын хэмжээнд бол хэрэгжиж байсан. Гэтэл манай улс нэгдэн орсныхоо хувьд бол хуульд гэмт хэрэг гэдгээр нь тооцсон тодорхой ажиллагаанууд хийж байгаа юм бол байгаа. Гэхдээ зарим нэг хүмүүсийн өөрийнхөө хууль ёс зүйн дүрмээ зөрчсөн ийм үйл ажиллагааны улмаас энэ хүмүүс эрүүдэн шүүгдэж байгаа гэдгийг хэлмээр байна. Тэгээд хамгийн гол юм бол хуульд өөрчлөлт оруулах ёстой гэдгийг би дэмжиж байна. Мөн өмгөөлөгч нарын хувьд бол тэгш эрхтэй шүүх хуралдаан дээр мэтгэлцдэг гэж яриад байгаа гэвч өмгөөлөгч өнөөдөр шүүх хуралдаан дээр тэгш мэтгэлцэж чаддаггүй. Яагаад гэхээр бид нарт бол хэргийг явцад нь хянах юм уу энэ ажиллагаанууд яаж байгааг мэдэх боломж байдаг уу мөрдөгч нар юу гэдэг вэ гэхээр юм хэлэхээр за мөрдөн байцаалт дууссаны дараа л та наадах хэрэгтэй танилцаад л наадхаа ярь бид нар одоо танд үзүүлэх ёсгүй хууль тийм шүү дээ гэдэг. Гэтэл прокурор бол дуртай үедээ татаад хянаад тэр хийлгэх ёстой юмнуудаа хийлгэчихдэг яллах талынхаа юмыг бүрдүүлээд байдаг.

Өмгөөлөгч нар өнөөдөр цагаатгах талынхаа баримтуудыг хийж чадахгүйн улмаас энд тэнд прокурорын байгууллагад хүсэлтээ гаргадаг. Тэгэхээр прокурорын байгууллага бараг бол хүлээж авахгүй шүү дээ. За ингээд шат дараалаад яваад бай, яваад бай, тэгж байгаад л наадах чинь шүүхээрээ л шийднэ шүүхэд л явуулчих гээд ингээд шүүх рүү хамаг ажлаа чихээд байдаг. Гэтэл энэ дээр бол одоо мөрд. Сүүлийн үед цагдаагийн байгууллагаас энэ эрүүдэн шүүхийн эсрэг бас тодорхой ажлууд хийгээд мөрдөн байцаалт авдаг, мэдүүлэг авдаг, өрөө байгуулсанг нь би их үр дүнтэй ажил болжээ гэж бодож байгаа. Энэ дээр бас нөгөө хүнийг эрүүдэн шүүх юм бол тэр камерын бичлэг дагуудна үг яриа нь бичигдэнэ. Одоо бүх газруудад ийм байлгамаар байна мөн энэ эрүүдэн шүүгдсэн хилсээр хэрэг их хүлээсэн хүн.

Сонсгол даргалагч П.Сайнзориг - Танд нэмж хэлэх зүйл байгаа юу? 2 минут нэмээд өгчихье.

Иргэн С.Оюунцэцэг - Миний өөрийнхөө өмгөөлж байсан хэргийн хувьд авахад бол би энд Загдаа гэж дээр нь энэ хэрэгт ял эдлүүлсэн учраас 2 нийгмийн ажилтныг хилс хэрэгт ял хүлээлгэх гээд явж байгаа. Энэ хүмүүсийг хэрвээ ял шийтгэх юм бол зөвхөн ганцхан хохирогчийн мэдүүлгээр ингэж шийдэх гээд шийтгээд байгааг би үндэсгүй гэж үзэж байгаа. Ер нь хүний эрх цаад талд нь гэр бүлийн эрх, үр хүүхдийн эрх давхар зөрчигддөг юм шүү гэдгийг хэлмээр байна. Тэгэхээр ЭХХШТХ-ийн 16.2-т заасан хэргийн талаар нотлох зохих асуудлыг тал бүрээс нь яллах цагаатгах бүх талыг нь бүрдүүлэх дээр нотлох баримтаар эргэлзээгүй байна гэдгийг хангаж л шийдэж байх шаардлагатай гэж үзэж байна.

Сонсгол даргалагч П.Сайнзориг - За баярлалаа дараагийн хүн Ганхуяг гэж хүн байна. 3 номерын микрофон нээж өгье.

Иргэн А.Ганхуяг - Тэгэхээр энэ сонсгол хяналтын сонсгол зохион байгуулж байгаа явдалд их баяртай байна энэний үр дүн гарах байх гэж бас итгэж байгаа. 2019 онд Их Хурлын дэргэд Түр хороо байгуулагдаж Зоригийн гэх энэ хэргийг шалгах түр хороо байгуулагдаж тодорхой хэмжээний үр дүнд хүрсэн. Энэний ач буянаар би хилийн хоригоо цуцлуулж байсан юм. Намайг Арцмаагийн Ганхуяг гэдэг. Би 2015 оны 8 сарын 31-нд Чимгээ, Содномдаржаа нарыг баривчлах тэр нэг өдөр хамт баригдаж Төв аймгийн цагдан хорих байранд бүтэн 8 сар буюу 240 хоног хоригдсон. 2016 оны 4 сарын 28-нд батлан даалтад гарч 2016 оны 9 сарын 21-нд хэргийг хэрэгсэхгүй болгох тогтоол гарснаар шүүхээр ороогүй. 2019 он хүртэл хилийн хоригтой байсан хүн байгаа юм. Тэгээд би энэ дээр товчхон хэлэхэд ер нь энэ хугацаанд би төдийгөөс өдий хүртэл 9 жил нөхөн олговорын талаар хөөцөлдөж байна. Прокурорын

байгууллага болохоор тэр хэрэгсэхгүй болсон тогтоолыг өгдөггүй байсан. Нууц гэдэг үндэслэлээр өгдөггүй байсан. Нууцаас гарсан хойно нь ч өгдөггүй байсан. Тэгээд ноднин буюу 2023 оны 7 сард прокурорын байгууллагаас биш мөрдөн байцаах газраас энэ тогтоолыг авч шүүхэд өгч байсан юм. Нөгөө нэхэмжлэл дээрээ хавсаргаж өгч байсан.

Тэгээд энэ олон улсад болоод Монголын нэр хүнд үнэхээр уначихлаа. Эрүүдэн шүүлтээрээ 1 дүгээр байранд явж байх шиг байна. Дэлхийн олон улсад элэгний хавдар цус харвалтаараа 1 дүгээр байранд явж байх шиг байна. Монгол Улсын нэр хүнд үнэхээр бүх юмаараа уначихлаа. Тэгэхээр энийг цаашид сэргээхийн тулд бид нарын зүгээс юу хийх ёстой юм бэ гэхээр миний бодлоор энэ нөхөн олговрынхоо асуудлыг эхний ээлжид шийдэж өгөөч. Хэзээ билээ? Бас нэг хэдэн жилийн өмнө энэ Их Хурал дээр яригдаж байсан Монгол Улс дефолт зарлах болчихлоо гээд тэнд арга хэмжээ аваад жилийн дараа бид нар дефолт зарлахгүйгээр эдийн засгаа дээш нь авч болж л байсан шүү дээ. Тэгэхээр нэр хүндээ энэ муу муухай юмнаас гаргахын тулд хамгийн эхний ээлжид энэ нөхөн олговрын асуудлыг шийдэх хэрэгтэй. Ингэж байж бид нар энэ балчиг шавраас гарах байх гэж бодож байна. Тэгэхээр энэ дээр хууль санаачилж тодорхой арга хэмжээ авч өгөөч гэж хэлмээр байна.

Сонсгол даргалагч П.Сайнзориг - За 2 минут нэмээд өгчихье.

Иргэн А.Ганхуяг - 2 дугаарт хүний эрхийн байгууллагыг эрх зүйн хувьд жаахан нөлөөтэй байгууллага болгомоор байна. Хууль эрх зүйн хүрээнд түрүүний илтгэл дээр гарч байсан үндэсний нэг байгууллага нөгөөх урьдчилан сэргийлэх байгууллага гэдэг юм байгуулсан юм шиг байна лээ. Тэгэхлээр энэ байгууллагынх нь бүрэлдэхүүнд Монголын иргэдээс оролцуулж өгөөч хэлмэгдсэн иргэдээс энд орох хэрэгтэй байна. Энэ бол их чухал байх гэж би бодож байна. Тэгээд түрүүн нөхөн олговор олгох сан гээд дээр дурдагдсан. Энэ санд ер нь ямар мөнгө байдаг юм болоо энийг бас нэг сонирхож үзмээр байна тэгээд ярих юм бол их юм байна. Гэвч одоо энэ цаг дуусаж байх шиг байна.

Сонсгол даргалагч П.Сайнзориг - Баярлалаа, уг нь Танд нэг минут байсан. Өөр хэлэх зүйл байсан уу? Би 1 минутыг чинь буцааж сэргээж болох юм. За 1 минутыг нь сэргээгээд өгчих.

Иргэн А.Ганхуяг - Би Хан-Уул дүүргийн анхан шатын шүүхэд нэхэмжлэл гаргасан юм. Тэгээд энэ дээр бол Шүүх шинжилгээний хууль гээд ноднин 7 сарын 1-нээс эхлээд мөрдөгдсөн хууль байгаа. Үүний дагуу энэ сэтгэл санааны хохирол гэдэг юмыг шинжээч томилж тодорхойлж өгөөч гэсэн боловч тэндээс ирсэн хариу нь боломжгүй тодорхойлох боломжгүй гэсэн хариу ирсэн байна лээ. Би нэхэмжлэхдээ сэтгэл санааны хохирол нь надаас илүү ар гэрийнхэн гэр бүлийн хүмүүс надаас хэд дахин илүү сэтгэл санаа хохирдог юм. Тийм учраас манай гэр бүл энэ сэтгэл санааны хохирлоос хуваалцах ёстой гэдэг утгаар өгсөн. Тэрийг бол гэр бүлийн гишүүд хамаагүй гээд хаячихсан байгаа. Ер нь бодит байдалд тэнд хоригдож байгаа хүн биш эцсийн эцэст гэр бүлийнхэн нь хамгийн их хохирдог юм.

Сонсгол даргалагч П.Сайнзориг - За дараагийн хүн Нарангэрэлийн Амгаланбаяр, 2 номер дээр суучих уу?

Иргэн Н.Амгаланбаяр - Сайн байцгаана уу? Би сэтгүүлч Өнөрцэцэгийн ар гэрээс өнөөдөр энэ хэлэлцүүлэгт хүрэлцэн ирсэн юм. Эрүүдэн шүүлттэй асуудлаар сэтгүүлч Өнөрцэцэг 2023 оны 12 сарын 04-нөөс хойш эрүүдэн шүүхээр явчихсан хүн юм байна. Тэр өдөр нь болохоор өглөө орой 2 өдөр шүүхийн шийдвэр нь хорих,

хилийн хориг тавих, 1 өдөрт 2 захирамж гараад сар хорих эрхтэй болчихсон. Тэр нь 5 дахь өдөр, сэтгэл санааны бэлдээгүй байсан хүний хувьд хагас бүтэн амралтын өдөр таарчихсан. Ингээд энэ хүнийг эрүүдэн шүүчихсэн юм байна. За энэ нэг дэх асуудал байна.

2 дахь асуудал нь 2024 оны 2 сарын 6-наас 7 сарын 18, 19-нд анхан шатын шүүх нь болоход энэ 2-ын хооронд хоригдсон 150 гаруй хоног нь 4,9 жилээс нь хасагдаагүй байна. Энэ бас мөн эрүүдэн шүүлт. Иймэрхүү төрлөөр анхан шатны шүүхээр ерөөсөө ганц ч өмгөөлөгч оролгүй 3 өдөр хуралдаад энэ хүнд 4,9 жил өгчхөөд байгаа юм. Тэгээд 105 хоног өөрөөр хэлбэл 5 сар гаран суучихсан нь энэ хүнд ерөөсөө унтаад босоод ирэхэд болдог асуудал юм уу, цэвэр эрүүдэн шүүлт болчихоод байгаа юм. Энийг ямар албан байгууллага, холбогдох улсууд, ямар тушаалын хүнд би энэ бичгээ өргөн барьж энэ асуудлаар хөндөж явах вэ гэдгийг та бүхнээс асуумаар байна.

Бас дарга цэргээс энэ хүн 4,9 жилээсээ ерөөсөө давж заалдах шатны шүүхээс ганц ч хоног асуулгүй ганц минут секунд ч асуугдаагүй одоо энд ялагдаад байж байна шүү дээ. Ийм л нийгэмтэй болчихсон байна. Энэ бол эрүүдэн шүүх гэдгийг би өнөөдөр энэ сонсголд ирээд нэлээн хүний амнаас сонслоо. Миний хувьд би малчин хүн хууль сайн мэдэхгүй зүгээр зодож цохиод ингээд байдаг юм уу гэсэн чинь л ерөөсөө л нэг өдөр 2 өөр тушаал гаргангуутаа 5 дахь хагас сайныг аваачаад ингээд хүн уулзуулахгүй гэхихээр чинь тэр хүнийг бүрэн эрүүдэн шүүх гээд хаячхаж байгаа байхгүй юу. Сэтгэл санааны гүн хохиролд оруулчихаж байгаа ийм л асуудалтай байна. Өөр хэлэх юм алга даа.

Сонсгол даргалагч П.Сайнзориг - За дараагийн хүн Болормаа гэж хүн байна. Даваадоржийн Болормаа хаана байх шиг байна. Болормаа гэж байна уу? За байхгүй байна гэж ойлголоо. О.Шинэбаяр гэж байна уу? 7 номер дээр сууна уу? Тэр бүсгүйд хэлээд зөвөөр ойлгуулаарай. Цаг алдаад байна. Шинэбаярын микрофон 7 номер.

Иргэн О.Шинэбаяр - Бүгдэд нь энэ өдрийн мэндийг хүргэе. Би бол сэтгүүлч Шинэбаяр 3 асуудлыг хөндөж ярьж бодож байна.

1 дүгээрт Монгол Улсын шүүх байгууллага дампуурчихсан юм шиг л юм хэлэлцүүлгийн үеэр яригдаад байна. Тэгээд нөгөө алуулсан Зориг нь ирээд үгээ хэлэх биш алсан нь 3 шатны шүүхээр тогтоогдчихсон хүмүүс ирээд төрөөс нэхэмжлэл нэхээд сууж байх юм. Шүүх рүүгээ дайраад. Одоо шүүхээс нь төлөөлөл байвал та нар одоо өөрсдийгөө тайлбарласан тайлбарыг хиймээр байна. Энийг маш олон хүн үзэж байна. Гадуур энэ шүүх хуулийн байгууллага өөрсдийгөө та хэд нэг өмөөрчихье гэх нь хаашаа юм. Тайлбараа хий. Ямар учиртай юмнууд болоод яваад байдгийг.

2-т нь Монгол Улсын Засгийн газар бол өөрөө ял захиалдаг болчихсон Оюун-Эрдэнэ, Засгийн газрын Тэргүүн шадар сайд Амарсайхан гэдэг хүнийг би яг энэ сонсгол дээр одоо тухайлаад ярьчихъя гэж бодож байна. Маш олон сэтгүүлчид хэрэг захиалсан эхнээсээ би эрүүгийн ялтан болчихсон явж байна. Баярмаа сэтгүүлч дахиад эрүүгийн ялтан болох гээд явж байна. Ерөнхийдөө энэ хуулийн гажуудал энэ хуулийг ашиглаж Эрүүгийн хуулийг ашиглаж Монгол Улсын Засгийн газар нь, дээрээс нь Тэргүүн шадар сайд нь, хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчдийг шантаажилдаг болсон. Бид нарыг хүмүүс шантаажилдаг гэж ярьдаг бол Засгийн газрын тэргүүн Шадар сайд нь хэвлэл, сэтгүүлчдээ шантаажилдаг нэг ийм байдал бий болчихсон байгааг анхаарч өгөөч гэж хүсмээр байна.

3 дугаарт нь Хууль зүй, дотоод хэргийн сайд Алтангэрэл сайд хаачив? Өөртэй нь ямар ч хамаагүй царигийн асуудал руу ороод олон юм яриад оролцох ёсныхоо хэр хэмжээнийхээ асуудлыг ярихгүй мөртөө өнөөдрийн сонсголд байхгүй нарийн цагирагийн төмөр зам нь буруу байсан юм гээд яриад хүмүүсийн толгой угаагаад сууж байсан. Алтангэрэл сайдыг яг энэ хэлэлцүүлэгт оруулж ирмээр байна. Цэргийн дэглэлт гэдэг юм чинь газар авчихсан, би өнөөдөр батлан хамгаалах салбар луугаа дайрах гэж байгаа юм биш. Хоёрхон сарын өмнө 2 цэрэг дэглүүлээд төмсөг нь задраад ирчихсэн хагалгаанд орсон өнөөдрийг хүртэл асуудал нь шийдэгдээгүй, тэгээд асуухаар ингээд зугтаагаад байж байдаг өөртэй нь ямар ч хамаагүй юмнууд ингээд яриад явж байдаг.

Ийм ийм ноцтой асуудлууд байгаа тул энэ дээр анхаармаар байна. Эцэст нь хэлэхэд бид нар тусгаар улсаа өөрсдийн гэсэн шүүхтэй хуулийн байгууллагатай боловч, мөрдөгчийн шатанд, прокурорын шатанд маш их асуудал байгаа. Хэргийн материалтай танилцуулдаггүй нуудаг хэвлэж авах боломжоор хангадаггүй. Ингээд энэ хэргийг нь явуулсаар байгаад шүүх дээр очдог 3 шатны шүүх нь үнэхээр хэрэг хийсэн бол ялыг нь өгч байгаа шүү дээ. Хэрэг хийгээгүй бол 3 шатны шүүхээр ороод цагааддаг. Шүүхийн байгууллагад чинь алдаа гаргадаг шүүгчид байна. Тэгэхдээ Монгол Улсын шүүх хуулийн байгууллага тэр чигээрээ дампуурчихсан юм бол ерөөсөө байдаггүй шүү гэдгийг би хориод удаагийн эрүүгийн хэрэгт шүүгдэгчээр орсон хүний хувьд бас хэлье гэж бодож байна. Шүүхийн байгууллагаас төлөөлөл ирсэн бол та бүхэн ямар учиртай ямар хэргүүд дээр ажилласан, тэр хэргийн доторх материалыг нь ярьдаггүй байх, тэгэхдээ ерөнхий шүүхийнхээ процессыг хүмүүсийг ойлгох хэмжээнд тайлбарлаж өгөөсэй гэж чин сэтгэлээсээ хүсмээр байна.

Сонсгол даргалагч П.Сайнзориг - Дараагийн хүн Болормаа байгаа. Оролцогчид бас нэг зүйлийг анхааръя. Бие биедээ хүндэтгэлтэй дээрээс нь энэ нөхцөл байдал дээр хүнийг нэр төр, алдар хүндэд хамаагүй халдаж болохгүй гэдэг зүйлийг би энэ дашрамд хэлмээр байна. Болормаа ирсэн байна. Танд микрофоныг нээж өгье 2 номер.

Иргэн Оюунцэцэг - даргалагч аа! Энэ Шинэбаяр гээд байгаа сэтгүүлч авсан хүмүүс нь ирчхээд мөнгө нэхээд байна гэж хэл дээ. Тэгэхээр өнөөдөр Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар бол гэм буруугүй.

Сонсгол даргалагч П.Сайнзориг - Оюунцэцэг гуай ойлгож байна би сая хэллээ, хэдүүлээ дэгээрээ явъя. Бүрэн мэдээлэлтэй байж ярина шүү бие биенийгээ доромжилж болохгүй шүүхийн шийдвэр гарсан юм байна энэ дээр бүгд тал талын мэдээллийг авч байгаа, ямар нэгэн байдлаар үндэслэлгүйгээр бие биенээ доромжилж болохгүй. Ингээд дэгийн дагуу явъя 2 номер Болормаа.

Иргэн Болормаа - Сайн байцгаана уу? Энэ өдрийн мэнд хүргэе. Би товчхон ярина. Би эмэгтэйчүүдийн хорих ангид байж байгаад гарч ирсэн хүн байгаа юм. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газартай холбоотой зүйлийг би ярина. Энэ асуудлаар Улсын Их Хурлын гишүүд, Хууль зүйн яам олон газруудад санал хүргүүлээд хамтраад ажиллаад явж байгаа болохоор энэ хууль батлах хэмжээний эрх мэдэлтэй сууж байгаа Улсын Их Хурлын гишүүдэд хандаж хэлж байгаа юм.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль мөн үе үеийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга нарын дур зоргоороо гаргасан энэ журмуудаас болж хорих анги, цагдан хорих байр, баривчлах байранд байгаа хүмүүсийн эрх зөрчигддөг. Тэгэхээр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг яаралтай шинэчлэн найруулах хэрэгтэй. Энэ 2017 оны хууль тэнд байгаа хорих ял эдэлж байгаа хүмүүстэй холбоотой Хөдөлмөрийн хууль, Боловсролын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын

хууль бүгдээрээ шинэчлэгдээд, найруулагдаад явж байгаа.

Тэгээд энэ 10 шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль болон тэр журмууд өөрөө маш их хүний эрхийн зөрчилтэй хүний эрхэд шууд халдсан, хүний эрхийг хязгаарласан зүйл заалтууд их байдаг учраас Улсын Их Хурлын гишүүд ээ бид нар Хориход эрх нь хязгаарлагдсан иргэдийн эрүүдэн шүүлтэд өртөж байна уу? Хүнлэг бус хэрцгий хандалтад өртөж байгаа зүйлийг мянга яриад дэмий. Энэ утгагүй хууль журмуудыг нь цэгцэлж шинэчлэх шаардлагатай юм. Гэхдээ шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг шинэчлэн найруулахдаа зөвхөн Хууль зүй, дотоод хэргийн яам, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар сууж байгаад шинэчилдэг энэ байдлыг одоо болио. Энэ дээр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам нь, Эрүүл мэндийн яам нь, Сангийн яам нь, Боловсролын яам нь, Өмгөөлөгчдийн холбоо, Хуульчдын холбоо, иргэний нийгмийн байгууллагууд нь ажлын хэсэгт нь эхнээс нь авхуулаад дуусан дуустал нь энэ хүмүүсийг оролцуулж өгөөч. Тэгэхгүй бол зөвхөн Хууль зүй, дотоод хэргийн яам хүний эрхээр өчнөөн жил энэ шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг 4 удаа шинэчлэхэд дөрвүүлэнд нь л энэ 2 газар оролцлоо шүү дээ. Тэгээд энэ байдлыг одоо болиулж өгөөч 1-д.

2-т би нэг зүйл хэлмээр байна. Энэ хорих анги, цагдан хорих байр, баривчлах байруудад байгаа камеруудыг дуу бичлэгийг нь давхар бичдэг болгож өгөөч. Тэгэхгүй бол сэтгэл санааны хүчирхийлэл, шаналгах, эрүүдэн шүүлтийг чөлөөтэй хийдэг. Тэгээд прокурор ирээд шалгахаар зөвхөн дүрс байгаад байдаг байхгүй юу. Амаараа юу гэж доромжилж байгаа нь сонсогддоггүй тэгэнгүүт таныг эрүүдэн шүүгээгүй байна шүү дээ таныг доромжлоогүй байна шүү дээ нэр төрд чинь халдаагүй байна шүү дээ гэсэн асуудал яригдаад байдаг. Тэгэхээр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, баривчлах байр, цагдан хорих байруудад байгаа бүх камеруудыг дуу бичлэгтэй болго тэгээд өдөр шөнийн камерыг бичдэг тийм хэлбэрт оруулж өгөөч гэж би хүсэж байна. Хууль зүйн сайд нь хаачихав алга болчихлоо. Дараагийн нэг зүйл нь болохоор энэ шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын...

Сонсгол даргалагч П.Сайнзориг - Ярьж дуусаагүй гэж байна. 2 минут нэмж өгье.

Иргэн Болормаа - Энэ хорих ангийн дарга, дэд дарга, төлөөлөгч нар, ер нь энэ шүүхийн шийдвэрт ажиллаж байгаа хүмүүс эрүүдэн шүүлт хүний эрхийн зөрчил гаргадаг юм. Би энэ талаар хорих ангид байхаасаа тэмцсэн. Надад зөвхөн прокурорын байгууллагад гаргасан энэ зүйл 20 хоригдол багатай гаргасан хариу ирсэн. Бүгдээрээ төрийн албан хаагчийг өмөөрсөн бичгүүд байна. Яагаад би энийг хэлж байна гээд. Тэгэхээр хорих ангийн удирдлагаасаа авхуулаад нөгөө нэг ахлагчаа хүртэл ингээд дэд ахлагчаа хүртэл хүний эрхийг зөрчидөг тэгээд гомдол гаргахаар яадаг вэ гээч дэвшүүлэн зайлуулна гэдэг нэг гоё арга Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар хэрэглэдэг. 407 дугаар хорих ангийн даргыг 2022 оны 11 сарын 14-нд асуудал гаргалаа гээд ажлыг нь авчхангуутаа шууд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын хорих ял эдлүүлэх албанд аваачаад ажиллуулчхаж байгаа юм. Тэгж байснаа дараа нь хүүхдийн хорих руу аваачаад даргаар нь тавьчихаж байгаа юм. Тэгээд сая Хүний эрхийн Үндэсний комиссоос шалгалт хийгээд асуудал гараад ирэнгүүт тэр хүнийг ажлаас нь чөлөөлөнгүүтээ буцаагаад эмэгтэйчүүдийн хорих ангийн дэд даргаар аваачаад тавьчихаж байгаа юм.

Тэгээд энэ хүн хүний эрхийн зөрчил гаргасан янз янзын асуудал гаргасан. Энэ хэдэн хурандаа, дэд хурандаа, хошууч нараа дэвшүүлэн зайлуулдаг энэ арга барилыг нь болиулж өгөөч гэж би хүсэж байна. Энэ үнэхээр ноцтой шүү. Энд тэнд очоод л хүний эрх зөрчөөд яваад байдаг, эрүүдэн шүүлт хийгээд яваад байдаг.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар энэ хэдэн хурандаа, дэд хурандаа, хошууч нарт одоо ямар их хэмжээний өртэй юм болоо гээд би гайхаад байдаг юм шүү. Өр төлбөр байдаг юм бол тэрийгээ шүүхээр ороод шийдээрэй. Битгий энэ хоригдогч нарын, хэдий хоригдол гэмт хэрэг үйлдсэн ч гэсэн энэ чинь Монгол Улсын иргэд хэвээрээ байгаа юм шүү. Энэ саналуудыг Улсын Их Хурлын гишүүд минь өөрсдийнхөө хууль боловсруулж байгаа ажлын хэсгийнхэндээ дуулгаад, миний энэ саналыг заавал тусгаж өгөөрэй гэж гуйж байна. Баярлалаа.

Сонсгол даргалагч П.Сайнзориг - Танд баярлалаа. Дараагийн хүн нь Д.Ганбаяр. 7 дугаар микрофон нээж өгье.

Иргэн Д.Ганбаяр - За би яг одоо эрүүдэн шүүгдэж байгаа шүүгдсэн энэ жилд эрүүдэн шүүгдсэн 2 кэйсийг ярья. Нэг асуудлаас болж хуульч өмгөөлөгч Батбаяр гэдэг хүн хорвоогийн мөнх бусыг үзсэн. Тэр хүн нас барахаасаа нэг хоногийн өмнө хүний эрхийн хороонд өргөдөл гаргасан. Тэр өргөдлийг нь би уншаад танилцуулчихья гэж бодож байгаа юм. Мөрдөн байцаах албаны эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн хошууч Бямбацэнгэл, дарга Батмөнх нар нь иргэн Г.Батбаярыг хийгээгүй гэмт хэрэг дээр нь холбогдуулан шалгахдаа хүнлэг бусаар, хэрцгий хандаж, сэтгэл санаанд нь шаналал зовуурь үүсгэж нотлох баримтыг устгах, өөрчлөх, эзэнгүй хэрэгт гүтгэхийн тулд бусдын орон байранд хууль бусаар нэгжлэг үзлэг хийж хууль зөрчин явуулж хуурамч нотлох баримтыг бүрдүүлэх.

Хамгийн гол асуудал нь Эрүүгийн хуулийн 13, 14 худал мэдээлэл тараах гэдэг асуудлаар талийгаач Батбаярт хэрэг үүсгэсэн.

Энэ дээр тулгуурлаад орон гэрийг нь нэгжсэн, тэр хүнд шаналал зовлол үзсэн хэдхэн хоногийн дараа тэр хүн алга болоод хорвоогийн мөнх бусыг үзсэн. Тэгээд энэ хүн хэлэхдээ Мөрдөн байцаах албаны Батцэнгэл гэдэг хүн Эрүүгийн хуулийн 22.1, 21.1.12, 21.1.2, 21.9.3, 13.6 дахь заалтын гэмт хэргийн шинж агуулгатай байгааг шалгаж өгнө үү гээд өгчихсөн.

Энэ асуудлаар гомдол гаргасан Хан-Уул дүүргийн 1 дүгээр хэлтэс дээр харамсалтай нь энэ асуудал явагдаагүй. Одоо болтол мань хүний яагаад нас барсан гэдгийг нь тогтоолгож чадахгүй байгаа. Энэ асуудлын эхлэл нь түүний охиноос эхлэлтэй. Бүхэл бүтэн 2021 оноос эхлээд тэр охиныг дарамталж байсан охиныг нь хаана явж байна гэдэг зургийг нь аваад аав руу нь фэйсбүүкээр явуулдаг байсан. Эцэст нь тэр охиныг сүүлд нь кофе асгасан болгоод сошиалаар сэвээд тухайн охин өнөөдөр гадаад улсад Монголд ирж амьдарч чадахгүй, маш хүнд нөхцөлтэй, айдастай байгаад байна. Аав нь хорвоогийн мөнхбусыг үзсэн, энэ асуудлыг шалгаж өгөхийг хүний эрхийн дэд хорооны дарга Эрдэнэболдод албан хүсэлт өгсөн байгаа юм.

Хоёр дахь асуудал. Энэ хүний бас нэг хийж байгаа асуудал нь надад учруулсан шүүх хуралд ажиглагчаар оролцсон Хүний эрх хамгаалагч эрх зүйн байдлын тухай хуулийн дагуу оролцсон. Гэтэл энэ хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль зөрчиж хэвлэл мэдээллээр шүүх хуралдааныг мэдээлэх тухай журмын дагуу шүүх хуралдааны нээлттэй, шууд явж байхад үүнийг таслан зогсоогоод сүүлд нь аргагүй байдалд ороод шүүхийн тамгын газарт өргөдөл гаргахад хүлээж аваагүй. Тэгсний улмаас шүүхийн гадна үг хэлснийх нь төлөө Шүүхийн ерөнхий зөвлөл нь өөрөө хохирогч болоод иргэнд эрүүгийн хэрэг үүсгэж байгаа юм.

Сонсгол даргалагч П.Сайнзориг: Хараахан дуусаагүй юм байна тэ? За 2 минут өгчихье.

Д.Ганбаяр: Цагдаагийн ерөнхий газрын даргад нь Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Онончимэг нэг бичиг явуулаад энэ хүнд хариуцлага тооц эргээд

мэдэгд гэсэн. Нөгөө мөрдөн байцаах ажиллагааны бие даасан байдал хаана байгаа юм байхгүй. Тэгээд сүүлд нь энэ явсаар байгаад нөгөө прокурорын дуудан ирэх мэдэгдэх хуудас гэж байдаг юм. Тухайн мөрдөгч нь 7 сарын 05-ны өдрийнхөө хуудаст 7 сарын 06-ны өдөр болгон тухайн захиргааны актын огноог өөрчилсөн, энэ нь хууль зөрчсөн үйлдэл гаргасан. Тэгээд шүүхээс албадан ирүүлэх захирамж гаргуулаад албадан ирэхдээ эрүүдэн шүүгээд миний биед гэмтэл учруулсан тухайн гэмтэл учруулсан асуудал нь байдаг.

Сүүлд нь хэргийн материалтай танилцахад хавтаст хэргийн 248, 249, 250 дугаар хуудсанд дуудан ирүүлэх мэдэгдэх хуудас гэхээд, огноогүй, дугааргүй, хүний нэртэй дуудан ирүүлэх мэдэгдэх хуудсыг нотлох баримтын хуурамчаар бүрдүүлж байгаа юм. Чингэлтэй дүүргийн прокурор хэн байна? Дэлгэрмөнхийн гарын үсэгтэй энэ асуудлыг нь гомдол гаргаад өгөхөөр нийслэлийн Ерөнхий прокурор Ариунболд нь О нь завсарласан нь үнэн юм байна гэж гаргаж байгаа. Улсын ерөнхий прокурор нь болохлоор завсарласан юм байна. Гэхдээ энэ чинь гэмт хэргийн чанартай үйлдэл биш байна, гээд энэ буруу үйлдлээс болоод хүн хохирчхоод байхад ямар ч арга хэмжээ авдаггүй.

Эцэст нь энэ асуудлаар гомдол гаргахлаар мөрдөн байцаах албаны тусгай субъект очдог. Тусгай субъектийн хэлтэс рүү очихлоор Цагдаагийн ерөнхий газрын дарга нь Мөрдөн байцаах албаны дарга Мишигдоржтой дэд дарга Ганзоригийн гарын үсэгтэй гэмт хэрэгт нөлөөлөх байдлаар албан бичиг явуулаад хэргийг хаалгуулдаг. Ийм байхад яаж эрүүдэн шүүлт болихгүй байх юм бэ? Өнөөдөр Эрүүгийн хууль дээр бүгд байж байгаа. Эрүүдэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.6 дээр байгаа шүү. Шүүх, прокурор, мөрдөгч нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагааг хуулийн дагуу явуулна, ерөөсөө шууд тулгахгүй гэдэг. Тэгтэл 16.1.2 гомдол гаргахад хүлээж авдаггүй энийг шийдэж өгөөч гэдэг хүсэлтэй байна

Сонсгол даргалагч П.Сайнзориг - Дараагийн хүн Зоригт гуай. 7 дугаар микрофон, та холдуулаад, үг хэлэх бололцоог хангаад өгөөрэй.

Иргэн Ч.Зоригт - Сайн байцгаана уу? Энэ өдрийн мэнд хүргэе. Намайг Чойжамцын Зоригт гэдэг хүн би одоо 73 настай, 1952 онд Улаанбаатар хотод 1 дүгээр төрөхөд төрсөн, бага тойрууд насаараа байсан тэгээд 1986 онд би хөгшнийхөө нэр дээр 1 дүгээр хороололд байранд орж байж байгаад. Тэгээд манай байрыг нэг банк бусад нэг нөхөр аваад тавиад ганцхан манай хөгшиний гарын үсэгтэй тэр байрыг тавьсан.

Би шүүхээр өрхийн тэргүүлэгч нь би зөвшөөрөөгүй гээд яваад одоо 7 жил хөөцөлдөж байна. Шүүх сэргийлэх болохоор танд бол хамаагүй. Тэр хүн чинь (Баадай) энэ хотын барилга трессээс авсан байр тэр хүн л хариуцах ёстой тэрнээс та нарт хамаагүй гэдэг. Би одоо 3 охин 12 зээтэйгээ гудамжинд гарчихсан байж байна. Би сонгуулийн үеэр ч гэсэн та нарт ярьж л байсан. Би тэр 2019 онд энэ талбай дээр суулт хийгээд зарлаад шударга 5 гээд явж байх үед чинь би ганц тэргэнцэртэй хүн би хүрч ирж л байсан. Надь бол ерөөсөө за яах вэ, тэр цагдаад оч, тэрэнд оч гээд. Тэгээд өчигдөр хүртэл 11-ээс Сонгинохайрхан цагдаагийн хэлтэс дээр Цамбагарав дээр оч гээд, Цамбагарав дээр очсон чинь таны энэ бол хамаагүй шүү дээ. Энэ хүн чинь тэр Баадай гэдэг хүний нэр дээр байсан байр байна. Тэрийг нь энэ банк бусынхан хурааж авсан.

Тэрийг яагаад авсан бэ гэхээр манай хүнийг коридорт суулгаж байж анхных нь гарын үсэг зурсан 2 дахь дээр нь тэр банк бусын Туул гэж хүүхэн нөхөртэйгөө цуг хүрч ирж байгаад гэрээс дагуулж гараад үгүй наадах чинь даралт нь ихэдчихсэн байна гэж байхад чинь хүчээр дагуулж гараад тэр машиндаа суулгаж байгаад 3

бичиг дээр гарын үсэг зуруулсан гэж байгаа юм. Чухам юун дээр зуруулсан манай хүн чинь өөрөө тайлбарлаж чадахгүй, тэргэнцэр дээр очоод сууж байхад та хэвтэж байсан хүн босчихсон тэргэнцэр дээр суучихсан зүгээр зүгээр гээд. Тэр Эрдэнэ гэж хүн бол энэ цагдаагийн байгууллага хүчний байгууллагыг бүрэн эзэмшдэг хүн та нар бол ийш тийшээ яваад хэрэггүй ээ битгий зарга хийгээд бай гээд л. Тэгээд л тэр 2 удаа шүүх хуралд орсон гэж байгаа. Тэгэхэд чинь шүүх хуралд бид нарын хэн нь ч ороогүй ганцхан тэр нөгөө залилан хийсэн хүүхэн банк бусын эзэн 2 орсон тэгээд 2 удаа шүүх хурал ороод тэр нөгөө залилан хийсэн хүүхэн чинь би төлнө, би болохгүй бол энэ байрыг нь өгнө гээд л гарын үсэг зурчихсан гээд байгаа юм. Тэгээд чухам бид нар яагаад ч юм ингээд хохирчихсон. Би одоо гудамжинд гарчихсан байж байна. Одоо энэ 10 сарын 2-нд тэр түрээсийн байранд оруулчихсан байгаа. Тэгсэн тэр нь одоо 12 сарын 01-нд гар гэж байгаа.

Сонсгол даргалагч П.Сайнзориг - Таны цаг дуусаж нэмж хэлэх юм байсан уу? Нэг минут сунгаад өгье. За нэг минутад багтаагаад мэдээллээ өгөөрэй.

Ч.Зоригт: За тэгээд би бол ерөөсөө 12 сарын 01-нд орон сууцнаас хүрч ирээд тэр байрнаас гар л гэвэл би тэр ач зээ нарыг талын нэг тараачхаад л өөрөө энэ талбай дээр хүрч ирж шууд суулт хийнэ. Нүцгэн суусан ч хамаагүй хувцастайгаа суусан ч хамаагүй суулт хийгээд, амь насаа, тэртээ тэргүй далан хэд хүрчихсэн хөгшин эмнэлэг ч байхгүй. Тэр битгий хэл халамжаас надаа улирлын 60 мянган төгрөг өгдөг эмийн эмчилгээнд тэр 60.000 төгрөгөөр нэг удаа би памперс авахад 72.000 төгрөг шүү дээ 10 ширхэг, тэр мөнгөөрөө памперс ч авч чадахгүй тийм л ард түмэнтэй яваа ийм л язарчихсан улсууд. Хий агаарт хууль батлах гээд байгаа юм биш.

Сонсгол даргалагч П.Сайнзориг - За дараагийн хүн Эрдэнэтуяа гэж хүн байна. Ш.Эрдэнэтуяа 2 номер уу. За дараа нь Туяа гээд хүн бас ойртоод сууж байгаарай.

Иргэн Ш.Эрдэнэтуяа - Энэ өдрийн амар амгаланг айлтгая. Хүний эрхийн зөрчил болон дамаа хохирогчийн эрхийн зөрчлийн талаар үгээ хэлэх гэж ирлээ. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийг “Био комбинат” төрийн өмчит хувьцаат хариуцлагатай компанийн хуулийн этгээд 2019 оны 9 сарын 20-нд ажилчдынхаа хийх ёсгүй ажлыг ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлыг хийлгэж эрүүл мэндээр хохироочхоод хууль түүнд нийцүүлэн гаргасан захиргааны эрх зүйн акт буюу 2020 оны 4 сарын 09-ний өдрийн 01 06079/126 тоот мэргэжлийн хяналтын улсын ахлах байцаагчийн дүгнэлтээр хүлээсэн үүргээ биелүүлэхгүй өнөөдөр хохирогч хохирогчийн ар гэрийг маш олон гэмт хэргийн золиос болгож эцэст нь хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг бүлэглэж үлдэх гээд завдаж удаа дараа ингэж байна.

Ийм учраас би энэ эрхээ эдлэхээр Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн дагуу хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийн 29.1-д заасан үүргээ ажил олгогч биелүүлээгүй нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс олгох өвчний даатгалын сангийн тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн үйлдвэрлэлийн осол хурц улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан даатгуулагчийн тэтгэврийг тогтоогоогүй. Харьяаллын бусаар хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн Эрүүл мэндийн төвийн Нийгмийн даатгалын ерөнхий газрын эмнэлэг Хөдөлмөрийн төв комиссын сэтгэцийн өвчин хурц хордлого мэргэжлээс шалтгаалахаар ингээд тогтоочхоод эс үгүй бол чи тэндээс албадан эмчилгээ нь байж аминдаа алдвал эс үгүй бол чи нийгмийн даатгалын сангийн тэтгэвэр тэтгэмжийн хуулиар чи буруу тэтгэвэр авч, амьдрал, амь нас, эрүүл мэнд, эд

хөрөнгөөрөө хохир гээд ийм олон гэмт хэргийн золиос болгоод хохироочихсон.

Өнөөдөр энэ байна 2019 оны 9 сарын 20-ны өдрийн, 2020-оны 4 сарын 09-ний өдрийн мэргэжлийн хяналтын улсын ахлах байцаагчийн дүгнэлт. Энэ бол Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 62.1-д түдгэлзүүлж болдог эрх зүйн акт. Өөрөөр хэлбэл энийг үндэслэж миний хөдөлмөрийн чадвар алдалтыг Хан-Уул дүүргийн Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комиссоор шийдвэрлүүлэх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хуулийн 30.2-т зааснаар харьяа дүүргийн эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссоор шийдвэрлэх чиг үүрэгтэй.

Сонсгол даргалагч П.Сайнзориг - За уучлаарай, Өнөөдөр би дэг сахиулах үүрэгтэй, ийм албан тушаал байгаа. Өнөөдөр эрүүдэн шүүх хүнтэй хүнлэг бус харьцах энэ эрхийн хэрэгжилт байгаа. Таны энэ тухайлсан асуудлуудыг хэдүүлээ жичид нь бас ярьж болно. Хүний эрхийн Үндэсний хорооны дарга байж байгаа хэдүүлээ, Таныг би бас дэгээ барьж бусдыг хүндэтгэхийг хүсэж байна манай Улсын Их Хурлын, Хууль зүйн, байнгын хороо, дэд хороо болон Хүний эрхийн дэд хороонд бас хандаарай гэдэг зүйлийг хэлмээр байна. Харин өнөөдрийн сонсголын сэдэв юм байгаа. За сүүлийн нэг минутыг нэмээд өгчих. За тэгээд энэ нэг минутандаа багтаагаад юмаа хэлнэ үү.

Иргэн Ш.Эрдэнэтуяа - Би энүүгээр хөдөлмөрийн чадвар алдалт амьсгалын замаар нэвтэрсэн химийн бодисын хордлого гэсэн. Энэ харьяаллаараа хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээг хураагаад байгаа. Захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэлээ шийдүүлэх гэхээр хуулийн этгээдийг шүүх төлөөлөх эрхгүй хүн орж өмгөөлөгч Мандахсайхан орж ирчхээд амь насанд заналхийлээд сууж байна. Шүүх буруу шийдвэр гаргах гээд өнөөдөр аминд халдах гээд сууж байна. Шүүхийн танхимд яаж байна гэвэл дэг сахь хэнийг хамаагүй оруулж ирж байна. Захиргааны хэргийн шүүхэд анхан болон давж заалдах шатанд дэг сахь тэгээд эрх чөлөөнд холдуулж байна. Шүүхийн цагдаагаар энэ хүний эрхийн зөрчил биш юм уу хохирогч өнөөдөр зөрчигдсөн эрхээ сэргээж шүүхэд хандаж байна шүү дээ.

Энэ хүний эрхийн зөрчил биш юм уу. Амьд явахын эсрэг гэмт хэрэг 10 сарын 08-нд үйлдэх гэж завдлаа. Энэ талаар бид нар гомдлоо гаргасан. Энд Ерөнхий прокурорын газрын орлогч прокурор Чинбат прокурор сууж байна. Миний гомдлоор шалгагдсан хэргийг харьяаллын бусаар шалгаад хэрэг шалгаж шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг бүлэглэж үлдсэн мөрдөгч нартай хариуцлага тооцоогүйгээс болж өнөөдөр миний нэр төрд халдсан байна. Үйлдвэрлэлийн осол, хурц хөдөлгөөн, улмаас хөдөлмөрийн чадвар алдсан даатгал...

Сонсгол даргалагч П.Сайнзориг - Таны энэ ярьж байгаа асуудлууд дээр дараа дараагийн байгууллагууд бас хандаж болно. Бид нар Хүний эрхийн Үндэсний Комисс, Дэд хороонд хандаад гаргачий, бид хэд бас байнгын хороогоороо ярья. За ингээд дэг барья. Туяа гэж хүн байна уу. 7 номер, үгүй хүнд шилжүүлж болохгүй, ийм дэгтэй бололцоогүй учраас таны үг хэлэх эрхийг би зогсоолоо.

Дараагийн Бат-Ялалт хэлчихсэн Гансүх гуай суучих урагшаа. 2 номерын микрофоныг нээе.

Иргэн Гансүх- Та бүхний энэ өдрийн амар амгаланг эрье. Тэгэхээр миний хэлэх гэж байгаа юм бол эрүүдэн шүүхэд холбоотой их олон баримтыг хэлж болно гэхдээ ерөнхий, үүний цаад талд юунаас эхлэлтэй вэ гэдгээсээ эхлээд энийг ямар байдлаар цаашаа засах ёстой юм бэ гэсэн байр сууриа л илэрхийлэх гэсэн юм.

Сонсгол даргалагч П.Сайнзориг - За ингээд Л.Гансүх гуайн минутыг эхнээс

нь тавьж өгье.

Иргэн Гансүх- За баярлалаа. Хурал даргалагч аа. За тэгэхээр энэ олон хүмүүсийн бухимдал ерөөсөө энэ хууль хяналтын байгууллагын завхралыг эхнээс нь засахгүй байгаатай л холбоотой юм. Яг ийм хурал бол аль 7 жилийн өмнөөс эхлээд л хийж байсан юм. Нямбаатар сайд анх эхлээд л яагаад энэ хонгил гэдэг юмыг хууль хүчний байгууллагынхан хэрхэн хонгил үүсгэсэн талаар энийг хэрхэн засаж болох вэ гээд бүр нэр нь хүртэл тийм нэртэйгээр хурал хийж байсан юм.

Яг энэ танхимд өөрөө таны байран дээр Нямбаатар сайд сууж байгаад бид нар хурлыг нь зохион байгуулалцаад хийж байсан юм. Тэгэхээр би энэ дээр хэлэх гээд байна вэ гэхээр ерөөсөө энэ хууль хүчний байгууллагуудын завхралыг Элбэгдорж гэдэг хүн удирдаад Хурц гэдэг хүнээр хууль хүчний байгууллагуудын хонгилыг бий болгоод тухайлбал прокурорын дэргэдэх мөрдөн Авлигатай тэмцэх газрын доор аваачиж хийгээд, прокурор, шүүх, цагдаагийн албан хаагчид, тагнуулын албан хаагчдыг бүгдийг нь Авлигатай тэмцэх газрынхан шалгадаг болгож байгаад.

Тэгээд эхлээд хууль хүчнийхээ байгууллагынхныг хүчирхийлээд өөрөөр хэлбэл эрүүдэн шүүлт тэлж, тулгаж, хүчирхийлж хонгилыг бий болгож байгаад өөрсдийн хүмүүсийг тавьж энэ хууль хүчний байгууллагын завхралыг хийгээд хувь хүнийг дээрэмдэхээс авхуулаад эхэлсэн та нар мэдэж байгаа шүү дээ. Алтан Дорнодын Ганболдыг яаж Дорлигжав дээрэмдэж байсан Хурцтай нийлээд гэх мэтчилэн. Ингээд л олон жишээ мэдэж байгаа. Хамгийн сүүлд төрийн эргэлт хүртэл хийсэн шүү дээ. Тухайлбал, Алтанхуягийн Засгийн газрыг унагаахын тулд 2 удаа оролдоод болохгүй болохоор нь ахлах зөвлөх болон Дэнзэн гэдэг юм гаргаж ирж байгаад тэгээд шонд өлгөж харуулж байгаад за та нар энэ гарын үсэг зурдаг уу шийдвэр гаргадаг уу?

Энэ ахлах зөвлөхөөр хамгаал хэлж чадахгүй Алтанхуяг та нарыг хамгаалахгүй шүү гэж байгаад Их хурлын гишүүдийг 7, 8 хүнийг шууд манай намынхныг хөөж гаргасан байхгүй юу айлгаад. Тэгээд тэр дунд би нэрээр нь хэлж чадна. Тэгэхдээ тэр нэр хэлээд яах вэ. Яг ганцхан хүний нэрийг хэлээд дахиад л нөгөө муу Ганболдыг ах Дэмбэрэлийг шантаажилж байгаад хуралд нь оруулаагүй тэр өдөр аягүй олон их хурлын гишүүний хаалгаар орж гараад энэ хуралд кнопоо дарна шүү тэгнэ шүү гэж хэлсэн гэсэн. Тэгэхдээ яах вэ энэ бол гэрчгүй гэж яригддаг шиг яриагаар бол бүгд л хоорондоо ярьдаг байхгүй юу. Би бол зургаа ороогүй хүний нэрийг нь шууд хэлж чадна. Тэгэхдээ одоо хайран цаг байна. Тэгээд 7 дахь нь Дэмбэрэл ингээд ороод кноп дарахад ганцхан хүний саналаар Алтанхуягийн Засгийн газар унаж байсан юм. Тэгээд Алтанхуягийн Засгийн газар унаад юу болсон юм?

Нөгөө алдарт Дубайгийн хэрэг чинь нөгөө саяын одоо яригдаж байгаа 5 толгойн чинь юмыг Сайханбилиг өөрөө тэр 5 толгойн ажлын хэсгийг ахлаад хэрэг эрхлэхийн дарга байхдаа Пи Боди гээд 3 компани манай төрийн 5 толгой Пи Боди Юу 3-ыг Шинхуа 3-ыг оруулаад явж байсан юмныг өөрөө Ерөнхий сайд болонгуутаа шууд ажлын хэсгийг нь тараагаад энийг хий. Хөөрхий муу захирал Батсуурийг нь шоронд явуулж байгаад тэгээд шал өөр. Тэр Японы нэг компани тэгээд өөр хувийн нэг нөгөө төрийн компани байхгүй гэх мэтчилэн хийж байсан.

Тэгэхээр би эндээс юу хэлэх гээд байна вэ гэхээр энэ муухай хонгил хуулийн хонгил гээд гаргасан энээс эхлээд энэ хууль хүчний байгууллагуудын энэ хонгилд хонгилын бүрэлдэхүүнд ордог улсуудыг шууд бүгдийг нь яллах ёстой. Тэгж байж энэ чинь цэвэршинэ. Тэгж байж эхнээс нь явна. Бид нар энийг цэвэршүүлэх гээд оролдсон шүү дээ. Тухайлбал, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл дээр ярьж

байгаад Ерөнхий прокурор, Ерөнхий шүүгч 2-ыг сольж үзсэн. Тэгээд доод бүрэлдэхүүнээ солиогүй шүү дээ. Өнөөдөр Дээд шүүхийн Эрүүгийн танхимын шүүгч нар байж л байгаа шүү дээ. Би тэрийг нөгөө Цензургүй яриан дээр бүгдийг нь хэлж байлаа шүү дээ.

Бүр нэртэй устай нь хэн нь Ховдоос ирсэн, хэн нь Эрдэнэтээс ирсэн, хэн нь хэний дүү, хэний хэн нь ах вэ гээд хэн нь тамгын газар ажиллаж байсан гээд бүгдийг нь л ярьсан шүү дээ. Яг л хэвээрээ байж байгаа шүү дээ. Тэгэхээр юу вэ гэхээр одоо хамгийн түрүүн энэ сонсголоос энэ улсын аюулгүйн зөвлөлдөө гаргаад энэ Элбэгдорж, Хурц хийсэн эд нарын хийсэн энэ хэлмэгдсэн улсуудын ихэнх нь тэд нарын хэлмэгдүүлэлтийн улсууд энд сууж байгаа юм.

Одоо энэ жишээлбэл, энэ хүн хэлж байна Зоригийн хэрэг гээд байгаа би тэр цензурүүдээ хэлж байсан. Энхбаярын хэрэг, Гансүхийн хэрэг, Зоригийн хэрэг ерөнхий прокурор нь хэн бэ? Батжаргал прокурор уу? Одоо тэр хүн ажлаа хийгээд л явж байгаа шүү дээ. Сандагсүрэн чинь яах вэ нэг ороод гараад ирж байгаа. Тэгээд одоо Авлигатай тэмцэх газар дээр хэн байсан юм Золжаргал гэж хүний гараар л бүх хүн явсан шүү дээ. Энэ Энхбат, тэр нөгөө түрүүн хэлж байсан Цэцэгээ гуай энэ тэр гээд л ерөөсөө ингээд л ойлгомжтой хэдхэн хүнийг аваачиж тавьж байгаад л хэдэн дарга нарыг нь сольж байгаад л бүгдийг хийж байсан шүү дээ. Одоо эд нарт эхлээд хариуцлагыг нь тооц. Энэ юмыг ажлын хэсэг байгуулаад шинэ үеийн хэлмэгдүүлэлт гэдэг, шударга бусын хонгил гэдэг юм байгаа юм уу, гэдгийг Хүрэлсүх Ерөнхийлөгч ч авхуулаад бүгд л хэлсэн шүү дээ. Хонгил байдаг юм байна гээд л өөрсдийнхөө амаар үгүй, тэгээд ийм юм хэлээд байхад яагаад энэ хонгил байгаагүй үгүйг нь тогтоогоод, байдаггүй юм байна.

Иргэн Баярмаа - Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Би сэтгүүлч Баярмаа гэж хүн байна. Би яг энэ сэтгүүл зүйн салбарт сүүлийн 20 жил ажилласнаас сүүлийн 10 жилд нь, хууль эрх зүйн эрэн сурвалжлах чиглэлд ажилласан сэтгүүлч байна. Тэгэнгүүт миний хувьд 2024 оны 1 сарын 11-ний өдрийн өглөөний 7 цагт миний гэр болон машинд нэгжлэг хийснээр намайг эрүүдэн шүүсэн байдаг юм. Энэ эрүү шүүлт бол өнөөдрийг хүртэл үргэлжилсээр байгаа ямар нэгэн байдлаар шууд болон шууд бус байдлаар яаж үргэлжилсэн бэ гэхээр мэдээж хэрэг сэтгүүлчдийг бичсэн мэдээ нийтлэлтэй нь холбогдож байнга шалгадаг. Жилд 10-20 удаа шалгадаг эрүүгийн хэргээр дандаа сэтгүүлчдийг тэгж шалгадаг. Тэр болгонд би сэтгүүлчид хэзээ ч гомдол мэдүүлдэггүй. Бид нар иргэний хэргийн шүүх Эрүүгийн хуулийн заалтаараа цагдаагийн байгууллагад шалгагдаад явдаг.

2024 оны 1 сарын 11-ний өдөр Мөрдөн байцаах албанаас нэр бүхий албан хаагч миний гэр болон машинд нэгжлэг хийсэн. Ингэж нэгжлэг хийж байхдаа намайг хилс хэрэгт гүтгэсэн, чиний хийсэн хэрэг чинь тогтоогдсон гэх мэтээр хэзээ ч болоогүй үйл явдлыг болсон мэтээр тогтоогдоогүй үйл явдлыг тогтоогдсон мэтээр шүүхийн үйл ажиллагааг нэг мөрдөгч нь хийгээд Баярмаа чиний гэм буруу чинь тогтоогдчихсон гэх мэтээр намайг гүтгэж, харлуулж, доромжилж, миний эрх зүйн байдлыг маш ихээр дордуулсан энэ үйл явдлыг яг одоо миний энэ хойно сууж байгаа нэг давхрын алба, цагдаагийн алба, дарга нар бол мэдэж байгаа. Энэ үйл явдлыг бол бүр нуун дарагдуулсан. За ингээд сэтгүүлчийг эрүүдэн шүүчихлээ.

Эрүүдэн шүүсэнтэй нь холбоотойгоор Авлигатай тэмцэх газарт хандсан. Гэтэл Авлигатай тэмцэх газар нь санаатай юм уу санамсаргүй юм уу ямар нэгэн байдлаар энэ эрүү шүүлтийг бол нуун дарагдуулж байна. Өөрөөр хэлбэл мэдүүлэг авах өрөөнд дууны болон дүрсний бичлэг зэрэг хийдэг байхад зөвхөн надаас авсан мэдүүлэг яахаараа дууны бичлэггүй байдаг юм, тэр надаас авсан мэдүүлэг дээр миний хэлээгүй үгийг бичсэн байдаг. Энийг нь шалгуулъя гээд Авлигатай тэмцэх

газарт хандахаар тэр нь нотлогддоггүй. За тэгвэл Баярмаагийн эрүүл мэндийн байдал нь буюу амин үзүүлэлт нь Баярмаагийн биеийн байдал муудаад мөрдөн байцаах албан дээр надаас мэдүүлэг авахгүйгээр өглөө 7 цагаас 12 цаг болтол зүв зүгээр суулгачихсан. Тэр Мөрдөн байцаах албан дээр чиний хэрэг чинь тогтоогдчихсон. Баярмаа гэж хүнийг улам гүтгэж, харлуулж, эрх зүйн байдлыг дордуулж хийгээгүй хэргийг тулгасаар байсан.

Тэгээд миний эмийг өгөөч гэхэд, эм өгөөгүй. Миний зүрхний эмийг өгөөгүй. Үүнээс болж миний эрүүл мэндийн байдал дордож түргэн тусламж дуудсан. Түргэн тусламж дуудахад миний зүрхээр өвдөнө, толгой эргэнэ, шөрмөс татна, хэл яриа ээдэрнэ, будилаантай ярина, сууж чадахгүй гэдэг. Ийм яаралтай түргэн тусламжийн хуудас бол байгаад байгаа. Энэ хуудас өглөө 7:12 цагт түргэн ирсэн байгаа. Гэтэл мөрдөн байцаах албаны тэр нэр бүхий алба хаагч надаас өглөө 7 цагаас эхэлсэн тэр нэг балай үйл ажиллагаа нь тайлбар ч авахгүй мэдүүлэг ч авахгүй цагдан хорино гэж намайг эрүүдэн шүүсээр байгаад ингээд мэдүүлэг нь өглөө 7 цагаас эхэлсэн. Нэгжлэг нь өрөөндөө албан өрөөндөө зүгээр тэр нэг ял тулгаж суулгасан, гадуур дагуулж явсан. Өөрөөр хэлбэл, миний 4 амин үзүүлэлтийн 2 нь ингээд хэлбийчихсэн байхад миний амь нас эрсдэлтэй нөхцөл байдалд байсаар байхад намайг дагуулж авч явсаар байгаад, хэрэг тулгаад миний эрх зүйн байдлыг дордуулсан. Энэ талаар Авлигатай тэмцэх газарт хандахаар ерөөсөө хэрэг үүсгэдэггүй өөрсдөө холбогдсон. Би тэгвэл энэ эрүүдэн шүүсэн гээд байгаа энэ хэргийг тэгээд шалгаад хааж байгаа юм бол би тэр хэргээс нотлох баримтаа хуулбарлаж авъя гэхээр хүсэлт хангадаггүй. Яагаад? Өнөөдөр тэр Мөрдөн байцаах албаны тэр мэдүүлэг авах өрөө чинь тэгвэл стандарт хангасан гэххээд дууг нь бичихгүй дан дүрсийг нь бичээд байгаа юм бэ? Энэ Авлигатай тэмцэх газар, мөрдөн байцаах алба, прокурор чинь өөрсдөө ингээд сэтгүүлчид эрүүдэн шүүххээд тэгээд хэргээ нуун дарагдуулаад байна шүү дээ.

Өнөөдөр хэний сэтгүүлчдийн энэ хохирсон эрх нь Хүний эрхийн Үндэсний Комисс нь нэг дүгнэлт гаргаж байж арай нэг амь насыг нь эрүүл мэндийн эрсдэлийг нь арай жаахан дөнгүүр болгож өгч байна. Гэхдээ энэ эрүү шүүлт нь шалгагдаж байгаа гэдэг утгаараа өнөөдөр эрүү шүүлт шалгагдаж байгаа хэрэг дээрээ Хүний эрхийн Үндэсний Комисс орох боломжгүй гээд өнөөдөр намайг эрүүдэн шүүгдсэн хэрэг шийдэгдэхгүй яваад байна. Энэнээс болоод өнөөдөр миний эрүүл мэндийн байдал дордчихоод байна. Одоо болтол дээрдэхгүй байна. Дагаад миний гэр бүл бас дордож байна шүү дээ. Ийм байдлаа энэ хуулийнхан өөрсдөө болиоч дээ. Прокурор нь яагаад ингээд нотлох баримттай улайм цайм ийм нотлох баримттай хэрэг байсаар байтал эрүүдэн шүүххээд байхад энэ Эрүүгийн хууль дээр чинь бие махбод сэтгэл санааг шаналан зовоосон бол гэж заачхаад байхад яагаад та нар өөрсдөө хуулиа хэрэгжүүлэхгүй байгаад байгаа юм бэ? Хүн сэтгүүлч үнэнийг нь биччихээд байхад Хүний эрхийн Үндэсний Комисс чинь Баярмаа бол хүний эрхийн хамгаалагч мөн юм аа гэсэн дүгнэлт гаргачихаад байхад цагдаа нь, прокурор нь, Авлигалтай тэмцэх газар нь ингээд эрүүдэн шүүсэн хэргээ нуун дарагдуулаад байна шүү дээ. Би энэ эрүүдэн шүүгдсэнээсээ хойш өнөөдөр нэг сард эрүүдэн шүүгдсэн. Одоо 11 сар энэ хэргийг одоо болтол шийдэхгүй, шийдэгдэхгүй байгаад маш их гомдолтой байна.

Сонсгол даргалагч П.Сайнзориг - Дараагийн хүн Жаргал гэж хүн байна. Б.Жаргал микрофон дээр хаана байна? 2 дээр үү? 2 Номерын микрофон.

Иргэн Б.Жаргал - За энэ өдрийн мэндийг хүргэе. Би Балжирын Жаргал гэж хүн байна Шүүх шинжилгээний үндэсний хүрээлэнгийн Эдийн засгийн шинжилгээний хэлтсийн даргаар ажиллаж байх төрийн албаны үүрэг гүйцэтгэж байхдаа 11 жилийн өмнө төрийн албаны үүрэг гүйцэтгэж үнэн зөв шударга ажилласныхаа төлөө Авлигатай тэмцэх газраас шинжээчээр томилогдож ажиллаад

2 сая төгрөгийн Хүн амын орлогын татвар, шинжээчийн дүгнэлт, Золжаргал байцаагч, шинжээчийн дүгнэлт аваад явахдаа хоёрхон сая дутчихлаа шүү дээ гэж уурлаж байсан. Энэ нь цаад зорилго нь болохоор одоо энд сууж байгаа Татварын хэлтсийн дарга Энхбатыг ял эдлүүлэх зорилготой байсан.

Тэгээд би шинжээчийн дүгнэлт гаргасны дараа 2013 оны 9 сарын 23-ны өдөр зөвлөлийн хурал дээрээс Золжаргал надыг 461-д хориод тэгээд 3 цагдан хорих байраар дамжуулан 151 хоног хорьсон. Эхний 108 хоногт нь бол ар гэрээс ямар нэгэн эргэлт оруулаагүй хорьсон байдаг. Тэгээд анхан шатын шүүх дээр бол шинжээчийн дүгнэлт гээд одоо би энэ нэг дүгнэлтийг гаргасан байдаг. Энийг анхан шатын шүүх дээр дахин шинжээч томилогдсон хүн маань шинжээчийн дүгнэлтээсээ буцдаг. Энэ хүн нь яасан гэхдээ зэрэг шүүхийн шинжилгээний хуульд эдийн засгийн шинжилгээний хэсэг бүлэг байдгийг мэдэхгүй.

Шинжилгээний тухай хууль мэдэхгүй 1 дүгээрт 2 дугаарт энэ шинжээчээр оролцсон Алтантуяа гэдэг хүн нь болохоор миний гаргасан дүгнэлтээр 461-д хоригдож байсан хүнийг хорихоос гаргаж ирээд 2,7 тэрбумын зөрчлийг юу илрүүлээгүй байна гэсэн. Эрүүд эрүүгийн хэрэгт эрүүгийн хэрэг үүсчихсэн байсан. Хүнийг сөргөөр над дээр дүгнэлт гаргуулаад миний энэ 15 сая, 50 сая болгож хэрэг наймаалцах зорилгоор ингэж тэр хүнийг дүгнэлт гаргуулсан байдаг. Тэгээд тэр хүн нь болохдоо зэрэг өмнөх 7 хоногт нь нэг жилийн тэнсэн харгалзах ял шүүхээс авсан учир миний шүүх хуралд оролцоогүй байдаг. За ингээд дараачийн анхан шатны шүүх хурал дээр надыг торгосон.

Дараачийн шүүх хурал, Нийслэлийн шүүх хурал дээр бол 100% цагаатгасан байдаг. Цагаатгахдаа Гэрэл гээд прокурор байгаа, тэрнээс энэ Жаргал чинь татварын хэрэг дээр огт хамааралгүй хүн байна шүү дээ шинжээчийн дүгнэлт худал гаргаагүй хүн байна шүү дээ ямар учиртай юм гэсэн чинь Гэрэл хэлсэн. Энхбат, Гансүх нарын хэрэг дахин дахин буцаад байхаар нь энэ Жаргал гэдэг шинжээчээр хүч оруулж энэ хэргийг шийдэхийн тулд, энэ хүнийг хүч нэмсэн юм гэж хэлсэн. Шүүх хурал дээр болохоор 70 гаруй хүмүүс оролцож байсан. Тэр хүмүүс бүгд сонссон, мэдсэн. Тэгээд Нийслэлийн шүүх дээр би 100% цагааддаг. Дээд шүүх дээр би ингээд Нийслэлийн шүүх дээр цагаадчихсан чинь Энхбат ял эдлэх боломжгүй болчихдог байхгүй юу.

Тэгтэл Дээд шүүх дээр аваачаад 151 хоног хорьсныг нь 150 ярьж ёстой юмаа хэлэх гэж байна.

Сонсгол даргалагч П.Сайнзориг - За 2 минут сунгаад өгчихье.

Иргэн Б.Жаргал - Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 150 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр торгосон. Энэ нь болохоор шинжээчийн дүгнэлт санаатайгаар худал гаргасан гэдэг зүйлээр ингээд торгоод, би төрд 28 жил ажилласныхаа дараа ингээд өнөөдрийг хүртэл би өөрийнхөө хэмжээгээр ингээд маргалдаад яваад байдаг. Энэ ганц миний цагаатгасан ажил болохоор энэ шинжээчийн дүгнэлт үнэн. Энийг мөрдөн байцаагч Жаргал шинжээчийн дүгнэлтийг байцаадаггүй. Шүүх хурал дээр дурын тоогоо асууя. Энэ 3 тооны нотлох баримтыг нь би энэ хавтаст хэргээс үзүүлье гэх зэрэг ямар ч хариуцагч, нэхэмжлэгч, шүүгч, прокурор асуудаггүй. Энэ Жаргал шинжээчийн дүгнэлтийг 11 жилийн өмнө тэр 2013, 2014 онд хуулийн байгууллага үйл ажиллагаа явуулахдаа энийг ерөөсөө асуугаагүй байхгүй юу надаас, тэгээд энийг бол нийслэлийн шүүх дээр бол яг үнэн зөв байна гэдгийг бол тогтоогоод цагаатгасан байдаг.

Гэтэл би өнөөдөр ингээд ял шийтгэлтэй тэтгэвэрт гартлаа би одоо ял

шийтгэлтэй учраас төрийн албанд боломжийн ажил хийх боломжгүй ингэж хасагдаад, ингээд хохиролтой байна. Энэ яадаг вэ гэхээр бүх шатанд очоод Дээд шүүхийн шийдвэр гарсан тул таны юмыг яаж ч шийдэх боломжгүй гэдэг бүх хариулт өгдөг. Би Нийслэлийн прокурорыг өөрчлөгдөх болгонд өргөдөл өгдөг, тэгээд шинэ нөхцөл байдал гээд байхаар энэ чинь болохоор бодит л байдал. Энийг ерөөсөө энэ Жаргалын дүгнэлт санаатай худал байх ёстой гээд л Энхбатыг яллахын тулд л өнөөдөр би хэрэглүүр болсон шинжээчийн дүгнэлтийг бодитоор үнэлээгүй. Би зүгээр л энэ Энхбатыг яллахын тулд Жаргал хэн ч биш, Жаргалын цаана ямар амьдрал байгаа ерөөсөө хамааралгүй байсан. Тэгээд цаашдаа болохоор энэ Дээд шүүхийн худлаа шийдвэрийг Дээд шүүх зөв гаргасан гээд ингээд бүх шатанд хэлээд байдгийг болимоор. Цаашдаа ингээд энэ бүх л хүмүүс тийм байгаа, тэгэхээр зэрэг энийг энэ дээр одоо дорвитой ямар гарц байна хэлмээр байна. Баярлалаа.

Сонсгол даргалагч П.Сайнзориг - За дараагийн хүн Гансүх гэж хүн байна. Ч.Гансүх гэж байх шиг байна. Зургаан 6 номер.

Иргэн Ч.Гансүх - За миний бие Чимэдийн Гансүх гэдэг хүн байна. 1982-2013 оныг хүртэл төрийн 2 байгууллага буюу Сангийн яам, Үндэсний татварын ерөнхий газарт 2 газар 31 жил ажиллаад, 2013 онд Авлигатай тэмцэх газрын мөрдөн байцаагч нарын шийдвэрээр цагдан хоригдож нийтдээ 1491 хоног хоригдож, гарч ирсэн байгаа. За намайг бол онц хүнд рецидив гэмт хэрэгтэн гэдэг нэр хоч өгсөн, намайг барьж хорьсон өдрийнхөө маргаашаас нь эхлээд тэнд сууж байгаа Жаргалбаатар хэвлэлээр эхэлж ялласан. Тэр нь 17 тэрбум төгрөгийг улсаас завшсан татварын Гансүх гээд тэрийг одоо болтол цайруулаагүй.

Тэр аль 2013 онд Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхэд ороод тэгээд тэр чинь байхгүй худлаа гэдэг. Одоо протокол нь энэ байж байна. Тэр шүүх хурлын протокол энэ энэ шүүх хурлын протокол дээр тухайн үед хэрэгт хяналт тавьж байсан Нийслэлийн прокурорын газрын прокурор Одгэрэл, Ш.Баярбилиг 2 ийм хэрэг байхгүй энэ бол Сарантуяа гэж шүүгч асуусан байгаа юм. Үгүй та нар ингээд баахан сенсацалсан хэвлэлээр тэр чинь одоо энэ хавтаст хэрэгт очоод нэг ч хуудас баримт байхгүй байна шүү дээ гэсэн чинь тийм хэрэг байхгүй энийг би ч сенсацлаагүй, Авлигатай тэмцэх газрынхан сенсацалсан юм гэж энэ хурлын тэмдэглэл дээр нь байж байгаа. За тэгвэл хяналт тавьж байгаа прокурорын хувьд Та нар яагаад энийг таслан зогсоогүй юм бэ гэсэн, тэр 2 прокурор дуугараагүй бас тэн дээр нь хариулт хийсэнгүй гээд энэ тэмдэглэл дээр нь байж байгаа. Энэ прокурор зүгээр. Тухайн үед энэ протокол бол тухайн үед хуралдаанд тэмдэглэвэл тухайн үед хуулуулж авсан маш муу гаргасан.

Энийг би эх хувиар нь хуулж авах гэж Улсын ерөнхий прокурорын архив, эрүүгийн хэргийн тусгай архив, хэрэг эрхлэх газарт нь 5 сараас хойш нийтдээ 6 удаа хандаад надад гаргаж өгөөгүй. Барьж байгаа үндэслэл нь юу гэхлээр Ерөнхий прокурорын 2022 оны 42 дугаар тушаал оролцсон журам дээр нь битгий хэл ямар ч хууль тогтоомж дээр шүүх хуралдааны тэмдэглэлийг хэрэгт оролцогчид хуулуулж өгөхийг хориглосон заалт байхгүй. Тэгэхэд л боломжгүй гэдэг. Тэр 2 дугаарт нь болохоор Гансүхийг бариад хорьчихсон бол миний бие Татварын ерөнхий газар, Хяналт шалгалт, арга зүйн хэлтсийн даргаар ажиллаж байхдаа Батын Хурц гэдэг хүнийг эхнэрийнх нь Сарнайх гэж компанитай нь хамт нийтдээ 3 удаа шалгасан юм.

Би өөрөө шалгаагүй л дээ шалгах ажил зохион байгуулсан манай байцаагч нар шалгасан, дараа нь Тагнуулын ерөнхий газрын дарга Гэрэл гэж хүний хүүхдүүдийн нэр дээр бүртгэлтэй байдаг.

Сонсгол даргалагч П.Сайнзориг - Дуусаагүй байна 2 минут нэмж өгье.

Иргэн Ч.Гансүх - Оюу Толгойн үйлдвэрийн баазыг барьж байсан Хятадын Жиансу Жиан Ду Монголиа гэж компанийг шалгуулсан энэ компани дээр 600 гаруй тэрбум төгрөг эхний ээлжид илэрчихсэн мөрдөн байцаагч руу шилжүүлэх гэж байхад тэр өдөр намайг барьж хорьсон. Тэр эрүүдэн шүүлт, хүнлэг бус харгис, хэрцгий хандахаас ангид, энд Жаргалбаатар оролцож байна. Энэ бол чиглэлийн ажил эрхэлж байгаа юм. Дээд зэргээр эрүүдэн шүүдэг байсан Дарханы мөрдөнд намайг хорьчихсон байхад очоод элдвээр хэлж хүний нүд рүү долоовор хуруугаар чичих, элдвээр хэлж ингэж хүний дургүйг хүргэхээд хүн урьдаас нэмүүлэхээр камер асаачихдаг өөрөө юм ярихаараа камер унтраачихдаг жишээ нь эргэлт тойролт өгөхгүй, хүүхдүүдийг чинь хорино, цагдана. Тэр битгий хэл 2013 оны 6 сарын 14-ний өдөр прокурорт миний хэргийг шилжүүлчхээд 5 дахь өдөр, хагас сайн өдөр нь 80 настай манай аав руу утасдаж ирж байцаалт өг, өгөхгүй гэвэл дахиад нэг хүүхдийг чинь хорино шүү гэж айлгаж байгаад 80 настай хөгшинг ирэхэд өмгөөлөгчгүй, манай дүүг өрөөндөө оруулахгүйгээр ганцааранг нь суулгаж байцаалт аваад 14-ний өдөр прокурорт хэргээ шилжүүлчихсэн.

Тэгээд одоо хараа муутай хөгшинг гарын үсэг зуруулж байсан. Тэр битгий хэл сэтгэцийн эмнэлэгт Шар хаданд үзүүл тэгээд албадан эмчлүүлнэ гэж тэр хөгшнийг айлгаж, сэтгэл санаагаар унагаж бүтэн сар даралт нь ихдэж зүрх өвдөж 80 гарчихсан хөгшин бүтэн сар хэвтэрт орж босож ирээгүй. Энэ бол зүгээр одоо ганц хоёрхон жишээ. Би бол 10 хэдэн жишээ энд дурдчихсан байгаа. Зөвхөн Жаргалбаатартай холбоотой шүү. Ийм байдлаар эрүүдэн шүүж байсан энд аав ээж, дүү миний аав, хүүхдүүдийг 3 үеэр минь хоморголон эрүүдэн шүүж...

Сонсгол даргалагч П.Сайнзориг - Дараагийн хүн Д.Энхбат. 5 номер уу? Энхбат байна уу? Д.Энхбат 5 номер.

Иргэн Д.Энхбат - Сайн байцаана уу? Энэ өдрийн мэндийг хүргэе. Юуны өмнө хурал даргалагчид нэг санал байна. Би Эрүүдэн шүүлт хэлмэгдүүлэлттэй тэмцэх үндэсний холбооны тэргүүн байгаа юм. Тэгээд би холбооныхоо бас хүмүүсийн өмнөөс 3 минут ярих ийм цаг авсан юм. Эрүүдэн шүүгдсэн Д.Энхбатаараа, би бас өөрөө ярих юм байгаа юм. Тэгээд энэ хоёрыгоо ингээд нийлүүлээд ярьчихъя гэдгийг даргалагчаас зөвшөөрөл авчихъя. Та надад 10 минутын хугацаа тавиад өгөх үү?

Сонсгол даргалагч П.Сайнзориг - Эхлээд иргэн Энхбат та ярина. Энэ дээр зүгээр 2 нэр байна. Бас Эрүүдэн шүүхийн хэлмэгдүүлэлтийн тэмцэх холбоо гээд байна. Энийг би бас дараа нь хэн төлөөлөх, дарга нь яг та өөрөө мөн юм уу? За ямар ч байсан эхлээд та ярьчих. Одоо эхнээс нь цагийг нь өгчих. Одоо ингээд хэдүүлээ та энэ дээрээс санал горим гаргах эрхгүй байгаа. Би ер нь хууль дэг сахиулж байгаа учраас дэс дарааллын дагуу явуулна.

Иргэн Д.Энхбат - За баярлалаа. Юуны өмнө энэ хяналтын сонсголыг зохион байгуулахад санаачилга гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа болон бусад Улсын Их Хурлын гишүүддээ талархсанаа, үг хэлэх боломж олгосонд талархаж байна. 2011-ээс 2016 онуудад улс төр бизнесийн тодорхой бүлэглэлийн зүгээс төрийн болон иргэдийн өмч хөрөнгийг луйвардах, өс хонзонгоо авах, бусад ашиг сонирхлын үүднээс хууль сахиулах шүүх эрх мэдлийн байгууллагыг ашиглаж бусдыг хэлмэгдүүлэн хохироох явдал хэрээс хэтэрч Монгол Улсын түүхэнд хуулийн хонгил гэх нэршлээр хэлмэгдүүлэлтийн нэгэн хар хуудас болон тэмдэглэгдэн үлдэх хүртлээ бүрэлдэн хөгжиж үүний улмаас олон иргэд амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөөрөө хохирсон.

Эдгээр хохирсон иргэд хамтран Эрүүдэн шүүлт хэлмэгдүүлэлттэй тэмцэх

үндэсний холбоог байгуулж ямар нэг хэлбэрээр үндэслэлгүйгээр цагдан хоригдсон, зохиомол хилс хэрэгт шалгагдаж, эрүүдэн шүүгдсэн, хууль бус нотлох баримтаар хорих ялаар шийтгэгдсэн 47 иргэн эвлэлдэн нэгдээд байна. Мөн түүнчлэн эдгээр хэлмэгдсэн иргэдийн ар гэр Авлигатай тэмцэх газарт шалгагдаж, хэвлэл мэдээллээр гүтгүүлж, гутаан доромжлогдож, сэтгэл санаа нь шаналган тарчилсан шууд бус бусаар хэлмэгдэж, хууль бусаар хоригдож, эрүү шүүлтэд өртсөн 200 гаран иргэн дэмжин ажиллаж байна. Миний бие төрийн албанд 20 жил ажилласан улсад 31 жил ажилласан Даваа овогтой Энхбат гэж Эрүүдэн шүүлгэх хэлмэгдүүлэлттэй тэмцэх үндэсний холбооны тэргүүн ийм хүн байгаа юм.

Би Татварын ерөнхий газрын, Эрсдэлийн удирдлага судалгааны үнэлгээний хэлтсийн даргаар ажиллаж байгаад 2013 оны 1 сарын 28-ны өдөр Авлигатай тэмцэх газарт цагдан хоригдсон. Намайг хүнд гэмт хэрэг үйлдсэн гэж 6 зүйл ангиар зохиомол хилс хэрэгт 3 цагдан хорих анги дамжуулан 380 хоног тасралтгүй хорьж, эрүүдэн шүүж, эцэст нь надад тохих эрх олдохгүй болохоор Авлигатай тэмцэх газарт авлига авсан хэргээр шалгагдан хоригдож байсан яллагдагч Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын улсын байцаагч Балтантуяаг даалтад гаргаж миний хувь хүний орлогын албан татварын тооцоололыг Шүүхийн шинжилгээний Үндэсний хүрээлэнгийн, эдийн засгийн шинжээчийн бүрэлдэхүүнтэй дүгнэлтийг санаатай өөрчлүүлж 50 сая 41 мянган төгрөгийн татвар төлөхөөс санаатай зайлсхийсэн гэх илт хууль бус шинжээчийн дүгнэлт гаргуулна.

Бүх шатын шүүх, шүүх хуралдаан дээр шинжээч буруу худал дүгнэлт гаргаснаа хүлээн зөвшөөрөөд байхад огт авч хэлэлцэхгүйгээр намайг татвар төлөхөөс санаатай зайлсхийсэн гэж чанга дэглэмтэй хорих ангид 7.6 жил ял оноож шоронд миний бие биеэр 1041 хоног хоригдсон ийм хүн байна. Шүүх бүрэлдэхүүн миний хувь хүний орлогын албан тооцоолол дээр зөрүүтэй шинжээчийн өөр өөр дүгнэлт байсаар атал бүрэлдэхүүнтэй шинжээч томилж хэргийг мөрдөн байцаалтад буцаалгүй зөвхөн яллах талыг баримталж Монгол Улсад анх удаа татварын хэрэгт хорих ял оноосонд гомдолтой явдаг юм би.

Би 2009 онд Баянгол дүүргийн Татварын хэлтсийн даргаар ажиллаж байхдаа Батын Хурц татварын ерөнхий газраас Батын Хурцын хамаарал бүхий Сарнайх компанид бол татварын акт ноогдуулсныг би актаар ноогдуулсан. Татварын өр төлбөрийг л барагдуулах ажлыг удирдлагаар хангаж энэ өр төлбөрийг төсөвт төвлөрүүлсэн. Энэнийхээ төлөө би Хурцын өс хонзонгийн бай болж хонгилын шүүгчийн шийдвэрээр эрх чөлөөгөө хасуулсан бодит кэйстэй хүн юм байгаа юм.

Намайг дараах байдлаар эрүүдэн шүүж сэтгэл санааг тарчлан зовоосон баривчилснаас хойш өмсөж явсан албаны хувцастай 72 цаг цагдан хорьж ар гэрт 4 сар эргэлт уулзалт өгөөгүй эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээгээ бүртгүүлээгүй гэх үндэслэлээр Авлигатай тэмцэх газраас 461 дүгээр ангид албан бичиг хүргүүлж намайг өмгөөлөгчтэй 7 хоног хариул уулзуулаагүй. Намайг 3 удаагийн хүн амины онц хүнд хэрэг үйлдсэн рецидив гэмт хэрэгтэн Т гэгчтэй 2 сар цагдан хорьж, дарамтлуулж, сэтгэл санааг тарчлаан зовоосон. Мөн намайг цагдаагийн байгууллагад төлөөлөгчөөр ажиллаж байхад мөрдөн орох байрнаас зэвсэглэн орсон онц аюултай гэмт хэрэгтэн Ч гэгчийг дайчлан баривчилж байсныг түүнд хэлж түүнийг миний хорих өрөөнд зориуд оруулж 3 сар 25 хоног хамт хорьж дарамтлуулсан.

Намайг Зүүнхараагийн урьдчилан цагдан хорих анги руу шилжүүлж хорихдоо 12 цаг бие засуулаагүй давтан аюултай орчинд тээвэрлэсэн мөн хорих ангид ял эдэлж байхад дахин гэмт хэрэг үйлдсэн давтан гэмт хэрэгт нартай хамт чийгтэй подвалд 110 хоног хорьсон. Мөрдөн байцаалтын шатад тасралтгүй 380 хоног хорьж

шалгахдаа шүүгчийн захирамжгүйгээр 20 хоног цагдан хорьсон байдаг юм. Авлигатай тэмцэх газрын комиссар Зоржаргал мөрдөн байцаагчийн шатад надаас мэдүүлэг авах бүрдээ одоогоос шоронгийн амьдралд ял авах чинь тодорхой гэж байнга доромжилдог байсан. Хяналтын прокурор Баярбилиг миний гаргасан эрүүдэн шүүгдсэн талаарх олон удаагийн гомдлыг шийдвэрлэж байгаагүй. Надтай нэг ч удаа биечилж уулзаж байгаагүйгээс гадна Авлигатай тэмцэх газраас яллах дүгнэлт үйлдүүлэхээр хүргүүлсэн. Хэргийг хүлээн авмагцаа миний өмгөөлөгчийн гаргасан цаад нотлох баримтыг хэрэгт авалгүйгээр нэг өдрийн дотор хэрэгт яллах дүгнэлт бичиж ингээд 5 минут маань дуусчхаад байдаг.

Сонсгол даргалагч П.Сайнзориг - Та бас хүсэлтүүд тавьсан? Энэ тийм байж байгаа, за ер нь яах вэ зүгээр би бас давхцуулж дахиад минут өгөх бололцоо бол байхгүй байна. Эрүүдэн шүүлт хэлмэгдүүлэлтийн тэмцэх иргэдийн холбоо гэдэг дээр бол сүүлд өгнө. Одоо иргэдийн дараа больё гэж бодож байна. За ингээд бас Гансүх гэж хүн байна. К.Гансүх 4 номер байх шиг байна. За танд микрофоныг нээж өгье.

Иргэн К.Гансүх - Албан тушаалтны буруутай үйлдлээс 23 жил төрийн байгууллагын үүд хаалга татаж, эд материал, сэтгэл санаа цаг хугацаагаар хохирч яваа Сонгинохайрхан дүүргийн 8 дугаар хорооны иргэн Гансүх гэж хүн байна. Үүнийг нотлох баримт болгож энэ Сонгинохайрхан дүүргийн шүүгчийн 2001 оны 11 сарын 20-ны өдрийн яг 23 жилийн өмнөх энэ өдрийн 437 дугаартай захирамж байна. Энэ захирамжийг зөрчиж зохиомол маргаан үүсгэсний улмаас Нийслэлийн Захиргааны хэргийн шүүх дээр газаргүй болж хохирсон. Шүүхийн шийдвэр эцэслэн гарсны дараагаар цагдаагийн байгууллагад хандсан. Шүүхийн шийдвэрээр газаргүй болж хохирлоо гэж цагдаагийн байгууллага газрын албаны албан тушаалтнуудад эрүүгийн хэрэг үүсгээд мөрдөн байцаалтаар буруутай үйлдлийг нь тогтоосон. За ингээд сая Ерөнхий сайдын 2023 оны 20 дугаар захирамж гэж гарсан. Монгол улсын ерөнхий сайдын 20 дугаар захирамжаар байгуулагдсан авлигатай тэмцэх үйл ажиллагааг үр дүнтэй болгох, төрийн албаны анхан, дунд нь дунд шатад хүнд суртлыг арилгах, таслан зогсоох, иргэд хувийн хэвшлийг чирэгдүүлж авлига үүсгэх нөхцөл барьдаг. Бүрдүүлж үйл ажиллагаа, чиг үүргийн талаар дүгнэлт гаргах ийм үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдаад ажлын хэсгийг нь Хууль зүйн дэд сайд Солонгоо гэж хүн ахалсан. Энэ Солонгоо гэж хүн Сонгинохайрхан дүүргийн газрын албан дээр ажлын хэсгийн зарим бүрэлдэхүүнтэйгээ ирж тэр 1, 2 дугаар газрын албаны дарга, Нийслэлийн газрын албаны Захиргаа удирдлагын хэлтсийн дарга Батнасыг байлцуулаад надыг дуудсан.

Ингээд тэр Бат-Үүл даргын 2013 оны 567 тоот захирамж гэж гарсан. Энэ захирамж хэрэгждэггүй 10 жил болсон, Ерөнхий сайдын энэ захирамжийн ачаар энэ 567 тоот захирамж 10 жилийн дараа хэрэгжиж Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын 2023 оны 27 тоот захирамжаар бидний газар эзэмших эрхийг сэргээсэн. Одоо яах вэ гэхээр газар эзэмших эрх сэргэчихсэн учраас газар зохион байгуулалтыг Нийслэлийн газар зохион байгуулалтын алба хийх ёстой. Энийг хийхгүй өдийг хүрч байна. Ингээд би одоо хохирсон чигээрээ яваад байна. Ийм учраас санал оруулж байгаа юм. Нэгдүгээрт Нийслэлийн газар зохион байгуулалтын албанд Нийслэлийн Засаг даргын 567 тоот захирамж...

Сонсгол даргалагч П.Сайнзориг - За баярлалаа цаг дууссан байна.

Ер нь ийм эрхийн зөрчлийн асуудал байвал манай хүний эрхийн дэд хороонд бас хандаж болно. Өнөөдрийн гол асуудал маань эрүү шүүлт тулгах хүнтэй хүнлэг бус харьцах гээд энэ зүйл байгаа юм. Энийг та ойлгоосой, бусдыг хүндэтгээсэй гэж бодож байна. Тийм учраас дараагийн хүнд микрофоныг өгье. Г.Хажидмаа 2 номер.

Иргэн Г.Хажидмаа -Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Тэгээд ерөнхийдөө болбол өнөөдрийн энэ сонсгол бол маш одоо хүний эрхийг боомилсон сонсгол болж байна гэж харж байна. Монгол Улсын Их Хурлын гишүүд нь одоо иргэдээ орж ирээд сонсох ч тэнхэл байхгүй санаачилсан гишүүд нь эрх нь зөрчигдөөд байгаа иргэдийнхээ үгийг сонсчихооч гээд хурлын даргадаа хэлж ч чадахгүй Баярмаа гишүүн та доошоо хараад л утсаа оролдоод л сууцгаагаад байх юм. Энэ ээж нар чинь тартагтаа тулчхаад өнөөдрийн сонсголд чинь баярлаад ирээд үгээ хэлэх гээд орж ирж байхад бараг уйлуулаад чирээд гаргаж байна шүү дээ. Үнэхээрийн хүний үгийг сонсохгүй юм бол попорч олон нийтэд гоё юм ярихаа болио. За тэгэхээр хүний эрх эрх чөлөөний талаар яримаар байна. Өнөөдөр би бол үзэл бодлоо илэрхийлээд сөрөг хүчин ганцаараа ингээд 8 жил болсон.

Талбайн хажууд, ордны гадаа миний эрхийг Ардчилсан намын Засаг дарга Сүхбаатар дүүргийн Засаг дарга Болормаа 8 жил миний эрхийг зөрчсөн. Энэ талбай дээр үзэл бодлоо илэрхийлдэг иргэн болгоны эрхийг зөрчсөн. Яагаад гэвэл ялгаварлан гадуурхаж тэр хүн хүний жагсаал цуглаан хийх хүсэлтийг хүлээж авах уу үгүй юу гэдэг шийддэг Ардчилсан намынхны үед гарсан шийдвэр. Энэ Ардчилсан намынхныг сөрөг хүчин хийгээд өгөөч ээ гэж зөндөө гуйсан 8 жил гуйсан. Сүүлдээ өөрөө очоод зодуулаад чирэгдээд. Тэгээд Их Хурлын Ардчилсан намын эмэгтэй гишүүд нь намайг цагдаад өгдөг болсон.

Сөрөг хүчин байхгүй байгаа учраас өнөөдрийн энэ дарангуйлал энэ нийгмийн эмх замбараагүй байдал үүсээд байгаа юм. Өнөөдөр байна шүү дээ. Мөнх-Эрдэнийг өмгөөлөөд Баярмаа бид 2, Баярмаа гишүүн бид 2 тэр шүүхийн гадаа зогсож байсан. Зөндөө л үзэл бодлоо илэрхийлээд хамтдаа явж байсан. Тэгэхэд микрофон болгоны урд очоод үзэл бодлоо илэрхийлдэг байсан гишүүд өнөөдөр энд орж ирээд үгээ хэлэх гэсэн иргэний үгийг сонсохгүйгээр шууд хурлын даргад эрх мэдлийг өгөөд явж байна шүү. Тэгээд иргэн, цагдаа 2-ыг байна шүү дээ хооронд нь Сүхбаатар дүүргийн Засаг дарга байлдуулдаг, ноцолдуулдаг, зодолдуулдаг. Цагдаа нар хөөрхий ажлаа хийгээд л та нар одоо юугаа өгсөн юм уу, хүсэлтээ өгсөн юм уу гэхээр нөгөө Болормаа нь өгөхгүй Ардын Намынхны юм уу, эсвэл хэн нэгэн үзэл бодлоо нөгөө мөнгөний жагсаалыг болохоороо бүртгэж авчхаад бид нарыг бүртгэдэггүй. Ингэж л өнөөдрийн энэ нийгэм чинь эмх замбараагүй байдал чинь үүсээд байна шүү дээ.

Цагдаа муухай л гээд байдаг. Яг бодит байдал дээр цагдаа нар чинь харин бид нарыг хамгаалах гээд та хуулиа хэрэгжүүлж ингэчих тэгчих гэдэг байдлаар бид нартай ханддаг учраас өнөөдөр муухай харагдаад байгаа. Цагдаа бид нарт шаардлага тавихгүй бол Их Хурлын гишүүд нь цагдаа нарыг дарамталдаг байхгүй юу. Өнөөдрийн энэ бүх муу муухай энд зовсон иргэн болгоны ард Их Хурлын гишүүд буруутай Их Хурлын гишүүдийг ёс зүйтэй болгох сонсголыг хийх саналыг гаргаж байна. Их Хурлын гишүүд нь дэгээ мэдэхгүй, ордон дотор цамнаж байхад Их Хурал дотроо цамнаж байхад энд байгаа иргэдээс дэг шаардаад яах юм тийм биз дээ.

Сонсгол даргалагч П.Сайнзориг - Нэмж хэлэхэд сэдвийн хүрээнд бас ярья би Таныг бас яриулаад дуусгалаа. Эргээд хүний эрхийн энэ зөрчил дээр бид хэд хаяхгүй, асуудлууд байвал манай Хууль зүйн байнгын хорооны хүний эрхийн дэд хороонд хандаарай. Бид асуудал болгоны араас явж хэлэлцэхэд бэлэн байна гэдэг зүйлээ хэлье. Өнөөдрийн сонсгол бол тодорхой сэдвийн хүрээнд явж байгаа гэдгийг би дахин тодотгож хэлье.

Ингээд дараагийн хүний микрофоныг нь өгье. Д.Отгонтуяа гэж хүн байна. 7 номер дээр сууж байгаа та юу? Танд микрофоныг нээж өгье.

Иргэн Д.Отгонтуяа - Сайн байцгаана уу? Өдрийн мэнд хүргэе. Намайг

Отгонтуяа гэдэг. Би одоо төрийн байгууллагад ажиллаад одоо дотор нь ажиллаж байгаад хууль бус үйлдлийг нь мэдээд гарч ирээд ард түмэндээ шүгэл үлээсэн иргэн Ган-Очирын кэйсийг ярьж өгөх гэж байна? Энэ хуулийн байгууллагад ажилладаг сая өөрөө сүүлд хэвлэлийн хуралдааныг зарлачихлаа. Би тагнуулын ажилтан байсан гээд тагнуулын ажилтан, ажилтны хийсэн ажлаар нь өөрийг нь буцаагаад хэрэгт гүтгээд тэгээд энэ хүнийг Монголд байх аргагүй болгоод энэ Франц улс руу ингээд явуулсан байдаг, гаргасан байдаг.

Энэ иргэнийхээ ерөөсөө шүгэл үлээсэн иргэнийхээ юуг ерөөсөө хамгаалдаггүй эрх зүйн байдлыг дандаа дордуулаад ингээд ял шийтгэл аваагүй байхад нь одоо тэр араас нь газар гишгэж гал үлээхээс бусад нь худлаа гээд ингээд иргэнээ гүтгээд зогсож байдаг. Ийм Хууль зүйн сайдтай байсан. Одоо гарчихсан байгаа. Энэ Хууль зүйн сайд ард иргэдийнхээ шүгэл үлээж байгаа иргэнээ хамгаалах хуулиа хурдан яаралтай батлуулаач. Хэдий болтол энэ шударга залуучуудынхаа амыг хумхиулах юм бэ?

Хэдий болтол энэ шударга залуучуудынхаа гарыг гавлуулах юм бэ? Одоо тэр иргэний маань эрх гадаадад ингээд явж байхад нь араас нь их хэмжээний төгрөг дансанд нь Хаан банкаар шилжүүлээд авахгүй болохоор нь буцаагаад өөрийнх нь мөнгөтэй нь тэглээд хаачихдаг. Хаан банкиг нь иргэнээ ингэж гадаадад явж байхад нь амь нас, эрүүл мэндэд нь ингэж шууд заналхийлж болохгүй биз дээ. Тэгээд худлаа сошиалаар худал үнэн мэдээллийг тэр Хаан банкаар нь хэлүүлээд л, яриулаад л, нөгөө шүгэл үлээсэн хүнээ ингээд нэг их худалч, нэг ийм хүн явж байгаа юм шиг ойлгуулаад, нэр төрийг унагаагаад, дараад байж байдаг.

Ахиж хэзээ ч энэ Монголын төрийн байгууллагад ороод ажиллаж байгаа шударга залуучууд гар хүрч, үгээ хэлж чадахгүй болно шүү дээ. Үгээ хэлэхээр. За энэ авчих шиг болно. Больё одоо энд ингээд шүгэл үлээчихмээр юм зөндөө гарах юм. Шүгэл үлээчихвэл яадаг бол гээд. Ингээд айдастай болж Төрийн байгууллагын нэг ажилтан таалагдсан буюу дэмжиж байгаа асуудал дээрээ лайк дараад ингээд бурууддаг гэж байна шүү дээ. Юу билээ даргаараа загнуулдаг, шийтгүүлдэг ч юм уу ийм байдал нь ерөөсөө бүх шатандаа дарангуйллын байдал чинь үнэхээрийн бүр дарангуйлал чинь ерөөсөө социализмын үе шиг боллоо шүү дээ.

Тэгээд энэ талбай дээр гарч ирээд үгээ хэлээд үзэл бодлоо илэрхийлж байгаа хүмүүсийг барьж аваад бүгдийг нь ингээд торонд хийгээд, эсвэл ингээд торгож шийтгээд ерөөсөө үгээ хэлэх хүн одоо олдохоо байсан. Айгаад. Энэ дээр шинэ сайд маань бас нэг хүний эрхийн мэдрэмжтэй ажиллаасай гэж би хүсэж байна.

Сонсгол даргалагч П.Сайнзориг - За Ганболд гэнэ овгийн эхний үсэг тавиагүй байна. 2 номер.

Иргэн Ганболд - Сайн байцгаана уу? Бүгдэд нь энэ өдрийн мэнд хүргэе! За Сэлэнгэ аймгаас би Сэлэнгэ аймгийн Сайхан сумаас би оролцож байгаа иргэн хүн байна. Сэлэнгэ аймгаас би хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй, ингээд ярих гээд энд орж ирсэн байгаа. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх нь маш ихээр Сэлэнгэ аймагт зөрчигдөж байна. Энийг одоо ямар байгууллага тэр эрх нь зөрчөөд байгаа юм. Байгууллагууд яагаад энэ эрх нь зөрчөөд байгаа хүмүүсийг ингээд авч хэлэлцэхгүй байгаа юм бэ?

Хүний эрхийн Үндэсний Комисс яагаад ажиллахгүй байгаад байгаа юм бэ? гэдгийг би одоо хэлье. Маш ихээр хүн нь эрх нь зөрчигдөж байгаа шүү тэр Сэлэнгэ аймаг. Гадаа ялангуяа энэ талуудаар байгаа хүмүүсийн эрх нь маш ихээр зөрчигдөж байгаа шүү 2022 оны нүүрсний сонсголын үеэр маш ихээр миний эрхийг зөрчиж юу

яасан хүмүүс энэ дотор сууж байна шүү. Би харж байгаа шүү. Энэ дотор миний эрхэд халдсан хүмүүс энэ дотор сууж байна. Янз янзаар харлуулсан, янз янзаар намайг мөнгө авсан хядсан гэж харлуулсан хүмүүсийн дотор энэ дотор сууж байна шүү, одоо энийг ямар хүмүүст би хандаж хэлэх вэ? Хүний эрхийг маш ихээр зөрчигдөж байгаа шүү би хэлье.

Намайг ганцхан биш, бүх хүмүүсийн эрхийг маш ихээр зөрчигдөж байгаа шүү. Энэ Монголын эрх, хүмүүсийн бүх эрх, Монголчуудын эрхийг нь бүгдийг нь зөрчиж байгаа шүү. Эрхийг нь зөрчөөд байгаа шүү, ямар ч хүний эрхийн байгууллага нь одоо ингээд ажлаа хийж чадахгүй л байна шүү дээ.

Тэгээд гомдол гаргаад очихоор араас нь очиж янз янзаар муулж телевизүүдээр очиж муулж ингэж явдаг тийм Хүний эрхийн комисс гэж юу байдаг юм. Ийм муухай бузрын муухай юмыг хийчхэж тануус, ичээч. Хүний эрхийн комиссынхоо хүнийг янз янзаар харлуулж байгаа тануус хүний эрхийг хамгаалж чадсан уу? Тануус. Өнөөдөр маш ихээр эрхийг нь зөрчиж байгаа хүмүүс маш ихээр байгаа шүү.

Гадаа ингээд талбай дээр чинь зогсож байгаа шүү тануус эрхийг тэр хүмүүсийн эрхийг нь хамгаалж өг. Одоо гараад тануус хамгаалж өгөөрэй, эрхийг нь эрх нь маш ихээр зөрчигдчихөөд байна. Тэр гадаа талбай дээр чинь суулт зарлаад сууж байна шүү дээ зарим хүмүүс нь. За баярлалаа ингээд миний хэлэх үг дууслаа.

Сонсгол даргалагч П.Сайнзориг - За баярлалаа дараагийн Н.Болдбаатар 7 номер дээр суусан хүн. 7 номерын микрофоныг өгье.

Иргэн Н.Болдбаатар - Та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтгая. Би улс төр судлаач, эрх зүйч, магистр, доктор судалгаа хийдэг хүн байгаа юм. Тэгээд би үндсэн хуулийн чиглэлээр судалгаа хийдэг. Тэгээд одоо би эхнийхээ бүтээлээ бол би ингээд гаргачихсан байгаа юм энд бол одоо ер нь өнөөдөр бол энд яригдсан асуудал бол ер нь бол энд хамаарч байгаа тэгэхдээ зэрэг бол одоо ерөнхийдөө энэ Үндсэн хуулийг болохоор бол 3 шалгуур үзүүлэлтээр ер нь дүгнэдэг юм байна.

Нэг нь болохдоо зэрэг шударга ёс буюу нөгөө хүлээн зөвшөөрөгдсөн байдал, 2 дахь нь болохдоо зэрэг хууль ёс буюу одоо нөгөө хууль ёсыг мөрдөх, 3-д нь үр нөлөөтэй байх. За өнөөдөр энэ хүмүүсийн энэ ярианаас харахад бол одоо манай Үндсэн хууль үр нөлөөтэй байдал гэдэг бол үнэхээр алдагдсан л харагдаж байна. Энэ юугаар дүгнэж болох вэ гэх дээр үндсэн хуулийн эрх буюу үндсэн эрхүүд зөрчигдсөн одоо хүмүүс бол маш их олон байна.

Тэр нь 10 гаруй жил болчихсон. Энийг бол шинэ хууль эрх зүйн орчноор энэ нөхцөлийг бүрдүүлэх хэрэгтэй. Энийг миний харж байгаагаар Үндсэн Хуулийн Цэц гэж байгаа бол Үндсэн хуулийн шүүх, Үндсэн хуулийг батлан хамгаалах, сахин хамгаалах тийм үүрэгтэй шүүх байгаа. Үндсэн хууль гэдгийн үүрэг нь юу вэ гэх дээр зэрэг ерөөсөө л хүний үндсэн эрхийг хамгаалах. Тэгэхээр энэ үндсэн хуулийн цэцийн маань үүрэг бол бас энэ үндсэн хуулийн эрхийг хамгаалах байдаг Үндсэн Хуулийн Цэц бол ерөөсөө дэлхий дахины жишиг бол одоо үндсэн 3 үүрэгтэй нэгд болохдоо зэрэг бол одоо Үндсэн хуулийг тайлбарлах гарсан хууль тогтоомжууд одоо Үндсэн хуульдаа нийцэж байна уу үгүй юу гэдгийг шалгадаг.

Хамгийн гол нь 3 дахь үүрэг Үндсэн хууль хуулийг бол одоо шууд үйлчилдэг эрх зүй болгодог. Жишээ нь маш их олон хүн энэ Зоригийн хэрэг гээд л сая зөндөө ярилаа. Энийг бол эцэстээ бол энэ прокурор шүүхээр биш. Хамгийн эцэстээ Үндсэн Хуулийн Цэц энийг чинь шийдээд эрх зүйн орчныг нь бүрдүүлчихсэн бол Үндсэн

Хуулийн Цэц шийдээд Үндсэн хууль дээр бол одоо хөх тэнгэрээс өөр юм байдаггүй гэдгээрээ тэр шийдвэрээр ингээд энэ асуудлууд дороо шийдэгдээд явах ёстой. Тэгэхээр манай шинэ бүрэлдсэн Их Хурал бол ерөөсөө энэ Үндсэн Хуулийн Цэцийн эрх зүйн орчинг яг олон улсын жишгийн хэмжээнд хүрэхийг үнэхээр энийг хамгийн түрүүнд хийх ёстой асуудал гэж би харж байгаа. Ерөнхийдөө энэ мөчлөгийн онол гэж одоо үндсэн хуулийн э судалдаг ийм онол байна. Энэ онолоор болохтой зэрэг бол ерөнхийдөө 6 үе шаттай байдаг. Энэ шатны тогтвортой байдлаас дараагийн тогтворгүй байдалд ордог юу бол? Одоо ингээд энэ үндсэн хуулиар шийдэгдэх ёстой энэ эрхийн зөрчил ингээд хуримтлагдаад байдаг.

Сонсгол даргалагч П.Сайнзориг - За баярлалаа. Тэгээд хэдүүлээ бас сэдвийн хүрээнд бас барина. Таны хэлэх гэж байгаа санааг ойлгож байна хүний эрхийн үндсэн маргааныг цэцээр шийддэг асуудал бас олон жил яригдаж байгаа. Энийг бас хөндөж саналаа хэлсэн танд бас баярлалаа. За дараагийн иргэн маань Отгонцэцэг гэж байна та за сэдвийн хүрээнд ярина шүү би танд дэг санууллаа. Сэдвийн өрөөнд ярихгүй бол таны бие микрофоныг бас хаана гэдэг зүйлийг урьдчилаад хэлье 2 номер.

Иргэн Отгонцэцэг - Сайн байцаана уу? Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе. Ингээд ямар ч л байсан хүний эрхийн асуудлаар энэ сонсгол хийж байгаад маш их баяртай байна. За миний хувьд болохлоороо хүний эрхийн төлөө болон хүүхдийн эрхийн төлөө явж байгаад бас хэлмэгдэж бас ял шийтгэл авч байсан хүн байгаа юм аа. Тэгээд ялын шийтгэл авахдаа би цахим гав 6 сар зүүсэн байгаа. Цахим гавыг болохлоороо зүүх шийдвэрийг шүүхээс өгчхөөд тэр цахим гав нь хүний эрүүл мэндэд маш хортой зүйлийг өөрийнхөө биеэрээ мэдэрсэн учраас 6 сарын хилийн хороо тогтоохдоо цахим гав зүүсэн тэгсний дараа цахим гав хэрэглэсний төлөө надаас бас төлбөр нэхэж байсан.

Энэ болохлоороо өөрөө нөгөө нэг ялаа 6 сар эдэлчихсэн байхад дахиад эрүүл мэндээрээ хохирч тэр гавыг нь зүүснийхээ төлөө одоо төлбөр төлнө гэдэг болбол энэ бас эрүүдэн шүүлтийн нэг хэлбэр гэж би бол үзэж байна аа. Тийм учраас энэ цахим гав зүүж байгаа. Тийм ээ энэ одоо иргэдэд иргэдээс энэ цахим гавын төлбөр авахаа болиоч ээ гэж бас хэлмээр байна. За хоёрдугаарх нь болохлоороо өнөөдөр хүүхдийн эрхийн тийм ээ хүүхдийн эрхийн төлөө олон улсын одоо конвенц батлагдсан өдөр байгаа.

Өнөөдөр эрх зүйн чадамжгүй хүүхдийн эрхийн төлөө сэдвээр хэзээ сонсгол хийх вэ гэдгийг бас асуумаар байна аа. Хоёрдугаарх нь болохлоороо энэ ковид 19 вакцинаас болж хохирсон иргэдийн тийм ээ хүний эрхийг маш их ноцтой зөрж байгаа тэр вакцинжуулалтыг тарьсан учраас энэ асуудлаар одоо бас хэзээ хүний эрхийн сонсгол бас хийх вэ?

Энэ 2 зүйлийг бас үнэхээрийн шаардаж байна. Одоо удахгүй ингээд үр хүүхдүүдэд маань ингээд бас тийм ээ ямар ч одоо вакцины орц найрлагын талаар мэдээлэл байхгүй байхгүй. Хүүхдийн эрхийн тухай хуулийн 6.1.15 дээр хүүхэд мэдээлэл авах эрхтэй гэсэн байна. Гэвчиг өнөөдөр би сургуулиудаар явлаа, нийтийн тээврээр явлаа, гудамжаар явлаа, хүүхдүүдээс асуулаа. Вакцины орц найрлагын талаар нэг ч хүүхдүүд мэдэхгүй байна түүний талаар эцэг эхчүүд ч мэдээлэлгүй байна.

Гэтэл эрх зүйн чадамжгүй хүүхдүүдэд мэдээ мэдээлэл өгөхгүй байж байгаад цус руу нь элдэв янзын вакцин тарих гэж байгаа асуудлыг нэн яаралтай зогсоож өгөөч ээ мэдээллээр хангасныхаа дараа болооч ээ. Тэгээд дээрээс нь Дархлаажуулалтын тухай хууль дээр гарсан байна. Дархлаажуулалтын тухай

хуулийн 5.1.3 дээр хүндрэл гарсан тохиолдолд ердийн өвчний тэтгэмж олгоно гэж байна. Гэвчиг ер за танд баярлалаа хэдүүлээ бас би танд уг нь учир явдлыг бас маш ойлгомжтой тайлбарлаж байгаа. Эрүү шүүлт тулгах хүнд таны хөндөж байгаа асуудлуудаар бид нар бас албан ёсоор хүний эрхийн дэд хороон дээр ирж болно.

Сонсгол даргалагч П.Сайнзориг - За танд бас дэгийг сануулж байна. Бусдаа хүндэтгэе. Уранчимэг гээд хүн байна уу? за сэдвийн хүрээнд ярина гэж итгэж байна. За 7 номер.

Иргэн Уранчимэг - Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргье! Тэгэхээр өнөөдөр манай байгууллага хүний эрхийн судалгааны Чандмань сэтгэл төв. Тэгэхээр бид нар өнөөдөр Улсын Их Хуралд хандаад дахиад, өнөөдөр энэ төрийн байгууллагаас хүүхдийн эрхийн асуудлаар түрүүн илтгэл тавигдсан тэр хүрээнд бас ярих гэж байна. Өнөөдөр Монголын нийгэм хүүхдэдээ хүнлэг бус хандаж байна. Үүний нэг тод жишээ нь өнөөдөр электрон тамхийг маш ихээр хэрэглэж байхад хуулийг нь гаргаж өгөхгүй байна. Манай байгууллага судалгаа хийсний үндсэн дээр 2023 оны 6 сард анх Улсын Их Хуралд хүүхдэд, 21 хүртэлх насны хүүхдэд электрон тамхийг худалдан борлуулах сурталчилгаа...

Сонсгол даргалагч П.Сайнзориг - За би дэг танилцуулсан сэдэв танилцуулсан. Танд уучлаарай энэ асуудлыг Хүний эрхийн дэд хороонд бас хандаж гаргаарай. Бид асуудлыг нягталж үзье. За ингээд дараагийн хүн Р.Нямдорж мөн үү? иргэн Р.Нямдорж гуай. 7 номер микрофоныг нээж өгье.

Иргэн Р.Нямдорж - Та бүгдийн энэ өдрийн амгалан амар амгаланг эрье. Би 2014 онд хуванцаргүй монгол, хавдаргүй монгол гэж төрийн бус байгуулсан. Хавдартай тэмцэх Монголын нийгэмлэгийн тэргүүн Нямдорж гэж хүн байна. Монголчууд өнөөдөр яагаад дэлхий дээр хорт хавдраар тэргүүлээд байгаа юм. Элэгний хорт хавдар яагаад 9-10 дахин өндөр байгаа юм. Энэ асуудлаар би та нөхдийн сонорт хүргэх гэсэн юм.

Сонсгол даргалагч П.Сайнзориг - Эрхэмээ хэдүүлээ дэг барина. Өнөөдрийн сэдэвтэй дэгтэйгээ Таны энэ асуудлаа Хүний эрхийн дэд хороонд хандчих. Бид нар энэ тухай асуудлаар тухайлан сонсгол явуулж болно Нямдорж гуай. За би энийг танд хэлье, хэдүүлээ дэгээ барья бусдыг хүндэтгэе. Өнөөдөр яг эрүү, эрүүдэн шүүхийн эсрэг хүнтэй хүнлэг бус харьцах энэ асуудлуудыг ярья гээд энд хүмүүс цуглачихаад байхад яг энэ дээр өөр сэдэв ярихаар бас шийдэл нь бас буруу болчих гээд байгаа юм. Тэгэхдээ энэ асуудлаараа Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо болон холбогдох байнгын хороо, магадгүй хүний эрхийн дэд хорооны хандаад асуудлуудыг хандвал бид бас асуудлуудыг ярилцахад бэлэн байгаа гэдэг зүйлийг би бас хэлмээр байна.

Ингээд Золбаяр гэж хүн байна уу? 2 номер дээр суучих, микрофоны цагийг нь эхнээс нь өгчхөөрэй.

Иргэн Золбаяр - Эрх чөлөөний эвсэл намын гишүүн Золбаяр байна. Тэгээд өнөөдөр яг сэдвийн хүрээнд гэж ярих юм бол энэ нь өдийгөөс яг 4 сарын өмнө буюу 7 сарын 21, 22-нд болсон. 21 настай хохирогч залуугийн талаар хууль хяналтын байгууллага, Авлигатай тэмцэх газар, Цагдаагийн ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий байгууллагын ажилчдын тэр залууг эрүүдэн шүүсээр байгаад хүний гар утас хулгайлаагүй зүгээр тэр хэрэгт сэжиглэгдэж шалгагдаж байсан хүнийг эрүүдэн шүүсээр байгаад нөгөө залуу чинь сар болоод гарч ирээд Авлигатай тэмцэх газарт хандахад нь дахиад Авлигатай тэмцэх газрын гаднаас цагдаагийн албан хаагчдад барьж өгөөд нөгөөдүүл нь дахиж нөгөө залууг хориод, эмнэлэгт бие нь

хүндрээд эмнэлгийн орон дээр эмнэлгийн үйлчилгээ авахад гавтай байж байгаад нас барсан. Тийм хүний асуудал байхгүй юу. Нэг ёсондоо Монгол Улсын Үндсэн хуулийн 16.1 буюу **амьд явах эрхтэй гэдэг эрхийг манай төрийн байгууллагууд 100% зөрчсөн.**

Тэгээд энэ асуудлыг яг гол болгоод энэ кэйсийг яагаад ийм юм болов, энэ хэрэг хэний утсыг хайхаараа ингэж хүнийг эрүүдэн шүүдэг юм гэдэг асуудал яригдахгүй байна. Жишээлбэл, Сүнжид даргын мэдээлэлд байна лээ 100 гаруй эрүүдэн шүүлттэй холбоотой гомдол ирэхэд, 55 нь Цагдаагийн ерөнхий газрын албан хаагчтай холбоотой гэж байх жишээний. Гэтэл Цагдаагийн ерөнхий газраас төлөөлөл удирдлагууд нь байхгүй байна. Ер нь цагдаагийн байгууллага ямар тохиолдолд хариуцлага хүлээдэг юм бэ? Хүүхэд хүчирхийлсэн хэрэг байна. Эрүүдэн шүүсэн хэрэг байна. Бид нар дөрөвхөн сарын өмнө болсон хэрэг шүү дээ. Гэтэл энэ чинь 26 жилийн өмнө болсон хэрэг сөхөгдөж байна. За яах вэ нэг талдаа энд эрүүдэн шүүсэн, шүүлгүүлсэн гэж энэ хүмүүс гаргаж байж болно. Нөгөө талдаа тэр чинь Зориг агсан. Тэгвэл амьд явах эрхгүй байсан юм уу? Нөгөө Лхагвасүмбэрэл агсан байна шүү дээ. Тэгээд бас нийгмийн төлөө олны төлөө дуугарч байгаад явсан. Тэгэхээр энэ хүний эрхийн 18 асуудал байгаагаас энэ төр засаг маань хүний эрхийг хангах гээд олон нийтээс сонсох гээд ингээд арван зургаа буюу үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг нь ингээд хангаж байгаа. Одоо гүйцэт хангаагүй л байна л даа. Жишээ нь талбай. Одоо төрийн ордны баруун хаалган дээр сууж байгаа хэдэн жил сууж байгаа эмэгтэйг яагаад та нар оруулж ирээгүй юм. Үнэхээр олон нийтэд сонсгож байгаа юм бол тэгэхээр ийм ийм асуудлуудаа гаргаж ирж тавихгүй тэгсэн мөртөөсөө зүгээр нийгмийн стресс ...

Сонсгол даргалагч П.Сайнзориг - За танд баярлалаа. Дараагийн хүнийг сонсоод Улсын Их Хурлын гишүүдээс дэгийн хуульд заасны дагуу төрийн байгууллагын мэдээлэл болон оролцогчдоос асуух боломжтой байна. За Мягмардорж болон Баттогтох нар бас ойртоод сууж байгаарай.

Иргэн Мягмардорж - За сайн байцгаана уу? Энэ өдрийн мэнд хүргье. Монголын Өмгөөлөгчдийн Холбооны гишүүн өмгөөлөгч Мягмардорж байна. За өнөөдөр энэ арга хэмжээг зохион байгуулж байгаа санаачилсан энэ гишүүд хүмүүст бас талархлаа илэрхийлж байна. Би яг юу хэлэх гэж байна гэхлээр бид нар энэ эрүүдэн шүүхийн асуудлыг ярихдаа эрх зүйн орчноо л яримаар байна Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиас эхэлмээр байна. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар өмгөөлөгч нар ямар ч эрх байдаггүй хүсэлт гомдол гаргахаас өөр цаашаа давах эрх байдаггүй. Гэтэл шүүх дээр очоод прокурортой тэгш мэтгэлцэх ямар ч боломж өмгөөлөгч нарт алга. Тэгэхээр энийг эхлээд бид нар шийдмээр байна. Мөрдөгч прокурорууд болбол цагаатгах нотлох баримтыг ерөөсөө бүрдүүлдэггүй яллах талын л баримтаа бүрдүүлдэг цагаатгах талын баримт бүрдүүлдэггүй. Тийм учраас энэ шүүх дээр шүүгдэгчийн болоод сэжигтэн яллагдагчийн эрх маш ихээр зөрчигдөж байна гэдгийг 1 дүгээрт хэлмээр байна

2 дугаарт болохлоор яг ойрын жишээ ярья л даа. Сая 2024 оны 4 сарын 05-ны өдөр миний үйлчлүүлэгч шүүх хурал дээр мэдүүлэг өгснийх нь төлөө маргааш нь тусгай албаныхан 461 дүгээр хорих ангиас авчрахдаа зодсон байгаа юм. За энийг би заавал ярих хэрэгтэй гэж бодоод байна. Яагаад энэ тусгай албаныхан гэж энэ хүмүүст хууль үйлчилдэггүй юм бэ? Энэний зохицуулсан хууль дүрэм журам алга. Хэн дуртай хүнээ зоддог, хэн дуртай хүнээ эрүүдэн шүүдэг байдал газар авсан байна. Тэгэхээр энэ төрийн тусгай алба тул, тусгай албаныхныг энэ зохицуулсан энэ хуулийн зохицуулалтыг нь бий болгож өгөөч.

Тухайн үед нь Хүний эрхийн Үндэсний Комисс тусгай субъектийн газар тэр бүх газарт гомдол гаргаад байхад өнөөдөр ямар нэг хариулт ерөөсөө алга байна. Энэ дээр бид нар хариулт авмаар байна. Өмгөөлөгч нарын хувьд дараагийн нэг асуудал гэхээр зэрэг хамгийн сүүлд 2024 оны 1 сард Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулахдаа бас нэг буруу юм хийчихсэн байна уу? гэж миний хувьд хараад байгаа юм. Яагаад гэхлээр цагдан хорих нийт хугацаа байгаад байдаг, цагдан хорих нийт хугацаанд шүүхэд байгаа хугацаа орохгүй ийм заалт орчихсон энийгээ яаралтай өөрчилж өгөөч ээ. Яагаад гэвэл шүүх дээр хэрэг хянан шийдвэрлэх ажил шүү. Шүүх хурал бол маш удаан явагддаг жил, 2 жил болдог. Гэтэл нөгөө нийт мөрдөн цагдан хорих тэр хугацаандаа орохгүй байна гэдэг ийм зүйлийг бас анхаарч энийгээ өөрчилж өгөөч гээд хүсээд байгаа юм. За ер нь мөрдөгч энэ хүмүүст арга хэмжээ авдаг эрх зүйн зохицуулалт байхгүй.

Тэгээд энэ хүмүүс чинь ажлаа хийгээд өнөөдрийг хүртэл яваад байна. Эрүүгийн хариуцлагын тогтолцоо нь буруу байгаа учраас энэ хүмүүс чинь дахин дахин эрүүдэн шүүгээд байна, арга хэмжээ авагдахгүй байна, ажлаа үргэлжлүүлж хийгээд байна, өнөөдөр энэ бүх хүмүүс эрүүдэн шүүгдчихсэн хүмүүсийн гомдол нь тайлагдаагүй хүмүүс нь ажлаа хийж байна. Нэмж хэлэхээр санал байна.

Сонсгол даргалагч П.Сайнзориг - 2 минут нэмж өгье.

Иргэн Мягмардорж - Дараагийн хэлэх юм бол энэ прокурорын байгууллагад хандаж хэлмээр байгаа юм. Прокурорууд яаж байна гэхээр Өнөөдөр ерөөсөө өмгөөлөгчийн гомдол, саналыг хэлэлцэж шийддэг тийм прокурор байхгүй болсон, бүгдээрэнд нь копи, паст хийж гомдол хэргийг татаж хяналаа таны гомдлыг хангахаас татгалзаж байна гэдэг байдлаар хариу өгдөг болсон. Тэгэхлээр прокурорын байгууллага үүргээ гүйцэтгэмээр байна гэдгийг бас хэлмээр байна. Дараагийн дугаарт эрүүдэн шүүх асуудал одоо хүртэл байна, үргэлжлээд байна. Шүүхээс өмнө гэм буруутай, буруутайд тооцчихоод байна. Прокурор тэгчхээд энэ талдаа арга хэмжээ авахгүй байна энэ тал дээр бас энэ Чинбат прокурор арга хэмжээ авч, өгөөч гэж ингэж хүсэж байна.

Дараагийн дугаарт энэ ялтны асуудал дээр асуудал ярих хэрэгтэй байгаад байна. Эмнэлгийн үйлчилгээ авч чадахгүй байна. Энэ орон нутгийн хоригдож байгаа хүмүүс эмнэлгийн үйлчилгээ авч чадахгүй байна. Энэ дээр бас анхаарч өгөөч гэж хүсэж байна.

Сонсгол даргалагч П.Сайнзориг - За баярлалаа. Дараагийнх Э.Баярхүү 7 номерын микрофон?

Иргэн Э.Баярхүү - Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргье! Төрийн хүний эрхтэй холбоотой төрийн чих онгойж байна гэж үзэж байна. Баярлалаа. Тэгээд энэ хүний эрхтэй холбоотой бүх зөрчлийг миний бие үзчихсэн сүүлийн 3 жил энэ Хууль зүйн байнгын хороо холбогдох бүх хурал дээр сууж ярьж байгаа. Тэгээд энэ удаа айхтар янз янзын юм ярихаа больё зүгээр л залуу хүний хувьд дахиад бид нарын үзэж туулаад байгаа зүйлийг нь хүмүүст үзүүлэхгүйн тулд л ингээд явж байгаа юм. Түүнээс бол завтай хийх юмнуудаа энд ярьж суугаагүй. Тэгээд Хүний эрхийн Үндэсний комиссыг би одоо хамгийн ихээр шүүмжилдэг хүн.

Тэгээд энэ удаа бол Та нөхдийг шүүмжлэхгүй, энэ нөхдүүдийг энэ улс төрчдөөс хараат бус л болгомоор байна. Үндсэн хуулийн байгууллага болгомоор байна. Ингэж байж энэ нөхдүүд ажиллахгүй бол эд нар бас л үнэхээр хангалтгүй байгаа. Тэгээд сүүлийн үед бол фэйсбүүкээр ажил хийгээд байх шиг байна.

Тэгээд энэ хүний эрхийн зөрчлийн ундарга бол ерөөсөө энэ төрийн ордноос эхлэлтэй л гэж харж байгаа юм. Ёс зүйгүй Улсын Их Хурлын гишүүд улс төрчид л өөрсдөө дандаа болж бүтэхгүй нэг юмнуудын ар талд өөгшүүлж даврааж байдаг. Хуулийн байгууллагын ажилтнуудын бүгд биш энэ дотор нь байгаа ёс зүйгүй этгээдүүдэд тооцдог хариуцлагыг нь чангатгахгүй бол ямар ч айдасгүй зүгээр өөдөөс хууль яриад л хараат бус нэрийн доор хууль зөрчиж явдаг ийм зүйл байж байгаа.

Тэгээд энийг тастахын тулд энэ Улсын Их Хурлын гишүүдийг л ёс зүйтэй болгомоор байгаа юм гэдэг зүйлийг хэлье. Одоо нэг асуулт байгаа юм. Эрдэнэтийнхээ наадмын талбайг Улаанбаатар хотын Төв цэнгэлдэх хүрээлэн шиг болгохгүй гээд л. Одоо миний бие сүүлийн 7, 8 жил ярьж байгаа. Тэгээд үүнээсээ болоод Улсын Их Хурлын гишүүн та нар уучлаарай намайг ийм юм хэлэх гэж байгаад Улсын Их Хурлын гишүүний дарамтад орчхоод байж байна.

Хөөе гөлөгөө, чи шээс, баас минь, чи хэн ч биш гээд чамайг Улсын Их Хурлын гишүүнээсээ татгалзаж байгаа юм нэг цохиж ална гээд л чи яахлаараа надад нэг удаа за, ойлголоо мэдлээ гэж хэлж болдоггүй юм гээд Улсын Их Хурлын гишүүн нь ийм юм яриад явж байна шүү дээ. Наадмын талбайгаа хамгаалж байгаа иргэнийхээ асуудлыг ярьж байна. Чамайг би нэг цохиж ална гээд Улсын Их Хурлын гишүүн. Өнөөдөр Хүрэлсүх даргын Ерөнхийлөгчийн анхдугаар хуралдаан дээр хэлсэн үг иргэнээ хамгаал, иргэнээ төлөөл, иргэнтэйгээ хамтарч ажилла л гэсэн. Тэгээд ингэж чадахгүй бол энэ танхимд багтахгүй гэсэн. Тэгэхээр энэ нөхрийн нэрийг нь хэлээд яах вэ. Тэр нөхөр иргэнээ төлөөлж чадахаа байчихсан. Сонгогдоод удаагүй байхдаа наадмын үеэр иргэнээ ална, баас, шээс, гөлөг, нохой, хамаа халаач, малаа гээд байгаа учраас энэ УИХ-ын гишүүд өөрсдөө ёс зүйтэй баймаар байна.

Дээр нь энэ хуулийн байгууллагын ажилчид, хүний эрх зөрчиж байгаа энэ асуудал чинь өөрөө бүр утгаа алдчихсан эд нарт ямар ч айдасгүй байгаа учраас эд нар санаатайгаар хуулийг зөрчдөг. Иргэний 21 дүгээр зуунд үл тэвчиж болох зүйл байхгүй юу. Энэ чинь эрүүдэн шүүлтийн.

Сонсгол даргалагч П.Сайнзориг - Бид нартай хамаатай зүйл байгаа учраас одоо болох байх ерөнхийдөө үндсэн асуудал руугаа оръё, хувь хүн бусдыг доромжилсон үнэхээр ийм зүйлүүд байвал холбогдох институцад бас мэдээллээ гаргаад явах нь зөв байх. Энэ индэрийг хэдүүлээ зохистой ашиглах ёстой, эсвэл тэр хүний нэрийг яг хэлээд ярь. Түүнээс биш ерөнхий юм яриад байж болохгүй. Тийм учраас би танд нэмэлт мэдээлэл өгөх нэмэлт цаг өгөх бололцоогүй байна.

Баттогтох гээд хүн байна уу? Хүний эрхийн Үндэсний форумоос, 20 номерын микрофоныг нээж өгье.

Иргэн Баттогтох - Сайн байцгаана уу? Намайг Баттогтох гэдэг би хүний эрхийн форумын дөчөөд байгууллага байдаг тэд нарын төлөөлөл болж ярьж байна. Манай хүний эрхийн форум бол олон чиглэлээр Нэгдсэн үндэстний байгууллагын Хүний эрхийн зөвлөлд сүүдрийн тайлан илтгэл явуулдаг. Өнөөдөр ирсэн манай багийнхан бол эрүү шүүлтийн эсрэг конвенцын хэрэгжилтийн талаар тайлан гаргадаг багийн ахлагч Баттогтох гэж хүн байна. За манай багийнхан олон жил энэ эрүү шүүлтийн эсрэг конвенцын хэрэгжилтийн талаар ажиллаж байгаа, 2010 оноос эхлээд хүний эрхийн ээлжит дүгнэлт хэлэлцүүлэг буюу бид нарын ярьж заншсанаар Ю Пи Арын тайлан гаргаж явсан 2010 онд бол бид нар ерөнхий утгыг нь хэлэхэд 7 сарын нэгэнтэй холбоотой асуудлыг тайланд тусгаж өгсөн.

2015 онд бол цаазаар авах ялыг халхаж эхэлсэн. Иргэний болон улс төрийн эрхийн 2 дугаар протоколд заасан биш 2 дугаар нэмэлт протоколд заасан. Энэ одоо

хэрэгжилтийг хангасан талаар мэдээлэл хүргэж байсан 2020 онд бол бид нар ковидтой холбоотой хүний эрхийн зөрчлийг эрүүлжүүлэлттэй холбож хүргэсэн. Одоо 2025 оны 3 сард бид нар Ю Пи Арын 4 дүгээр циклийн тайлан гаргахаар ажиллаж байна аа. За манай багт болбол ажиллаж байгаа хүмүүс мөн энэ эрүү шүүлтийн холбоотой асуудлыг хүлээж авч хэрэгжилтийн талаар тайлан бэлддэг.

Манай энэ Ю Пи Арын тайлан эрүү шүүлтийн тайланг бол 2025 оны 3 сард Нэгдсэн Үндэстний Байгууллагад илгээнэ. Энэ тайлан бол одоо сүүдрийн тайлан байна. Сүүдрийн тайлан Засгийн газрын тайлантай Монгол Улсын тайлантай зэрэгцэж явдаг ийм зохицуулалтаар явагддаг. За ингээд Монгол Улсад Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн зөвлөлөөс ирүүлсэн эрүү шүүлттэй холбоотой 13 зөвлөмж байгаа. 13 зөвлөмжийг бид нар үнэлсэн дүгнэсэн ерөнхийд нь бас зохих байгууллагуудад мэдээллээ хүргэсэн байж байгаа. За ингээд эрүү шүүлтээр энэ чиглэлээр ирсэн 13 зөвлөмжөөс, 4 зөвлөмж бүрэн биелсэн гэж бид нар үнэлсэн байгаа 4 зөвлөмжийн ерөнхий агуулгыг хэлбэл товчилж би ярья.

1. үндэсний урьдчилан сэргийлэх механизм байгууллага байгуулах гэсэн тийм зөвлөмж байсан. Энэ зөвлөмж бол байгууллага маань байгуулагдаад явж байгаа учраас энэ зөвлөмжийг бүрэн хэрэгжсэн гэж бид нар тооцож дүгнэлтэд оруулсан байгаа.
2. За дээр нь 8 зөвлөмж бол хэрэгжих шатандаа явна гэж бид нар дүгнэсэн. Энэ 8 зөвлөмж нь бол эрүү шүүлттэй холбоотой гомдлыг хүлээж авах, түүнийг шийдвэрлэх асуудал, бас хорих ангийн нөхцөл байдлыг сайжруулах хорих ангийн одоо нөхцөл байдлыг сайжруулах хэт багтаамжийг бууруулах гэсэн чиглэлийн мөн эрүү шүүлттэй холбоотой сургалт

Сонсгол даргалагч П.Сайнзориг - Нэмж хэлэх зүйл байх шиг байна. 2 минут нэмээд өгчихье.

Иргэн Баттогтох - За ингээд энэ зөвлөмжийг бол 8 зөвлөмж хэрэгжих шатандаа яв гэж үзсэн. Энэ бол нийт зөвлөмжийн 69, 62%-ийг эзэлж байгаа. 13 зөвлөмжөөс нэг зөвлөмжийг огт хэрэгжээгүй гэж бид нар дүгнэсэн байгаа. Энэ зөвлөмж бол удаа дараагийн зөвлөмжид ирдэг ямар агуулгатай зөвлөмж байсан гэвэл Улсын Ерөнхий прокурорын дэргэд эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх мөрдөн байцаах албыг 2015 онд татан буулгасан одоо бол энэ ажиллахгүй байгаа. Тийм учраас олон улсын байгууллагуудаас ирүүлж байгаа зөвлөмжийн агуулга нь энэ мөрдөн байцаах албыг дахин байгуулаач гэсэн ийм зөвлөмж ирдэг. Энэ зөвлөмж бол одоогийн байдлаар манай хүний эрхийн байгууллагуудын дүгнэснээр огт хэрэгжээгүй гэсэн ийм дүгнэлт хийгдсэн. За ингээд би товчилж хоёр 3-н зүйлийг нэмж хэлье. За бид нарын одоо тайланд тусгасан зүйлүүдийг өнөөдрийн сонсгол дээр яригдсан зүйлүүд маш их чухал чухал мэдээллүүд хийгдлээ. Цаг үеэ олсон сайхан сонсгол болж байна зохион байгуулсан бүх хүмүүст талархлаа оролцсон хүмүүст талархлаа. Бид нарт болбол нэг санал байна.

Энд оролцсон тэр гомдол гаргах, гомдлыг хүлээж авах, шийдвэрлэх асуудалтай холбоотой илтгэлүүдийг бид нарт одоо файлаар өгнө үү гэсэн хүсэлтийг хурал даргалж байгаа хүмүүст тавимаар байна. За 2 дугаар асуудал бол сая 1 хүн ярьж байна манай тайлан илтгэлд орсон дүгнэлт дотор байж байгаа 21 настай залуугийн нас барсантай холбоотой энд 2 эрүү шүүлттэй холбоотой дүгнэлт орсон байж байгаа

- 1 дүгээрт нь бие махбодын эрүү шүүлтийг тулгасан гэж үзсэн. Яагаад гэвэл Баянгол дүүргийн 1 дүгээр хэлтсийн одоо нэр бүхий цагдаагийн албан хаагч нар энэ залууг зодож удаа дараа эрүүдэн шүүлтэд өртүүлсэн. Ийм

- одоо байдал 1 дүгээрт нь дүгнэгдсэн
- 2 дугаарт нь за 3 дугаар эмнэлэгт хэвтэж байх үед нь 4 цаг орчим гав зүүсэн диализын аппаратад ороход

Сонсгол даргалагч П.Сайнзориг - Таны бас хэлж байгаа саналуудыг бид анхааръя аа. За ингээд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 126 дугаар зүйлийн 126.1.4-д заасны дагуу биечлэн бас санал мэдээллийг танилцуулах иргэдийг бид сонсож дууслаа. Ингээд сонсголд бас биечлэн оролцох боломжгүй боловч бичгээр санал илгээсэн иргэдийн саналыг би товчхон бас дурдаад тэгээд УИХ-ын гишүүдээс төрийн байгууллагын мэдээлэл болон за сонсголд оролцож байгаа иргэдээс асуух асуулттай гишүүдийн нэрсийг авна аа гэж одоо бодож байна. За дээрээс нь өөрийн биеэр ирж чадаагүй Завхан аймгийн Дөрвөлжин Буга багийн иргэн С.Чимгээгээс ирүүлсэн мэдээллийн би товч агуулгыг та бүгддээ бас протоколд тэмдэглүүлэн үлдээхийг хүсэж байна. Та бүгддээ бас сонордуулаад за иргэн “С.Чимэг миний бие нь Завхан аймгийн Дөрвөлжин сумын Буга багт амьдардаг аа.

Манай гэр 2019 оны 1 дүгээр сарын 28-нд шатсан. Миний бие тэр цагаас хойш гал гарсан шалтгаан нөхцөлийг тогтоох галын дүгнэлт гаргуулахаар шат шатны төрийн байгууллага эрх бүхий албан тушаалтанд уулзахад хүнд сурталтай, хариуцлагагүй, хүнлэг бус, хэрцгий авирлаж хүний эрхийн мэдрэмжгүй хандаж байна”. Энэ асуудлыг сэргээн шалгаж өгөөч ээ гэсэн ийм одоо агуулга бүхий одоо бас энэ хүнлэг бус харьцаж байна аа гэсэн байдлаар мэдээллийг ирүүлснийг би бас уншиж сонсоё. За мөн иргэн нэрүүдийг бол хэлж болж байгаа тэ. Энэ нээлттэй байгаа за

Иргэн П.Нямдэлгэр: мэдээлэл ирүүлсэн байна. За миний бие 2017 онд надад тохиолдсон Монголын чамайг тайван амьдруулахгүй гэж оронд нь байр нэвтэрч орон байранд нэвтэрч орохыг завдаж, амь насыг хохирохоор заналхийлсэн үйлдлийг цагдаагийн байгууллагад гомдол гаргасан боловч тус гомдол мэдээлэл, цагдаа, прокурорын байгууллагын нэр бүхий ажилтнууд арга хэмжээ авахгүй ажилдаа хайнга хандсаны улмаас намайг заналхийлсэн. Энэ үйлдэл нь үргэлжилж бусдыг санаатай үйлдсэн.

Ослын улмаас миний бие зүүн нүд нүүрэндээ засаршгүй гэмтэл авч, эрүүл мэнд, гоо сайхан, сэтгэл санаагаараа хохирохоос гадна хөдөлмөрийн чадвараа эрүү алдлаа. 2017 оноос хойш 7 жилийн хугацаанд Бүгд Найрамдах Солонгос Улсад эмчилгээ хийлгэсээр одоо нүдний цавчих булчин ажиллахгүй, 24 цаг хараагүй байдаг. Үүнийг Солонгос улсад нөхөн сэргээх боломжийг илэрхийлж Америкийн Нэгдсэн улсад эмчлүүлэх санал болгосон. Бид 2 удаа Америкийн визэнд орсон боловч гараагүй ээ намайг төлбөрийн чадваргүй гэж тодорхойлоод байна. Хуульд зааснаар эмчилгээнд зарцуулах мөнгөн дүнг нотлох баримтаар эсхүл эмчилгээ хийлгэж ирсний дараа шийдвэрлэдэг эдийн засгийн зохицуулалттай юм байна. Би өндөр өртөгтэй орны баталгааг хангаж чадахгүй виз авч чадахгүй байна. Миний амь насанд заналхийлж байгаа талаар гомдол гаргаад байхад арга хэмжээ аваагүй цагдаа прокурорын нэр бүхий албан хаагчид хариуцлага хүлээгээгүй.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирлоо аргуулах эрүүл мэндээ сэргээхэд дэмжлэг хэрэгтэй байгаа талаар хүсэлтэд дурдсан байна”. За би ингээд бас товч танилцуулья. Өнөөдрийн яг энэ сонсгол эхлэхэд бас 3, 4 бичиг ирсэн. Энийг би бас одоо дэгийн тухай хуульд заасны дагуу бас сонсоё гэж бодож байна. Үүнд:

Монголын Ардчилсан Шинэ Холбоо гэдэг байгууллагаас Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх, за Д.Амарбаясгалан, Л.Оюунэрдэнэ нарт хандаж гаргасан ийм шаардлага ирүүлсэн юм байна.

За ингээд айн танилцуулчихсан энэ шаардлагыг бол бичгээр ирсэн Улсын Их Хурлын гишүүд ирсэн учраас би товч танилцуулаад өнгөрье. Эрүү шүүлтгүй хүний эрхийг дээдэлсэн нийгэм байгууллагад нэн тэргүүнд хийх бодлогын саналууд гээд Бат-Ялалтын санал бичгээр ирсэн байгаа.

Мөн Хүний эрхийн Үндэсний Комиссын Цогтбаатар даргын нэр дээр нэр бүхий иргэдийн байгуулсан холбоо байгуулагдсан талаарх мэдээллийг бид хэд энэ сонсгол зохион байгуулах ажлын дараанаас ирүүлсэн гэдэг зүйлийг энд товчхон дурдаад бичиг нь энэ сонсголын үеэр ирсэн байгаа гэдэг зүйлийг хэлье. Ингээд хүний эрхийг хамгаалахтай холбоотой эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахаас ангид байх эрхийн хэрэгжилт сэдвийн хүрээнд Улсын Их Хурлын хяналтын сонсголд оролцож байгаа Улсын Их Хурлын гишүүдээс холбогдох төрийн байгууллага албан тушаалтнууд сонсголд оролцогчоос 10 минутад багтааж асуулт асууж, хариулт авна.

Тэгэхээр 10 минутынхаа 5 дээр нь асуултаа асуугаад, 5 минут дээр нь холбогдох байгууллагууд мэдээллүүдийг хариултуудыг өгнө. Оролцогчид асуулт асуух эрхгүй байдаг. Энэ дэгийг та хэд маань ойлгоорой Улсын Их Хурлын гишүүдээс та бүгдээс сонирхсон энэ чиглэлийн мэдээлэл өгсөн байгууллага, албан тушаалтнуудаас асуулт асууна. Ингээд асуулт асуух, асуулттай Улсын Их Хурлын гишүүдийн нэрсээ өгнө үү? Нэрс хаана гарч байна? Алтанхуяг дарга та ирц нь яах билээ? Асуух билүү яах билээ? Дараа нь болох уу? нэр авч дуусаж байна. Ингээд Нарантуяа нараа гишүүнээр тасалъя. Ж.Алдаржавхлан гишүүнд микрофоныг өгье.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлан - Оройн мэнд хүргэе. Хэдүүлээ бас олон хүний зовлон бэрхшээлийг сонслоо. Надад нэг ийм асуулт байна. Хууль зүй дотоод хэргийн сайдаас ингээд л эрүүдэн шүүлт ер нь хаана болоод байна гэхэд л дандаа хүчний байгууллагууд болоод байна шүү дээ. Тэгэхлээр тэгээд тэнд асуудал ярихлаар мөрдөн байцаах ажилд одоо саад учрууллаа гэдэг? Тийм ээ. Тэгээд эргээд тийм асуудал үүсдэг. Тэгээд мөрдөн байцаах үйл ажиллагаанд саад учруулах эрхийг Хүний эрхийн Үндэсний Комисст өгвөл яасан юм бэ гэсэн. Надад ийм санал байгаа юм. Хүн хэрвээ өргөдөл гаргаад миний эрхийг ингэж зөрчиж байна гэх юм бол Хүний эрхийн Үндэсний Комиссоос мөрдөн байцаалтыг эрхийг хангахад л зогсох тийм эрхийг нь өгвөл яасан юм цагдаад тийм ээ цагдаа нарт чи миний эрхийг зөрчөөд байна гээд цагдаад эргээд өгөхөд цагдаа өөрөө өөрийгөө шалгахгүй байгаа юм. Хүчний байгууллага чинь өөрөө өөрсдийгөө шалгахгүй байгаа байхгүй юу. Тэгэхлээр Хүний эрхийн үндэсний комисс гэж нэг энэ нэг том байгууллагыг жоохон хүчтэй болговол яасан юм. Дараагаар 2-т нь энэ Хүний эрхийн Үндэсний Комиссын 7 гишүүнийг энэ намаас, энэ дээрээс сонгодог биш энэ ард түмнээс сонгодог тэр хүмүүст эргээд хяналт тавьдаг болбол яасан юм бэ гэсэн. Надад нэг ийм асуулт байна шүү.

Асуулт санал 2 дахь нь энэ их хүчний байгууллагын том том дарга нарыг хүчний байгууллагын том том дарга нарыг нэг хүний гарын үсгээр томилдгоос ер нь татгалзвал яасан юм. Ирээдүйд нийтийн мэргэжлийн хүмүүсийн дунд нээлттэй сонгон шалгаруулалтаар томилдог бол яасан юм. Цагдаагийн дарга одоо том том дарга нар байдаг шүү дээ. Тэднийг 1 хүний гарын үсгээр томилогддог эргээд тэр хүндээ үйлчилдэг. Тийм учраас ер нь ардчилсан зарчим нийгмийн одоо хэв журамт улсуудын жишгээр энэ том том дарга нарыг чинь нээлттэй сонсголоор нээлттэй иргэдийн дунд энэ жишиг рүү бид нар энэ нэг хүчний байгууллагуудын асуудлыг оруулбал яасан юм. Тэгэхгүй бол одоо тэгээд л одоо нэг гомдол гаргадаг.

Хэрвээ энэ хурал үр дүнтэй байсан бол дахиж ийм хурал болохгүй байсан. Өмнөх хурлууд үр дүнтэй байсан бол тийм өмнөх хурлууд ямар ч үр дүнгүй зүгээр сонсоод өнгөрсөн учраас бид нар өнөөдөр дахиад хуралдаж байгаа байхгүй юу.

Тэгэхлээр энэ хурлаас хэдүүлээ ямар нэгэн бодитой шийдвэр гаргахын тулд тэр Хүний эрхийн Үндэсний Комисс гэдэг байгууллагад нь эрхийг нь өгөөд эрх зөрчигдөж байгаа тэр ажиллагааг таслан зогсоодог түүний дараа үргэлжлүүлдэг болох ёстой гэсэн. Би одоо энэ зарчмын саналыг одоо гаргаж байна аа. Маш товчхон за энэ зүйлүүдэд Хууль зүйн сайдыг бас хариулж өгөөч ээ. Хэрвээ та бүгд зөвшөөрөх нь би хууль санаачлахад ч бэлэн байна энэний дараа хариулж өгөөчийг хүсэж байна.

Сонсгол даргалагч П.Сайнзориг - За баярлалаа. Улсын Их Хурлын гишүүн О.Алдаржавхлан Хууль зүй, дотоод хэргийн сайдаас яг тодорхой 3 асуулт асуулаа. Алтангэрэл сайдын микрофоныг өгье.

Хууль зүй, Дотоод хэргийн сайд: О.Алтангэрэл - Юуны түрүүнд нэг юм ойлгох ёстой өнөөдөр мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаа гурванч байгууллага байна. За хамгийн түгээмэл нь цагдаагийн байгууллага тэгээд Авлигатай тэмцэх газар, тагнуулын байгууллага эдгээр байгууллагуудын мөрдөн шалгах үйл ажиллагаанд хүний эрх хангагдах ёстой тэгэхдээ дахиад энэ мөрдөн шалгах ажиллагаа маань өөрөө бас хүний эрхийг хангахын төлөө явдаг гэдгийг бодох ёстой өнөөдөр амь насаараа хохирчихсон, эрүүл мэндээрээ хохирчихсон, өмч хөрөнгөөрөө хохирчихсон хэрэг дээр авлига албан тушаалын хэргийн улмаас зөрчигдсөн нийгмийн харилцааг сэргээх гэж энэ мөрдөн байцаах ажиллагаа маань мөрдөх ажиллагаа маань явагдаж байгаа гэдгийг бас бид нар давхар бодох ёстой.

Өөрөөр хэлбэл процесс ажиллагаа өөрөө тасралтгүй явагдаж байж тухайн хэрэг зөрчлийг шалгадаг зохих этгээдүүдийг цагаатгана. Эс үгүй бол хариуцлага хүлээлгэхээр прокурорын байгууллага нь хяналт тавиад шүүх рүү шилжүүлдэг учраас энэ ажиллагаа маань 2 талтай. Бид нар мөрдөн шалгах ажиллагаанд өртөж байгаа иргэнийхээ эрх ашгийг хамгаалах нь чухал. Мөн гомдол гаргасан тэр мөрдөн шалгах ажиллагааны үндэс болсон хүмүүсийнхээ эрхийг ч бид нар давхар бодох ёстой учраас энэ үйл ажиллагааг мөрдөн шалгах үйл ажиллагаа явуулах эрхгүй. Дундын субъектээс шууд цогцлоох гэдэг энэ асуудал бол яригдахад хүнд байх аа? Харин тэр Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга гишүүдийг бол олон нийтийн шалгуураар гэдгийг би бас өөрөө тэгж боддог хүн.

Өнөөдөр Улсын Их Хурлын дэргэдэх байгууллага гэж ярьж байгаа юм. Яах вэ статусыг нь Улсын Их Хурлын дэргэд авчраад тэгээд Улсын Их Хурлаар илтгэл нь хэлэлцдэг учраас Их хуралтай хамааралтай байлгаад байгаа. Ер нь бол олон жил энэ нийгэмд хүний эрхийн чиглэлээр явж байгаа амь хайргүй явж байгаа маш олон зүтгэлтэн хүмүүс байгаа. Энэ дундаас сонгон шалгаруулдаг болох энэ тогтолцоог санаачлаад явах юм бол дэмжинэ. За энэ хуулийн байгууллагуудын дарга нарын асуудал ярьж байна. Өнөөдөр хуулийн мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаа байгууллага болгон өөрсдийн тусдаа хуультай.

Хуульд зааснаар бол жишээлбэл, Цагдаагийн ерөнхий газрын дарга Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргыг Засгийн газрын хуралдаанаар томилж байгаа. Хамтын шийдвэрээр тус тусынх нь хуульд шалгуурыг нь заачихсан байгаа Цагдаагийн ерөнхий газрын дарга дэд дарга болох гэж байгаа нь цагдаагийн байгууллагад 10-аас доошгүй жил ажилласан гэдэг ч юм уу шийдвэр гүйцэтгэл, байгууллага бусад байгууллагууд Авлигатай тэмцэх газрын дарга удирд. Одоо бүгдээрээ хуульд заасан шаардлагууд байгаа. Тэгэхээр эдгээр байгууллагуудын удирдлагатай холбоотой асуудлууд тус тусын хуулиар зохицуулагддаг учраас бүгдийг нь нэг дор гэдэг юм уу солих бололцоогүй бүгдээрэнгийнх нь хуульд өөрчлөлт оруулаад яаж томилох вэ гэдгийг сонгон шалгаруулах ёстой болно. За ер нь бол таны хэлсэн зүйл дээр нэг зүйл дээр зарчмын хувьд маш санал нийлж байна.

Энэ байгууллагуудыг удирдаж байгаа нэн ялангуяа хүний эрх эрх чөлөөтэй холбоотой үйл ажиллагаа өдөр тутам явуулдаг байгууллагын удирдлагууд хүний эрхийн хамгийн дээд зэргийн мэдрэмжтэй байх ёстой би зүгээр хамгийн ойроор нь юу гэж бодож байгаа вэ гэхлээр шаардлагатай.

Одоо бид нар судалгааг хийж байна. Нэн тэргүүнд одоо тэр яригдаж байгаа Прокурорын дэргэдэх мөрдөн байцаах байгууллага гэж байнга яригдаж байгаа асуудлыг бидний нэрлэж заншсанаар Тусгай субьекттэй холбоотой мөрдөн шалгах аж. Үйл ажиллагаа явуулах энэ байгууллагыг хуучин нэрээр дахарын дэргэд за шинэ хуулийн төсөл боловсруулагдаж байгаа нь Шүүх аюулгүй байдлын албаны дэргэд бид нар байгуулж өнөөдрийн мөрдөн шалгах үйл ажиллагаа явуулж байгаа Цагдаа, Тагнуул, Авлигатай тэмцэх газраас тусдаа үйл ажиллагаа явуулах явуулах нь зүйтэй юм байна аа гэсэн энэ үзэл санааны дагуу ажил хийж байгаа гэдгээ хэлье. За баярлалаа.

Сонсгол даргалагч П.Сайнзориг - За хариулт болсон. Энэ дээр нэмээд хэлэхэд Хүний эрхийн Үндэсний Комиссыг бол бас нээлттэй сонгон шалгаруулалтаар одоо Томилгооны сонсголыг хийж Улсын Их Хурлаас томилдог. Энэ жишиг рүү 2020 оноос хойш орсон. За үүний дараагаар Шүүхийн сахилгын хороо Шүүхийн ерөнхий зөвлөл гээд аль болохоор бас боломжит байдлаар бид нар өөрөө өөрсдийгөө дэвшүүлдэг даргын карманаас нэр гарч ирэх биш өөрөө өөрийгөө мэргэжлийн этгээдүүд энэ салбартаа би хүлээн зөвшөөрөгдсөн байна гэж үзсэн этгээд бол нэр дэвшүүлж нээлттэй сонгон шалгаруулалт орж бас Улсын Их Хурлаас томилогддог ийм тогтолцоо руу бас алхам алхмаар явж байгаа гэдэг зүйлийг би бас энэ дашрамд хэлье. Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир - За баярлалаа. Өнөөдөр өглөөнөөс хойш маш олон иргэдийн жаргал зовлонг сонслоо. Гомдолыг сонслоо 5 10 жил 20 жилээр сэтгэл санаа, эрүүл мэнд, эдийн засгаараа хохирч яваа иргэд өнөөдөр үнэхээр дээшээ тэнгэр хол доошоо газар хатуу гэдэгчлэн үнэхээр арга ядсандаа ингэж одоо гомдол саналаа хэлэх гэж сэтгэл зүтгэл гаргаж өнөөдөр төрд үгээ хэлье гэж ирсэн байна аа. За нэг талаар одоо сонсгол хийж зовлон бэрхшээлийг сонсоод өнгөрөх нэг хэрэг. Энэ сонсголоос гарах үр дүн юу юм бэ гэдгийг би одоо бас сонсгол даргалагч болоод сонсголыг зохион байгуулагч санаачлагч нараас асуух гэсэн юм.

Бид нар 30 40 хүний бэрхшээлийг сонсоод энэ чинь ирж байгаа нь л 30 40 хүн болохоос биш ер нь хууль, шүүхийн байгууллагатай холбоотой санал гомдол, бэрхшээл, хүндрэл, зовлонг ярьж гэвэл энэ талбай ч одоо багадаа байлгүй дээ. Ирж чадахгүй ирэх юм санал, гомдлоо ярих юм сан. Хууль, шүүх, прокурорт гомдолтой байгаа иргэд гэвэл бас хэдэн 100 мянгаар яригдах байх. Ийм байгаа учраас энэ иргэд төрд итгэх итгэлгүй болж байна. Шүүхэд их итгэх итгэлгүй болж байна цагдаагийн байгууллагад итгэх итгэлгүй болж байна Улсын Их Хурал, Засгийн газартаа итгэх итгэлгүй болсон ийм л байгаа байхгүй юу. Тийм учраас энэ хууль байдаг хуулийн хэрэгжилт үнэхээр хангалтгүй хуулийг хэрэгжүүлж байх ажиллах ёстой тэр цагдаагийн байгууллага мөрдөгч нараас авхуулаад бүх шатын одоо энэ ажилтнуудын хуулийг хэрэгжүүлж ажилладаггүй.

- **Нэг.** Түрүүн тэр нэг мэдээлэл оролцогч хэлж байх шиг байсан хуулиа л хэрэгжүүлдэг байх л гэж хууль нь байгаа хуулийг хэрэгжүүлдэггүй учраас тэр эрх мэдэл албан тушаалаа ашиглаж хүнийг эрүүдэн шүүж хүнлэг бусаар харьцдаг хүнийг дордох доромжилдог ийм асуудлууд гараад байна аа. Тийм учраас энэ сонсголын үр дүн юу юм бэ ямар арга хэмжээ авах юм энэ 30 40 хүний асуудлыг яах юм. Өнөөдөр бид нар сонсох гэж ирсэн юм уу энэнээс гарах үр дүн нь юу юм гэдгийг асууя
- **Хоёр.** Хууль зүйн сайдаас асууя Хүний эрхийн Үндэсний Комиссын

Сүнжид даргын илтгэлд гарсан 2016-аас 2023 он Сүүлийн 7 жилийн хугацаанд хүний эрхийн эрүүдэн шүүлттэй холбоотой нийтдээ 414 гэмт хэргийн шинжтэй мэдээлэл шалгагдсан. Эндээс үндсэндээ 14 гэмт хэргийг л сүүлийн 7 жилд 3 шатын шүүхээр шийдвэрлэсэн. Энэ нь энэ хугацааны нийт гэмт хэргийн 0,05%-ийг эзэлж байгаа. Тэгэхээр энэ юу харагдаж байна вэ гэхээр 2017 оны Эрүүгийн хууль Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль энийг дагаж 2024 оны 5 сарын 08-ны өдрийн Монгол Улсын ерөнхий прокурорын журам байгаа. Энэ журам нь болохоор хэргийн харьяалал тогтоосон гэмт хэргийн талаарх гомдол мэдээлэл, эрүүгийн хэрэг шалгах, түүнд прокурорт хяналт тавих харьяалал тогтоох тухай гэсэн журам. Энэ журам ямар журам бэ гэхээр энэ хүний эрхийг эрүүдэн шүүлттэй холбоотой асуудлаар цагдаа тагнуулын байгууллагын алба хаагчийн үйлдсэн эрүү шүүлтийг тулгах гэмт хэргийн талаарх гомдол мэдээллийг Авлигатай тэмцэх газар шалгана. Авлигатай тэмцэх байгууллагын алба хаагчийн энэ асуудалтай холбоотой гэмт хэргийг Цагдаагийн ерөнхий газрын Мөрдөн байцаах алба шалгана гэсэн ийм журам байгаа. Ингэхээр эндээс юу харагдаж байна вэ гэхээр ерөөсөө манай мөрдөн шалгах эрх бүхий байгууллагууд харилцан нэг нэгнээ шалгах ийм хууль журам үйлчилж байна. Тийм учраас саяын тэр 14 гэмт хэргийн чинь дийлэнх олонхыг нь торгоод л өнгөрүүлсэн байна лээ торгоод л өнгөрүүлсэн байна лээ. Ингэхээр манай хууль шүүхийн байгууллагууд мөрдөн шалгах байгууллагууд харилцан бие биеийнхээ үйл ажиллагааг шалгаж чаддаггүй 7 жилийн дотор арван дөрөвхөн гэмт хэрэгтэй ингээд сууж байгаа. Тэгэхээр энэ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль энэ ерөнхий прокурорын дагаж гаргасан энэ журмыг хэзээ өөрчлөх юм бэ Хууль зүйн сайд аа!

Энэ байдлаас чинь болж өнөөдөр энэ асуудлууд урган гарч байгаа юм байна шүү. Энэ дээр Хүний эрхийн комиссын 2022, 2023 дугаар илтгэлдээ дурдсан байна лээ. Энэ энэ талаар арга хэмжээ авагдаагүй өнөөдрийг хүрсэн байна Засгийн газарт үүрэг, чиглэл өгсөн байна. Энүүгээр арга хэмжээ авагдаагүй байна. Өнөөдөр шинэ Хууль зүйн сайд томилогдоод даруй бас тодорхой хугацаа

Сонсгол даргалагч П.Сайнзориг – Асуулт, хариултыг нь эхлээд өгүүлчхээд тэгээд тодруулаад дэгийн хуулиар явах ёстой. Ер нь яах вэ гишүүддээ зүгээр нийтлэг байдлаар хэлье, зөвхөн төрийн байгууллага гэлтгүй оролцогчдоос асуух бүрэн боломжтой байгаа шүү гэдгийг тодруулж хэлье. Ингээд Алтангэрэл сайд хариулсны дараа би сонсголын үр дүн юу юм бэ гэдэг дээр товч хариулт өгөөд дараа нь Сандагаа гишүүн тодруулах шаардлагатай гэвэл тодруулгыг, асуултын цагийг өгье. О.Алтангэрэл сайдын микрофоныг өгье.

Хууль зүй дотоод хэргийн сайд О.Алтангэрэл - За Сандаг-Очир гишүүний асуулт бол их чухал асуулт байгаа юм. Улсын ерөнхий прокуророос гаргасан журам бол яах вэ байгууллага өөрөө дотоодхоо шалгахгүй, мөрдөн шалгах аж байгуу ажиллагаа явуулж байгаа байгууллагууд бие биеэ шалга гэсэн л агуулгатай. Ингэж энэ хэрэгцээн дээр үндэслэж гарсан журам юм билээ. Өөрөөр хэлбэл, цагдаагийн байгууллага өөрөө цагдаагийн байгууллагын ажилтан шалгахгүй ээ Авлигатай тэмцэх газар нь тодорхой шалгахгүй ээ гээд амьхандаа зөрүүлсэн л юм байна лээ. Тэгээд амьдрал дээр юу болдог вэ гээд үзэхээр нэг үеийнхэн байдаг нэг ангийнхан байдаг түрүүнд нь хамт ажиллаж байсан хүмүүс байдаг. Ингээд нэг нэгнийгээ шалгаж шийдвэрлэхэд хүндрэлтэй байдаг юм уу даа гэж харсан юм. Статистик тоо баримт бол яг үнэн. Энэ бол 2016-2023 оны өнгөрсөн 8 жилийн хугацаанд гарсан статистик 0, 10-ны 0, 100-ны хэдэн хувь байгаа нь ч үнэн. Тэгэхээр бид юу харж байна вэ гэхлээр 2 зүйлийг бодоод байгаа юм.

Нэгдүгээрт. Бас хандлагынхаа хувьд бид нар мөнгө угаах гэмт хэргээр шийтгэгдсэн хүмүүсийн тоо бага байна аа саарал жагсаалтад орж байна аа гэж байгаад малын хулгай халаасны хулгайгаа хүртэл мөнгө угаах руу оруулж байгаад нэг баахан амьтан шийтгэсэн. Энэн шиг хоморголгүйгээр бас одоо ингээд илрэхгүй байгаа нөхцөл байдал 400 гаруй хэргүүдээс дөнгөж арван дөрөвхөнд нь ял шийтгэл оногдуулж байгаа. Энэ нөхцөл байдлаа бас дутуу үнэлэхгүйгээр бид балансыг нь олж энэ асуудлаа шийдвэрлэх ёстой. Улсын Их Хурлаас бас манай түрүүчийн Их Хурал та бүхэн хүний эрхийг хангах чиглэлээр Улсын Их Хурлын тогтоол гаргаад Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хүний эрхийг хангах чиглэлээр маш сайн тогтоол гарсан. Энэний биелэлтийг хангах үүднээс бид нар одоо хүний эрхийн багц хуулиуд дотор Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай төсөл хийгээд явж байгаа юм. Энэ дотор бид нар өмгөөлөгчийн эрх хэмжээг нэмэгдүүлэхтэй холбоотой зүйлүүд хийж байгаа. Бас дахиад энэ гомдол гаргаж шийдвэрлүүлэхтэй холбоотой асуудлуудаа хийгээд явж байгаа.

Хуулийн төсөл нь дуусчихсан ирэх 7 хоногоос саналуудаа аваад Засгийн газрын хуралдаанаар танилцуулаад Их Хурлын энэ удаагийн чуулганаар өргөн баригдах төлөвлөгөөтэй ажиллаж байгаа. Шүүхийн аюулгүй байдлын хууль буюу маш амжилттай ажиллаж байгаад татан буугдсан. Үүнээс нь хойш одоо цагдаа шийдвэр гүйцэтгэх байгууллага дандаа асуудлыг нь тавьдаг. Хуучин нэрээр Тахарын байгууллага за олон улсын нэршлээр Маршалын албаны тухай хуулийн төслийг бид нар боловсруулж байгаа. За энэ дээр энэ тусгай субъектийн үйлдсэн байж болзошгүй хэргүүдийг мөрдөн шалгах албаны статус хараат бус байдал энэ бүх зүйлүүдийг нарийвчлан зааж өгч байгаа. Тэгээд энэ маань Улсын Их Хурлаар дэмжигдэх юм бол бид энэ чиглэлийн гэмт хэргийг мөрдөн шалгадаг. Саяын Таны нэр дурдсан байгууллагуудаас хамааралгүйгээр энэ хэргийг мөрдөн шалгадаг энэ байгууллага байгуулагдана гэсэн ийм төлөвлөгөөтэйгөөр ажиллаж байна аа.

Сонсгол даргалагч П.Сайнзориг – Сандаг-Очир гишүүн энэ сонсголын үр дүн юу вэ гээд хурал даргалагчаасаа асууя гэж хэлсэн. Би бас товч зорилгыг нь өгье.

Нэгдүгээрт, 1992 оны үндсэн хуулийн баталсан агуулга үзэл санаан дээр бол хүний эрхийг дээдэлж ийм аливаа хууль бус зүйл энэ нийгэмд байх ёсгүй ээ гэж үзэж байгаа. Гэтэл бас тодорхой, өнөөдөр Монгол Улсад 843 одоо байршил буюу хүн өөрийн хүсэл зоригоороо тэр объектыг орхиж гаргах боломжгүй байгаа.

Үүний цаана магадгүй хууль сахиулах үйл ажиллагаа явж байгаа. Үүний цаана албадан эмчилгээний асуудал явж байдаг. Үүний цаана тэр хүүхэд, эсвэл настнууд, ахмад настнуудыг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асаргааны асуудал явж байдаг. Үүний цаана бас энэ эрүү шүүлт гэдэг юм уу хүнлэг бус харьцах асуудал байна уу байхгүй юу гэдэг зүйл бас яригддаг.

Тэгэхээр бид эндээс одоо ойрын өдрүүд ч гарсан кэйсүүд дээр санаа авч манай сонсгол зохион байгуулах гишүүдээс санаачилга гаргасан байх. Энийгээ ч дурдаж хэлж байсан. Тэгэхээр бид ийм зөрчлүүдийг цаашид гаргахгүй байх. Гарсан зөрчлөөс нь шалтгаан нөхцөлийг тогтоож хүний эрхийг яг сэргээж энэ төрийн буруутай үйл ажиллагаанаас хохирчихоод байгаа иргэдийнхээ эрх ашгийг яаж хамгаалах вэ гэдэг бодлого явах ёстой. Энэ хүрээндээ сонсголын дараанаас тодорхой хууль эрх зүйн орчныг сайжруулах зохион байгуулалт, магадгүй шаардлагатай бол төсөв мөнгөний асуудлыг ч гэсэн Улсын Их Хурлаас шийдэх ёстой түрүүн иргэдээс болон холбогдох байгууллагуудаас хэлж байна.

Хамгийн том зүйл бол энэ камержуулалтыг мэдүүлэг тайлбар авах өрөөг камержуулсан асуудал гэмт хэргийг бууруулах нөхцөл байсан энэ байхгүй бол өөр түвшинд ч байхыг үгүйсгэхгүй гэж, нэг өмгөөлөгч хэлж байх жишээтэй. Тэгэхээр бид нар энэ хэлэлцүүлгийн үр дүнг ингээд хаячихгүй. Би богино хугацаанд за ирэх 7 хоногт нэг амралтын өдөртэй байгаа хуваарь яаж гарахыг мэдэхгүй байна.

Түүний дараагийн 7 хоногоор би энэ хэлэлцүүлгийн үр дүн болон гарч байгаа санал санаачилгуудыг Хууль зүйн байнгын хороонд танилцуулна, Хууль зүйн байнгын хороонд танилцуулахдаа холбогдох Улсын Их Хурлын тогтоолын төсөл болон тодорхой чиглэлүүдийг зааж оруулсан байдлаар явъя гэж үзэж байгаа. Хууль зүйн байнгын хороон дээр шийдвэл Улсын Их Хурлын чуулганаар ч гэсэн уг асуудлыг мэдээллийг өгч танилцуулж болно. Ийм үр дүн хүлээж байгаа буюу ер нь цаашдаа олон нийт зөв мэдээлэлтэй байх, зөвхөн олон нийт биш энэ иргэд олон нийтээс гадна төрийн байгууллагууд өнөөдөр эрүү шүүлт хүнтэй хүнлэг бус харьцах асуудал дээр ойлголт 1-тэй байж чадахгүй байгаа. Жишээ нь манай боловсролын байгууллага эрүүл мэндийн байгууллага ерөөсөө биднээс хол хөндий сэдэв гэж ойлгоод байдаг.

Батлан хамгаалахын яам энэ дээр сүүлийн үед ойлголт өөрчлөгдөөд энэ дээрээ ахиц авчиръя гээд байгаа. Тэгэхээр энэ зүйлүүдийг бид нар ярьж байж төрийн бодлого зохицуулалт энэнээс урьдчилан сэргийлэх механизмыг үр дүнтэй яаж ажиллуулах вэ гэдэг зүйлийг ярина гэсэн хүлээлттэй байгаа гэдэг зүйлийг би товчхон хэлье. Ингээд та тодруулах уу? Сандаг-Очир гишүүнд нэг минут.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир - за би прокурорын байгууллагаас асууя. Прокурорын байгууллагад Хууль зүйн байнгын хорооны даргын 24 оны 9 сарын 17-ны тоот хүргүүлсэн энэ тоотын утга агуулга бол сая түрүүнд одоо гомдлоо хэлсэн Монпас интернэйшнл компанийн захирал Ганболд иргэний гаргасан гомдолтой холбогдуулж энэ иргэний асуудал 3 шатны шүүхээр шийдэгдээд өнөөдрийг хүртэл одоо шүүхийн шийдвэр хэрэгжихгүй байгаа асуудал. Тэгээд энэ иргэний зүгээс бол Монгол Улсын одоо Ерөнхийлөгчөөс авхуулаад байдаг бүх л одоо төрийн албан тушаалтнуудад одоо бичгээр хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудлаар тавьсан ямар ч албан тоот бичиг хариу ирээгүй байгаа. Яагаад ирэхгүй байгаа учир шалтгааны талаарх энэ сонсгол дээр холбогдох мэдээллийг бэлтгэж ирүүл, танилцуул гэсэн ийм албан тоотыг Хууль зүйн байнгын хорооны даргаас прокурорт хүргүүлсэн байгаа. Тэгээд прокурорын байгууллага энэ дээр мэдээлэлтэй ирсэн байх гэж бодож байна. Энэн дээр одоо та бүхэн хариулт өгөөч.

Сонсгол даргалагч П.Сайнзориг - За Чинбат дарга хариулах уу? Микрофон хэд дээр байх шиг байна 15 уу? За 15 дугаар микрофоныг нээе.

Иргэн Чинбат - за иргэн Ганболдын талаар мэдээлэл бид бэлтгэсэн Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны даргын албан бичгийн дагуу тэгэхээр энэ иргэний асуудлаар болбол шат шатны одоо байгууллагууд төрийн байгууллагуудад одоо өргөдөл гомдол гаргасан хариу өгөхгүй байна гэдэг энэ агуулга 1 дүгээрт байгаа. За бид энэ хүний одоо прокурорын байгууллагад өгсөн бүх одоо өргөдөл гомдол хэд хэчнээн онд хаана хаана өгч байсныг бүгдийг нь судалгаа гаргаад мөн Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Улсын Их Хурал, Засгийн газраас Хууль зүйн яамнаас бас дамжуулж ирсэн бүх одоо өргөдөл, гомдлыг нь судалж, шалгаж үзсэн байгаа. Тэгээд ингээд судалгааны эцэст энэ хүний гомдлыг бид хуульд заасных нь дагуу тухай бүр нь хариу өгч байсан. Нэг удаа ч хариу өгөөгүй тохиолдол байхгүй Хууль зүйн байнгын хорооны албан бичиг дээр өөрийнх нь энэ хүний өөрийн бичсэнээр одоо тийм асуудал бодитой тогтоогдоогүй ээ. Ганболд гэдэг хүн маань өөрөө одоо 2011-ээс 2019 онд эрүүгийн хэрэгт одоо шалгагдаж, прокурор шүүхийн

байгууллагаар явж байсан энэ асуудал дууссан тэрнээсээ гадна иргэний хэргийн нэхэмжлэл гаргаж иргэн хэргийн шүүхэд хандсан байдаг.

Прокурорын байгууллагад хамааралгүйгээр шүүхийн шатандаа шийдвэрлэгдсэн нөхцөл байдалтай байгаа.

Сонсгол даргалагч П.Сайнзориг - Гомбын Ганбаатар гишүүн асуултаа асууя.

Улсын Их Хурлын гишүүн Г.Ганбаатар - Оройн мэнд бид хэд чинь өглөө 10 цагаас хойш 7 цаг нэлээн юм сонслоо. Энэ сонсгол 21 настай хүүхэд нас бараад тэгээд Ардчилсан намын энэ Баярмаа гишүүн хажууд сууж байна. Мөнхбаясгалан гишүүн бид нар анх хэвлийн бага хурал хийгээд, дараа Улсын Их Хурлын сонсгол сонсьё. Энэ нь хүний эрхтэй холбоотой гээд 22 гишүүн гарын үсэг зураад Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 26.1.1-ийн дагуу хүний эрх, эрх чөлөөтэй холбоотой сонсгол явуулж байгаа.

Мэдээж телевиз, радиогоор явж байгаа хэн юу ярьж байгааг бүгдээрээ сонсож байгаа байх төрийн холбогдох төрийн албан байгууллагуудын тавьсан илтгэлийг сонсохлоор манай улсад бол нэг хүний эрх, эрх чөлөө хангагдаад ч байгаа юм шиг. Өнөөдөр энд оролцож байгаа та бүхний зовлон жаргалыг сонсохоор манай улсад бол хүний эрх, эрх чөлөө ямар байгаа эрүүдэн шүүлт ямар байсан Ардчилсан намын үед ч ардын засгийн үед ч гэдэг шиг ер нь ямар байсан тухай хангалттай сонслоо. За ер нь үе үеийн парламент Засгийн газрын үндсэн үүрэг бол хүний эрхийг л хангах асуудал байдаг.

Энэ бүрэн эрх нь хэрэгжиж байгаа манай энэ удаагийн парламент ч гэсэн өнгөрсөн 7 хоногт стратеги батлахдаа хүний эрх бол хамгийн эрхэм дээд зүйл гэж стратеги баталсан. Тэгээд энэ сонсголын агуулга чиглэл ч бас энэтэй холбогдох байх гэж бодож байна. Хүний эрхийн Үндэсний Комиссын эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны тайлан одоо энэ миний өмнө байж байна. Өнгөрсөн 20 он 21 он, 22 онд 20 онд гэхэд л 793, 21 онд 809, 22 онд 1072 гээд шүүхийн зөвшөөрөлгүй баривчлагдсан иргэдийн тоо энэ юуг хэлж байна вэ гэж. Үүнтэй холбоотой тэр холбогдох шүүхийн шийдвэр одоо биш шүүхээс энэ үүнтэй холбоотой нэг мэдээлэл авъя асуулт асууж байгаа юм мэдээлэл үүнтэй холбоо дэлгэрэнгүй мэдээлэл авъя гэж бодож байна.

Өнөөдрийн энэ иргэдийн одоо энэ оролцож байгаа хүмүүсийн юунд хамгийн их гарч байгаа юм бол хүнийг эрүүдэн шүүж хохироосон тэр нэр бүхий албан тушаалтнууд албаа хашиж байна хүний эрх удаа дараа зөрчсөн албан тушаалтнууд яагаад одоо болтол хоорондоо албан тушаалаа сэлгүүлээд ажиллаад байдаг юм бэ гэдэг асуулт байсан. Үүнийг Хууль зүйн сайдаас асууя гэж бодож байна.

Ер нь энэ хүний эрх зөрчөөд зөрчсөн албан тушаалтнуудын одоо хар жагсаалт гэж байдаг юм уу? Дата гэж байдаг юм уу? жишээ нь ажил үүргээ үгүйсгэж чадахгүй компаниудын хар жагсаалт гэж байдаг шүү дээ хүний эрхийг зөрчсөн энэ хуулийн ажилтнууд холбогдох албан тушаалтнууд энэ дээр ямар бодлого чиглэл барьдаг юм. Та бүхэн саяхан санаж байгаа бол нэг сошиалд нэг залууг хэлмэгдүүлээд бүр нэр бүхий цагдаагийн албан тушаалтны 2 нэр яваад байсан.

Би одоо буруу санаагүй бол нэг нь Сүхээ гээд байсан нэг нь Ядмаа 15 жил аваачаад тэр хүүхдийн амьдралаар тоглодог юм байна лээ шүү дээ. Тэгээд аав, ээж нь байхгүй нас бараад хүний амьдралаар гарч ирээд сайн өмгөөлөгч таарсан юм байна лээ. Гарч ирээд хөөрхий 50 сая төгрөгийн нөхөн олговор авсан байгаа байхгүй юу. Тэгээд үүнтэй холбоотой бас дараагийн асуулт бол нөхөн олговор. Нөхөн

олговрын санд чинь юм байдаг юм уу? Нийт өнгөрсөн хугацаанд энэ нөхөн олговортой холбоотой ер нь яаж шийдэж ямар аргачлалаар шийдэж ирсэн юм? За бас нэг зүйл энд энд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга Нандинболор байна уу? Шүүхийн шийдвэрийн гүйцэтгэх энэ албанаас хэн байна хэн билээ? Дэд дарга нь ?

Энэ хэрэг нэг хүн амины хэрэг хохироод нуун дарагдуулдаг зүйл газар авсан байна. Их Хурлын гишүүдэд маш их мэдээлэл ирдэг юм. Танай Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар дээр Улсын Их Хурлын сонгуулийн өмнө 421 дүгээр анги дээр хүн толгойгоо таслуулж нас барсныг та нар яагаад нуун дарагдуулсан бэ? Энэ тухай тухайн үед Хүний эрхийн Үндэсний Комисс мэдсэн үү? тэр үеийн Хууль зүйн сайд болсон Энхбаяр мэдсэн үү, мэдсэн бол одоо яагаад энэ тухай ярихгүй байна вэ? Эсвэл Улсын Их Хурлын сонгууль болж байгаатай холбоотой нуун дарагдуулсан уу? Энэ мэтийн нуун дарагдуулсан хэд хэдэн хэргийн тухай бид нарт мэдээлэл ирээд байна. Зөвхөн нэг баримт нь энэ. Дараа нь тэр Нийслэлийн шүүхтэй холбоотой хүн байна уу тэр Нийслэлийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны даргын цэргийн гэж хүн байна уу? Энд тэр нөхөртэй холбоотой бас хүний амь эрсэдсэн шагналаа угааж салхинд гарч явж байгаад согтуурч байгаад нэгийгээ нухаад хаячихсан тэгээд яагаад ийм мэтийн юмнуудыг Алтангэрэл сайд мэдэж байгаа юу?

Энэ мэтийн нуун дарагдуулах асуудалтай холбоотой ер нь Шүүхийн шийдвэрийнхэн хоригдож байгаа улсуудаа эрүүдэн шүүлгэсэн дээрээс нь эмчилдэг газар нь Сонгдо эмнэлгийн 8 давхар болчихоод байгаа юм байна лээ шүү дээ түрүүнд.

Сонсгол даргалагч П.Сайнзориг - Хууль зүйн сайд эхлээд хариултыг өгнө үү бас дутуу байна гэж үзвэл тодруулах шаардлагатай гэж үзвэл бас нэмэлт өгье. Алтангэрэл сайд, дараа нь прокуророос, тэгээд шүүхийн шийдвэрийнхэн бэлдэж байгаарай.

Хууль зүй дотоод хэргийн сайд О.Алтангэрэл - Ганбаатар гишүүний ярьж байгаа энэ хүний эрхийг зөрчсөн албан тушаалтнуудын дата бүртгэл гэж байхгүй. Юу байдаг вэ гэхлээр төрийн байгууллага, албан тушаалтны буруутай үйл ажиллагаанаас хохирсон энэ хүмүүсийн ийм олгож байгаа төлбөртэй холбоотой мэдээлэл байгаа юм. Ингээд араас нь явдаггүй төрийн байгууллага, албан тушаалтан иргэдэд хохирол учруулчихаад тэр хохирлыг нь төрөөс нөхөн төлчихдөг тэрнийхээ араас төр нь явдаггүй ийм асуудал байгаа юм. Тэгээд бид бол нэг Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулаад хууль гэхээр удах байх гэж бодоод тухайлах юм бол энэ албан тушаалаас нь халсан шийдвэр гаргасан албан тушаалтантай холбоотой зүйлийг хуулиараа Төрийн албаны зөвлөл нь за хууль бусаар цагдан хорьдог ч юм уу ингээд эрүүдэн шүүдэг ч юм уу хохирол учруулаад, ингээд хохирол учруулчихсан бол тэр мөрдөгч нь, прокурор нь, шүүгч нь төлдөг байх энэний араас төр явдаг байх нөхцөлийг бүрдүүлээд нэг Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулаад батлуулах гээд л явж байгаа юм. Энэ бол маш чухал асуудал. Өнөөдөр эрүүдэн шүүж, эрүүдэн шүүх гэмт хэрэгт хохирсон иргэдэд нөхөн олговор олгох сан байгаа. Өнгөрсөн жилүүдэд 3 тэрбум гаруй төгрөг энэ сангаас олгогдсон. Одоо ингээд эрүүдэн шүүсэн байна. Энэ хүний хохирлыг нөхөн төл өө гэвэл төрөөс тэр гэмт хэргийн хохирогчдод нөхөн олговор олгодог сангийнхаа журмаар олгоод явна.

Тэгэхдээ энэ их мөнгийг дахиж яаж буцаж төрд нь төвлөрүүлэх юм бэ гэдэг үйл ажиллагаа доголдолтой байгаагаас болж нэг мөрдөгчөөс нэг албан тушаалтнаас нэг прокуророос, нэг шүүгчээс болж төрд хохирол учирчихаад тэрнийхээ араас явахгүйгээс болж энэ үйл ажиллагаа бас дахиж давтагдаад байна гэж бид нар үзээд байгаа юм. Хэрвээ одоо сая таны дурддаг жишээ Хувцагаан өмгөөлөгчийн ажилласан хэрэг л дээ тэр хилсээр хоригдсон маш харамсалтай. Завханы Эрдэнэ-

Очир гэдэг хүнийг 3 удаа 4 удаа цаазын ял оногдуулчхаад сүүлд 6 жил 7 сар 10 гаруй хоног хорьчихоод Монголын шүүх 20 жилийн өмнө хориод жилийн өмнө 50 гаран сая төгрөг шийдэж байсан. Өнөөдөр дахиад л 50 сая төгрөг хүний олон жилийн амьдралыг шоронд өнгөрүүлчхээд шийдээд сууж байгаа тэр 50 гаран сая төгрөгийн хохирлыг нь ч бүр эргэж хэн төлөх нь ойлгомжгүй байгаа. Тэгэхээр Таны дэвшүүлж байгаа асуудал дээр 1 дүгээрт бүртгэл байхгүй, 2 дугаарт бид нар энэ төрд учруулсан хохирол иргэдэд олгосон нөхөн олговрыг тэр албан тушаалтнуудаас нь заавал авдаг болох энэ эрх зүйн орчныг хийх шаардлагатай л гэж үзэж байгаа.

Сонсгол даргалагч П.Сайнзориг - За тэр шүүхийн зөвшөөрөлгүй цагдан хорионы асуудал дээр 14 дүгээр микрофоныг өгье.

Прокурор Мөнхбаатар - Сэжигтнийг хойшлуулшгүйгээр баривчлах ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг хариулт өгье. Тэгэхээр Эрүүгийн хянан шийдвэрлэх тухай хуульд бол 24 онд өөрчлөлт орсон. Сэжигтнийг баривчлах үйл ажиллагааны талаар зохицуулалт 8 сарын 01-нээс хэрэгжиж эхэлж байгаа. За өмнө нь бол шүүхийн зөвшөөрөлгүйгээр баривчилга гэдэг нэр томьёо хэрэглэж явж байсан. Тэгэхээр энэ нэр томьёо дээр бас жоохон зөрөөтэй ойлголтууд хаа хаанаа үүссэн байсан.

Шүүхийн зөвшөөрөлгүй баривчлах ажиллагаа гэдэг бол шүүхийн зөвшөөрлийг нөхөж авах хэлбэрээр явах ажиллагаа байсан. Эрх зүйн зохицуулалтад бол мөрдөгчийн сэжигтнийг шүүхийн зөвшөөрөлгүй баривчилсан тогтоолыг шүүхэд хүргүүлэх шүүх тэрийг хүчинтэйд тооцох эсэх асуудлыг шийдвэрлэх зохицуулалттай. Шүүхийн шатад бол мөрдөгчийн шийдвэрээр энэ саналыг хэлэлцэх боломжгүй ээ гэдэг. Бас нэг хуулийн хэрэглээ гарсан 2 дугаарт энэ шүүхийн зөвшөөрөлгүйгээр баривчлах ажиллагаа бол бас тодорхой ажлын бус цагаар амралтын цагаар баяр наадмын тохиолдсон өдрүүдэд явагддаг учраас тухайн шүүх ажилладаггүй байдаг учраас энэ тоонууд бас нэг их өндөр гарсан тийм тохиолдлууд байгаа 8 сарын 01-нээс хойш бол энэ үйл ажиллагаа бол бас тодорхой хэмжээнд бас тоо хэмжээнд буурсан. Зохицуулалтууд боловсронгуй болсонтой холбоотойгоор бол бас үйл ажиллагаа бол хэвийн явагдаж байна гэж үзэж байгаа. 8 сарын 1-нээс хойш бол нийтдээ 124 сэжигтнийг тийм хойшлуулшгүйгээр ажиллагаагаар баривчилсан. Үүнийхээ 77 сэжигтнийг шүүхийг шийдвэрээр нөхөж аваад тооцуулчихсан ажиллаж байна. Прокуророос мөрдөгчийн шийдвэрийг одоо баривчилсан 43 тогтоолыг хүчингүй болгож сулласан. Ийм тоотой ажиллаж байна.

Сонсгол даргалагч П.Сайнзориг - Албан тушаал, нэрээ хэлээрэй микрофон өгчих яг протоколд үлдэх ёстой. 14-ийг дахиад өгчих. Нэр усаа л хэлээрэй.

Прокурор Мөнхбаатар – Улсын ерөнхий прокурорын туслах прокурор Мөнхбаатар

Сонсгол даргалагч П.Сайнзориг - Дараагийн шүүхийн шийдвэрээс хэн хариултад бэлдэж байгаа хүн бас нэр ус албан тушаалаа хэлээрэй 3 номер.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Тэргүүн дэд дарга Намсаманд - Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын тэргүүн дэд дарга хурандаа Намсаманд гэж хүн байна. Тэр 1 дүгээр асуулт 421 дүгээр анги дээр толгой тархийг нь тастаад хүн алчихсан юм биш үү гэдэг асуудалтай байна. Энэ дээр хэн нэгэн, хэн нэгний толгой тархийг тастсан тэгээд хүн амины хэрэг бол болоогүй. Өөрөөр хэлбэл, 6 сарын 21-ний өдөр тэр 421 дүгээр ангийн хашаанд үйл ажиллагаа явуулдаг манай Төрийн өмчит компани байдаг. Хэрэм цамхаг гээд өөрөөр хэлбэл, хоригдол ажиллуулдаг, хоригдлыг ажлын байраар

хангадаг, цалин хөлс өгдөг, энэ ажлын байран дээр энэ үйлдвэр дээр тэр чулуу бутлагч машин байдаг. Тэр чулуу бутлагч машинд тухайн үеийн хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа зөрчигдсөн байж болзошгүйгээс болоод тэнд нэг хоригдол хавчуулан амь хохирсон асуудал бол болсон. Энийг бол харьяалах цагдаагийн байгууллага өнөөдөр шалгаж байгаа. Дараагийн асуулт Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх газрын даргаар ажиллаж байсан цэргийн хүү гэж хүн амралтын өдрөөр агаар салхинд гаргаад архидаад нэгийгээ хохироосон гэдэг асуудал бол, агаар салхинд явсан нь бол тогтоогдсон зүгээр архи дарс уусан эсэх гэдэг юм уу, ямар нэгэн хэн нэгэн зодоон цохионы асуудал болоогүй гэдэг нь бас холбогдох хууль хяналтын байгууллагын асуудлаар шалгагдаж тогтоогдсон байдаг хохирогч Х гээд манай алба хаагч байсан эрүүл мэндийн шалтгаанаар бурхан болсон. Тэгээд яг ямар шалтгаанаар гэдгийг нь бид хувь хүний нууц эмзэг мэдээлэл учраас тэр болгон дэлгэрэнгүй ярих боломжгүй байна. Хариулж дууслаа. Баярлалаа

Сонсгол даргалагч П.Сайнзориг – Г.Ганбаатар гишүүн тодруулах уу? нэг минут өгье. тодруулга

Улсын Их Хурлын гишүүн Г.Ганбаатар - Хууль зүйн сайд бол ямар ч байсан төрийн байгууллага болон албан тушаалтны буруугаас болж хохирсон. Өөрөөр хэлбэл энэ төрд учруулсан хохирлыг барагдуулах талаар нэг тогтоолын төсөл явж байгаа юм байна.

Хууль зүйн яамнаас Мөнхбат туслахтай холбоотой 8 сарын 01-нээс хойш хууль хэрэгжээд гайгүй. Одоо бол бас нөгөө шүүхийн шийдвэргүйгээр баривчилсан асуудал нэлээн цөөрсөн гэдэг асуудал. Сая тэр хариулт өөрөө хэн билээ Намсаманд билүү тэ яах вэ иргэдээс ирсэн мэдээлэл шүү энэ ингээд нуун дарагдуулаад байна. Ямар ч байсан 2 хүн бол нас барсан юм байна надад ийм сонсгол хийх гэж байгаа гээд тэгэхэд та энүүнийг бүр яг асууж өгөөрэй ийм юм болсон шүү наад эрх мэдэл албан тушаалтнууд чинь ингээд хэргийг нуун дарагдуулаад байна шүү гэсэн юм. Тэгээд энэ сонсголыг бид нар 8 сарын 05-нд хэвлэлийн бага хурал хийхдээ зарлачихсан учраас.

Сонсгол даргалагч П.Сайнзориг – Х.Баасанжаргал гишүүн асуултаа асууя. Би Шинэбаяр гуай танд дахиад сануулъя. Та өдрөөс хойш бусдыг одоо үл хүндэтгэж дэгийг удаа дараа зөрчих юм. Би танд бас олон удаа ойлгуулаад л хэлээд байгаа. Тэгэхээр та бас бусдад жоохон хүндлэлтэй хандана уу? Баасанжаргал гишүүний цагийг эхнээс нь өгье.

Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал - Бүгдээрээ үлдсэн цагаа үр дүнтэй өнгөрүүлэхийн тулд бас би нэлээн хэдэн асуулт асууя. Холбогдох албан тушаалтнууд нь тэмдэглэж авч байгаад яг оновчтой хариулт өгөөрэй гэж хүсье. Тэгээд энэ танхимд бас тухайн үедээ миний үйлчлүүлэгч явж байсан би тухайн үед өмгөөлөгчөөр нь ажиллаж байсан тэр хэргийн мөрдөгч байсан прокурор гээд мөр зэрэгцэж ажиллаж байсан олон хуульчид маань цугласан байна. Тэгээд илэн далангүй хэлэхэд бол бид нар хүнээ Зүүнхараад хориулах, Төв аймагт хориулах, эсвэл 7 сарын 10-нд хүн маань хоригдох эсвэл битүүний өдөр хүн хоригдвол тэгээд л бид нар ер нь бол дотроо бүгд л ер нь хүндэрлээ шүү байдал нөхцөл байдал ер нь хүндэрлээ шүү гэдэг ойлголтыг бүгд л авдаг. Тэгэхээр энэ байдал бас л хэвээрээ байгаа юм байна гэдэг мэдрэмжийг би өнөөдөр дахиад энэ танхимаас авлаа.

Тэгээд маш харамсалтай энэ удаагийн парламент энэ дээр ахиц дэвшил гарах байх гэсэн найдлага байна. Бусад гишүүд маань ч гэсэн бүгдээрээ энэ зүйлийг таслан зогсоолгохын төлөө ажиллах байх. Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Цэлмэн гишүүнээс асууя. Нэг, хүүхдүүд эрүү шүүлтэд өртсөн тохиолдол танай

судалгаагаар гарав уу? Хоёр, 1026 хүнтэй албан хаагчтай ганцаарчилсан ярилцлага хийсэн гэдэг. Ийм үр дүнг танайхаас ирсэн материал дээр байдаг энэ ганцаарчилсан ярилцлагын үр дүн юу байв. Гурав, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд мөрдөж байгаа хэм хэмжээний акт дүрэм журмууд дээр эрүү шүүлт үүсгэхүйц нөхцөл байдал байгаа эсэх дээр дүн шинжилгээ хийсэн үү? түүнтэй холбоотой ямар судалгаа баримт байна вэ? гэдгийг асууя.

Хууль зүй, дотоод хэргийн яамнаас 5 асуулт. Эрүүлжүүлэгдсэн болон саатуулагдсан хүний тоог ялгаж гаргах шаардлагатай байна. Тэр дундаа саатуулагдсан хүмүүсийн шалтгаан, нөхцөл тоо, статистикийн чиглэлийн судалгааг сүүлийн 3 жилийн байдлаар гаргаж өгөөч. 3 дугаарт, хохирогчид олгож байгаа нөхөн төлбөрийн талаар яг тухайн жилдээ барагдаж чаддаггүй. Одоо шүүхийн шийдвэр нь гарсан боловч энэ эрүү шүүлттэй холбоотой нөхөн төлбөр нь барагдаагүй хэчнээн хүн байгаа вэ? хэчнээн төгрөгийн хохирол байгаа вэ? 3 дугаарт цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээний хугацааг тоолохдоо шүүх рүү хэрэг нь шилжчихсэн болбол тэр цагдан хорих хугацааг нийт цагдан хорих хугацаанд нь тоолдоггүй байсан.

Би өөрөө өмгөөлөгч байхдаа үүнтэй холбоотой удаа дараа гомдол гаргадаг байсан. Одоо болтол хэвээрээ байгаа гэж сая бас манай өмгөөлөгч хэллээ. Энэ хуулийн өөрчлөлт хэзээ орох вэ? Цагдан хорих нийт хугацаанд яагаад энэ шүүхийн шийдвэр шүүх рүү хэрэг нь шилжчихсэн байгаа хүний цагдан хорих хугацаа ордоггүй юм бэ? 4 дүгээрт, гадаад улсад байгаа иргэдийн эрхийг хамгаалах талаар ялангуяа Солонгос улсад албадан баривчилгаагаар нутаг буцаахаар ийм нөхцөл байдалд манай иргэд ордог. Үүнтэй холбоотой эрүүдэн шүүлтийн нөхцөл байдлууд үүсдэг гэдэг мэдээнүүд байдаг. Үүнтэй холбоотой ямар арга хэмжээ авч байгаа вэ? 5 дугаарт, Эрүү шүүлт гарч болзошгүй гэх тодорхой газрууд байна. Сая хуралдаан даргалагч бас дурдлаа. Эдгээрийг бүрэн камержуулах тэр дундаа дуу чимээг бичдэг байх талаар Хууль зүйн яамнаас ямар бодлого ямар зүйл баримталж байгаа вэ?

Хүний эрхийн Үндэсний Комиссын илтгэлтэй холбоотой 3 асуулт эрүү шүүлтийн хохирогч нэг хүүхдийн талаар сая дурдлаа. Энэ шүүхийн шийдвэр ямар түвшинд байгаа тухайн хүүхдийн нөхцөл байдал ямар байна вэ? 2 эрүү шүүлт үйлдсэн гэх алба хаагчдын талаарх хариуцлагын талаарх судалгаа хэр оновчтой байгаа талаар та бүхэнд тусгайлсан судалгаа байгаа юу? Гуравт, хугацаат цэргийн алба дээр энэ тоо буурахгүй байгаа шалтгаан нөхцөл юу вэ?

Ялангуяа энэ дээр бас Батлан хамгаалах яамнаас хүн байвал хариулаад өгөөрэй. Хэрэгжилт 30%-тай гэдэг дүгнэлтийг сая Хүний эрхийн Үндэсний Комисс танилцууллаа. Энэний шалтгаан нөхцөл юу вэ? гэдгийг асууя. Улсын Ерөнхий прокуророос нэлээн хэдэн асуулт байна. Яг энэ эрүү шүүлттэй холбоотой гэм буруу нь тогтоогдсон этгээдүүд хариуцлага ялын бодлого хэр оновчтой байна гэж та бүхэн харж байгаа юм. Үүнтэй холбоотой криминологийн судалгаа байдаг уу? 2019 оны албан даалгаврын тухай сая удаа дараа мэдээлэл дээрээ өглөө.

2019 оноос хойш албан даалгавар цар хүрээ ерөөсөө өөрчлөгддөггүй юм уу? Танай мэдээн дээр 67,6% нь хэрэг нээхээс татгалзжээ. Прокурорын зүгээс үүний шалтгаан нөхцөл юу юм бэ? Өөрөөр хэлбэл, иргэдийн гаргасан гомдлын дийлэнх олонх дээр нь хэрэг нээхээс прокуророос татгалзсан гэдэг ийм мэдээ сая танай дээр гарч байна. Үүний шалтгаан нөхцөл тухайлбал танхимд байгаа Д.Энхбат, Б.Жаргал гээд эдгээр хүмүүсийг эрүүдэн шүүсэн гэдэг асуудлаар нийтдээ 6 удаа санал явсан байдаг. Хэрэг нээхээр дандаа прокуророос татгалзсан байдаг. Үүний шалтгаан нөхцөл юу вэ гэдгийг бас их тодорхой болгож өгөх хэрэгтэй байна. Авлигатай тэмцэх газраас нэг асуулт танай өгсөн бид нарт гишүүдэд танилцуулсан мэдээллээр 97

хэрэг дээр хэрэг бүртгэлтийн хэрэг нээх саналтай байсан боловч 83 дээр нь хаах саналыг прокуророос гаргасан байна. Тэгээд үндэслэл шалтгаан нөхцөл нь юу гэж байдаг юм бол? Үүний нэгдсэн судалгаа нь байна уу?

Сонсгол даргалагч П.Сайнзориг - О.Алтангэрэл сайдаас эхлээд хариулъя. Дараа нь Я.Цэлмэн дэгээрээ явъя тэгэх үү? Уг нь 5 минутад байх ёстой бүр тодруулах шаардлага байна. Уг нь 10 хүртэл энд хариулт нь орох ёстой байхгүй юу. Та нар өөрсдөө ядаж эхлээд дэгээ судалчих л даа. Я.Цэлмэн хэд дээр байна. Хууль зүй, дотоод хэргийн сайдын микрофоныг өгье. Дараа нь Я.Цэлмэнгийн 11 номерын микрофоныг өгье.

Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл - Хохирогчид олгож байгаа нөхөн төлбөр жилдээ багтааж олгоно. Ер нь бол одоо ингээд ирэнгүүт нь хэд болгож байгаад шүүхийн шийдвэр гүйцэтгэлээс материал ирэнгүүт тодорхой хэмжээний тоотой болгож байгаад Хууль зүй, дотоод хэргийн сайдын доор тодорхой хүмүүс хариуцаж ажиллаж байгаад тушаалаа гаргадаг зүйл байгаа юм байна. Үүнээс жилдээ багтааж бид нар хуримтлуулалгүйгээр ирэх болгонд нь шийдэж явъя гэсэн чиг баримжаатай байгаа. Гадаадад байгаа иргэдийн асуудал үнэхээр байна.

Албадан гарах хүртлээ жишээлбэл, Бүгд Найрамдах Солонгос Улсад эрүүдэн шүүгдэж байгаа энэ үйл ажиллагаанд өртсөн байж болзошгүй гэдэг мэдээллүүд их байгаа учраас бид нар Гадаад явдлын яам руу хандаад гадаадад байгаа нэн ялангуяа монголчууд олноороо оршин сууж байгаа газар монголчууддаа эрх зүйн туслалцаа үзүүлдэг хүнтэй больё гэдэг асуудал тавиад байгаа юм. Ялангуяа монголчууд олноороо оршин сууж байгаа Америкийн Нэгдсэн Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс гэх газруудад тухайн улсынх нь сургуулийг төгссөн хууль зүйн боловсролтой, тухайн улсынхаа Хуульчдын холбоо, Өмгөөлөгчдийн холбоотой холбоо тогтоогоод иргэдийнхээ эрх ашгийг хамгаалаад явах бололцоотой ийм хүн Элчин сайдын яаман дээр дагнаж гаргая. Тэгэхгүй бол иргэдийн эрх ашиг зөрчигдөөд байна гэдэг асуудлыг Б.Батцэцэг сайдад албан ёсоор тавьчихсан байгаа.

Камержуулалттай холбоотой чухал асуудал Х.Баасанжаргал гишүүний энэ маш чухал асуулт байна. Яагаад гэвэл өнөөдөр төсөвт Ерөнхийлөгч хориг тавилаа сайдуудтай холбоотойгоор энэ асуудлыг ярьж гэж ярьж байгаа юм. Я.Цэлмэн гишүүний ярианд гарах байх. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хорих байгууллагууд байнга шаардлага авч байгаа дээвэр нь цөмрөх гэж байгаа, орчин нөхцөл хангагдахгүй, тоо нь хэтэрхий их байна гээд үүнийгээ бид нар олшруулж чаддаггүй. Ирэх жил мөрдөн байцаалт явуулж байгаа хот хөдөөгүй цагдаагийн байгууллагын хүнээс мэдүүлэг авч байгаа.

Бүх өрөөг камержуулж байгаа. Зөвхөн дууны бичлэг гэлтгүй Та мэднэ шүү дээ бид нар байцаагчийн өмнө хүнээ дагуулаад очдог эрх үүрэг сануулж байна гээд л. Шинэ ирсэн нь удаан тогшдог хурдан байгаа нь бол хурдан тогшдог байцаалт аваад компьютерын кибард нүдээд байдаг. Үүнийг ирэх жил бид нар бүтэн хална гэж ажиллаж байгаа. Байцаагчаас шалтгаалахгүйгээр тэр өрөө тасалгаанд ярьсан яриа болгон бичигдээд чимэгэ системээр дамжуулаад хэвлэж гаргаад, гарын үсэг зурах өөрчлөлтийг бид нар хийгээд явж байгаа юм. Энэ өөрчлөлтүүдээ цагдаагийн байгууллага яриад ирэх жилийн төсөвт суулгаад явж байгаа. Камержуулалттай холбоотой хүний эрхийг хангах чиглэлээр Хууль зүй, дотоод хэргийн сайдын багцад байгаа хүний эрхийг хангах чиглэлийн зүйлүүд нийлээд шийдвэр гүйцэтгэх байгууллага дээр ярьж байгаа асуудлууд дээр ч гэсэн бид нар төсөв тавьчихаад байгаа. Тэгэхээр энэ маань л хасагдчихгүй бол бид нар ирэх жил эрүүдэн чиглэлээр ярьж байгаа зүйлүүд дээр нэлээн олон арга хэмжээ авч хэрэгжүүлнэ гэж төлөвлөж

байгаа. Хурал даргалагч аа эрүүлжүүлэгдэх болон саатуулагдсан чиглэлээр манай цагдаагийн байгууллагын 7 номерын микрофоноос тэндээс хариулуулъя.

Сонсгол даргалагч П.Сайнзориг -Тэр цагдан хорих хугацааг шүүхийн шатан дахь цагдан хорих хугацааны хугацаа тоолох асуудал дээр хариулт байгаа юу?

Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл- 7 номерын микрофон дээр яг энэ асуудал хоёуланг нь.

Сонсгол даргалагч П.Сайнзориг -Дэс дарааллаар явуулъя. Я.Цэлмэн Хүний эрхийн Үндэсний Комиссын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Үндэсний комиссын гишүүн Я.Цэлмэнд 11 номерыг өгье 3 асуулт асуусан тодорхой.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн Я.Цэлмүүн - Баярлалаа. Я.Цэлмэн эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн. Х.Баасанжаргал гишүүний асуултад хариулъя. 1 дүгээрт, хүүхдүүд эрүү шүүлтэд өртсөн талаар ийм судалгаа байна уу? ийм тохиолдол гарсан уу? гэж байна. Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 7 дугаар бүлэгт заасан эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх ажиллагааны 4 чиг үүргийн нэг нь бол хяналт шинжилгээ хийх байдаг. Энэ хяналт шинжилгээний хүрээнд бид шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага болон Өнөр бүл, хүүхдийн төв, хүүхдийн асрах байр зэрэг газруудад хүүхдийн эрхийн хэрэгжилтийн талаар хяналт шинжилгээ хийдэг.

Энд сургалт хүмүүжлийн тусгай байгууллагууд хүүхэдтэй хүнлэг бус харьцсан албан тушаалтнуудын асуудлыг камерын бичлэг болон бусад хүүхдүүдтэй уулзсан. Энэ асуумжийн хүрээнд илрүүлж шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад хариуцлага тооцуулахаар бичиг хүргүүлсэн. Хүүхдийн эрхийг сэргээлгэхээр мөн холбогдох байгууллагад хандсан. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас тухайн байгууллагын даргыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын тушаалаар албан тушаал бууруулах сахилгын шийтгэл ногдуулсан харуул хамгаалалт гүйцэтгэх ажил эрхэлсэн дэд даргад мөн албан тушаал бууруулах сахилгын шийтгэл ногдуулсан, байгууллагын нийгмийн ажилтан өөрийн хүсэлтээр албан тушаал чөлөөлөх хүсэлтээ өгсөн. Тухайн зөрчлийг гаргасан гэх харуул хамгаалалтын ахлах ажилтан мөн сахилгын шийтгэл ногдуулсан гэсэн бичгийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас ирүүлсэн байна.

1024 хүнтэй ганцаарчлан уулзлаа гэж байна. Бид 21 аймагт байгаа Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага болон Сэтгэцийн эрүүл мэндийн Үндэсний төвийн харьяа байгууллага, ахмад настны үндэстний төв, ахмадын асрамжийн газар хүүхдийн асрах байр төвүүдтэй холбоотой уулзалт хийдэг. Уулзах иргэдийн тоо бол жилээс жилд, мэдээж, өсөж байгаа. Үндсэндээ 21 аймгийг бид өнгөрсөн 2 жилийн хугацаанд 21 тойрч, эдгээр хүмүүстэй уулзсан, бүх хорих ангиудаар орсон.

Сонсгол даргалагч П.Сайнзориг -Уг нь бол ингээд бүр яг асуугаад байна шүү дээ. Яг өөрөө биечилж ганцаараа уулзсан юм уу? Тийм боломж байсан уу? Холбогдох тэр дүн шинжилгээ гээд битгий тийм дэлгэрэнгүй хариулт өгч байна гээд асуултад нь хариулахгүй цаг идээд бай л даа. Тодорхой хариул нэгийг дахиад өгчихье. Нэг минут.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн Я.Цэлмүүн -1024 хүнтэй уулзах боломж бол гарсан. Хамтран хяналт шинжилгээ хийсэн эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны хамт олон бас хүмүүстэй хамт уулзаж явдаг. Хүнтэй уулзсаны хүрээнд нийт шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад 21 зөвлөмжийг өнгөрсөн хугацаанд хүргүүлсэн. Энэ 21

зөвлөмжийн 3-ыг нь 2022 онд, 15-ыг нь 2023 онд, 3-ыг нь энэ онд хүргүүлсэн байгаа. Энэ зөвлөмжийн дээрээс нь гомдлыг анх эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаанд 2022 онд 6 гомдол, 2023 онд 10 гомдол 66 болж 11 дахин өсөж байсан. Энэ жил нийлээд 135 гомдлыг харьяа байгууллагад шалгуулахаар шилжүүлж ажилласан байгаа. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын журамд хяналт шинжилгээ хийсэн үү гэж. Бид маш олон журамд нь хяналт шинжилгээ хийсэн.

Сонсгол даргалагч П.Сайнзориг -Хүний эрхийн Үндэсний Комиссоос Б.Энхболд тэр нэг хүүхэд яг эрүү шүүлтэд өртсөн үү? гэдэг ийм тодорхой асуулт асуусан хариулт өгье. Микрофон хэд дээр байна. 12-ыг өгье нэг минут.

Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Б.Энхболд -Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Хүний Эрхийн Үндэсний Комиссоос тодорхой эрүү шүүлтийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нөхцөл байдлууд дээр дүн шинжилгээ хийж ажилладаг. Тэгэхээр 2022 оны 11 сарын 14-ний өдрийн 205 шүүхийн шийтгэх тогтоолоор нэг хүүхэд эрүү шүүлтийн хохирогч болж тогтоогдож гэм буруутай албан хаагч нар хариуцлага хүлээсэн байгаа.

Энэ шийтгэх тогтоол дээр эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэхтэй хамт хохирогчид эрүү шүүлтийн улмаас учирсан ямар нэг хохирол нөхөн төлбөрийг олгох талаар дурдаагүй холбогдох нэхэмжлэлийг иргэний хэргийн журмаар шийдвэрлэх боломжтойг дурдаж гаргасан шийтгэх тогтоол байдаг. Бас анхаарал татсан ийм кэйс болсон энэ дээр алба хаагч нар хариуцлага хүлээсэн.

Сонсгол даргалагч П.Сайнзориг - 3 байгууллагынх байна. Улсын Ерөнхий прокурор хариулах уу? М.Чинбат дарга 15 дугаар микрофоныг өгье. Тодорхой асуултууд асуусан.

Улсын Ерөнхий прокурорын орлогч М.Чинбат - Х.Баасанжаргал гишүүний асуултад хариулья. Улсын Ерөнхий прокурорын газраас 2019 оны 4-өөс 5 дугаар саруудад бид шалгалт хийсэн. Нэлээн өргөн хүрээтэй шалгалт. Энэ юу вэ гэхээр сэжигтнийг баривчлах, яллагчийг цагдан хорих ажиллагаа хууль тогтоомжийн дагуу хэрхэн нийцэж байна вэ? хорьж саатуулж байгаа цагдан хорьж байгаа байрны нөхцөл журам нь ямар байна вэ? гэдэг өргөн хүрээний шалгалт хийгээд шалгалтын үр дүнд илэрсэн нөхцөл байдлыг цаашдаа дахин давтан гаргуулахгүй байх. Ер нь мөрдөн шалгах ял эдлүүлэх ажиллагааны явцад хүний эрх зөрчигдөх, хүнлэг бус, хэрцгий хандахаас эрүүдэн шүүлтийн аливаа хэлбэр гаргуулахгүй байх үүн дээрээ дээд шатны прокурорын хариуцлагыг сайжруулах үүднээс зургаа дугаартай албан даалгавар гаргаж хэрэгжилт,

Сонсгол даргалагч П.Сайнзориг -Батлан хамгаалах яамны Жанжин штабаас хариулья дараа нь Авлигатай тэмцэх газраас микрофон өгч байгаарай тэгээд Цагдаагийн ерөнхий газраас хариулт өгье.

Батлан хамгаалах яам Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга, хошууч генерал С.Ганбямба - Зэвсэгт хүчний жанжин штабын дарга хошууч генерал С.Ганбямба гишүүний асуултад хариулья. Энэ Хүний эрхийн Үндэсний Комиссын 21 дүгээр илтгэлээр цэргийн алба хаагч хоорондын дүрмийн бус харилцааны дүн шинжилгээ хийгээд 5 зөвлөмж өгсөн, 5 зөвлөмжийн үнэлгээ дүгнэлтийг 30% гэж гаргасан нь бол Хүний эрхийн Комиссын талын асуудал байх. Бид бол түрүүн би бас хэлсэн зөвлөмжийн дагуу Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд энэ ялгаварлан гадуурхах хүнлэг бус харьцааны асуудлыг хуульчлан тогтоож өгсөн байгаа. Хамгийн эхний зөвлөмж хоёрдугаарх нь хил хамгаалалттай холбоотой. Хил

хамгаалах байгууллага манай Батлан хамгаалах яамны харьяа биш гэдгийг та бүхэн мэдэх байх. Мөн гэмт хэрэг зөрчлийг бууруулах талаар тодорхой урьдчилан сэргийлэх ажлыг үр нөлөөг дээшлүүлэх чиглэл өгсөн. Үүний дагуу батлан хамгаалах хяналт шалгалтын нэгдмэл тогтолцоог бүрдүүлсэн байгаа.

Түрүүн би бас илтгэл дээрээ оруулсан байгаа. Мөн цэргийн алба хаагчдад үзүүлэх сэтгэл зүйн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр бид нар сэтгэл зүйч болон соёл хүн.

Сонсгол даргалагч П.Сайнзориг - 4 номер Авлигатай тэмцэх газар бүгдээрээ ажил албан тушаалаа хэлээрэй.

Авлигатай тэмцэх газрын дэд дарга, эрхэлсэн комиссар Г.Азжаргал - Авлигатай тэмцэх газрын дэд дарга Г.Азжаргал гишүүний асуултад хариулья. Энэ 97-гоос 93 энэ бол ийм тоо юм аа. Нийт ер нь бол 14, 15 бага байна гээд яриад байгаа шүү дээ гомдол 400 хэд байна. Үгүй ээ энэ ийм учиртай юм 10,14,15 гэдэг бол зөвхөн 21.12-оор шийдэгдсэн шүүхээр эцэслэн шийдвэрлэгдсэн, эцэслэн шийдвэрлэгдээгүй болон шүүх дээр 21.1 гэж байгаа нотлох баримтыг хуурамчаар үйлдэх 57 шийдэгдсэн байна эцэслэн. 4 хэрэг бол 13.9-өөр буюу хууль бусаар баривчлах саатуулах гэсэн зүйл ангиар гээд явсан байгаа шүү. Дээрээс нь нэмээд 14 гээд байгаа 2017 оноос хойш бид нар хараад байгаа 2017 оноос өмнө 251.1-ээр, 250-аар.

Сонсгол даргалагч П.Сайнзориг - 7 номер Цагдаагийн ерөнхий газраас орж байгаа төлөөлөгч 7 номер байна нэр, албан тушаал

Цагдаагийн ерөнхий газрын Мөрдөн байцаах албаны дарга, хурандаа П.Очбадрах - Цагдаагийн ерөнхий газрын Мөрдөн байцаах албаны дарга хурандаа П.Очбадрах Х.Баасанжаргал гишүүний асуултад хариулья. Бид 2020 оноос 2024 оны эхний 10 сарын байдлаар сүүлийн 5 жилийн хугацаанд эрүүлжүүлсэн саатуулагдсан хүний статистик мэдээллийг товчхон танилцуулья. Нийтдээ эрүүлжүүлэгдсэн сүүлийн 5 жилийн хугацаанд 27.047 иргэн байна. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 5.2 дугаар зүйлийн 1.2-т зааснаар саатуулагдсан 220.419 иргэн гэсэн ийм статистик мэдээлэлтэй байна. Таны хүссэний сүүлийн 3 жилийн байдлаарх мэдээллийг цагдаагийн байгууллагаас гаргаж өгөхөд бэлэн байгаа. Эрүү зөрчил хянан шалган шийдвэрлэх тухай хуулийн 5.2-т болохоор хүнийг саатуулах энэ зөрчил үйлдсэн, согтуурсан, мансуурсан холбогдогчийг 24 цаг хүртэл хугацаагаар саатуулагдана гэж хуульчлагдсан байгаа. Яг саатуулагдсан тоо бол 220.419 гэсэн ийм мэдээлэл байгаа.

Сонсгол даргалагч П.Сайнзориг - Х.Баасанжаргал гишүүн тодруулья гэсэн нэг минут.

Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал - Би Авлигатай тэмцэх газраас асуугаад байгаа асуулт 2020-оос 2024 оны 21.12 дээр байгаа байхгүй юу. Хэрэг бүртгэлтийн хэрэгтэй 97 хаах санал 83 гэдэг ийм тоо танайхаас ирсэн байхгүй юу? Дахиад тусдаа 21.1,13.9-ийн тоонууд бол тусдаа байгаа. Миний асуусан 21.12-той холбоотой асуулт гэсэн үг. Би сая криминологи судалгааны талаар асуугаад байна. Прокурор дээр ч гэсэн асуугаад байна. Та хэд хариулаадхаач цагдаа дээр бас байдаг юм уу? эсвэл Улсын дээд шүүхийн судалгааныхан бас ирчихсэн байх шиг байсан. Ер нь энэ төрлийн гэмт хэргийн яг ийм криминологи судалгааг хийсэн газар байна уу? байгаа бол гишүүдэд өгөөч. Хамгийн сүүлд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгаалын яамнаас хүн байвал тэр хүүхдийг яагаад шашны байгууллагад зуучилж байгаа юм бэ? Танай байгууллага хүүхдийг шашны байгууллагад зуучилснаас

болоод 5 хүүхэд өнөөдөр хүчирхийлэлд өртчихөөд байна шүү дээ. Түүнийхээ хариуцлагыг яаж хүлээх юм.

Сонсгол даргалагч П.Сайнзориг - Хариулт өгөх Н.Мөнхзулын микрофон 9 номерыг өгье. Дараа нь Авлигатай тэмцэх газар уу?

Цагдаагийн ерөнхий газрын дэд дарга, цагдаагийн хурандаа Н.Мөнхзул - Өнөр бүл гээд улсын асрамжийн газар байгаа хүүхэд халамжлах хувилбарт үйлчилгээ мөн давхар явуулдаг. Энд үйлчилгээ авч байсан 5 хүүхдийг өөрсдийнх нь хийсэн ярилцлага, хүсэлт, мэдээлэл дээр үндэслээд тухайн асрамжийн төвийн даргын шийдвэрээр Налайхад байгаа сүм хийдэд шавилуулан суулгасан. Эдгээр хүүхдэд бие махбодын шийтгэл авсан байж болзошгүй шинж тэмдгийг цагдаагийн байгууллагаас илрүүлсэн. 2024 онд энэ асуудлын дагуу бид 10 дугаар сард ажлын хэсэг байгуулан Өнөр бүл төв дээр хяналт шалгалтын ажил хийгдэж байгаа. Хяналт шалгалтын ажил эцэслэгдэж байгаа. Эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр Өнөр бүлийн удирдах албан тушаалтан ийм шийдвэр гаргаж гэрээ байгуулаад энэ хийддээ шавилуулан суулгасан. Тэгээд энэ асуудал дээр бид нар шалгалт хийсэн. Шалгалтын эцсийн дүн хүүхдийн эрхийн улсын байцаагч нар дүгнэлтээ гаргаад ажиллаж байгаа.

Сонсгол даргалагч П.Сайнзориг - Прокурор М.Чинбат дарга 15 дугаар микрофон.

Улсын Ерөнхий прокурорын орлогч М.Чинбат – Ял шийтгэлийн талаар криминологи судалгаа байна уу? Гэсэн. Ер нь эрүү шүүлт тулгах гэмт хэргийн шалгаж шийдвэрлэсэн байдал шалтгаан нөхцөлийг бид судалж үзсэн. Одоо 2017 оны хагас жилээс 2024 оны 11 дүгээр сарын 15-ны байдлаар бид 36 хүнд холбогдох 18 хэргийг яг энэ зүйл хэсгээр шүүхэд яллах дүгнэлт үйлдэж шилжүүлсэн байгаа. Шүүхээс 30 хүнд холбогдох 14 хэргийг эцэслэн шийдвэрлэсэн. Энэ 30 хүнээс 2 хүний хэргийг нь хэрэгсэхгүй болгож цагаатгасан. 17 шүүгдэгчид нь торгох шийтгэл, торгох ял оногдуулсан. 11 шүүгдэгчид нэг жилээс 3 жил 6 сарын хорих ял оногдуулж шийдвэрлэсэн байгаа. Энэ Эрүүгийн хуулийн тусгай ангийн 21.12.1-д зааснаар бол 5400 нэгжээс 27 мянган төгрөгтэй тэнцэх торгох шийтгэл торгох ял нэг жилээс 5 жилийн хорих ял.

Сонсгол даргалагч П.Сайнзориг - Жудагийн Баярмаа гишүүн асуултаа асууя.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа - Та бүгдийн энэ өдрийн амрыг эрье. Тэгээд өглөө 9-өөс авхуулаад өдий 5 өнгөртөл бүтэн 8 гаруй цаг маш идэвхтэй сууж байгаа оролцогчдоо баярлалаа. Нөгөө талаас бол бас харамсалтай байна. Яагаад гэвэл ингэж их тэвчээртэй сууж байна гэдэг чинь Монгол Улсад хүний эрхийн зөрчил эрүү шүүлттэй холбоотой асуудал ямар их байгаагийн илрэл гэж бодож байна. Тийм учраас энэ улсууд өнөөдөржингөө тэвчээртэй хүлээцтэй хандаад сууж байна. Тэгээд их орой болсон тул нэг их олон юм асуухгүй. Би нэг товчхон 2 гуравхан асуулт асууя гэж бодлоо. Прокурорын байгууллагаас асуумаар байна. Яагаад гэвэл прокурорын байгууллагатай холбоотой санал, гомдол маш их ирдэг. Тэгэхээр энэ уг нь прокурорын байгууллага маань мөрдөн шалгах ажиллагаанд хяналт тавих ёстой дээрээс нь ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих ёстой. Хяналт тавьж байх явцад ер нь эрүү шүүлттэй холбоотой хүнлэг бус харилцаатай асуудлуудыг илрүүлсэн тийм тохиолдлууд байна уу? Байдаг бол хэд юм бэ? 2 дугаарт энэ Монгол Улс чинь бас нэг дэлхийн хамтын нийгэмлэгийн гишүүн учраас олон улсын гэрээ конвенцуудад нэгдчихсэн байдаг. Эрүү шүүлтийн эсрэг конвенцод 2014 онд нэмэлт протоколд нь элссэн байгаа. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх ажиллагаагаа

сайжруул гээд байгаа юм. Тэгэхээр бид нар өнөөдөр ниргэсэн хойно нь хашхирав гэгчээр урьдчилан сэргийлэх ажиллагаа байхгүй хяналт байхгүй явж байгаад олон хүний эрхийн зөрчил, эрүү шүүлттэй холбоотой асуудлууд үүсдэг. Тэгээд арга хэмжээгээ ч авч чадахгүй өдий хүрээд ирчихсэн.

Гэтэл энэ урьдчилан сэргийлэх ажиллагаа яаж явагддаг юм бэ? Энэ тайланд маш их байдаг юм байна. Тайланг уншиж байхад энэ заалтууд нь Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд байгаа эрүү шүүлтийн эсрэг заалтуудын хэрэгжилт дээр үнэлгээ хийсэн байна. Тэгээд юу гэж дүгнэсэн байна гэвэл зорилгод хүрсэн байдал нь 50% практикт нийцэж буй байдал нь 22,7% гэж байна. Тэгэхээр урьдчилан сэргийлэх ажиллагаа ер нь яаж явагдаж байгаа юм бэ гээд энэ дээр бас нэг ноцтой дүгнэлт байна л даа. Нэгдсэн Үндэсний Байгууллагын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо хуралдаанаараа хэлэлцээд юу гэж дүгнэсэн бэ гэвэл Монгол Улсад энэ механизм хангалттай ажиллахгүй байна гэж үзсэн байгаа юм. Хараат бусаар үр дүнтэй хэрэгжүүлэхэд хүндрэл үүсэж байна гэж дүгнэсэн байна. Одоо өөрөөр хэлбэл, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх энэ ажиллагаа нь өөрөө хараат бусаар үр дүнтэй хэрэгжихэд бэрхшээл хүндрэл тулгарч байна гээд дүгнэчихсэн байна. Энэ яагаад байгаа юм бэ? ямар хүндрэл үүсээд байгаа юм бэ? Бид нар чинь урьдчилан сэргийлэх ажиллагаандаа л илүү ач холбогдол өгмөөр байна.

Гуравдугаарт, цэргийн ангитай холбоотой цэргийн ангиуд дээр дөнгөж сая бид нар зөндөө л ярилаа дүрмийн бус харилцаа гээд. Тэгэхээр миний энэ тайлангаас олж мэдсэн зүйл юу гэвэл 800 гаруй байгууллагад шалгалт хийх эрхтэй гэж ойлгосон болов ч энэ дунд цэргийн ангиуд байдаггүй гэж ойлгосон. Ялангуяа урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж болохгүй гээд байгаа юм. Тэгэхээр энд ямар шалтгаан байдаг юм бол. Уг нь бол урьдчилан сэргийлэх ажиллагаагаа хийгээд явж байвал хэдэн бор цэргүүд маань ямар нэгэн дүрмийн бус үйл ажиллагаанд өртмөөргүй байх шиг байх юм. Энд ямар шалтгаан байдаг юм бол? Эцсийн асуулт бид нарын өнөөдрийн энэ сонсгол хийж байгаа хамгийн гол зүйл бол харамсалтай үйл явдал тохиолдсон тэр 7 сарын эмгэнэлт явдалтай холбоотой. Харамсалтай нь тэр үед нь сонсгол хийж амжилгүй өнөөдрийг хүрсэн учраас ямааны мах халуун дээрээ гэдэг байдал алдагдаад өнөөдөр энэ асуудлыг дурдаж байгаа хүн маш бага байна.

Би асуумаар байна 21 настай талийгч залуугийн хэрэг юу болсон бэ? Би прокуророос асуумаар байна. Энэ 1 дүгээр сард гомдол өгсөн байдаг. Гэтэл одоо хүртэл юу болж байгаа нь тодорхойгүй энэ ямар нэгэн ажилтан хариуцлага хүлээх тийм нөхцөл байдал үүссэн үү үүсээгүй юм уу? Ер нь бол хэргийг удаашруулж шийдэхгүй байгаа нь өөрөө эрүү шүүлтийн нэг хэлбэр гэж үздэг. Эмнести Интернэшнл ч тэр энэ эрүү шүүлтийн эсрэг байгууллагын тодорхойлолтоор хамгийн гол тэр залуугийн асуудал талийгч залуугийн асуудал юу болсныг энэ прокурор, Авлигатай тэмцэх газраас асуусан боловч мөрдөн байцаах ажиллагааны нууц гээд хариулдаггүй юм. Тэгэхээр боломжийнхоо хэрээр энэ дээр хариулт өгөөч. Энэ чинь бид нарын өнөөдөр суусан энд цугларсан бас нэг шалтгаануудын нэг шүү. Ийм асуудлууд байсаар л байгаа гэтэл энэ чинь хамгийн гол юм нь төрийн шийдвэрээр эрхээ хязгаарлуулчихсан байгаа хүмүүс төрийн шийдвэр шүү. Төрийн шийдвэрээр эрхийг нь хязгаарлачхаад амь настай холбоотой асуудлыг үүсгээд байгаа нь өөрөө болж байгаа юмуу?

Сонсгол даргалагч П.Сайнзориг - Улсын Ерөнхий прокуророос эхлээд хариулья, 15 дугаар микрофон дараа нь 2 байгууллага байгаа.

Улсын ерөнхий прокурорын орлогч М.Чинбат -Прокурор ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих ажлынхаа хүрээнд хорих анги, цагдан хорих байр, бусад

албадах байруудад хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалгадаг танилцдаг. Энэ хүрээндээ илэрсэн зөрчлийг арилгуулах хэмжээнд бид өөрсдийнхөө бүрэн эрхийн хэмжээнд хүрээнд авч хэрэгжүүлэх эрхийнхээ хэмжээнд тодорхой арга хэмжээг авч ажилладаг. Гэмт хэргийн шинжтэй аливаа асуудал албан хаагчийн харилцаа хандлага хууль бус үйлдлийг бид зөрчлөөрөө илрүүлээд хэрвээ гэмт хэргийн шинжтэй гэж үзвэл мөрдөх байгууллагад шилжүүлдэг. Гэмт хэргийн шинжгүй сахилгын хөдөлмөрийн харилцааны асуудал байна гэвэл тухайн байгууллагад нь бид албан ёсоор тавьж шийдвэрлүүлдэг.

Энэ зарчмаараа хяналтыг хэрэгжүүлж ажиллаж байна. Урьдчилан сэргийлэх ажил урьдчилан сэргийлэх ажиллагааны хувьд бол прокурорын байгууллага яг энэ асуудлыг онцгойлон анхаараад 2019 оны 6 сард, 4 сард Ерөнхий прокурорын газрынхаа бүтцэд хууль сахиулах байгууллагууд дотроо анх удаа байх Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх зөвлөл гэдгийг байгуулж энэ зөвлөлийнхөө хүрээнд бид нэгж прокурорын газрууд болон мөрдөн шалгах эрх бүхий байгууллагууд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагуудад хамтарч Хүний эрхийн Үндэсний Комисстой хамтарч сургалт зөвлөгөөн зохион байгуулах, мөрдөгч, эрх прокуроруудын хууль эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх олон улсын гэрээ конвенцын талаар сургалт зохион байгуулах гээд төрөл бүрийн арга хэмжээг авч хэрэгжүүлж явж байна. Дараагийн асуудал нь амь хохирогч нас барсан хэргийг асууж байна. Энэ бол эрүүдэн шүүсэн зүйл хэсгээр Баянгол дүүргийн цагдаагийн 1 дүгээр хэлтсийн 2 мөрдөгчийн асуудлыг мөрдөн шалгах ажиллагаанд эрүүдэн шүүсэн хэрэг нь бол яллах дүгнэлт прокурорын шатанд үйлдэгдээд одоо шүүхэд шилжүүлэх шатандаа байж байгаа. Прокурорын шийдвэрт гомдол гаргасан байгаа. Энэ шат шатандаа хянагдаад явж байна.

Сонсгол даргалагч П.Сайнзориг – Дараагийнх нь Хүний эрхийн Үндэсний Комисс уу Я.Цэлмүүн юмуу. Дугаар 11-г өгье.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн Я.Цэлмүүн - Ж.Баярмаа гишүүний асуултад хариулья. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа Монгол Улсад 2022 онд гишүүнийг Улсын Их Хурлаар томилсноос үүслээ гэж үзэж байгаа. Тэгээд бид олон улсын хүний эрхийн энэ байгууллагуудын зөвлөмж ялангуяа Хүний эрхийн зөвлөмжийн 54 дэх хуралдаанаар хэлэлцэж баталсан Нэгдсэн Үндэсний Байгууллагын дур зоргоор саатуулах асуудал хариулсан ажлын хэсгийн дүгнэлт Засгийн газарт ирүүлсэн зөвлөмж Нээлттэй нийгэм форум төрийн бус байгууллагаас хийсэн судалгаа зэргийг бол үндэслээд Хууль зүйн байнгын хороонд танилцуулсан. Хууль зүйн байнгын хорооноос Улсын Их Хуралд санал хүргүүлж 2024 онд бол Улсын Их Хурлын 37 дугаар тогтоол дээр эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг бол олон улсын нэгдэн орсон гэрээ конвенцод нийцүүлж өөрчлөх үүргийг өгсөн байгаа.

Сонсгол даргалагч П.Сайнзориг - С.Ганбямба дарга хариулья.Батлан хамгаалах яамнаас.

Батлан хамгаалах яам Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга, хошууч генерал С.Ганбямба-Ж.Баярмаа гишүүний асуултад хариулья. Зэвсэгт хүчний нэгтгэл ангиудад энэ дүрмийн бус харилцаа урьдчилан сэргийлэх ажил хийх гэж байгаа хүмүүсийг нэвтрүүлэхгүй байгаа гэдэг бол худлаа мэдээлэл шүү. Зэвсэгт хүчний нэгтгэл ангиуд нээлттэй байгаа. Холбогдох төрийн болон төрийн бус байгууллагууд яг энэ чиглэлээр зэвсэгт хүчинд үйл ажиллагаа явуулахад бол бид нар зөвшөөрөл олгож нэвтрүүлж байгаа. Ялангуяа Хүний эрхийн Үндэсний Комиссынхон бол Жанжин штабт хүсэлт гаргаад тэгээд нэгтгэл ангиудаар ажиллаж

байгаа. Одоо Хүний эрхийн Үндэсний Комиссынхон илтгэх байх. Би бас дээр нь эрхэм гишүүдийг урьж байгаа. Зэвсэгт хүчний нэгтгэл ангиудад та бүхэн ажиллаач Хууль зүйн байнгын хороо, хүний эрхийн дэд хороо бид та бүхнийг зэвсэгт хүчний нэгтгэл ангиуд дээр хүний эрхтэй холбоотой Зэвсэгт хүчний нэгтгэл ангиудын үйл ажиллагаа ямар байгаа талаар тодорхой мэдлэг мэдээлэл авахын тулд манай зэвсэгт хүчний ангиудад ажиллахыг та бүхэнд урьж байна. Нээлттэй байгаа баярлалаа.

Сонсгол даргалагч П.Сайнзориг - Ж.Баярмаа гишүүнд нэг минут өгье тодруулах шаардлагатай гэж үзсэн байна.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа - Дахиад асууя, сая дутуу хариулчихлаа яагаад гэвэл энд их ноцтой дүгнээд байгаа байхгүй юу. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх ажиллагаанд бэрхшээл хүндрэл тулгараад байна. Хараат бусаар үр дүнтэй ажиллаж чадахгүй байна гээд энэ дээр чинь дүгнэчихсэн байгаад байна шүү дээ. Үүнийг л бид нар үнэхээрийн үр дүнтэй хараат бусаар хийж чадахгүй л юм бол энэ урьдчилан сэргийлэх ажиллагаа чинь хийгдэхгүй юм биш үү? бид нар дахиад л магадгүй жилийн дараа сууж байх юм биш үү? гэдэг би асуудалд санаа зовоод байгаа учраас ямар хүндрэл бэрхшээл тулгараад байгаа учир энд ингэж дүгнээд байгаа юм бэ? гэдгийг л дахиж асуумаар байна. Маш тодорхой хариулж өгөөч.

Сонсгол даргалагч П.Сайнзориг - Я.Цэлмүүнд микрофон өгье. 11 байх шиг байна.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн Я.Цэлмүүн - Я.Цэлмүүн Ж.Баярмаа гишүүний асуултад хариулья. Бидэнд ирүүлсэн Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хүний эрхийн зөвлөмжөөс ирүүлсэн зөвлөмжид бол тодорхой заасан байгаа. Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцод Монгол Улс нэгдэж орсон түүнд нэмэлт протоколд үндэсний урьдчилан сэргийлэх байгууллага байгуулах үүрэгтэй гэж тухайн улсыг заасан. Энд бол бие даасан хараат бус байдалд тодорхой үндсэн дараах чиглэлүүдийг бие даасан хараат бус байдлаар нь шийдэж өгөх ёстой гэдэг заалттай. Нэгдүгээрт, хүний нөөцийн асуудлыг хэрхэн шийдэх вэ? гэдгийг хараат бусаар шууд томилох ёстой гэдгийг заасан. Хоёрдугаарт, төсөв санхүүгийн хувьд бие даасан хараат бус байх ёстой гэдэг энэ асуудлыг заасан. Гуравдугаарт, нэвтрэн орох буюу хяналт шинжилгээ хийх бүх газруудыг хязгаарлалтгүйгээр тогтоох ёстой гэдгийг заасан. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 33.1 дээр эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааг хяналт шинжилгээ явуулах тэр бүх газарт цэргийн ангийн хувьд цэргийн сахилгын байр гэж хязгаарласан байдаг. Баярлалаа.

Сонсгол даргалагч П.Сайнзориг - Одсүрэнгийн Номинчимэг гишүүн асуултаа асууя.

Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг - Бүгдэд нь энэ оройн мэнд хүргье. Бас өглөөнөөс одоог хүртэл ингээд идэвхтэй сонсголдоо оролцож байгаа Та бүхэндээ бас талархал илэрхийлье. Тэгэхээр бид нар өнөөдөр олон ч бас хүмүүсийн кэйсийг сонслоо. Олон ч зөв зүйтэй саналыг гаргаж байна. Мэдээж энэ урьдчилан сэргийлэх ажиллагааг илүү үр дүнтэй болгох энэ механизмыг үр дүнтэй байлгах тал дээр зөвлөмжүүд гарсан үүнийг хэрэгжүүлээд явах нь бидний бас үүрэг гэж харж байгаа. Өнөөдрийн сонсгол дээр би хөндмөөр байгаа нэг асуудал ерөөсөө хохирлын асуудал байгаа. Энд өнөөдөр олон хүмүүс ирээд эрүүдэн шүүгдсэн хилс хэргээр хэрэг хүлээсэн үүнийхээ дагуу хохирлоо нөхөн төлүүлэх гээд ерөөсөө системтэй тулаад үүнийгээ чадахгүй байгаа тухай хэлж байна. Ер нь бид нар түрүүн хэлсэн Эрүүдэн шүүлтийн эсрэг конвенцод нэгдэж орсон. Энэ конвенцын 14 дүгээр зүйлийн

нэгд конвенц манай Монгол Улсын хуультай хүчин төгөлдөр бас бидэнд үйлчлэх ёстой. Энэ хуульд бол оролцогч улс өөрийн эрх зүйн тогтолцоогоороо эрүүдэн шүүгдсэн этгээд хохирлоо арилгуулах, шударга, хангалттай нөхөн төлбөр авах эрх түүний дотор эрүүл мэндээ бүрэн сэргээхэд шаардлагатай төлбөр гаргуулах эрхийг хүлээн зөвшөөрнө гэсэн байгаа юм. Тэгэхээр энэ чинь эрүүл мэндээрээ бүх л юмаараа хохирчихсон хүмүүс үүнийгээ заавал авхуулах эрх зүйн орчинтой байх ёстой гэдгийг энэ конвенцоор манай Монгол Улс бол хүлээн зөвшөөрчихсөн байгаа юм. Гэтэл бидэнд ирсэн Хүний эрхийн Үндэсний Комиссын ирсэн дүгнэлтүүдээс харахад ингээд хохирол хохирогчид нөхөн сэргээхэд чиглэсэн үйл ажиллагаа дутмаг тэгээд процессын олон үе шатыг дамжиж ач холбогдолтой нотлох баримт гаргуулах явцад олон саад бэрхшээлтэй учирдаг учраас нөгөө хохирогчид маань давхар давхар хохироод байна гэсэн дүгнэлтийг хийсэн байна.

Тэгэхээр хохирлын нэгэнт мэдээж нөхөн төлшгүй сэтгэл санааны янз бүрийн гэр бүлд нь хохирол учирч байгаа. Гэхдээ түрүүний хэлсэнчлэн тэр кейс дээр гарсан 15 жил хилсээр хэрэгт шоронд байж байгаад гарч ирээд тавьхан сая төгрөгийн нөхөн төлбөр авна гэдэг бол байж болшгүй асуудал хүний эрхийн бас нэг тод дохио зөрчил тийм үү? Тэгэхээр энэ хохирлыг нөхөн төлөх дээр би харлаа л даа. Хууль зүйн яамнаас ирсэн мэдээлэл дээр болохоор гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгосон байдлыг нь харахаар эрүүдэн шүүлт тулгах зүйл ангиар шүүхээр шийдвэрлэгдэж энэ сангаас авсан хэрэг нэг ч байхгүй юм байна. Тэгэхээр 14 хэрэг шийдвэрлэгдсэн гээд бүгдээрээ яриад байгаа. Энэ 8 жилийн хугацаанд 14 хэргээ одоо яах вэ? Хариуцлага нь торгууль байсан боловчиг иргэний журмаар юм уу? эсвэл Хууль зүйн яамны доор байгаа сангаас нэг ч төгрөг гаргаж авч чадаагүй гэсэн үг юм уу? Хохирогч төрөөс иргэний журмаар нэг ч төгрөг энэ 14 хэргийн хохирогч мөнгө төгрөг төлбөр хохирлоо гаргаж аваагүй гэсэн үг үү? гэдгийг би тодруулмаар байна.

Прокуророос хоёрдугаарт, прокурор дээр бас асуулт байна. Прокурорын байгууллага Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 31.1-ээр төр нийтийн ашиг сонирхлоор зөрчилдсөн гэж үзэх юм бол төрийн байгууллагын хүсэлтээр эсвэл өөрийнхөө санаачилгаар төрийн нэрийн өмнөөс оролцох ёстой байдаг. Тэгээд ялангуяа энэ эрүү шүүлттэй холбоотой асуудал дээр хохирогчид нөхөн төлбөрөө төлүүлэе, хохирлоо барагдуулъя, нэр төрөө сэргээе гээд шүүхэд хандахад прокурор 14 хэргийн хэд дээр нь ер нь төрийг төлөөлж нийтийн эрх ашиг зөрчигдөж байна хүний эрх ашиг зөрчигдсөн байна гэж оролцсон юм бэ? Энэ талаар прокурор тоон мэдээллээ өгөөч.

Гуравдугаарт, Хууль зүйн яамнаас асуумаар байна. Хүний эрхийн Үндэсний Комиссын дүгнэлт дээр байна 5 дугаар дүгнэлт. Энэ төрлийн гэмт хэргийг үйлдэхдээ төрийн нууц, гүйцэтгэх ажил, нууц мөрдөн шалгах ажиллагаагаар халхавчлах хандлага гарч ирж байгаа нь хор уршгийн хувьд илүү ноцтой илрүүлэх, нотлох, хяналт тавих, шүүхээр эцэслэн шийдвэрлэхэд хүндрэл учруулж байна гэж эрүү шүүлт тулгах. Тэгэхээр энэ дахиад л нөгөө түрүүний 2012-оос 2016 оны үед гарсан хэргүүдийн хохирогчид. Түрүүн хэлсэн прокурор нь, Авлигатай тэмцэх газар нь, шүүх нь яаж худал хүчээр байж байгаад мэдүүлэг авдаг юм. Яаж ял наймаалцах байдлаар ингэж хийсвэр хэрэгт гүтгэдэг вэ? Энэ бүгдийн чинь ард бүгдээрээ л хууль хүчний байгууллагынхан. Системчлэгдсэн юм аваад байна шүү дээ.

Тэгэхээр үүнийг бид нар задлахын тулд дахиж ийм хэрэг гаргахгүйн тулд Гүйцэтгэх ажиллагааны тухай хууль, Төрийн нууцын тухай хууль дээрээ Хууль зүйн яам ямар бодлого барьж хэзээ энэ талаар өөрчлөлт шинэчлэлд оруулах бодлогыг барьж байгаа вэ? гэдгийг асуумаар байна.

Сонсгол даргалагч П.Сайнзориг - О.Алтангэрэл сайдад хандсан 2 асуулт байна. Улсын ерөнхий прокурор тэгээд О.Алтангэрэл сайдаас эхэлье. Микрофоныг нь өгье.

Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл- Энэ эрүүдэн шүүгдсэн этгээд хохирогчид давхар хохироод байгаа нь бол үнэн. Тэр хохирол төлбөрийн хэмжээ чамлалттай гарч байгаа нь ч үнэн. Одоо 10 гаран жил хүнийг хорьчихоод 50 гаран сая төгрөг олгодог гэж байх. Энэ бол маш харамсалтай хэрэг. Бид нар 2 төрлийн үндсэн асуудал байгаа. Хохирлоо яаж үнэлэх юм бэ? гэдэг асуудал тэгээд Шүүх шинжилгээний үндэсний хүрээлэн дээр холбогдох шинжилгээнүүдийг хийж байгаа. Сэтгэл санааны гэм хор, эрүүл мэнд, учирсан хохирлууд гээд энийгээ бид нар улам боловсронгуй болгоё гээд л бас ярьж байгаа Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар батлагдсан нэг журмыг бид нар саяхан баталсан юм.

Сэтгэл санааны, гэм хортой холбоотой, бусад энэ хохиролтой холбоотой зарим төрлийн харилцааг яаж боловсронгуй болгох вэ? гээд. Өнөөдөр бид нар үүнийгээ бодохгүй бол хүний хоригдсон 1 хоног ямар үнэтэй юм хилс хэрэгт тулгагдаж шаналж хоносон нэг шөнө ямар үнэтэй юм тэрийгээ бодож хэдэн жил уйлж яваа эхийн нулимс ямар үнэтэй юм гээд. Бид нар үүнийг нэг ийм дорвитойхон хохиролд тооцдог тэрийгээ буцааж нэхэмжилдэг болох цаг нь ирчихсэн. Нэн ялангуяа буруутай албан тушаалтан төрд буцааж төлдөг цаг ирчихсэн. Хохирогчид нөхөн олговор олгох асуудал дээр та маш тодорхой асуулаа. Би тодорхой хариулья. Өнөөдрийг хүртэл бид нар энэ сан дээр шүүхийн шийдвэр дээр тодорхой тусгай заачихсан мөнгийг олгодог хүн амины гэмт хэрэг ч юм уу тодорхой төрлийн гэмт хэрэгт хохирчихсон хүмүүст олгодог. Өнөөдрийг хүртэл энэ сангаас эрүүдэн шүүгдсэн гэмт хэргийн хохирогчид олгогдсон нэг ч төгрөг байхгүй. Үүнийг бол одоо тодорхой хариулья. Энэ нууц мөрдөн шалгах ажиллагаа буюу гүйцэтгэх ажлын тухай асуудлууд яригдаж байгаа. Өнөөдөр гүйцэтгэх ажил нэрийн доор цагдан хорих харьяаллыг тогтоодог. Х.Баасанжаргал гишүүн хэлж байна. Үнэн шүү дээ. Өмгөөлөл хийгээд л явж байхад Төв аймаг руу хорилоо гэвэл бас л хэцүүдлээ шүү наадах чинь өндрийг авчихсан байна шүү л гэдэг шүү дээ.

Дахиад энэ гүйцэтгэх ажлын арга хэмжээ зохиож байна гээд. Хүний төрөл бүрийн эрхэнд халддаг ийм байдал байсан. Тухайлбал, Чимгээ, Содномдаржаа нар эрүүдэн шүүгдсэн хэрэгт холбоотой тэр Амгаланбаатар гэж нөхөр байдаг тэр хүнтэй холбоотой шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад бүх шилжилт хөдөлгөөн явагдаж байгаа. Мөрдөн шалгах ажиллагаанууд бүгд гүйцэтгэх ажлын шугамаар нууцаар явагдаж байсан. Хүний эрх яаж зөрчигдөж байгааг хянах ямар ч боломжгүй байсан. Тэгэхээр нууц мөрдөн шалгах ажиллагаа бол өөрийн зорилго чиглэлийн хүрээнд өөрийнхөө зорилгыг биелүүлэх гэж явж байх хүрээндээ хүнийг эрүүдэн шүүх үйл ажиллагаанд өртүүлэх хамгийн магадлалтай ажил гэдгийг ойлгож байгаа. Тэгэхээр энэ тал дээр бид нар дахиад цаашдаа арга хэмжээ авахаар ажиллана гэдэг зүйлийг хэлье.

Сонсгол даргалагч П.Сайнзориг - 15 дугаар микрофон 14 нэр албан тушаалаа хэлээрэй. Улсын ерөнхий прокурорын туслах прокурор О.Мөнхбаатар О.Номинчимэг гишүүний асуултад хариулья.

Улсын ерөнхий прокурорын туслах прокурор О.Мөнхбаатар - Эрүүдэн шүүлт тулгах гэмт хэрэг бол шүүхээр 14 хэрэг эцэслэн шийдвэрлэгдсэн гэж дүн тоо баримт байгаа. Үүнээс хохирогчдоос нэхэмжилж байгаа зүйл гэвэл 2 хохирогчийн мөрдөн шалгах ажиллагааны явцад нэхэмжилсэн хохирол бүрэн төлөгдсөн байна гэж шийтгэх тогтоолд дурдагдсан. Өөрөөр хэлбэл, хохирогчдын мөнгөн дүнгийн илэрхийлэл 1-ээс 3 сая төгрөгийг ил нэхэмжилсэн байна. Тэр нь төлөгдсөн гээд 6 хохирогчийн асуудал дээр хохирол төлбөр нэхэмжлээгүй гэж тогтоолд дурдагдсан.

4 хохирогчийн асуудлыг баримт бүрдүүлээгүй үндэслэлээр иргэний журмаар жич нэхэмжлэх эрхтэй гэдэг ийм байдлаар тусгасан байна. Прокурор бол төр нийтийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлтээр эс үгүй бол өөрийн санаачилгаар иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцдог, нэхэмжлэл гаргадаг, мөн гуравдагч этгээдээр оролцдог ийм л хуулийн зохицуулалттай. Эрүү шүүлт тулгах гэмт хэргийн хохирогчоос нэхэмжилсэн мөнгөн дүнтэй холбоотой асуудал дээр бол нэхэмжлэл гаргасан оролцсон тохиолдол байхгүй.

Сонсгол даргалагч П.Сайнзориг - О.Номинчимэг гишүүнд нэг минут өгье.

Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг - Тэгэхээр прокурорт бас хэлэхэд энэ иргэд уг нь хүсэлт гаргадаг юм байна лээ шүү. Та хэдэд оролцоод өгөөч бид нар хохирлоо нэхэмжлэх гэсэн юм аа төрийг төлөөлөөд оролцоод өгөөч гээд. Тэгэхээр танай салбар прокурорууд ерөөсөө татгалзчихдаг юм байна. Түүн дээр ямар ч хяналт байхгүй яагаад орохоосоо татгалздаг юм яагаад энэ эрүү шүүлттэй холбоотой хэрэг дээр прокурор ийм хайнга хойрго ханддаг юм гэдэг дээр дүгнэлт хийж цааш цаашдын Улсын Их Хурал дээр ч гэсэн холбогдох ажлын хэсгүүд байгаа. Энэ дээр нарийвчилж ярина гэж бодож байна. Дахиад нэг зүйл хэлэхэд шүүх, шүүгч нь 3 шатны шүүхээр шийдчихээд байгаа хэргүүдээ яах вэ? гээд хохирогчид байсан. Тэр үедээ нотлох баримтаа буруу Б.Жаргал хүн энд ярьж байсан. 3 шатны шүүхээр шийдэгдсэн тэгэхдээ миний мэдүүлгийг хүчээр авсан гээд. Тэгээд ийм сонин парадокс л бид нар орчхоод байна. 3 шатны шүүх чинь шийдвэр гаргачихсан юм чинь гээд.

Сонсгол даргалагч П.Сайнзориг - Улсын ерөнхий прокуророос 14 дүгээр номерын микрофоныг өгье.

Улсын ерөнхий прокурорын, туслах прокурор О.Мөнхбаатар - Би сая хуулийн зохицуулалтыг хэлсэн. Прокурор хүсэлт гаргасан тохиолдол гаргахгүй байна оролцохгүй гэдэг хариу өгсөн байгаа гэж О.Номинчимэг гишүүн хэлж байна. Тэгэхээр хуулийн зохицуулалт өөрөө төр нийтийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн ашиг сонирхол зөрчигдөхгүй нийтийн ашиг сонирхол гэдэг бол нэг хүнээр тодорхойлж илэрхийлж тэр ч гаргадаггүй зохицуулалттай.

Сонсгол даргалагч П.Сайнзориг - О.Алтангэрэл сайд О.Номинчимэг гишүүний сүүлийн асуултад хариулах уу? Засгийн газраас цаашдаа ямар бодлого барих гэж байна. Одоо ингээд 3 шатны шүүхээр хэрэг маргаан шийдвэрлэгдсэн гэдэг байдлаар энэ олон хохирсон иргэд эрхээ сэргээлгэх асуудал дээр төвөгтэй байдлууд ч юм уу ойлгомжгүй байдлууд үүссэн гээд түрүүн хэд хэдэн хүний кэйс дээр гарсан. Та бас хариултыг өгнө үү?

Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл- Үгүй ерөөсөө нэг л асуудал байгаад байгаа юм. Хууль зүй, дотоод хэргийн сайдын нэр дээр өргөдөл гомдлын агуулга манай П.Сайнзориг гишүүн өөрөө сайн мэднэ. Дандаа шүүхийн шийдвэртэй зүйлүүд ирээд байдаг. Түүнийг нь шилжүүлээд 3 шатны шүүхийн шийдвэртэй юм байна гээд буцаахаас арга байхгүй эрх мэдэл байдаггүй. Тэгэхээр гол гомдол хаана явж байна гэвэл шинээр илэрсэн нөхцөл байдал гэж юу ойлгох вэ? гэдэг хууль зүйн ойлголтоо бид нар эргэж харах болчихсон юм байна гэж үзэж байгаа юм. Шинээр илэрсэн нөхцөл байдал гэдэг тухайн хэргийг шийдвэрлэх явцад мэдэх боломжгүй байсан гэдэг ч юм уу? ийм нотлох баримт гээд одоогийн тодорхойлолт нь хууль зүйн хувьд нэлээн явцуу бөгөөд ямар нэг байдлаар үүнийг хөндөх бололцоогүй харагдаад байгаа юм. Тэгээд үнэхээр дараа нь харахад хуульчид өөрсдийнхөө эрх зүйн ухамсрын түвшинд болоод үзсэн туулсан туршлагаараа

үзэхээр үгүй яагаад ингээд шийдчихсэн юм болов уу гэмээр юмнууд байгаад байгаа. Үүний хамгийн том жишээ бол Улсын дээд Шүүх. Чимгээ, Содномдаржаа нартай холбоотой хэргийг үндсэндээ дахиж хэлэлцээд буцаасан шүү дээ. Үүнтэй адилаар бид нар энэ шинээр илэрсэн нөхцөл байдал гэдгээ шинээр тодорхойлох шаардлагатай л гэж үзэж байгаа.

Сонсгол даргалагч П.Сайнзориг - М.Нарантуяа-Нара нар гишүүн асууя.

Улсын Их Хурлын гишүүн М.Нарантуяа-Нара - Та бүхэнд оройн мэнд хүргье! Тэгэхээр өглөөнөөс хойш маш их зүрх эмтрэм мэдээ мэдээллийг сонсоод үнэхээр өр зүрх өмөрч байна. Ер нь бол энэ оролцогчдын суудал дээр ирээдүйд яг энэ асуудлыг парламентын хугацаанд шийдэж хууль эрх зүйн орчныг нь сайжруулахгүй юм бол дараа дараагийн оролцогчдын ширээн дээр хэн ч сууж байж болох юм байна гэдгийг би олж харлаа. Юуны өмнө Эрүүдэн шүүлт хэлмэгдүүлэлттэй тэмцэх үндэсний холбоо гэж нийтэд үйлчлэх Төрийн бус байгууллагад үнэхээр чин сэтгэлийн талархал дэвшүүлмээр байна. Энэ 47 хүн түүний ард өчнөөн олон эрүүдэн шүүлтэд өртсөн, хэлмэгдсэн, ар гэрийг нь цуглуулаад зовлон нэгтэй хүмүүсийг төр засаг нь сонсохгүй байгаа арга хэмжээ авахгүй байгаа хүмүүсийнхээ эрх ашгийн төлөө явж байгаад нь чин сэтгэлээсээ талархал дэвшүүллээ. Энэ дундаа би М.Хувцагаан өмгөөлөгчид үнэхээр болдог бол энэ хурлын дараа би очиж тэвэрмээр байгаа. Би тэр сошиалаар мэдээ, мэдээллийг үзсэн. Яагаад ч юм мэдэхгүй цурхиртлаа уйлсан. Та бүхэн өөр өөрсдөө дээр бодоод үзээрэй. Таны хүүхдийг хилс хэрэгт гүтгээд хэн нэгэн эрх мэдэлтэн хүн ял тулгаад зөвхөн өөрийнхөө ажил үүргийг, хэргийг шийдвэрлэсэн гэдэг зүйлийг гаргахын тулд таны хүүхдийг бүхэл бүтэн 15 жилийн туршид хилс хэргээр шоронд хатаагаад энэ хооронд нь эцэг эх, үр хүүхэд, ах дүү үр үхэж үрэгдээд бүхэл бүтэн айлын амьдрал байхгүй болчихсон бол ямар байх вэ? гэдгийг үнэхээр бодоорой. Үнэхээр М.Хувцагаан өмгөөлөгч хүний төлөө, чин сэтгэлтэй, өөрийнхөө эзэмшсэн мэдлэг боловсрол мэргэжлээ тууштай олон жил хүний төлөө явуулсан учраас өнөөдөр тэр хүн магадгүй 25 жил шоронд нас барчихаж болох байсан энэ эрсдэлээс ядаж л 15 жилийн дараа гарч ирсэн байна.

Тэгэхдээ Та бүхэн бодоорой. Монголын төр засаг 2002 онд Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцод нэгдчихээд түүнээс 5 жилийн дараа хүнийг эрүүдэн шүүгээд ял тулгаад, хэлмэгдүүлээд шоронд хорьчихсон байж байгаа юм 15 жилийн дараа тэр хүнийг гараад ирсэн чинь 50 сая төгрөг өгч байгаа бол доромжлол 50 сая төгрөгийг 180 сард хуваахаар хүн сард 277.000 төгрөг авч байгаа. Хэрвээ тэр хүн энэ нийгэмд амьдраад ажил хөдөлмөр эрхлээд гэр бүлийн аз жаргал үр хүүхэд, хамт олонтой байх маш олон аз жаргалаа гээгдүүлээд зогсохгүй энэ хүн ердөө 277.000 төгрөгөөр үнэлэгдсэн ийм зүйлийг авч байгаа. Би түрүүнээс хойш бодож байхдаа энэ бол үнэхээр нэг хуулийн хүрээнд нөхөн олговор дээр маш олон зүйлийг ярих ёстой юм байна. Зөвхөн хүний хөдөлмөрлөх эрхийн асуудал биш хөдөлмөр хөлсний доод хэмжээ биш мөн тэр битгий хэл гэр бүлийн сэтгэл санаа тэр дундаа ялангуяа аавгүй, ээжгүй амьдарсан хүүхдүүдийн сэтгэл санааны хохирлыг мөн түүнчлэн эрүүл мэндээ алдсан хөдөлмөрлөх эрхээ алдсан энэ бүх юмнуудыг үнэхээр бас хуульд нь зааж өгөх хэрэгтэй юм байна.

Тэгээд би Хууль зүйн яамнаас асуух гэсэн юм. Энэ М.Хувцагаан өмгөөлөгчийн хохирогчийн ял тулгасан. Цагдаа нарт ямар арга хэмжээ авсан юм бэ? Мөн энэ тал дээр Хүний эрхийн Үндэсний Комисс хэлмэгдсэн хүн дээр ямар арга хэмжээ авсан бэ? Мөнгөн дүн 50 сая төгрөгийг нь та бүхэн бас юу гэж үнэлсэн юм бэ? Дараагийн асуудал нь 21 настай залуу нас барчихсан байгаа? Авлигатай тэмцэх газар юу гэж хэлж байгаа вэ? гэхээр таниулах ажиллагааг хийж амжаагүй байхад энэ хүн нас барсан гээд өөрөөр хэлбэл Монгол Улсад үхсэний хохь болдог. Ийм жишиг тогтоод

удаж байна. Угтаа бол хариуцлага алдсан төрийн албан хаагч Авлигатай тэмцэх газар ажлаас нь халсан гэж яриад байж байгаа зөвхөн ажлаас нь халаад зогсох биш. Энэ ажилтнуудаа хүний эрхийн мэдрэмжээр эрүүдэн шүүхийн эсрэг наад захын энэ сургалт арга зүйгээр хангаж чадаагүй дээд удирдлагуудыг ч гэсэн хариуцлагыг нь бас давхар авч байх ёстой гэж би хувьд бодож байна.

Мөн Л.Гансүх, Д.Энхбат, Б.Жаргал гээд хүмүүс байгаа. Эд нар үүрэгт ажлаа хийж байгаад эрх бүхий албан тушаалтны буруутай үйлдлээс холбоотой компанид нь өөрийнхөө ажил үүргийн хүрээнд тогтоосон ажлаа хийснийхээ дагуу хонгилоор чирэгдсэн байж байгаа. Тэгвэл энэ хүмүүсийн хохирлыг яаж барагдуулах вэ? Дээрээс нь иргэн Д.Энхбатаас асуумаар байна. Та эрүүдэн шүүлгэчихсэн өчнөөн ноцтой зүйлүүдийг яригдаж байна. Та эрүүдэн шүүсэн гомдлоо холбогдох газарт нь өгсөн үү? Арга хэмжээ авсан байгаа юу? Тэр талаар бас та надад сайхан хариулж өгөөрэй. Тэгээд дахиад давхар эрүүдэн шүүх хүнийг хэлмэгдүүлэхийг хэн хийж чадах вэ? ямар хүн хийж чадах вэ? Зөвхөн эрх мэдэлтэн.

Сонсгол даргалагч П.Сайнзориг - Хууль зүй, дотоод хэргийн сайд дараа нь хариулья. 4 номер Д.Энхбат хариулья.

Иргэн Д.Энхбат – Эрүүдэн шүүлт, хэлмэгдүүлэлттэй тэмцэх Төрийн бус байгууллагын тэргүүн Д.Энхбат. М.Нарантуяа-Нара гишүүний асуултад нь хариулья. Миний бие түрүүн хэлсэн өөрийнхөө энэ кэйсийн талаар өмнө нь мөн томилгооны сонсгол дээр бол хамгийн анх шүгэл үлээж буюу нийтэд ийм хонгил байдаг юм гэдгийг ярьж байсан. Би үндсэндээ 1041 хоног хилс хэрэгт хэлмэгдэж хоригдож гарч ирсэн даруйдаа би цагдаагийн байгууллага Эрүүдэн шүүгдсэн сая би ярьсан. Би талыг нь хэллээ л дээ. Намайг яаж эрүүдэн шүүгдсэн яаж тарчлаасан минут багтаагүй. Би бараг уншлага хийж байгаа юм шиг ярьсан. Та бүхэн анзаарсан байх. Миний гомдлын дагуу Улсын мөрдөн байцаах албаны тусгай субъектийн үйлдсэн гэмт хэргийг шалгах хэлтсээс 6 жил шалгасан. 6 жил шалгахдаа 10 хавтаст боть надтай хамт нөгөө өрөөнд оруулж хорьж байсан Т гэгчийг гянданд байхад нь ч очиж мэдүүлэг авсан байдаг юм. Над дээр урьд нь төрийн албаны ажил хийж байсантай холбоотой дайчлан баривчилсан. Тэр Ч гэсэн нөхрөөс ч мөн мэдүүлэг авсан байдаг юм. Надтай зориуд оруулж яаж намайг тарчлаан зовоож байсан гэх мэт маш олон нотлох баримтуудыг 10 хавтаст хэрэг шалгаад 6 жил шалгахдаа 6 удаа Д.Энхбат, Б.Жаргал гээд надтай хамт Б.Жаргал шинжээчийн гомдол бас явдаг юм. Мөрдөн байцаах албаны тусгай субъектээр үйлдсэн гэмт хэргийг шалгах хэлтсээс 6 удаа Д.Энхбатад ял шийтгэл тулгах зорилгоор эрүүдэн шүүсэн сэтгэл санааг нь тарчлаан зовоосон доромжилсон энэ үйлдлүүд нь эрүүдэн шүүсэн гэмт хэргийн шинжтэй байна гэсэн мөрдөгчийн саналыг Нийслэлийн прокурорт удаа дараа явуулсан байдаг.

Тэгээд 2002 оны эрүүгийн хуулиар хариуцлага хүлээх Авлигатай тэмцэх газрын комиссар Золжаргал, Нийслэлийн прокурорын газрын хяналтын прокурор Баярбилиг нарыг эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх хөөн хэлэлцэх хугацаа дууссан гэдгээр энэ хэргийг хаах санал Нийслэлийн прокурор дээр очсон байдаг. Энэ хэргийг Нийслэлийн прокурор хянаад гэмт хэргийн шинжгүй гэсэн ийм дүгнэлтийг гаргасан. Би гомдлоо Улсын ерөнхий прокурорт саяхан одоо хүргүүлээд Улсын ерөнхий прокурор дээр энэ хэрэг хянагдаж байгаа зургаа дахь жил нь өнгөрөөд явж байна.

Сонсгол даргалагч П.Сайнзориг - Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл Шууд 7 номероо явчих уу? Нэр албан тушаалаа хэлээрэй.

Цагдаагийн ерөнхий газрын Мөрдөн байцаах албаны дарга, хурандаа П.Очбадрах - Цагдаагийн ерөнхий газрын Мөрдөн байцаах албаны дарга хурандаа

П.Очбадрах М.Нарантуяа-Нара гишүүний асуултад хариулья. Иргэн Г-тэй холбоотой асуудлыг сая ярилаа. Шалгагдаж байх хугацаандаа 2 жил, нэг сар, 14 хоногийн хугацаанд цагдан хоригдсон. Бусад хугацаанд гадуур шалгагдаж байсан ийм мэдээлэл хэрэгт авагдсан байгаа. 2020 оны 5 сарын 26-ны өдрийн 583 тогтоол дээр цагаатгаж шийдвэрлэсэн. Тухайн хэргийг шалгаж байсан мөрдөгчтэй холбоотой шалгалтууд Авлигатай тэмцэх газар хуучнаар Улсын мөрдөн байцаах газар Прокурорын дэргэдэх мөрдөн байцаах алба гээд 3 байгууллага энэ 2 субьекттэй холбоотой албаны шалгалт болоод гэмт хэргийн шинжтэй үйлдэл гаргасан эсэхийг шалгаж шийдвэрлэсэн.

Ийм мэдээлэл манай дээр байгаа. Холбогдох байгууллагуудаас гарсан шийдвэр нь одоо яг миний гар дээр байна. Улсын мөрдөн байцаах газраас тухайн хэргийг шалгаж байсан мөрдөгч П, С нарт буруутай үйл ажиллагаа тогтоогдоогүй ёс зүйн сахилгын арга хэмжээ авсан гэсэн ийм албан бичиг тухайн оролцогчид хүргүүлсэн. Дараагийн удаад Мөрдөн байцаах алба, Прокурорын дэргэдэх мөрдөн байцаах алба бас гэмт хэргийн шинж байгаа эсэхийг шалгаж шийдсэн. Энэ дээр гэмт хэргийн шинжгүй эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзаж шийдвэрлэсэн дараагийн дугаарт Авлигатай тэмцэх газар мөн урьд гарсан шийдвэрт хүчинтэй гээд хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж шийдвэрлэсэн ийм 3 шатны шийдвэр байгаа хариулж дууслаа.

Сонсгол даргалагч П.Сайнзориг - Б.Энхболд. Хүний эрхийн Үндэсний Комисс 12, 1 минут.

Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Б.Энхболд - Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Б.Энхболд. М.Нарантуяа-Нара, гишүүний асуултад хариулья. Энэ саяын болсон тохиолдолтой холбоотойгоор 50 сая төгрөгийн хохирлыг шүүхээс гаргуулж авсан. Энэ бол мэдээж, ямар ч үндэслэлээр авсан хангалтгүй. Зөвхөн материаллаг хохирлын асуудлыг энэ дээр ингэж оруулсан байгаа. Хүний эрхийн Үндэсний Комиссоос бол нийтдээ өнгөрсөн хугацаанд 40 гаруй хүнийг төлөөлөн нэхэмжлэлээр шүүхэд төлөөлж 4,8 тэрбум төгрөгийг нэхэмжилсний 557 сая төгрөг буюу зөвхөн материаллаг хохирлыг ингэж шийдсэн. Ийм практик байдаг. Энэ тохиолдолд эрүүдэн шүүлт гэсэн асуудал яригддаггүй, дандаа цагдан хоригдсон, хилсээр шийтгэгдсэн, өөр хэргийн улмаас холбогдож шалгагдсан гэдэг. Энэ зүйлүүд гараад байдаг гэдгийг танд хэлье. Мөн дээр нь нэг асуудал юу вэ? гэхээр эрүүдэн шүүлт. Энэ хэлмэгдүүлэлтийн холбооны асуудал дотор анхаарч үзвэл зохих зайлшгүй хэдэн хүний кэйс байгааг энэ сонсголын үр дүнд авч үзэх.

Сонсгол даргалагч П.Сайнзориг - М.Нарантуяа-Нара гишүүн тодруулах уу? нэг минут.

Улсын Их Хурлын гишүүн М.Нарантуяа-Нара - Энэ 15 жил хилс хэрэгт хэлмэгдэж хоригдсон хүнийг хилс хэрэгт ял тулгасан цагдаа нарын асуудлыг 1 дүгээрт 2 дугаарт иргэн Д.Энхбат, Б.Жаргал нарыг шүүсэн хүмүүсийг та сая хэлчхэв үү? Хэрэгсэхгүй болсон гэдэг нь сая хэлдэг чинь 15 жилийн хорих ял авсан иргэн Ганбатын асуудал байна уу? эсвэл Д.Энхбат, Б.Жаргал нарын асуудал байна уу? гэдгийг тодруулья. Нэмээд Хууль зүйн яаманд хэлэх ёстой бид нар манай Нийгмийн бодлого байнгын хороо Сэтгэцийн эрүүл мэндийн Үндэсний төв дээр ажиллаад ирэхдээ тэндээс маш эмзэглүүштэй дүр төрхтэй ирсэн. Энд Хууль зүйн яам өөрөө хүнийг ял шийтгэхдээ хууль зүйн үндэслэлээр хэрэг хүлээх чадваргүйгээр Сэтгэцийн эрүүл мэндийн Үндэсний төвд өгчхөөд Сэтгэцийн эрүүл мэндийн Үндэсний төвд ажил буюу Эрүүл мэндийн яамны ажил болчихдог юм байна. Тэгэхээр зэрэг эмч нар маш хүнд нөхцөлд байна.

Сонсгол даргалагч П.Сайнзориг - О.Алтангэрэл сайд.

Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл - Түрүүн тэр яг таны асуусан иргэн Г- тэй холбоотой зүйл дээр манай цагдаагийн байгууллага хариулсан. Та зөв ойлгосон байна лээ шүү. Тэр эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ буюу Сэтгэцийн эрүүл мэндийн Үндэсний төвд холбоотой асуудал байгаа юм. Шүүх бол шийдээд л хаячхаж байгаа юм. Эмнэлгийн чанартай албадаж арга хэмжээ ав гээд л хаячхаж байгаа юм. Шүүхийн шийдвэрийн гүйцэтгэх байгууллага тэд нарыг чинь байлгах газар ч байхгүй. Өөрсдөө нэг журам гаргасан болоод 4 ээлжийн харуул хамгаалалт зохион байгуулаад Сэтгэцийн эрүүл мэндийн Үндэсний төвд тэр хүмүүсийг нэг манаад л 4 ээлжээр манаад л шийдвэр гүйцэтгэх байгууллагынхаа албан үүргээ гүйцэтгэж байгаа юм. Энэ ганцхан Сэтгэцийн эрүүл мэндийн Үндэсний төвийн асуудал биш дахиад архины албадан эмчилгээ гэж ярьдаг.

Төв аймгийн Баян сумд байгаа Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын хариуцаж байгаа эмнэлгийн архины албадан эмчилгээ гэхэд төсөв мөнгө байхгүй. Очоод ганц нэгхэн удаа дусал хийгээд л хүнийг баахан хориод л гадаа нь сууж байдаг. Бүгд төсөв мөнгөтэй холбоотой бүгд манайх анхаарал хандуулаад олон жил тавиад ирчихсэн ийм асуудал байгаа шүү.

Сонсгол даргалагч П.Сайнзориг - Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн асуулт асууя.

Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд - 10 сарын 22-ны өдөр хүний эрхийн дэд хорооны дарга болоод 28 хонож байгаа энэ хугацаанд хүний эрхийн зөрчилтэй холбоотой нэлээн олон хүмүүстэй уулзсан. Энэ сонсгол болох гэж байгаатай холбогдуулж өгсөн олон хүмүүс санаа бодлуудаа хэлж байгаа. Иргэн Ж.Занаа тэргүүтэй үзэл бодлоо илэрхийлэх гээд байгаа хүмүүс байгаа шүү дээ. Энэ хүмүүстэй ирэх 7 хоногийн 2 юм уу 3 дах өдөр уулзаад тусад нь ийм сонсгол хийх боломжийн талаар хэдүүлээ хэлэлцүүлэг хийе гэж ярьсан байгаа. Тэгэхээр хүний эрхийн дэд хорооны даргын хувьд хэлэхэд өнөөдөр бүх юмаа ярьж амжаагүй байгаа зарим хэргийнхээ тухай эд нар минутдаа амжиж яриагүй байгаа хүмүүст хүний эрхийн дэд хороо бол нээлттэй байгаа шүү. Та бүхэн дараагаар нь уулзаад тэгээд зөвхөн өнөөдрийн сонсголттой сонсгол тойрч биш үргэлжлүүлээд асуудлуудаа хэдүүлээ нээлттэй ярилцаад явах боломж байгаа шүү гэдгийг хэлмээр байна. Улсын Их Хурлын стратеги 2024-2028 оны стратеги өнгөрсөн 5 дахь өдөр батлагдсан.

Үүнтэй холбогдуулж Улсын Их Хурал нь өөрөө анхны 126 гишүүнтэй парламент хүн төвтэй бодлогыг хэрэгжүүлнэ гэдэг шалгуур тогтооно гэсэн байгаа үнэхээр боломжтой юу гэдэг асуулт. Үүнийг хэрэгжүүлэх нь маш их эр зориг иргэдийн оролцоо шаардсан ажил. Тэгээд үүнийг боломжийг нь цахим болгох, иргэдтэй ойр болгох, хүнд суртлын алга болгох гээд аягүй олон зорилгууд тавьчихсан байгаа. Энэ дээр та бүхнийг хамтарч ажиллаасай гэж хүсэж байна. Мөн 21 аймаг 9 дүүргийн иргэдийн Төлөөлөгчийн Хурлын дарга нарт бүгдэд нь үйл ажиллагаандаа шийдвэр гаргалтандаа хүний эрхийг хангаж ажиллах чиглэлээр чиглэл өгсөн албан бичгүүд явуулж байгаа. Он гараад нэг сард хүний эрх ба эрүүл мэнд гэсэн сэдвээр нээлттэй сонсгол явуулах талаар судалгаа хийгээд ажиллаж байгаа. Энэ дээр одоо жишээлбэл бид нар эрүүдэн шүүлтийн асуудал мөсөн уулын орой цаана нь иргэн өөрөө эрхээ зөрчүүлж байгааг мэдэхгүй байгаа амьд явах эрхээ дээрээс нь эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхээ утааны асуудал маш олон асуудлаас болоод алдаж байгаа амь нас эрүүл мэндээрээ хохирч байгаа маш том асуудлууд байгаа. Энэ дээр ч гэсэн бид нар сонсгол явуулах зайлшгүй шаардлагатай гэж үзэж байгаа. Өнөөдөр ордны гадаа суулт хийж байсан иргэдтэй хүлээж авч уулзсан.

Тэд нар маань өлсгөлөнгөө зогсоосон байгаа. Тэгээд сар болгоны тодорхой нэг өдөр Улсын Их Хурлын Хүний эрхийн дэд хорооноос хүний эрхийн өдөр болгоод иргэдийг сард нэг өдөр ордонд нээлттэйгээр яг энэ асуудлыг хэлэлцдэг байхаар ярьж байгаа. Миний асуулт бол эрүүдэн шүүсэн, шүүлгэсэн ч гэх юм уу даа. Ийм хохирогчийн гэр бүл ер нь эрүү шүүлт хүний эрхийн зөрчилтэй холбоотой асуудлыг бид нар тэр болгон ярихгүй тойроод байдаг нэг зүйл бол Монгол Улсад бүүр онцгой тохиолдлоор олон дахин давтагддаг зүйл нь төрийн өндөр албан тушаалтан.

Нөлөө бүхий улс төрчдийн захиалгаар энэ зүйл хийгддэг. Хэн нэгэн хүнийг хэрэгтэн болгоё гэх юм бол түүнийг нь ямар нэгэн байдлаар хэрэгжүүлдэг. Ийм бүтцийн тухай маш олон жил бид нар ярьж ирсэн. Энэ дээр тодорхойлж аль нэгэн байгууллага юм уу хувь хүн гэхээсээ илүүтэйгээр шулуухан хэлэхэд хэдий ардчилсан хүмүүнлэг иргэний ардчилсан нийгмийг цогцлоон хөгжүүлэхийг эрхэм зорилгоо болгоно гэж бид нар ярьдаг. Маш олон хурал цуглаан, симпозиум, олон улсын хөрөнгө оруулалттай зүйлүүд хийдэг ч гэсэн бодитоороо байсаар байгаа зүйл нь энэ шүүх засаглал хуулийг хэлбэрэлтгүй хэрэгжүүлэх ёстой байгууллагуудад нөлөө бүхий улс төрчдийн оролцоо хэн Монгол Улсад хэрэгтэн байх вэ? гэдэг асуудлыг шийддэг зүйл байсаар ирсэн гэж үздэг.

Үүний хамгийн энгийн жишээ бол хэн нэгэн хүнийг гэмт хэрэг хийсэн мэтээр хэвлэл мэдээллээр нүддэг компани ажил өрнөдөг. Нийгмийн сэтгэл зүйг залуурдаад тэр хүнийг бараг өөрөө өөртөө эргэлзэхээр түвшинд хүргэж байгаад араас нь нийгмийн сэтгэл зүйг дагуулж ялладаг нийгмээрээ алга ташдаг. Энэ үнэхээр ийм болчихсон юм байна гэж хэвлэл мэдээллийг тодорхой зорилгоор худалдан авдаг нөлөөлдөг ийм зүйл байгаад байгаа юм. Тэгэхээр энэ өнөөдрийн нээлттэй сонсгол дээр би прокуророос Хууль зүйн сайдаас Авлигатай тэмцэх газар, тагнуул ирээгүй юм шиг байна. Нэг асуулт асуух гэж байгаа юм.

Энэ нээлттэй сонсгол учраас Та бүхний үйл ажиллагаанд Та бүхэн хариуцлагатайгаар хариулах байх гэж бодож байгаа. Ямар нэгэн улс төрч Монгол Улсын төрийн өндөр албан тушаалтан тодорхой хэргийг зорилготойгоор чиглүүлэх, залуурдах, хэргийн үйл явцад чиглэл өгөх шүүхэд тухайн субъектийг шалгагдаж байгаа субъектийг ч юм уу, яллаарай тэгж яллаарай гэдэг чиглэл өгдөг зүйл байна уу? үгүй юу? гэдгийг би зүгээр асууя. Мэдээж Та нар үгүй гэж хариулна л даа. Ойлгомжтой тэгэхдээ цаг хугацаа үнэний шалгуур байдаг. Та бүхэнд ямар нэгэн улс төрч төрийн өндөр албан тушаалтан чиглэл өгдөг үү гэж асууя.

Сонсгол даргалагч П.Сайнзориг - Асуултанд 15 уу? С.Эрдэнэболд гишүүн хэнээс асуусан нэг минут өгөөдхөөч. Яг асуултаа гүйцээгээд Яг тодорхой нэр аль байгууллагаас асууж байгаагаа хэлмээр байна.

Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд - Хууль зүй байнгын хорооны дарга Дамдины Цогтбаатар гишүүн Монгол Улсын хамгийн том мега төсөл бол ардчилал өөрөө гэсэн ийм ярилцлага өгсөн байгаа юм бид нар энэ ардчилал гэдэг нь хүний эрх, эрх чөлөөний тухай асуулт байхгүй юу. Өнөөдөр ямар асуулт асууж байна гэхээр прокуророос, Авлигатай тэмцэх газраас, Хууль зүйн сайдаас асууж байна. Тагнуул болон бусад байгууллага байвал уг нь сайн байна. Мэдээж та бүхнийг юу гэж хариулахыг мэдэж байгаа. Гэхдээ яг одоо бид нар хожим үнэний шүүлтүүр дээр цаг хугацааны ирмэг дээр өнөөдрийн энэ протокол дээр хариултыг чинь үлдээе гэж хүсэж байгаа юм. Та бүхэнд монголын томоохон улс төрчид төрийн өндөр албан тушаалтан тодорхой хэргийн шийдвэртэй холбогдвол чиглэл өгдөг үү? гэсэн асуулт байгаа.

Сонсгол даргалагч П.Сайнзориг - Прокуророос эхлээд хариулья. Прокурор,

цагдаагийн байгууллага, Авлигатай тэмцэх газар, шүүхийн шийдвэрийнхэн байж байх шиг байна. Хууль зүй, дотоод хэргийн сайд ч бас хариулах ёстой юм байна. О.Алтангэрэл сайдын микрофоныг өгөөд явчихъя.

Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл - Хууль зүй, дотоод хэргийн сайдын үүрэгт ажлыг авснаас хойш мөрдөн шалгах ажиллагаанд хөндлөнгөөс нөлөөлөх гэсэн ямарваа нэгэн улс төрийн албан тушаалтан субъектээс ийм хандлага гараагүй. Гэхдээ ямар нэг төрийн өндөр албан тушаалтны зүгээс хууль бус нөлөөлөл гарах юм бол Хууль зүй, дотоод хэргийн сайдын хувьд асуудалтай эвлэрэхгүй олон нийтэд бас мэдээлнэ гэдгээ хэлье.

Сонсгол даргалагч П.Сайнзориг –14 номер.

Улсын ерөнхий прокурорын, туслах прокурор О.Мөнхбаатар - Улсын ерөнхий прокурорын туслах прокурор О.Мөнхбаатар Прокурорын тухай хуульд прокурор үйл ажиллагаандаа баримтлах 5 зарчмыг тодорхойлсон. Үүний нэг нь прокурор хараат бусаар бие даан хэрэг маргааныг шийдвэрлэх зарчимтай. Энэ зарчмыг хэрэгт хяналт тавьж байгаа прокуророос эхлүүлээд дээд шатны прокурор хүртэл бүгд үйл ажиллагаандаа баримтлах зарчимтай. Тэгэхээр дээд шатны прокурор ч хүртэл доод шатны хяналтын прокурорынхоо шийдвэрт нөлөөлөх тийм бол байхгүй. Тэгэхээр зарчмаа хэрэгжүүлээд ажиллаж байгаа гэдгийг хэлье.

Сонсгол даргалагч П.Сайнзориг - Авлигатай тэмцэх газар урагшаа микрофондоо суучихъя.

Авлигатай тэмцэх газрын дэд дарга, эрхэлсэн комиссар Г.Азжаргал - Тийм зүйл байхгүй.

Сонсгол даргалагч П.Сайнзориг - Цагдаагийн ерөнхий газар 7 номер.

Цагдаагийн ерөнхий газрын Мөрдөн байцаах албаны дарга, хурандаа П.Очбадрах - П.Очбадрах бид хэрэг зөрчил шалгаж шийдвэрлэх ажиллагааг хуульд заасан үндэслэлийн журмын дагуу явуулдаг. Энэ процессын ажиллагаа бол бүгд прокурорын байгууллагын хяналтад явагдаж байгаа. Өнөөдрийн байдлаар цагдаагийн байгууллагын хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт болон зөрчил хянан шийдвэрлэх ажиллагаанд төрийн өндөр албан тушаалтнаас нөлөөлж байгаа шийдвэрт нөлөөлөх үүрэг чиглэл өгсөн асуудал бол байхгүй хариулж дууслаа.

Сонсгол даргалагч П.Сайнзориг - Би бас хурал удирдаж байгаа гишүүн ч гэсэн тодорхой хэдэн зүйлүүдийг төрийн байгууллагын төлөөлөл болон оролцогчдоос бас асууя гэж бодож байна. Энэ салбарт ажиллаж байсан үе үеийн яриа хөөрөө гардаг. Үүнийг телефон жастис гэж ярьж байгаа юм. Утсаар цохох буюу сая С.Эрдэнэболд гишүүн хэлээд байна. Энэнээсээ би цаашаа халиад ерөнхийдөө аливаа гэмт хэрэгт холбогдсон хүмүүсүүдийг хэд хэдэн шатаар ч гэдэг юм уу эцсийн шатаар яваад нэг бол цагаадсан нэг бол зохих хэмжээний хариуцлагаа хүлээж байгаа хүмүүсийг урьдчилсан сошиал медиа жастис буюу сошиалаар яллах гэдэг нэг ийм асуудал байна. Үүнийг бас би хэд хэдэн эрүү шүүлтэд тулгарсан хүмүүсийн ар гэртэй уулзаж байхад мэдэрсэн. Өөрөөр хэлбэл, тэр нотлох баримтууд гэдэг юм уу тодорхой хэргийн үйл баримтууд дээр авагдаж байсан баримтуудыг ерөнхийдөө нийгэмд цацчихсан байдаг.

Хэдийгээр бид цагаадсан ч гэсэн энэ асуудлыг хэзээ ч арилахгүйгээр, гэр бүл, үр хүүхдээрээ давхар хохироод явдаг энэ үзэгдэл байсаар байна. Үүнийг хэрхэн яаж анхаарах ёстой юм бэ гэдэг олон асуудлуудыг тавьж байсан. Тэгэхээр энэ дээр

бодлогын түвшинд бид яаж шийдэх ёстой юм бэ? гэдэг зүйл дээр бас хариултыг өгөөч. 2 дугаарт, эрүү шүүлт хэлмэгдүүлэлттэй тэмцэх үндэсний холбоо гэж байгуулагдсан юм байна. Энэ 47 хүмүүс ямар нэгэн байдлаар эрүү шүүлтэд тулгамдсан гэдэг ийм ноцтой баримтыг Хууль зүй байнгын хорооны дарга Д.Цогтбаатар даргын нэр дээр ирүүлсэн. Тэгэхээр энэ сая хүн Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Б.Энхболд ч гэсэн тодорхой анхаарч авч үзэх ёстой гээд байгаа юм.

Тэгэхээр би энэ байгууллагын тэргүүн. Яг одоогийн нөхцөл байдал дээр энэ 47 хүн шүүхийн 3 шатаар шийдэгдээд цагаадчихсан ямар нэгэн байдлаар эрүү шүүлтэд, эсвэл хохирсон гэдэг нь шүүхээр шийдэгдчихсэн ийм 47 хүний кэйс байгаа юу? гэдэг зүйлийг нэг тодруулж би зүгээр хэлмээр байна. Үүний цаана та хэдийн нөхөн олговор авах асуудал ч гэдэг юм уу? ямар байдлаасаа болоод энэ удаашраад зарим түрүүн А.Ганхуяг гээд хүн хэлж байх шиг байна 9 жил яваад чадахгүй байна. Түрүүчээсээ маш олон жил явсан ч гэсэн иргэний шүүх нь янз бүрийн хууль заагаагүй үндэслэлээр нэхэмжлэлийг авахгүй байдалтай ч гэдэг юм уу? иргэдийг хохироогоод байна гэдэг зүйл яригдаж байна. Тэгэхээр энэ дээр танай байгууллагын эрх юу гэдэг юм? Энд нэгдсэн иргэдийн нийтлэг эрх ашгууд юм уу? хөндөгдөж байгаа зүйлүүд дээр очиж гацаад байна гэдэг зүйлийг товч тодорхой нэг асуултыг хариулж өгөөч.

Хууль зүй, дотоод хэргийн сайдаас хэд хэдэн асуулт байна. Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын хуулийг өргөн бариад сая парламент шинээр бүрдсэнтэй холбоотойгоор дэгийн тухай хуулийн дагуу Засгийн газарт буцаасан үүнийг маш хурдтайгаар буцаагаад оруулаад ирээч гэдэг зүйлийг ярьж байгаа. Энэ хэзээ орж ирэх вэ? 2 дугаарт, Гэр бүлийн тухай хууль байгаа. Энэ Гэр бүлийн тухай хуулийг асрамжит гэр бүл ч гэдэг юм уу? хүүхэд дагасан аливаа эрх зүйн үйлдлүүдийг шүүхээр шийдвэрлүүлье гэж байгаа юм. Үрчлэлтээсээ эхлээд байж байгаарай. Би асуултаа яриад дуусаагүй байна. Түрүүн маш ноцтой мэдээллийг Х.Баасанжаргал гишүүн асуулаа. Асрамжийн газар байгаа хүүхдүүдийг асрамжийн газрын дарга нь дур мэдэн шавилан суулгуулж байна. Үнэхээр энэ хүсэл зоригийн ийм асуудал байгаа бол магадгүй төрийн байгууллагуудын холбогдох дүгнэлт өөрийнх нь хүсэлт ч байдаг юм уу? шүүхээр эцэслэн шийдэх гэдэг юм уу? маш том үүний цаана янз бүрийн байдлаар эрүү шүүлт тулгах хүчээр гэдэг юм уу? дур зоргын асуудал гарч байхыг үгүйсгэхгүй. Тэгэхээр Гэр бүлийн тухай хуулийг хэзээ оруулж ирэх гэж байна вэ? 2 дугаарт, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зөвхөн асуудал биш. Энэ өөрөө эргээд бүх шатанд яригддаг зүйл нотлох баримтыг цуглуулахаасаа эхлээд л алдаа гарвал аль ч иргэн болон ч тэр захиргаа ч тэр, эрүүгийн хэрэг ч гэсэн ингээд буруу замаараа будаа тээдэг.

Бид цаашдаа нотлох баримтын тухай бие даасан хуультай болбол яах вэ? гэдэг бодлогыг Хууль зүй, дотоод хэргийн яамны одоогийн удирдлага ямар байр суурьтай байгаа вэ? Дахиад нэг асуулт байна. Шүүх шинжилгээний асуудал маш том бүтэц. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцыг түргэтгэе. Энд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хүний эрхийг зөрчихгүй байя. Эрүү шүүлт явахгүй гэвэл хэрэгт авагдсан цуглуулагдсан нотлох баримтуудыг маш хурдтай шинжлэх ухааны ололттойгоор шинжлэн магадалж дүгнэлтээ гаргах ёстой. Энэ асуудал нь шүүх шинжилгээний байгууллага дээр очоод тоног төхөөрөмж болон хүний нөөцөөсөө гацдаг. Энэ дээр үндсэндээ Засгийн газар цаашдаа ямар арга хэмжээ авах бодлого байгаа вэ? Ирэх жилийн төсөв дээр шүүх шинжилгээний байгууллагуудыг өндөр хүчин чадалтай лабораториор хангах асуудал байгаа юу? Ингэж байж энэ дээрээс хүн хэлмэгдэхгүй байх нэг талдаа хурдан гарна. Үнэхээр зарим хүмүүс чинь буруутай бол шүүхээрээ хурдан шилжүүлээд өгөөч гэдэг хүртэл өргөдлийг өгч байгаа шүү дээ.

Хүнийг залхаан цээрлүүлж байгаа юм шиг маш удаанаар явдаг. Энэ нь өөрөө эргээд нотлох баримтын хэмжээнд асуудлууд нь шүүх шинжилгээний байгууллага гаргаж өгч чадахгүй байна гэдэг зүйл бас байгаа. Тэгэхээр энэ дээр ямар байр суурь байна вэ? гэдэг зүйлийг асууж байгаа юм. Эцэст нь би бас асуумаар байна. Сэтгэцийн эрүүл мэндийн Үндэсний төвд хэвтэн эмчлүүлдэг байнгын асаргаанд байдаг нэлээн олон хүмүүсийн асуудал эрх зүйн байдал маш тодорхойгүй ар гэрээсээ орхигдчихсон хамаатан садан гэж байдаггүй. Үүн дээр Төрийн бодлогыг цаашдаа яаж авч явах вэ? гэдэг дээр Засгийн газрын байр суурь ямар байна вэ? Энэ дээр Улсын ерөнхий прокурор Хүний эрхийн комиссоос хийж байгаа үе шатны ажлууд юу байгаа вэ? Цаашдаа яаж анхаарах вэ? Энэ дээр ялангуяа Эрүүл мэндийн яам ямар байр суурьтай байгаа юм бэ? Тэгэхээр эдгээр иргэдийг зөнд нь хаяж болохгүй. Энэнээсээ гадна цаад хүмүүс чинь бусад эрхүүд нь зөрчигдөж байна. Сурч боловсрох болоод нийгмийн халамжийн эрхүүд нь үнэхээр зөрчигддөг юм байна. Дөнгөж найм аравны нэгхэн хувь нь өөрийнхөө халамжийн мөнгийг зарцуулдаг бусад бүх халамжийг нь хэний гараар юм уу орж байгаа нь мэдэгдэхгүйгээр захиран зарцуулагддаг ийм үзэгдэл байдаг юм байна. Тэгэхээр үүнийг тодорхой хэлээд өгөөч гэж бодож байгаа юм. О.Алтангэрэл сайдаас эхлээд асуултанд хариулчихья.

Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл - Шүгэл үлээгч эрх зүйн байдлын тухай хуулийг өргөн барина. Ер нь барихаас ч арга байхгүй 5Ш ажиллагаа Монгол Улсын Засгийн газар зарлаад чамгүй хугацаа өнгөрлөө. Тэгэхдээ 1 зүйлийг бид нар ер нь анхаарах ёстой гэж бодож байгаа. Мөнхийн үргэлжилдэг ажиллагаа гэж байхгүй үр дүнд хүрээд ажиллагаа дуусах ёстой шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийг батлуулаад бид нар ер нь энэ шүгэл ажиллагаа дууслаа эрх зүйн орчин бүрдлээ цаашаагаа хэвийн үргэлжилнэ гээд зарлах нь зөв байх гэж урьдчилж бодож байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нотлох баримтын асуудал чухал. Бид нарын хамгийн том зовлон бол нэг данхар хуультай маш жижигхэн процесстой нэг ийм л зүйл байгаад байна. Тэгэхээр энэ процесс хуулийг процессжуулах нэн ялангуяа эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг процессжуулах ажиллагааны цөмд бид нар энэ нотлох баримтын тухай хууль асуудал гэж үзэж байгаа. Тэгэхдээ одоогоор бол бие даасан хуулийн тухай асуудал бол яригдаагүй байна. Энэ шүүх шинжилгээ шинжлэн магадлах асуудал маш чухал. Бид нар бол ирэх жилийн төсөвт яах вэ нэг зарим төрлийн урвалж бодис шүүх шинжилгээний байгууллагын үйл ажиллагаанд шаардлагатай багавтар зүйл нэмсэн. Ер нь бол байрлах байрнаас авхуулаад хэцүү байна. Аз болж Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газрын тусламжаар өнөөдөр ДНК гэдэг ч юм уу хэдэн лабораториуд ашиглалтад орж сүүлийн жилүүдэд үнэхээр 5 жилийн байдлаар шүүх шинжилгээний байгууллага нэн ялангуяа сүүлийн 4 жилд нэлээн сайн бэхэжсэн байна.

Тэгэхдээ энэ бол монгол төрийн гэхээсээ илүүгээр тухайн үеийн дарга удирдлагуудынх нь санаачилга төсөл хэрэгжүүлж байгаа гаднын байгууллагуудын төсвөөр болсон зүйл. Тэгээд ирэх жилийн төсөвт бол яг хангалттай сайн тусаагүй. Одоо урвалж бодис үйл ажиллагааны зардал нэлээн том зүйл тусгачихсан байсан одоо хасагдчихсан байгаа. Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв дээр бүх эрх нь зөрчигддөг нь үнэн. Бид онцгой анхаарал хандуулж ажилласан тэгээд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авхуулчихсан гэмт хэрэг үйлдчихсэн гээд ядаж хугацаа нь дуусаад гарахад ар гэр нь хүлээж авдаггүй, очих газар байдаггүй, бүх эрх нь зөрчигдөж байгаа ийм байдал байгаа.

Сонсгол даргалагч П.Сайнзориг - О.Алтангэрэл сайдад нэг минут Гэр бүлийн тухай хуулиа тодорхой бодлогын хувьд хэлэх нь зүйтэй.

Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл - Тэгээд шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг бид нар шинэчилсэн найруулга хийгээд ажлын хэсэг гарчихсан явж байгаа. Энэ дээр бол иргэн болоод Захиргааны хэргийн шийдвэр гүйцэтгэл нөгөө талд эрүүгийн ял ялын шийдвэр гүйцэтгэл.

Бид нар эрүүгийн шүүхийн шийдвэрийн шийдвэрийг гүйцэтгэх асуудал ярьж байгаа. Энэ хүрээнд бид нар зайлшгүй боловсронгуй болгох ёстой Сэтгэцийн эрүүл мэндийн Үндэсний төвийн асуудал байна гэж үзээд байгаа юм. Одоо энд тавьсан төсөв мөнгө нь хангалтгүй шийдвэр гүйцэтгэх байгууллага нь урд хормойгоороо хойд хормойгоо нөхөөд л аргалаад л яваад байдаг. Бид нар үүнийг эрх зүйн үндсийг нь тодорхой болгоод яг эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ юм бол ямар шат дараалалтай байх юм. Хэзээ нь гаргах юм. Албадлагын арга хэмжээ юм бол хорих ялтай адилхан. Энэ дээр нийгэмшүүлэх ажил зохиогдох юм уу үгүй юу? Эмчилгээ үйлчилгээтэй нь холбоотой бусад байгууллагууд ямар эрх үүрэгтэй байх юм бэ? гэдгийг нарийвчлах шаардлагатай гэж үзэж байгаа. Гэр бүлийн тухай хуультай холбоотой зүйл Н.Мягмар даргаар нэг минут яриулъя.

Сонсгол даргалагч П.Сайнзориг - Н.Мягмар Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, дараа нь Л.Мөнхзул дарга, П.Очирбат дарга нар бэлдэж байгаарай.

Хууль зүй, дотоод хэргийн Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар - П.Сайнзориг гишүүний асуултад тодруулж хариулья. Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга өнгөрсөн парламентын үед өргөн мэдүүлж хэлэлцэх эсэх нь шийдэгдсэн явж байгаад буцаагдсан. Засгийн газрын шинэ бүтцээр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам байгуулагдсантай холбоотойгоор Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яамтайгаа ярьж байгаад Гэр бүлийн тухай хуульд байгаа бүтцийг 2 салгая гэж ярьж тохирсон. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас гэр бүлийн хөгжил хамгаалал талаасаа тусдаа хууль болгож эндээ орчихсон явсан зохицуулалтаа салгаж авч явъя гэсэн ийм саналыг тавьсан учраас үүнийг Хууль зүй, дотоод хэргийн яам дэмжиж үзэл баримтлалууд нь ирэхээр бид нар асуудлыг шийдээд гэр бүлийн тухай хууль дээр үлдэж байгаа. Бид нар энэ үзэл баримтлалаа шинэчилж баталж хаврын чуулганаар өргөн мэдүүлэхээр төлөвлөж байна.

Сонсгол даргалагч П.Сайнзориг - Өргөн барих нь гарцаагүй. Хүүхдийн асуудал үрчлэл жишээ нь шүүхээр явах уу эсвэл Засаг даргаар явах уу? энд асрамжийн газар байгаа хүүхдийн эрх зүйн байдлыг шүүхээр явах уу? эсвэл асрамжийн газрын дарга шийдээд байх юм уу? гэдэг л асуултын хариултыг авах гэж байсан юм. П.Очирбат дарга дараа нь Л.Мөнхзул дарга, П.Очирбат дарга хэддүгээр микрофон байх шиг байна 10 байна. 10 номерын микрофоныг өгье.

Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Очирбат - Эрхэм гишүүн П.Сайнзориг гишүүний асуултад хариулья. Өнөөдөр илтгэлдээ дурдсан Сэтгэцийн эрүүл мэндийн Үндэсний төв дээр маш олон асуудлууд байна. Тэгээд өнөөдрийн энэ хүний эрх, эрх чөлөө, хүний эрхийн үндсэн ёс зүйн асуудлуудын доголдол, дордож байгаа асуудлууд, эрх зөрчигдөж байгаа асуудлууд давхар яригдаж байгаа. Үүний нэг нь Сэтгэцийн эрүүл мэндийн Үндэсний төв дээр болж байгаа асуудлууд байгаа. Тэгэхээр О.Алтангэрэл гишүүн сайд маш сайн ойлголттой байдаг юм байна. Би бас талархаж байна. Яагаад гэвэл манай энэ Сэтгэцийн эрүүл мэндийн Үндэсний төв хуучнаасаа л 60 жил, 100 жилдээ энэ нэг шар хадны эмнэлэг нэртэй гээд л яг энэ асуудлыг хөндөж ирсэн. Одоо Шар хаданд тэр хүмүүсээ аваачаад хаячихдаг сэтгэцийн эрүүл мэндийн өвчтэй улсууд нь маш удаан жил эдгэдэггүй. Тэнд бүр 36 жил болсон хүн тэнд байна.

Сонсгол даргалагч П.Сайнзориг - Нэг минутыг нэмээд өгчихье. Бас чухал асуудлууд олон нийт мэдэх эрхээ хангагдах ёстой гэж бодож байгаа учраас өгье.

Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Очирбат - Тэгээд энд 244 хүний асуудал байдаг. Тэр шүүхийн шийдвэр албадан гүйцэтгүүлж байгаа 33 хүн байдаг. Тэгэхээр энэ эмнэлгийн байгууллага бол эмчлэн сувилах, эмчлэх эрхээ л хэрэгжүүлж байх ёстой. Одоо 640 ортой боловч 244 хүнийг эмчлэхийн зэрэгцээгээр урт хугацааны хугацаанд асарч байгаа асрах нэртэй боловч манай дээр асаргааны зардал гэж тавигддаггүй. Энэ 33 гэмт хэрэг үйлдсэн улсууд дотор 244 хүнтэйгээ зэрэгцэж байгаа. Гэмт хэрэг хийсэн улсууд саяхан тасаг дотроос нь нэг нэгнийхээ амийг бүрэлгэсэн асуудлууд өнгөрсөн хугацаанд гарсан. Энэ улсуудыг эрүүл мэндийн салбартаа эмчилж байгаа энэ цагт албадан эмчилж байгаа болохоос албадан саатуулж байгаа асуудал биш учраас ялгаж салгаж харах асуудал хууль зүйн хүрээнд, эрх зүйн хүрээнд зохицуулах.

Сонсгол даргалагч П.Сайнзориг - Л.Мөнхзул дарга хэдэн номер вэ? 9 номер, дараа нь 12 номер Б. Энхболд

Цагдаагийн ерөнхий газрын дэд дарга, цагдаагийн хурандаа Н.Мөнхзул - Гишүүний асуултад 2 хүрээнд хариулья. 1 дүгээрт, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргын хэлсэнчлэн Гэр бүлийн тухай хуулийг ялгаатай байдлаар оруулахаар манай яамдаас санал солилцоод дэмжигдээд харилцан санал солилцсон байгаа. Засгийн газрын хуралдаанаар эцэслэн шийдвэрлэгдэх байх. Үндсэн рүүгээ нийтийн эрх зүй, хувийн эрх зүй, хоёроо ялгаад илүү хувийн эрх зүйн нэн тулгамдсан асуудлаа түлхүү шийдээд явъя гэдэг ийм байр суурьтай байна. 2 дугаарт Сэтгэцийн эрүүл мэндийн Үндэсний төвд насанд хүрэгчдээс гадна хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн маш хүнд асуудлууд байгаа. Тэгээд үүнийг Эрүүл мэндийн яам манай яам 2 аль аль талдаа хүч хомсддог. Эрүүл мэндийн эмч нарын эмчилгээ шаардлагатай байдаг. Гэхдээ тэр хүмүүст хөгжих оролцох, хүний эрхийг нь хангах өөр нөхцөлүүд шаардлагатай байгаа. Хөрөнгө оруулалтын асуудал хэрэгтэй байгаа.

Сонсгол даргалагч П.Сайнзориг - 12 номер Б.Энхболд дараа нь 4 номер байх шиг байна.

Хүний эрхийн комиссын гишүүн Б.Энхболд - Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Б.Энхболд. Сэтгэцийн эрүүл мэндийн Үндэсний төвтэй холбоотой асуудлыг Хүний эрхийн Үндэсний Комисс нийтдээ 4 удаа авч илтгэлдээ оруулсан байдаг. Энэ дээр нэг асуудлыг байнга яригддаг сэтгэцийн эмгэгтэй хүний асрамжийн газрыг байгуулж өгөөч гэдэг. Энэ асуудлыг байгуулснаараа 36 жил эмчлэгдэж байгаа хүн ар гэр нь орхигдчихсон мөн Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяанд байдаг зарим асрамжийн газрын сэтгэцийн эмгэгтэй хүмүүсийг харах тогтолцоог бүрдүүлэхгүй бол өнөөдөр бүх насаар хорих ялтай ижилхэн тэнд олон тооны хэсэг бүлэг хүмүүс ийм тодорхойгүй байдлаар хоригдсон байдалтай байгааг тогтолцооны хувьд заавал шийдэх ёстой үзэж байгаа. Тэгээд энэ чиглэл дээр өнгөрсөн жил багц хуульд тодорхой саналуудыг оруулсан. Хууль зүй, дотоод хэргийн яам өргөн барих байх гэж найдаж байгаа.

Сонсгол даргалагч П.Сайнзориг - 4 номер Та өөрийгөө танилцуул. 47 иргэн ямар байдлаар нэгдээд энэ асуудалд хандаж байгаа вэ? Хүний эрхийн Үндэсний Комисс эдгээр хүмүүсийн асуудлыг нэг нарийвчлан судлах ёстой гэдэг агуулгатай бичгийг Хууль зүйн байнгын хорооны даргын нэр дээр ирүүлээд байгаа учраас би тодруулж асууж байгаа юм.

“Эрүүдэн шүүлт хэлмэгдүүлэлттэй тэмцэх үндэсний холбоо” Төрийн бус байгууллагын удирдах зөвлөлийн дарга Д.Цогтбаатар - Эрүүдэн шүүлт хэлмэгдүүлэлттэй тэмцэх үндэсний холбоо Төрийн бус байгууллагын удирдах зөвлөлийн дарга Д.Цогтбаатар асуултад хариулж байна. Манай байгууллагад 2012-2015 оны хооронд тодорхой улс төрчдийн хувийн ашиг сонирхол бусад улс төрийн явцуу ашиг сонирхлын үүднээс хуулиас гадуур хэлмэгдчихсэн гэсэн гомдолтой ямар нэгэн байдлаар хохирсон 47 хүн эвлэлдэн нэгдээд байна. Энэ хүмүүсийн 60% нь 3 шатны шүүхээр шийтгэгдсэн. Гэхдээ ихээхэн гомдолтой, юу байна гэхээр гэрч шинжээчийн мэдүүлгийг хуурамчаар авсан, хууль бусаар нотлох баримт бүрдүүлсэн ямар нэгэн байдлаар нөхцлийн болон бусад байдлаар эрүүдэн шүүгдсэн. Тийм учраас би хилсээр ял шийтгэл шийтгүүлчихлээ гэсэн. Ийм иргэд үлдсэн одоо 2 категори болсон. Нэг нь болохоор ямар нэгэн байдлаар ял шийтгэл шийтгүүлээгүй боловч тодорхой хугацаагаар цагдан хоригдох буюу бусад байдлаар таслан сэргийлэх арга хэмжээ авагдаад бусад байдлаар хохирсон улсууд үлдсэн.

Гуравдахь хүмүүс болохоор шүүхээр цагаатгагдсан боловч нөхөн олговроо авч чадахгүй байгаа хүмүүс байгаа юм. Дашрамд өөрсдийн Төрийн бус байгууллагаас үндсэн саналаа тавьчихъя. Энэ асуудлыг шийдвэрлэхэд хуулийн болон зохион байгуулалтын янз бүрийн бэрхшээл тулгарч байна. Үүнийг шийдэхийн тулд хяналтын сонсголоос гарах шийдвэрт Улсын Их Хурлаас асуудлыг дахин нягтлах чиг үүрэг бүхий тийм боломж бүхий ажлын хэсгийг байгуулаад өгөөч. Шаардлагатай бол дахиад энэ асуудлаар тусгайлсан сонсгол зохион байгуулаад өгвөл энэ 47-гоор тогтохгүй Монгол Улсын иргэд тийм зөрчигдсөн эрхийг сэргээхэд онц чухал ач холбогдолтой асуудал болох юм байна гэсэн ийм саналыг дэвшүүлж байна. Та бүхэн бас хэлэлцэж шийдвэрлэж энэ хяналтын сонсголын шийдвэрт тусгаж өгнө үү гэсэн саналыг энэ дашрамд гаргаж байна.

Сонсгол даргалагч П.Сайнзориг - Би түрүүн бас цаг дуусаад ирсэн. Би уг нь хэлэх үгэндээ тэгээд хэлье. Ер нь Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ конвенцын нэр томъёо агуулгыг бас нэг зөвтгөх асуудал угаасаа зөвхөн эрүү шүүлттэй холбоотой конвенц биш маш олон конвенц дээр яригддаг орчуулга нь төөрөгдүүлэх байдлаар. Бид энэ ойлголтоо нэгтгэж чаддаггүй ийм зүйлүүд байдгийг бид анхаарах ёстой дээрээс нь тэр С.Шаарийбуу гуайн хэлж байгаа саналтай би 100% санал нэг байна.

Өнөөдөр Монгол Улсын иргэд гадагшаа олноороо зорчиж байгаа энэ үед маш олон иргэдийн эрх зөрчигдөх байдал байгаа боловч өнөөдөр Засгийн газрын тусгай сан гадаадад байгаа иргэдэд туслах санч жилдээ зургаан зуухан сая төгрөгтэй 600 сая төгрөгөөр нь тэнд эрх ашиг нь зөрчигдөж байгаа хүмүүсийн өмгөөлөгч авах байтугай орчуулгын зардлыг нь ч дийлж чаддаггүй. Ийм зүйлийг төсөв дээрээ бид тавьчихаад Монгол Улсын иргэдийнхээ эрх ашгийг хамгаална гээд явж байгааг Засгийн газар цаашдаа анхаарч яг шаардлагатай тэр төсөв хөрөнгийг нь тавьж өгөөч. Ер нь эрх зүйн харилцан туслалцааны гэрээнүүдийг идэвхжүүлэх чиглэлдээ бас анхаараач гэдэг зүйлийг би бас мөн Засгийн газраас асууя гэж бодсон. Нэгэнт цаг байгаа учраас зүйлийг энэ дашрамд хэлээд явчихъя. За ингээд Улсын Их Хурлын гишүүдээс асуулт асууж дууслаа. Монгол Улсын Их Хурлын дэгийн тухай хуульд заасны дагуу Дэгийн тухай хууль болон дэгийн тухай хуулийн 126.1.5-д заасны дагуу асуулт асууж дууссан. Одоо гишүүдээс бид нар үг хэлэх гишүүдийн нэрийг авъя. Үг хэлэх гишүүд нэрсээ өгье. Баярлалаа. Ж.Баярмаа гишүүнээр тасалж байна. Дамдины Цогтбаатар гишүүн микрофоныг нь өгье.

Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар - Өнөөдөр энэ арга хэмжээ болж байгаа манай иргэний нийгэм ийм идэвхтэй оролцож байгаад би маш их баяртай

байна хүний эрхийн асуудлыг саяхан ярьдаггүй байсан шүү. Ярихлаар би хүний эрх хамгаалагчийн хуулийг оруулж ирэхэд энд иргэний нийгмийн маш олон төлөөлөл намайг дэмжээд оруулж ирж байсан. Яг энэ зааланд элэглээд хөөгөөд наадхаа буцааж татаж ав Монгол Улс шиг хүний эрх нь бүрэн хангагдсан эрх чөлөөтэй улс байхгүй гээд сонины тэргүүн нүүрэнд ярилцлагууд хүмүүс өгөөд намайг яг тэнд одоо цохиж авах гээд л зогсож байсан үе бий. Энэ бол яг саяхан.

Одоо бол ордон дотор үүнийг ярьдаг болжээ. Энэ юу гэсэн үг вэ гэхээр энэ сэтгэлгээ хандлагын маш том өөрчлөлт гарч байгаа юм. Тэгээд та бүгдийн түрүүн хэлээд байдаг үнэн энд гол бид нарыг энд суулгаж мандат өгч оруулж ирсэн хүн чинь та нар энэ ордон чинь та нарын ордон байхгүй юу. Ямар сайндаа л одоо энд орж ирэхэд хувцасны код тавьчихсан сонгогдох болохлоороо өөрсдөө ямар ч хувцастай байсан хамаагүй очоод саналаа өгөөч гэххээд дараа нь хүрч ирээд ордонд нь уулзах гэхлээр төрийн ордноо хүндэтгэхгүй байна уу? та жинстэй орж ирж болохгүй эд нар гээд би залуу оюутан байхдаа ганц жинснээс өөр өмдгүй явж байсан үе зөндөө бий шүү дээ. Тэгээд хүнд саналаа өгчихсөн ороод ирэх гэсэн чинь өөр хувцас өмсөж ир гээд гишүүнтэйгээ уулзаж болохгүй байсан ийм үе бий. Их энгийн асуудал юм шиг боловч энэ маш том хандлагын асуудал байхгүй юу.

Тэгээд би энэ дээр юу хэлмээр байна гэхээр Улсын Их Хурлын гишүүд манай байнгын хороо бол энэ дээр анхаарч ажиллаж байгаа цаашдаа ч анхаарч ажиллана. Би бол эхнээс нь энэ зун тэр 461 дээр гарсан хүүхдийн асуудал гарахад л юу хүний эрхийн дэд хороог яаралтай хуралдуул гээд Улсын Их Хурлын удирдлагатай яриад Улсын Их Хурлын удирдлага дэмжээд тэр хурлыг нь хийлгэсэн тэндээс энэ сонсголыг хийнэ гэдэг шийдвэр гарсан бид нар бүгдийг нь дэмжээд хийлгэж байгаа юм. Гэхдээ би иргэддээ хандаад нэг зүйлийг хэлмээр байна. Юу гэвэл хүний эрхийн баталгаа бол чөлөөтэй иргэд өөрсдөө шүү. Яагаад гэвэл одоо энд сууж байгаа гишүүд 4 жилийн дараа хэд нь ч байх вэ, хэд нь байхгүй, дандаа байхгүй байхгүй юу. Иргэд бол дандаа байж байна ард иргэд тэгэхээр үгээ хэлж чаддаг байх та нарын тэр үгээ хэлэх эрх чөлөө чинь баталгаатай хамгаалагдсан байх шаардлагаа тавьж чаддаг байх.

Өнөөдөр цагт нь ирүүлээч наад хүмүүсээ гээд шаардаж байгаад оруулж ирж байна шүү дээ. Энэ чинь л эцсийн дүндээ хүний эрхийн баталгаа шүү. Түүнээс өнөөдөр Үндсэн хуулиараа Үндсэн хууль чинь эхлэхдээ ард түмэн бид гэж Үндсэн хуулиа төрөө байгуулья гэдгийг ард түмэн шийдсэн. Эцсийн шийдвэрүүдийг дандаа ард түмэн гаргаж байгаа тэгэхээр эрх чөлөөгөө мэдэрсэн иргэн хамгийн том хүний эрхийн баталгаа шүү. Та нар энэ шаардлагаа тавьж хуулийн хэрэгжилтийг шаардаж байх хэрэгтэй. Өнөөдөр надаа жоохон ичиж байгаа нэг зүйл байна юу гэвэл эрүүдэн шүүх асуудлаар бид нар өнөөдөр хурал хийгээд сууж байна. Уг нь ардчилсан Үндсэн хуультай оронд бол ийм асуудал бүр огтоосоо байх ёсгүй байхгүй юу тэр Torture гэдэг чинь өөрөө энэ Jus Cogens Preemptory Norm (Эрүүдэн шүүхийг хориглох эрх зүйн үндсэн хэм хэмжээ) гэдэг байхгүй юу? Өөрөөр хэлбэл хүн төрөлхтөнд хориотой олон улсын хуулиар тасан хориотой зүйл байхгүй юу?

Өнөөдөр тэгэхэд бид нар ийм нөхцөлүүд байгаад байна зарим нь үндэслэлтэй л байх зарим нь үндэслэлгүй л байх гэхдээ энэ байгаад ийм олон одоо тохиолдлууд байгаад байна гэдэг бол энд лав л манай Хууль зүйн байнгын хороо амрах эрхгүй байнга ажиллаж байх шаардлагатай байнга хараа цавчихгүй харж байх шаардлагатай байна гэдгийг энэ хурал харуулж байна. Тэгээд би зүгээр эцэст нь нэг зүйлийг хэлмээр байгаа юм. Би энэ С.Эрдэнэболд даргад бас эртээд хэлсэн. Улс төрийн хилс хэрэгт хамрагдсан хүмүүсийг цагаатгах хууль Монгол Улс гаргачихсан юм. Хохирогчдыг нь цагаатгаад байгаа хохироосон нөхдүүдийг оролдоогүй байгаа байхгүй юу. Хэрэв үүгээрээ яваад байвал Монголд Улс төр байгаа цагт энэ цаашаа

үргэлжилнэ. Тийм гэнэн байцгааж болохгүй. Тэгэхлээр тийм хуулийг оруулж ирээд улс төрийн хэрэг хүнийг хилсээр хэрэгт оруулж байгаа хүн гэдэг чинь авлига авч байгаа хүнээс хэдэн 10 дахин дор гэмт хэрэг хийж байгаа юм. Тэрийг 20 жил болон түүнээс дээш хамгийн дээд хэмжээгээрээ ялладаг байх ёстой. Тэрэнд оролцсон шүүгч, прокурор, цагдаа бүгдийг нь нас барсан байсан ч. Яагаад гэвэл нас барчихсан хүнийг гаргаж ирээд цагаатгаад байгаа биз дээ. Тэгвэл буруу юм хийсэн хүнийг нас барсан байсан ч гаргаж ирээд энэ иргэн нь буруу болжээ гэдгийг нь тогтоодог байх ийм хууль оруулж ирэх ёстой л гэж би ярьж байгаа юм.

Сонсгол даргалагч П.Сайнзориг - Д.Цогтбаатар гишүүнд баярлалаа. Дараагийн үг хэлэх гишүүн нь Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн. Таны микрофон.

Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал - Хэдэн зүйлийг би түрүүн асуултандаа асууж чадаагүй хэдэн зүйлээ нэмээд хэлчихье. Юуны өмнө ямар ч байсан энэ танхимд хүрэлцэн ирсэн Та бүхэнд бүгдэд нь баярлалаа. Энэ асуудлаар шүгэл үлээж зоригтой чанга дуугарч байгаа иргэн бүхэн ирээдүйнхээ төлөө оруулж байгаа хөрөнгө оруулалт цагаа зарцуулж байгаа гэж би бол хувьдаа итгэж үнэмшиж байгаа учраас та бүхэнд бүгдэд нь талархлаа гэж хэлье. Гэхдээ бас нэг зүйлийг залруулахгүй бол болохгүй нь. Одоо яг сошиалаар дахиад л шуугиад эхэллээ. С.Чимэгээ болон энэ С.Зоригийн хэрэгт холбогдож ял шийтгэгдсэн боловч эргээд энэ хүмүүст холбогдох хэрэг нь хэргийг нь тухайн Дээд шүүх нь өөрөө хүчингүй болгосон буцаагаад энэ хүмүүстэй холбоотой хэргээ прокурор нь өөрөө хэрэгсэхгүй болгосон гэдгийг чанга дуугаар хэлмээр байна. Тэгэхгүй дахиад л шүүхийн шийдвэрт итгэсэн хэвээрээ хүмүүс танхимд сууж байна гэдэг зүйл гадуур яваад байна. Тэгэхээр олон нийт үзэж байгаа учраас би бас энийг хэлэх нь зөв байх гэж бодож байна. Дараагийн 2 дахь санал зохион байгуулалтын хувьд бид нар бас нэг хэдэн зүйлийг цаашид дараагийнхаа сонсгол дээр анхаармаар юм байна. Энд оролцож байгаа төрийн байгууллагууд сүүлийн 3 жилийн, 5 жилийн байдлаар нэгдсэн байдлаар тоо баримтаа ирүүлдэг баймаар байна. Хооронд нь харьцуулаад анализ хийх ямар ч боломжгүй байна. Жишээ нь, Улсын ерөнхий прокурор 2017 оноос хойших тоо Хууль зүйн яам 2012 оноос хойших тоо Улсын Дээд шүүх 2019 оноос хойших тоо гээд хооронд нь анализ хийх ямар ч боломжгүй нөхцөл байдалтай байлгаад байна. Энэ дээр бид нар бас өөрсдөө анхаарах ёстой байх.

Хоёрдугаарт, сонсголын дарааллын хувьд эхлээд төрийн байгууллагаа сонсох биш эхлээд иргэдээ сонсоод төрийн байгууллага нь иргэдийнхээ энэ асуудалд хариулт өгөх замаар өөрсдийнхөө мэдээ тайлангаа гаргадаг баймаар байна. 3 дугаарт, гишүүдэд урьдчилж тараасан мэдээ материал баримтыг мөн адил энд оролцох хүсэлт гаргасан иргэдэд ч гэсэн бас өгдөг баймаар байна гэсэн. Зохион байгуулалтын хувьд бол нэг ийм 3 зүйлийг бид нар анхаарах ёстой юм байна гэж бодож байна. Эрүү шүүлттэй холбоотой нэг зүйлийг бид нар энд ерөөсөө ярьж чадахгүй орхигдуулаад байна. Ээжтэйгээ хамт хоригдож байгаа хүүхдүүдийн асуудал 2 хүртэл настай нярай нялх хүүхдүүд хоригдож байгаа гэхдээ энэ хүүхдүүд 24 цаг гэрэлтэй орчинд байгаа хүүхдүүд эрүү шүүлтэд өртөж байна.

Өнөөдөр орчин цагт техник хөгжөөд харанхуйд ажилладаг камертай болчихсон. Тэгэхээр хүүхдүүдийн асуудлыг Хууль зүй, дотоод хэргийн яам шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага анхаараад өгөөч. Дараагийнх нь хохирол барагдуулах асуудлыг тухайн жилдээ шийдвэрлэхээс гадна ер нь энэ төрлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг бас боломжит хамгийн бага хугацаанд шийдвэрлэдэг байх талаар холбогдох судалгаа хийлгэх талаар яг энэ санал дээр тусгуулъя. Бид нар жишээ нь сонгуулийн маргааныг тухайн жилдээ заавал шийдвэрлэдэг гээд процессын хувьд хөнгөвчилсөн процессууд байдаг. Тэгэхээр нэгэнт энэ хүмүүст

хэрэг нь хэрэгсэхгүй болчихсон бол дахиж энэ хүмүүсийн хохирлын асуудлыг иргэний шүүхээр шийдэх гэж заавал ингэж хэдэн жил дамнуулдаг байдлыг эргэж нэг харах ёстой юм байна хууль тогтоомжийнх нь хувьд гэж бодож байна.

Гуравдугаарт, криминологийн судалгаа энд тэнд эдгээр байгууллагуудад байгаа бол нэгтгэж өгөөч. Ялангуяа прокуророос хэрэгсэхгүй болгох ийм санал өгөөд байгаа тоонууд энд тэнд гараад байна. Тэгэхээр үүнтэй холбоотой судалгааг нь хийгээд Авлигатай тэмцэх газар хийгээд ирүүлээч гэдгийг хүсье. Тэгээд нэгэнт эрүүдэн шүүлтэд өртөж болж буй нөхцөл байдал ялангуяа энэ хатуу хөрөнгө оруулалтын асуудлыг энд дурдаж байна. Шоронгийн нөхцөл байдал хорих байрны нөхцөл байдал цагдаагийн байр гэдэг. Эдгээрт хөрөнгө оруулъя гэхээр иргэд маань та нар шоронгийн төсөв ярилаа л гээд эргээд л улс төрийн, улс төрчид рүүгээ уурладаг л даа. Бид нар яг одоо нөхцөл байдлаа харж байгаа шүү дээ? Энэ шоронгийн төсөв, шүүхийн төсөв, цагдаагийн байгууллагын төсөв, прокурорын байгууллага гээд шүүх эрх мэдлийн байгууллагын төсөв гэдэг чинь өөрөө ямар их ач холбогдолтой болохыг өнөөдрийн ойлголттой болсон байх гэж найдаж байна. Тэгээд хамгийн сүүлд гадаад улсад байгаа иргэдийнхээ эрхийг хамгаалах тал дээр манай ажлын хэсгийн дүгнэлт дээр дурдаасай. Ялангуяа Солонгос улсаас албадан буцаагдах процесс ажиллагааны явцад хүмүүс эрүү шүүлтэд өртөж байгаа тохиолдлууд нэг биш удаа гарсан. Тэгэхээр бид нарын өнөөдрийн тоо баримт мэдээнд энэ улсуудын талаар мэдээлэл огт дурдагдсангүй. Манай ажлын сонсголын үр дүнд бол энэ асуудлыг тусгайлан авч үзэх, ёстой байх гэж бодож байна.

Сонсгол даргалагч П.Сайнзориг - Баярлалаа. Х.Баасанжаргал гишүүн маш чухал саналуудыг хэллээ. Дараагийн үг хэлэх гишүүн бол Гомбын Ганбаатар гишүүн байна микрофоныг өгье.

Улсын Их Хурлын гишүүн Г.Ганбаатар - Нэлээн орой болсон байна. Тэгээд нэн тэргүүнд сая Д.Цогтбаатар гишүүний тэр хэлсэн хэрвээ тэр хуулийн төсөл, өөрөөр хэлбэл, ардчилсан нийгэмд хүнийг эрүүдэн шүүсэн улс, албан тушаалтантай холбогдох ер нь хэрхэн яаж шийдвэрлэх талаар ийм хуулийн төслийг оруулж ирэхийг нэн тэргүүнд дэмжиж байгаа гэдгээ илэрхийлье. Ийм хууль байх юм бол асуудал бас харьцангуй гайгүй болох байх гэж бодож байна. Өнөөдөр ярьсан зүйлүүдээ ер нь багцлахад 7 гол зүйл дээр л бид ярилцсан юм байна. Хүний эрхийн энэ зөрчлүүд бол цэргийн анги, хорих байр, мөрдөн байцаах шатанд л хамгийн их гардаг юм байна.

Нэгдүгээр зүйл бол би түрүүнд хэлсэн Хууль зүйн сайд нэг тогтоолын төсөл хууль бэлдэж байгаа гэж ярьсан. Тэр хүний эрхийн зөрчил гаргасан нөхдүүд одоо болтол ажлаа хийгээд явж байгаа талаар нэг л мэдээлэл дата үүсгэх ёстой юм байна.

Хоёрдугаарт, тэр Хүний эрхийн Үндэсний Комиссын эрх зүйн орчныг сайжруулах асуудал байна. Биеэ даасан байдал хараат бус байдлыг нь хангах асуудал байна.

Гуравдугаарт, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг олон нийтийн оролцоотой өөрчлөх тэнд хуулиас давсан журмууд үйлчлээд байгаа. Тэр нь хүний эрх эрүүдэн шүүлттэй холбоотой асуудлууд их гараад байгаа тухай түрүүнд бас энэ оролцогчдоос санал гарч байсан.

Дөрөвдүгээрт, С.Шаарийбуу гуай хэлж байсан, энэ үнэнийг хэлсэн хүнийг хамгаалах буюу Шүгэл үлээгчийн тухай хуулиа парламент бас яаралтай батлах шаардлагатай юм байна.

Тавдугаарт, улс төрчдийн захиалгаар энэ сэтгүүлчдийг хилсээр хохироож байгаа асуудал дээр 2-3 сэтгүүлч өнөөдөр байр сууриа илэрхийллээ. Хэлмэгдэгсдийн нөхөн олговортой холбоотой асуудал байна. Өнөөдөр хамгийн их яригдсан зүйл шүүхээс цагаадсан мөртөө нөхөн олговроо авч чадахгүй байгаа нөхөн олговрыг яаж үнэлэх аргачлал байдаггүй юм болов уу гэсэн сэтгэгдэл төрлөө. Мөрдөн байцаах болон цагдан хорих байруудыг дуу дүрстэйгээр ямарваа нэгэн нөлөөлөл орохгүйгээр тэр бичлэгийг хадгалах хөндлөнгийн хяналттай биеэ даасан тийм хараат бус системтэй болгох. Энэ дээр төсөв мөнгийг тавьж өгөх асуудал Хууль зүйн сайдын яриад байгааг дэмжих ёстой юм байна. Улсын Их Хурал дээр хамгийн сүүлийн асуудал бол гадаадад байгаа улс иргэдийнхээ эрх ашгийг хамгаалах эрх нь зөрчигдөж байгаа иргэдийг тэр дэмжих сангийн төсөв мөнгөтэй холбоотой асуудлыг бол Улсын Их Хурал дээр дэмжих нь зайлшгүй. Иймэрхүү 7 зүйл дээр та бүгдийн саналуудыг хувь хүнийхээ хувьд хувь гишүүнийхээ хувьд багцаллаа гэдгийг хэлье. Тэгээд өнөөдрийн хяналтын сонсголд хүрэлцэн ирж оролцсон Та бүхэндээ бүгдэд их баярлалаа.

Сонсгол даргалагч П.Сайнзориг - Мөнхтөрийн Нарантуяа-Нара гишүүн үгээ хэлье.

Улсын Их Хурлын гишүүн М.Нарантуяа-Нара - Тэгэхээр юуны өмнө эрүүдэн шүүгдээд хэлмэгдээд маш олон эрхээрээ хохироод байж байхад нь нэмэлтээр төр засгаас эрхээ сэргээлгэх гэж дахин дахин төрийн хүнд суртал удаа дараагийн нэмэлт ийм дарамтуудыг авсаар байгаа энэ олон жил болоход хэрэг нь шийдэгдэхгүй. Одоо бүр аргаа бараад явж байгаа нийт иргэдэдээ төр засгийн өмнөөс чин сэтгэлээс уучлал хүсье. Өнгөрсөн хугацаанд ийм байсан юм байж. Тэгвэл энэ шинэчлэгдсэн 126 гишүүнтэй парламент арай өөрөөр ажиллана гэдэгт би итгэлтэй байна. Ялангуяа энэ эрүүдэн шүүлтийн асуудал дээр. Үнэхээр манай Монгол Улс эрүүдэн шүүлтийн эсрэг конвенцод нэгдсэн улс юм бол ядаж л энэ эрүүдэн шүүлт мөн хэлмэгдсэн асуудлаар хохирсон хүмүүсийн нөхөн олговрыг олон улсын жишигт нийцсэн байдлаар нь олгодог болох хэрэгтэй. Жишээлбэл хэлмэгдээд 15 жил шорон хоригдоод, хэлмэгдээд гараад ирсэн хүнд ядаж л хэрвээ тэр хүн хөдөлмөрлөж байсан бол наад зах нь 2 өрөө байртай болчихсон л байх ёстой гэх мэтчилэн ийм зүйлүүдийг мөнгөн дүнгээр хэмжигдэх болон мөнгөн дүнгээр үл хэмжигдэх энэ нөхөн олговруудыг үнэхээр хуульд шигтгэж өгөх эрхтэй юм байна. Энэ иргэний алдагдсан боломж алдагдсан эрхийг сэргээлгэх боломжуудыг үнэхээр зүйл нэг бүрээр нь хуульд тусгаж оруулдаг юм уу?

Эрүүл мэнд, сэтгэл санааны хохирол, ар гэр бүлийн хохирол гээд ийм зүйлүүдийг үнэхээр нэг бүрчлэн шигтгэж оруулахгүй болохоор зэрэг тийм зүйл байхгүй гэж явдаг. Улсын Их Хурлын гишүүн болсноос хойш би нэг зүйлийг анзаарсан. Төрийн байгууллагууд маань еэвэнгийн үлгэр шиг байдаг юм байна. Нэг ийм гоё, мөлжүүртэй журам, тэгээд л тэрийгээ л тэр чинь тэгсэн гээд тэгэхээр тэр нь яасан юм бэ гэхээр тэр нь харин тэр байхгүй юу гээд хүний ам таглаад сурчихсан байдалтай байдаг юм байна. Энэ дээрээ шинэ засаг, яам, агентлагийн газрууд үнэхээр дорвитой ажилладаг байгаасай гэж чин сэтгэлээсээ хүсэж байна. Төрийн албаны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах ёстой юм байна гэж би харсан. Яагаад гэвэл хүнийг эрүүдэн шүүсэн хэлмэгдүүлсэн асуудлаас үүдэлтэй эрх мэдэлтэн албан тушаалтанд хариуцлага тооцох механизм нь байхгүй байгаа учраас зүгээр л ажлаас нь халсан, албан тушаалаас нь бууруулсан гэдэг нэрийдлээр хүний амьдрал, амь нас, эрүүл мэнд, сэтгэл санаа хохироод байж байж болохгүй.

Тийм учраас цаашид ийм асуудал гарахгүй байх хамгийн том үндэслэл бол төрийн албан хаагчийн тухай хуульд удирдах албан тушаалд ажиллаж байгаа хүн

ямар нэгэн иргэний санал гомдлоор хүний эрх зөрчигдсөн нь батлагдсан тохиолдолд дахин өөр нэгэн удирдах албан тушаалд томилогддоггүй байх тухай асуудлыг заах. Мөн түүнчлэн дор шууд удирдлагатай албан тушаалтан нь хүний эрхийг ноцтой зөрчсөн, хэлмэгдүүлсэн, эрүүдэн шүүсэн ийм асуудал үүссэн тохиолдолд мөн дээд, шууд удирдлагад нь хамтарсан хариуцлага тооцдог механизмыг бий болгохгүй бол зүгээр л албан хаагчийг ажлаас нь халсан албан тушаал бууруулсан гэдгээр яваад байх юм бол асуудал цааш цаашид хэдэн 10 жилийн туршид хэн нэгэн айлын хүү, айлын аав ээж, иргэн хохирсоор байх болно гэдэгт би бол итгэлтэй байна.

Тийм учраас цорын ганц арга бол хуулиар зүйл, заалтыг зайлшгүй бий болгож өгөх асуудал гэж бодож байна. Дээрээс нь нэмэлтээр хэлэхэд М.Хувцагаан өмгөөлөгч шиг ийм сайхан, хүний төлөө сэтгэлтэй, тууштай өмгөөлөгч нарыг бид нар Хууль зүйн байнгын хороо, хуулийн байгууллагуудаар орохоор зэрэг дэв хүсээд цалин урамшуулал нэмэх асуудлыг аягүй их хөнддөг юм байна. Тэгвэл энэ хүний төлөө ажиллаад байгаа чин сэтгэлээрээ, тууштай өчнөөн олон он жилүүдийг зарцуулаад байгаа өмгөөлөгч нартаа олгодог ийм ёстой нээрээ яадаг юм? Тэр зэрэг дэв, урамшуулал гэж байдаг бол тийм зүйлүүдийг нь өгөөд хүний эрхийн төлөө үнэхээрийн тууштай ажилладаг аливаа нэгэн хүчин зүйл мөнгө санхүү хүрэлцэхгүй байсан ч гэсэн хүний эрхийн төлөө тууштай тэмцдэг ийм өмгөөлөгчдийг бас үй олноор бэлтгэхэд том хөшүүрэг болох юм болов уу гэж би хувьдаа бодож байна. Анхаарал тавьсанд баярлалаа. Тэгээд нийт бүх иргэддээ дахин талархсанаа илэрхийлье. Тэгээд дахин уучлал хүсье.

Сонсгол даргалагч П.Сайнзориг - Цэндийн Сандаг-Очир гишүүнд микрофоныг нь нээе.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир - Баярлалаа. Юуны өмнө 3 санал хэлье. Төрийн албан хаагч албан тушаалтны үйлдсэн эрүү шүүлт тулгах гэмт хэрэгт оногдуулах ялын бодлогыг чангалах ёстой юм байна гэж би хувьдаа бодож байгаа. Энэ дээр Хууль зүйн яам, Хууль зүйн байнгын хороо бас анхаарна биз дээ. Яагаад гэхээр бид нар 2022 онд Эрүүгийн хуулийн 22 дугаар зүйл авлига албан тушаалтай тэмцэх гэмт хэрэгт оногдуулах ялын бодлогыг чангалсан. Яг үүнтэй адилхан энэ 21 дүгээр зуунд эрүү шүүлт тулгаж байгаа, хийж байгаа, хянаж байгаа энэ албан тушаалтнуудыг зүгээр нэг хэдэн төгрөгөөр торгоод өнгөрөх асуудал байж болохгүй. Тийм учраас энэ ялын бодлогыг чангалах ёстой. Хуулийн төслийг бас Хууль зүйн яам бас цаашид анхаарч оруулж ирээч. 2-т Эрүүгийн хууль, Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулж мөрдөн шалгах эрх бүхий байгууллагууд бие биесээ хянадаг шалгадаг одоогийн энэ бүтэц тогтолцоог өөрчлөх асуудлыг Хууль зүйн яам оруулж ирээч гэж өнөөдрийн сонсголоос гарах шийдвэрт тусгамаар байна.

Яагаад гэхээр 7-8 жилийн хугацаанд 14-хөн гэмт хэрэгт л 3 шатны шүүхээр ял оноосон. Жилдээ 8 жилийн дотор хэдэн 100 мянган гэмт хэрэг үйлдэгддэг Монгол Улсын хэмжээнд. Гэтэл түүний 0,05 хувь гэмт хэрэг 414 гомдол санал ирж байхад түүний 14-ийг 3 шатны шүүхээр шийдээд тэрний 8 нь өнөөдөр торгох ялаар оногдоод л явж байна. Ингэхээр албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж хууль, шүүхийн байгууллагууд хоорондоо хэн нэгэндээ хяналт тавих асуудал хариуцлагагүй асуудалд хандаж байна гэж үзэхээр байна. Тийм учраас цаашид гарах тогтоолын төсөлд бас энэ асуудлыг тусгах ёстой юм шиг байна.

Эцэст нь өнөөдрийн энэ сонсголд оролцсон 40 орчим иргэд гуравхан минутад багтааж 5,10,20 жилийнхээ жаргал зовлон, зовлон бэрхшээлийг ярих гээд зарим нэг нь ярьж ч чадахгүй өнгөрөөж байна. Бид чинь иргэн төвтэй, хууль засагладаг, хүмүүнлэг иргэний нийгмийг байгуулах гээд явж байгаа улсууд. Гэтэл Хууль зүйн

байнгын хорооноос тогтоолын төсөлд юу гэж оруулах гэж байгаа вэ? гэхээр би өнөөдрийн энэ хууль хяналтын байгууллагуудыг бүгдийг оролцуулсан ажлын хэсэг гаргаж түрүүн нэг хохирогч иргэн хэлж байна лээ. Хэн билээ миний санааг шууд хэлчихэж байна лээ. Ажлын хэсэг гаргах үгүй ээ бид нар чинь иргэний төлөө ажиллах гэж байгаа юм бол энэ хууль хяналтын байгууллагууд би нэгэнт шүүхээр шийдэгдсэн шүүхийн шийдвэрийг авч хэлэлцэх асуудлыг яриагүй.

Энэ хооронд иргэдийн асуудлыг ярихад маш олон асуудал мэдээллийн зөрүүтэй буруутай байдлаас болж иргэд бухимдалтай гомдолтой явдаг. Төрийн байгууллагууд хууль шүүхийн байгууллагуудад гомдолтой явдаг зүйлүүд асар их байна. Тийм учраас ажлын хэсэг гаргаж эрүүдэн шүүлттэй холбоотой гомдсон хохирсон иргэдийн асуудлыг тусгайлан авч үзэж ажлын хэсэг дээр саналыг нь сонсож яагаад 40 хүнийг 40 өдөр нэг хүний асуудлыг нэг өдөр яагаад ярьж болохгүй юм. Үгүй ээ бид нар үүнийг төрийнхөө иргэдийнхээ төлөө сонсдог төр байя л даа. Яагаад? гуравхан минутын дотор нэг хүний асуудлыг 30,10,20 жилийн асуудлыг ярьж яагаад ч амжихгүй. Тийм учраас нэг хүний асуудлыг нэг өдөрт ярихад ч болохгүй юм байхгүй. Ийм ажлын хэсэг гаргаж өнөөдрийн сонсголын үр дүнд хүрэх ёстой байхгүй юу. Энэ улсуудыг төрд шүүх хяналт прокурорын байгууллагуудад гомдоод байгаа мэдээллийн буруутай байгаа байдлыг нэг тийш нь гаргах, нэг тал руугаа оруулах үүднээс таны энэ шийдвэр ийм учиртай юм байна. Танд эрхээ сэргээх, нөхөн төлбөрөө авах гэдэг юм уу хууль зүйн зөвлөгөө өгөх, талаас нь хүн ёсоор нь авч хөндөж үзэх ийм ажлын хэсэг гаргаж цаашдаа байнгын энэ сонсголоос бас шийдвэртээ ингэж тусгаж өгөөч гэж би хувьдаа хувь гишүүнийхээ хувьд санал оруулмаар байгаа юм.

Ингэж байж бид нар өнөөдөр энэ сонсголыг үр дүнд хүргэнэ гэж бодож байна. Тэрнээс өмнө нь бид нар яалаа нүүрсний хэргээр, ногоон автобусны хэргээр, эмийн сонсгол, ашигт малтмалын лицензээр хийсэн өнөөдөр ямар үр дүн гарсан, хэн хариуцлага хүлээсэн юм мартдаг байхгүй юу. Аягүй бол магадгүй бид нар 2024-2028 онд дараагийн парламент дээр ахиад л энэ асуудлыг өнөөдөр шиг яриад л байж байна. Тийм учраас ахиж ийм асуудлыг ярихгүйн тулд өнөөдрийн гомдолтой байгаа иргэдийг төр нь иргэдээс сонсдог нээлттэй байх үүднээс энэ хүмүүсийн асуудлуудыг шалгаж үзэх мэдээллийн буруутай байдлыг нэг тийш нь оруулах үүднээс ажлын хэсэг гаргаж ажиллаж өгөөч гэж би ажлын хэсгийн даргад хэлэх гэж байгаа юм.

Сонсгол даргалагч П.Сайнзориг - Дараагийн үг хэлэх гишүүн маань Даваагийн Цогтбаатар гишүүн байна. Микрофоныг нээе.

Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар - Энэхүү сонсголд оролцож байгаа оролцохоор өнцөг булан бүрээс ирсэн оролцогч та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Энэ төрийн байгууллагуудад бас ирж мэдээлэл өгч байгаад баярлалаа. Тэгээд бид нар Монголын төр эрүүдэн шүүлттэй тэмцэх Төрийн бус байгууллага байгуултал нь иргэдээ эрүүдэн шүүж байна гэдэг энэ нотолгоо нь энд ийм Төрийн бус байгууллага байгуулчихсан явж байна. Тэгээд бид нар заавал нэг ажлын хэсэг гаргаад ч юм уу сонссон болоод үр дүнд хэзээ хүрэх юм мэдэхгүй явж байсан дорхноо үүнийг сар гэвэл арай их багадчих байх.

Хагас жилдээ юм уу, жилдээ нэг удаа бүгд бөөнөөрөө цуглаад энэ асуудлуудаа өнөөдөр зөвхөн эрүү шүүлттэй холбоотой асуудал. Тэгэхдээ энэ чинь эрүү шүүлтээс гадна дахиад асуудлуудаа ярих хүмүүс. Сая Ц.Сандаг-Очир гишүүн хэлж байна. Хэлж чадаагүй бас энэ мэдээллүүд хоцроод зөндөө үлдчихлээ. Тэгэхээр бүгдээрээ хагас жилдээ юм уу жилдээ нэг удаа ингээд сонсдог байвал яах вэ гэж. Хүний эрхийн дэд хорооны дарга энд сууж байна Хууль зүйн байнгын хорооны дарга сууж байна. Энэ 2-т бас нэг ийм санал хэлж байна. Тэгээд дээрээс нь эрүүдэн

шүүлттэй холбоотой тэр Төрийн бус байгууллагаас гаргаад байгаа Улсын Их Хурлын гишүүдээс бүрдсэн тийм ажлын хэсэг гаргах ёстой юм бол энэ тогтоолынхоо төсөл дээр гаргаад бүгдээрээ энд ажлын хэсгийг нь байгуулаад хамтраад хурдан ажиллаад, нэг талд нь үр дүнд нь хүрчихье гэдэг ийм санал гаргаж байна. Та бүхэнд маш их баярлалаа гэдгээ бас дахин илэрхийлье.

Сонсгол даргалагч П.Сайнзориг - Улсын Их Хурлын гишүүн Сүхбаатарын Эрдэнэболд Танд микрофон нээлттэй байна.

Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд - Энэ танхимд Л.Гансүх гуай сууж байна. Манай Тулгаа сууж байна. Яг бид нарын нүдэн дээр хэлмэгдээд ачуулаад эрүүл мэндээрээ хохироод явж байсан хүмүүс байж байна. Маш олон хүмүүс гарч ирж байна шүү дээ. Тэгэхээр энэ зүйл дээр бид нар одоо нэг улс болж тогломооргүй байгаа юм түр зуур яриад өнгөрдөг нүд хуурсан зурагтаар шуугиад өнгөрдөг маргааш нь мартдаг баймааргүй байгаа юм. Энэ дээр бол хууль хүчний байгууллагынхан шударга ёсыг сахиулах ёстой байгууллагынхан Улсын Их Хурлын сонсоход зориулж хууль эшилж хэлдэг биш өдөр тутмын үйл ажиллагаандаа хүний эрхийг хамгаалах энэ үйлсэд үнэнчээр зүтгэх шаардлагатай байгаа.

Хоёрдугаарт хүний эрхийг хангахад төсөв, санхүүгийн асуудал маш их тулдаг юм байна. Хүний эрхийн Үндэсний Комисс дээр 2 удаа очиж ажилласан нэг удаа Улсын Их Хурлын даргатай 9 сарын 02-нд нөгөөдөх нь уржигдар очоод 5-6 цаг сууж ажилласан дундуур нь албан бус уулзалтууд хийсэн. Манайхан мөнгө төгрөг гэхээр үрэлгэн данхар төрийн үйл ажиллагаанд асар их зардлыг хайхрамжгүй зарцуулдаг мөртлөө яг хүний эрх, эрүүл мэнд, боловсрол гэсэн гол асуудлууд дээр мөнгөө татчихдаг. Яг ингээд тулаад асуухаар хүний эрхийг хангах процесст санхүүжилтийн асуудал маш том асуудал. Тийм учраас энэ Хууль зүйн байнгын хорооны дарга энд байж байна. Мөн Хүний эрхийн дэд хороо байна. Энэ ирэх жилийн төсвүүд дээр хүний эрхийг хамгаалах, хангахтай холбоотой төсөв дээр нэлээн тод дуугарч иргэд олон нийтэд тайлбарлаж явна. Жишээлбэл, ганц 461 дүгээр анги дээр яваад очихоор өмгөөлөгчтэйгөө уулзах 8 кабин нь хажуу талдаа ямар ч дуу тусгаарлагч байхгүй өөрийнхөө асуудлыг ярих боломжгүй байх жишээтэй. Тэнд байгаа хүмүүсийн 90% нь Тухайлбал эрүүл мэндийн даатгал байхгүй өвддөг, хавдар тусдаг эмчилгээ байхгүй. Тэгээд хөөрхий хорих ангийн хүмүүс нь өөрсдөө зардал гаргаад, машин тэргээр эм, эмч, эмчлүүлээд явдаг тэгээд 1 шоронд л орсон бол хүн биш юм шиг ийм харгис нөхцөл байдал гарчихсан байгаад байгаа.

Тэгэхээр бид нар хүмүүнлэг шийдлүүд гаргах хөрөнгө оруулалтын хөрөнгө мөнгийг нь шийдэх ёстой. Дараагийн 3 дахь нь сонгуулийн өмнө маш гоё гоё юм ярьдаг намууд улс төрчид хүний эрхийг хангана Монгол Улс аз жаргалтай Улаанбаатар хотод амьдарна ч гэдэг юм уу маш их зүйлүүд ярьдаг. Тэрийгээ бол гялгар цалгар студи бичлэг болгоод маш олон цацдаг бас сонгуулийн үеэр хүний нэр төр алдар хүндэд халдаж хэн нэгнийг гэмт хэрэгтэн мэтээр орон даяар сурталчилдаг. Сонгууль дуусаад нэг баривчилсан болж байгаад сонгууль дуусаад л гаргаад явчихдаг. Яагаад буруутгасан яасан юм бүү мэд. Тэгээд эндээс дүгнээд хэлэхэд бол бид нар шударга ёсыг наймаалцдаг ийм улсын иргэд баймааргүй байгаа юм. Энэ өөрчлөлт бол хууль тогтоогч нараас эндээс хуулийг хэрэгжүүлж байгаа хүмүүсээс эхлэх ёстой эцэст нь би энд байгаа бас хүмүүст болон үзэж байгаа хүмүүст хэлье.

Ялангуяа шүүхийн прокурорын хууль хэрэгжүүлдэг байгууллагад ажиллаж байгаа хүмүүс хэзээ нэгэн өдөр та бүхэнд чиглэл өгсөн улс төрчид өөрсдөө уснаас хуурай гарч чаддаг шүү. Хэргийг нь та нар үүрдэг та нар хохироод үлддэг шүү. Ийм тохиолдлууд байсаар байсан өнөөдрийн даргыг дагаж битгий шийдвэр гаргаарай.

Хэн нэгэн өндөр албан тушаалтныг ая тал дагаж нутаг ус наадах цаадах юмаа бодож цол зэргээ бодож өнөөдөр та бүхнийг хуулийн биш шийдвэр гаргахад нөлөөлж байгаа энэ үйлдэл чинь эргээд таныг хэрэгтэн болгоно шүү. Таныг үе удмаар чинь авлигачин хэрэгтэн ямар нэгэн тийм асуудалд унагаана шүү. Тийм учраас ямар ч дарга хүн танд чиглэл өгч байсан байсан тэрнийхээ оронд хуулийнхаа дагуу зогсож чаддаг ямар ч том даргын өмнөөс зарчим ярьж чаддаг системийг л манай хууль хүчний байгууллагаас эхлүүлэх юм бол нөгөө яриад байдаг хуулийг, хүний эрхийг зөрчдөг хүний амь нас эрүүл мэндийг хохироодог эд хөрөнгийг нь үгүй хийдэг энэ байдлыг бид нар таслан зогсоох боломжтой юм.

Мэдээж иргэд эрх нь зөрчигдсөн асуудал дээр чанга дуугар тод дуугарах уйлан дуулаад ч болтугай асуудлаа ярих эрхтэй. Эрх чөлөөтэй үүнийг нь бид нар сонсдог шийдвэрлэхийн төлөө явдаг байх ёстой. Эцсийн эцэст нэг зүйлийг хэлэхэд бид энд мянган гоё гоё юм яриад шийдэл яриад байгаа ч гэсэн Монгол Улс өөрөө энэ улс төрийн соёл нь хууль шүүхийнхээ системд гүн нэвчсэн ийм учраас шударга ёсыг тогтоох хүний эрхийг хамгаалах энэ зүйл дээр ийм өрөөл татанхай шийдвэрүүд гараад байгаа гэдгийг бүгдээрээ шулуухан ярьдаг байх ёстой. Тийм учраас цаашдаа хууль бусаар нөлөөлж байгаа албан тушаалаа урвуулан ашиглаж байгаа ямар нэгэн фактороор шийдвэр гаргалтад нөлөөлж байгаа энэ процессыг мэдээлдэг тогтолцоог бид нар хэрэгжүүлэх ёстой байгаад байгаа юм. Ингэхгүй бол ажил албан тушаалтай ярина шүү хэрэг төвөг тохно шүү гээд ийм айлган сүрдүүлдэг. Айдсан дор хуулийн байгууллагынхан ч гэсэн хуульчид маань ч гэсэн шударга ажиллах боломжгүй болчихоод байгаа. Үүнийг бид нар тооцож бодох ёстой. Өнөөдөр ирсэн хүн болгонд баярлалаа.

Сонсгол даргалагч П.Сайнзориг - Баярлалаа. Жудгийн Баярмаа гишүүн өнөөдрийн сонсголыг бас санаачлагч гишүүдийн нэг байгаа. Микрофон нээлттэй байна Танд.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа - Юуны өмнө өнөөдрийн сонсголыг зохион байгуулах шаардлагатай хэмээн үзэж санаачилгыг дэмжиж гарын үсэг зурсан Ардчилсан намын 21 гишүүндээ баярлаж байна. Үүнийг хүлээж авч зохион байгуулах шаардлагатай гэдгийг хүлээн зөвшөөрч өнөөдөр зохион байгуулж цаг хэдий сунасан ч гэсэн тэвчээртэй суусан энэ зохион байгуулсан Хууль зүйн байнгын хороонд баярлалаа. Тэгээд хамгийн гол баярлах ёстой хүмүүс бол Та бүхэн байна. Өнөөдөр энд иргэдийг төлөөлж энэ цаана нь асуудалтай маш олон хүн байгаа энд өнөөдөр хүрэлцэж ирж чадахгүй байгаа маш олон хүмүүсийг төлөөлж та бүхэн энд энэ Монгол Улсад явагдаж байгаа эрүү шүүлт хүнлэг бус харьцаа, хэрцгий асар олон сар жилээр хүмүүсийг чирэгдүүлдэг энэ явдлын гол төлөөлөгчид болоод энд ирээд тэвчээртэй суусан та бүхэнд баярлалаа. 1992 оны Үндсэн хууль шинэ үндсэн хуулийн гол үзэл санаа бол хүний эрх байсан. Хүний эрх, эрх чөлөө бид нар өмнө нь үг үзэл бодлоо илэрхийлэх, эрүүдэн шүүлгэхгүй байх, хэрцгий хандалтад өртөхгүй байх ийм эрх бас байгаагүй. Энэ эрхийг бол бид нар 1992 оны шинэ Үндсэн хуулиар олж авсан.

Харамсалтай нь өнөөдрийг хүртэл энэ эрхээ бүрэн дүүрэн эдэлж чадахгүй иргэд маш их байна. Өнөөдөр бид нар энэ орчин үед 21 дүгээр зуун гарчихсан байхад яриад сууж байдаг бол бас үнэхээр шившиг. Бүх байгууллагад энэ асуудлууд байна. Тэгэхээр энэ байгууллагууд байнгын хандлагаа өөрчлөхөөс эхэлмээр байна. Цэргийн байгууллага гэхэд социализмын үеийн яргалал, дэглэлт байхгүй болсон гэж ярьж байгаа үнэн байх. Нэг талаасаа нөгөө талаасаа өнөөдөр 21 дүгээр зуунд муухай харах нь өөрөө бараг л дээд албан тушаалтнаасаа доошоо муухай харах нь өөрөө бараг социализмын үеийн ярга дэглэлт гэж ойлгох ёстой. Ингэж байж сая хүнлэг сэдэл хүмүүст бий болох юм.

Тэгэхгүй бол социализмын үеийн яргалал дэглэлттэйгээ харьцуулаад байх юм бол энэ хандлага өөрчлөгдөхгүй. Үүнийг би бас зориуд цэргийн байгууллагад хандаж хэлмээр байгаа юм. Энэ хариуцлага хүлээхгүй байгаад л байх юм бол хэрэг зөрчлүүд хэзээ ч тасрахгүй. Тэгэхээр би дахиад нэг зүйлийг онцгойлж хэлмээр байгаа нь гэвэл эрүүдэн шүүлт хийсэн хэрцгий хандсан хүнлэг бус харьцсан төрийн албан тушаалтнуудад хариуцлага тооцохоос гадна хөөн хэлэлцэх хугацааг тооцохгүй байх ёстой юм байна. Дээрээс нь хүн хэлмэгдүүлсэн хүмүүст хөөн хэлэлцэх хугацааг тооцохгүй баймаар байна. Хэрвээ би та нараас нэг юм асууя. Цаазын ял гэж байсан бол өнөөдөр 15 жил ял авсан хүн цаазлуулчихсан байх байсан байна шүү дээ. Тэгэхээр цаазын ял байхгүй болсон нь өнөөдөр үнэхээрийн дэвшилтэд юм болж гэж би бүр зүрх сэтгэлээсээ мэдэрч байна.

Тэгэхээр тэр хуулийнхаа өөрчлөлтийг нэн яаралтай хийгээд хүн хэлмэгдүүлсэн эрүүдэн шүүсэн хүмүүст ямар ч тохиолдолд хуулийн хөөн хэлэлцэх хугацаа гэж байхгүй болгох ёстой үүнийг би бүүр хатуу хэлье гэж бодож байна. Тэгээд хамгийн сүүлд нь хэлэхэд бол сонсголыг санаачилсан эцсийн зорилго ийм сонсголыг дахин дахин битгий хийгээсэй л гэж хүссэн юм. Бид нар арай өөр гэгээлэг зүйлээр уулзаж баймаар байна. Өнөөдөржингөө бид нар маш хүнд сэдвийг ярилаа. Тэгэхээр энэ бүх асуудалтай байгаа хүмүүсийнхээ асуудлыг нэг бүрчлэн авч шийдээд олгох ёстой тэр нөхөн олговрыг нь тултал нь өгөөд дахиж Монгол Улсад ийм асуудлаар сонсгол хиймээргүй байна. Би үүнийг л хэлмээр байна. Энэ эцсийн зорилго байх ёстой. Баярлалаа.

Сонсгол даргалагч П.Сайнзориг - Баярлалаа. Бичгээр Норовын Алтанхуяг гишүүн надад саналаа гаргачихаад явсныг би бас уншиж танилцуулья. Хууль зүйн байнгын хороон дээр хэлэлцэж байгаа энэ ажлын хэсэг байгуулж ажиллая би өөрөө ажлын хэсэгт нь орж ажиллах саналтай байна гээд бичгээр үлдээж явсан. Би түрүүн ярианахаа эхэнд хэлсэн байгаа. Өнөөдрийн хийж байгаа энэ сонсголын үр дүн, хэлэлцэж байгаа асуудал, хөндөгдсөн асуудлуудыг Хууль зүйн байнгын хорооны хуралдаанд танилцуулна. Хуралдаанд оруулахдаа бид нар ингэлээ гээд өнгөрөх биш. Одоо миний зүгээс бас тодорхой Улсын Их Хурлын тогтоолын төслийг оруулъя гэж бодож байгаа. Хууль зүйн байнгын хороо дэмжсэн тохиолдолд Улсын Их Хурлын тогтоолыг чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж батлуулах бүр боломгүй бол ядаж Хууль зүйн байнгын хорооны тогтоол байдлаар албажуулж энд хөндөгдсөн асуудлуудыг шийдвэрлэх арга замуудыг ярилцаж ажиллана гэдэг зүйлийг би энэ дашрамд хэлмээр байна. Ингээд хуралдаан даргалагчийн хувьд ерөөсөө гуравхан товч санал хэлье.

Нэгдүгээрт, Засгийн газрын тусгай сангийн хууль гэж байдаг. Энд хохирогчдын нөхөн төлбөрийн асуудлыг олгох зохицуулалт байгаа. Энэ өнөөдөр учир дутагдалтай байна. Энэ сангийн хөрөнгө хаанаа ч хүрдэггүй. Сангийн хөрөнгө дээр жил болгон одоо юу гэдэг юм шүүхийн шийдвэрлэж ирж байгаа хэргүүдийн иргэдийн хохирсон кэйсүүд л нэмэгдэж ирдэг хохирол барагдалт маш тун багатай байгаа энэ дээр маш том үнийн дүнтэй хэргүүд одоог хүртэл шийдэгддэг ч асуудлууд байдаггүй. Тэгэхээр өнөөдөр Засгийн газар мэдээллээ би түрүүн гүйцээж л асууя гэж бодож байсан. Бараг хохирлын хэмжээ хэдэн тэрбум хүрчихээд байхад бид жилдээ хоёрхон тэрбумыг тавьдаг байхгүй юу.

Тэгэхээр иргэдийнхээ хохирлыг яаж барагдуулах вэ? гэдэг асуудал дээр Улсын Их Хурал хууль тогтоогч мэдрэмжтэй хандмаар байна. Энэ хохирлыг барагдуулах хөрөнгө төсөв мөнгийг тавьдаг баймаар байна. Түүнээс биш ерөөсөө асуудлыг илээд өнгөрдөг нэг их ярилцаад өнгөрдөг биш ийм зүйлийн төлөө явна гэж байгаа. Тийм учраас Засгийн газрын тусгай сангийн тухай хууль дээр миний бие

санаачлаад холбогдох хуулийн төслийг бичсэн байгаа. Энэ дээр авлига, ашиг сонирхлын буюу 22 дугаар бүлэгт заасан гэмт хэргийн улмаас хураагдсан хөрөнгүүдийг хохирол барагдуулах ажиллагаанд зарцуулья.

Дээрээс нь шүүхийн шийдвэр гарахаас өмнө ямар ямар хохирлуудыг тэргүүн ээлжид барагдуулаад буруутай этгээдээс гаргуулж байх вэ? гэдэг зохицуулалтыг оруулсан энэ хуулийн төслийг холбогдох гишүүдтэйгээ би хамтарч санаачилъя гэдэг зүйлийг гаргасан хуулийн төсөл бэлэн болсон байгаа. Үүнийгээ бас би удахгүй иргэд олон нийтээсээ санаачилж саналуудыг нь аваад Засгийн газраас санал авна гэдэг зүйлийг энэ дашрамд хэлье. Дээрээс нь нэг зүйл анзаарагдлаа. Түрүүн би Ц.Сандаг-Очир гишүүний саналтай туйлын ижил саналтай байна. Эрүүдэн шүүхийн конвенцын орчуулга, агуулга нэр томъёог бид нар зөвтгөхөөсөө гадна үүндээ нийцүүлж эрүүгийн 2015 оны Эрүүгийн хуулийн эрүү шүүлт тулгах гэмт хэргийн шинжийг тодорхой болгох ёстой оролдлогыг Засгийн газраас хийсэн байсан боловч хууль маань хэлэлцэгдээгүй.

Шинэ парламент байгуулагдсантай холбоотойгоор буцсан Засгийн газар, Хууль зүй, дотоод хэргийн яам яаралтай оруулж ирэхийг анхаарья. Энэ дээр нэг зүйлийг орхигдож яриад байдаг улс төрд нөлөө бүхий этгээдүүд энэ төрлийн гэмт хэргийн захиалга гэдэг юм уу ийм зүйлд орооцолдсон байх юм бол илүү өндөр хариуцлага хүлээлгэх энэ зүйлүүдийг оруулж ир. Ял хариуцлагыг нэлээн чангатгах ёстой гэдэг байр суурийг Хууль зүйн, дотоод хэргийн яам барьж байсан. Эндээс битгий ухраарай гэдэг зүйлийг би одоогийн Хууль зүй, дотоод хэргийн яамны удирдлагуудад хэлмээр байна. Аливаа эрүү шүүлтийг дандаа эрх мэдэлтэй болоод үүний цаана магадгүй өнөөдрийн олон кэйсүүдийг сонсоод дандаа улс төрийн нөлөө орсон байгааг ерөөсөө бүгд л тод томруун харж байна гэдэг зүйлийг бас хэлье. Ингээд Д.Цогтбаатар дарга бас байгаа учраас Хууль зүйн байнгын хороонд Та бүгдийн яригдаж байгаа бүх асуудлуудыг бас хөндөж холбогдох тогтоолын төслийг ямар ч байсан одоо хийж оруулна.

Тэгэхдээ энэ дээр манай Хууль зүйн байнгын хорооны гишүүд бол маш идэвхтэйгээр сайжруулах ажил дээр нь оролцох байх гэж бодож байна. Ер нь одоо Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль, Шүүх шинжилгээний хуулиудыг би өөрөө бас гардаж бичиж, боловсруулж, батлуулахын төлөө явсан. Энэний цаана бас бага зэрэг ахиц байгаа юм байна. Тэгэхдээ энэ хуулиудыг сайжруулах ёстой юм байна гэдгийг би бас өнөөдөр өөрөө ч гэсэн биеэрээ мэдрээд сууж байна. Энэ зүйлүүд тийм амар байгаагүй. Өнөөдрийн энэ нийтийн сонсголыг хийж байхад манай Хууль зүйн байнгын хороо болон Улсын Их Хурлын гишүүд хүний эрхийн өндөр мэдрэмжтэй, бас үүний төлөө тууштай явцгаая гэдэг итгэл цог байгаа учраас илүү их энэ зүйлүүд дээр дэвшилттэй зүйлүүд гарна гэдэг дээр итгэлтэй байна. Иргэд Та бүгд ч гэсэн бас санал оноогоо хэлээрэй гэдэг зүйлийг хэлье.

Тэгээд уулын мод урттай, богинотой байдаг гэдэгтэй адил манай хууль сахиулах байгууллага болон зарим эрүүдэн шүүлт, хүнлэг бус, хэрцгий хандах нөхцөл байдлыг бүрдүүлж болзошгүй энэ байгууллагуудын зарим нэг алба хаагчид дээрээс нь улс төрийн нөлөө орсноос болж энэ бүх энэ одоо албууд нэлэнхүдээ муухай харагдах нөхцөл байдлууд байдаг юм. Тэгэхдээ энэ дээр бид нар ялгаж авч үзэх ёстой шударга албан хаагчид нь олон байдаг. Ямар ч үед, ямар ч цагт. Тийм ч учраас өнөөдөр Монгол Улс өнөөдөр хүний эрхээ дээдэлсэн ардчилсан ийм нийгмийн цогцлоон хөгжүүлэхийн төлөө явж байгаа гэдэг зүйлийг хэлье.

Өнөөдрийн сонсгол маань Монгол Улсад Үндсэн хуульт ёс бэхэжсэний 100 жилийн ойн өмнө болж байгаа. Энд хамгийн том яригдах юм бол хүний эрхийн асуудал. Энэ хүний эрхийн асуудал бол өнөөдрийн Монгол Улсын хамгийн хайрлаж

явах үнэ цэнтэй зүйл байгаа юм. Ингэж байж өнөөдөр Монгол Улсын тусгаар тогтнол аюулгүй байдлын баталгаа хангагдах юм. Бид бие биедээ хуулийн дагуу харьцдаг хайртай байх буюу хэзээ ч хууль зөрчиж хүнийг хилс хэрэгт тохдоггүй байх, хүчээр гэмт хэргийг тулгадаггүй байх ийм зүйлээс ангид байж Монгол Улсын асуудлууд шийдэгдэнэ гэдэг зүйлийг би бас энэ дээр хэлье.

Энэ гэмт хэргийн явцад хамгийн их бие мах сэтгэл санаагаар хохирохоос гадна яригдаагүй зүйл. Үүний цаана яригдаж байгаа зүйл нэр төр гэдэг зүйлээ бүгд яг энэ гэмт хэрэгт холбогдсон хүмүүс алддаг юм байна. Үүнийг анхаарах ёстой гэдэг зүйлийг бас эндээс олон хүмүүс харлаа.

Өнөөдөр бас 40 гаруй иргэд санал бодлоо хэллээ. Нийт 70 гаруй иргэд маань бүртгүүлээ бүгд идэвхтэй оролцлоо. Хүний эрхийн Үндэсний Комисс маань дүгнэлтээ гаргаж ирүүлээ. Энэ чиглэлийг хариуцаж ажилладаг төрийн байгууллагууд маань бас тодорхой мэдээллүүдээ өгсөн, иргэд, олон нийт маань мэдэх эрхээ хангаж байгаа байх гэж бодож байна.

Гишүүд үг хэлж дууслаа. Өнөөдрийн сонсголыг хааж миний бие бас сая товч тодорхой хэлсэн учраас дахиж нуршиж үг хэлэхгүй.

Ингээд хяналтын сонсгол хаасныг мэдэгдье. Сонсголд идэвхтэй оролцсон Улсын Их Хурлын гишүүд болон нийт иргэддээ, төрийн байгууллагын албан хаагчиддаа баярлалаа гэж хэлмээр байна.